

АЛСЫН ХАРАА  
**2050**  
МОНГОЛ УЛС

**ЭЗХТ** Бизнес  
Ээлтэй  
Монгол

ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

# ХӨГЖЛИЙГ ХУРДАСГАХ СУДАЛГАА

2025.07 сар №02



## Орон сууцны санхүүжилтийн ТОГТОЛЦООГ төрөлжүүлэн хөгжүүлэх загвар

Сэргээгдэх эрчим хүчний төсөл  
шалгаруулалт хэрхэн хийгддэг вэ?

Түүхий эдийн зах зээл болон  
төсвийн шокын нөлөө

АЛСЫН ХАРАА  
**2050**  
МОНГОЛ УЛС

**ЭЗХТ** Бизнес  
Ээлтэй  
Монгол

ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

# Хөгжлийн хурдасгах судалгааг бодлого боловсруулагчид, судлаачид, хувийн хэвшил, олон нийтэд зориуллаа



Эрхэм уншигч Та бүхэнд энэ өдрийн мэндийг өргөн дэвшүүлье.

Зөв тооцоон дээр суурилсан бодлого нь аливаа улс орны эдийн засгийн хөгжлийг хурдасгаж, эрсдлийг тооцож, тойрон, товчилдог жамтай. Тиймдээ ч Монгол Улсын хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлийг тодорхойлох Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх нэн чухал үүргийг “Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төв”-ийн эрдэмтэн, судлаачид 2022 оноос гүйцэтгэж ирсэн. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 77 дугаар тогтоолоор “Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төв”-ийн чиг үүргийг Эдийн засгийн хөгжлийн зөвлөлийн ажлын албатай нэгтгэсэн.











Өнгөрсөн хугацаанд нийт 40 гаруй судалгааны ажил тус төвөөс боловсруулжээ. Эдгээр судалгааг олон нийтэд нээлттэй хүргэх зорилгоор “Хөгжлийг хурдасгах суурь судалгаанууд” цувралын тэргүүн хэвлэлийг 2024 оны 1 дүгээр сард хэвлэн нийтэлсэн. Тэргүүн хэвлэлээр Төрийн албаны чанарын судалгаа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хийгдэх процессын дахин инженерчлэл, Улаанбаатар хотын зорчигч хөдөлгөөний математик загварчлал, Эрчим хүчний салбарын өнөөгийн нөхцөл байдал ба холимог өрсөлдөөнт зах зээл, Мах, махан бүтээгдэхүүний экспортын боломж зэрэг судалгааг танилцуулсан билээ.

“Хөгжлийг хурдасгах судалгаанууд” сэтгүүлийнхээ 2 дахь дугаараар Монгол Улсын эдийн засгийн өмнө тулгамдсан, салбар дундын зохицуулалт шаардсан асуудлаар үнэ цэнтэй мэдлэг, баримт нотолгоог бүрдүүлэн уншигчид та бүхэнд толилуулаж байна. Дэлхийн түүхий эдийн

зах зээлийн огцом өөрчлөлт, Хятадын үл хөдлөх хөрөнгийн зах зээл болон гангийн үйлдвэрлэлийн хэлбэлзэл нь Монгол Улсын эдийн засагт шууд нөлөөлдөг боловч анх удаа тоон үзүүлэлтээр харилцан хамаарлыг харуулж 2025 оны эцэст манай орны ДНБ, төгрөгийн ханш, инфляцийн түвшинд үзүүлэх нөлөөллийг боломжит хувилбараар тооцоолсон. Мөн манай улсад хэрэгжиж буй татварын хөнгөлөлт, урамшууллын бодлогыг аж үйлдвэрийг дэмжих бодлоготой уялдуулах саналыг танилцуулж байна. Орон сууцны зах зээлийн санхүүжилтийн тогтолцоог шинэчлэх загварыг ГБНХХЯ, ХБОСЯ, Монголбанк, Үндэсний баялгийн сан, орон сууцжуулалтын Үндэсний хорооны ажлын алба, НЗДТГ зэрэг олон байгууллагын хамтын ажиллагаанд үндэслэн боловсруулсныг танилцуулж байна. Үүнд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн сонгон шалгаруулалт буюу аукционыг нэвтрүүлэх судалгаа Казакстан улсын, БНХАУ-ын эрчим хүчний нэгдсэн сүлжээний талаарх судалгаа, Төрийн цахимжилт ба ирээдүйн ажил эрхлэлт зэрэг судалгааны ажлууд багтаж байна.

Хөгжлийг хурдасгах судалгааг бодлого боловсруулагчид, судлаачид, хувийн хэвшил, олон нийтэд зориулж байгаа бөгөөд Монгол Улсын тогтвортой, хүртээмжтэй хөгжилд оюуны хөрөнгө оруулалт болно гэдэгт итгэлтэй байна.

**Хүндэтгэсэн,  
Дашдоржийн ЗОРИГТ  
/Хуулийн ухааны доктор/  
Эдийн засгийн хөгжлийн төв УТҮГ  
Гүйцэтгэх захирал**

<p><b>01</b></p>  <p>ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ БОЛОН ТӨСВИЙН ШОКЫН НӨЛӨӨ</p> <p>хуудас 05-16</p>	<p><b>02</b></p>  <p>ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ, УРАМШУУЛЛЫН БОДЛОГО</p> <p>хуудас 17-35</p>	<p><b>03</b></p>  <p>СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ДУУДЛАГА ХУДАЛДАА -АУКЦИОН</p> <p>СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭКСПОРТ</p> <p>хуудас 37 -46</p>	<p><b>04</b></p>  <p>БНХАУ-ЫН ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ТОЙМ</p> <p>хуудас 47-57</p>	<p><b>05</b></p>  <p>ЭСТОНИ УЛСЫН ЦАХИМ ЗАСАГЛАЛЫН ХӨГЖИЛ</p> <p>хуудас 59-64</p>
<p><b>06</b></p>  <p>ИРЭЭДҮЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ БА АЖЛЫН БАЙРНЫ ШИЛЖИЛТ</p> <p>хуудас 65-72</p>	<p><b>07</b></p>  <p>ОРОН СУУЦНЫ САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦООГ ТӨРӨЛЖҮҮЛЭН ХӨГЖҮҮЛЭХ ЗАГВАР</p> <p>хуудас 73-105</p>	<p><b>08</b></p>  <p>ЭЗХТ-ИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ</p> <p>хуудас 107-113</p>	<p><b>09</b></p>  <p>ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ШИНЭЧЛЭЛ</p> <p>хуудас 115-124</p>	<p><b>10</b></p>  <p>ХУВИЙН ХЭВШЛИЙН ТӨЛӨӨЛЛӨӨС ХОЛБОГДОХ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ХҮРЭЭНД ИРҮҮЛСЭН САНАЛ, ЗӨВЛӨМЖ</p> <p>хуудас 125-141</p>

АЛСЫН ХАРАА  
**2050**  
МОНГОЛ УЛС

**ЭЗХТ** Бизнес  
Ээлтэй  
Монгол

**Хянаж ажилласан:**

Галсангийн АЛТАНСУХ  
ЗАХИРАЛ  
"ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТЭС"

Шилгарьдын СОЛОНГО  
ЗАХИРАЛ  
"ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ  
ШИНЭЧЛЭЛИЙН ХӨТӨЛБӨР"

**Редактор :**

Онгоогийн МӨНХГЭРЭЛ  
ТӨСЛИЙН МЕНЕЖЕР  
"МАРКЕТИНГИЙН ХӨТӨЛБӨР"

Чинбатын ГЭРЭЛЧУЛУУН  
МЭРГЭЖИЛТЭН  
"МАРКЕТИНГИЙН ХӨТӨЛБӨР"

**Судалгааны  
график дизайнер:**

Будын ГАНБААТАР  
МЭРГЭЖИЛТЭН  
"ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ  
ХӨТӨЛБӨР"

Эдийн засгийн хөгжлийн төв  
Mongolia Economic  
Development Board EDB

**Хаяг:** Улаанбаатар хот  
Чингэлтэй дүүрэг  
Нэгдсэн үндэстний гудамж –  
Засгийн газрын 2 дугаар байр

**Утас:** 70116838  
**Facebook:** EDB- Mongolia.mn

# 01



## ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ БОЛОН ТӨСВИЙН ШОКЫН НӨЛӨӨ



### СУДЛААЧИЙН ҮГ



**Олонбаяр  
ЭРДЭМБАЯР**

СУДЛААЧ


"Шинэ сэргэлт,  
Инновацын хөтөлбөр"

Email: erdembayar@nrpa.gov.mn

Утас: 70116838

Энэхүү судалгааны ажлаар түүхий эдийн зах зээл болон төсвийн шокын Монгол Улсад үзүүлэх нөлөөг сүүлийн 20 жилийн хугацааны цувааны өгөгдөлд үндэслэн Бүтцийн вектор авторегрессив (SVAR) загвар ашиглан үнэлсэн болно. Судалгааны үр дүнгээс харахад түүхий эдийн зах зээл болон худалдааны гол түнш орнуудын эдийн засгийн өсөлтийн хэлбэлзэл нь Монгол Улсын эдийн засгийн мөчлөгт нөлөөлдөг бөгөөд үйлдвэрлэл, татвар, засгийн газрын хэрэглээ, валютын ханш, инфляцийн 27-63 хувийг тайлбарлаж байна. Түүхий эдийн нийлүүлэлтийн шок эрэлтийн шокоос илүү нөлөөтэй байгаа бөгөөд түүхий эдийн нийлүүлэлтийн шок татварын орлого болон засгийн газрын хэрэглээг өсгөж давхар нөлөө үзүүлж байна.

# ДЭЛХИЙН ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ БОЛОН ТӨСВИЙН ШОКЫН МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ



## 1. Танилцуулга

Өнгөрсөн 30 жилд дэлхийн улс орнуудын эдийн засаг, санхүү болон гадаад худалдааны хувьд бие биеэсээ харилцан хамааралтай байдал өмнө нь хэзээ ч байгаагүйгээр эрчимтэй нэмэгдэж байна. Үүний дотор хөгжиж буй улсуудын нөхцөл байдал нь олон улсад гурван үндсэн үйл явдлаас үүдэлтэй байна (Ган-Очир, 2022). Нэгдүгээрт, Хятадын эдийн засгийн өсөлт болон гадаад худалдаа (Бүтцийн удаашрал, COVID-19-ийн эсрэг бодлого, санхүүгийн хараат байдал) нь хөгжиж буй болон түүхий эд экспортлогч орнуудад нөлөөлдөг. Хоёрдугаарт, АНУ-ын мөнгөний бодлого болон санхүүгийн зах зээлд гарсан шокуудад бодлого боловсруулагчдын үзүүлэх хариу үйлдэл нь дэлхийн санхүүгийн нөхцөл байдлыг хумих замаар бусад улс орнуудад нөлөөлж байна. Гуравдугаарт, Украины дайн, Израйлын зөрчилдөөн зэрэг геополитикийн цочрол, түүнтэй холбоотой хориг арга хэмжээнүүд нь нийлүүлэлтийг тасалдуулж, түүхий эдийн үнэд нөлөөлснөөр бусад хөгжиж буй улс орнуудад нөлөөлж байна. Өнгөрсөн түүхэн хугацаанд гадаад шокууд (2008 оны хямрал, 2016 оны түүхий эдийн үнийн бууралт, COVID-19 болон одоо болж буй худалдааны дайн-тариф) нь мөн адил Монгол Улсын эдийн засагт тодорхой хэмжээнд нөлөөлж ирсэн байдаг.

Монгол Улсын хувьд гадаад шокуудаас хамааралтай жижиг нээлттэй эдийн засаг бөгөөд 2024 онд нийт гарч буй экспорт болон түүхий эдийн бүтээгдэхүүний 91, 88 хувийг тус тус БНХАУ эзэлж байна. Мөн Монгол Улсын нийт гадаад өрийн хэмжээ 2024 онд ДНБ-ий 157 хувь, засгийн газрын өр 33 хувийг эзэлж байгаа нь Монгол Улс түүхий эдийн гадаад зах зээл болон мөнгөний урсгалаас өндөр хамааралтай байгаа байдлыг харуулж байна.

Засгийн газрын төсвийн бодлогын үндсэн хэрэгслүүд болох төсвийн зарлага ба татвар нь эдийн засгийн үзүүлэлтүүдэд гол нөлөөг үзүүлдэг. Үүнийг Кейнсийн эдийн засгийн онол ёсоор, засгийн газрын зарлага нэмэгдэх нь богино хугацаанд нийт эрэлтийг (aggregate demand) шууд нэмэгдүүлж, улмаар эдийн засгийн идэвхжлийг дээшлүүлдэг гэж үздэг. Ялангуяа эдийн засгийн уналт эсвэл зогсонги үе шатанд уг арга хэмжээ нь үйлдвэрлэл, орлого, хэрглээг нэмэгдүүлдэг гэж үздэг (Olivier Blanchard, David R. Johnson, 2012). Мөн засгийн газрын зардал нь үржүүлэгчийн (multiplier) нөлөөтэй тул анхны зарлагын өсөлт нь илүү өргөн цар хүрээтэй эдийн засгийн нөлөө болж хувирдаг байна.

Нөгөө талаар сонгодог (неоклассик) онолын хандлага: Засгийн газрын зарлагын өсөлт нь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг "шахан гаргах" (crowding out)



замаар хүүгийн түвшнийг өсгөж, урт хугацааны эдийн засгийн өсөлтийг сааруулдаг гэж үздэг байна. Мөн өрийн санхүүжилтээр нэмэгдүүлсэн засгийн газрын зардал нь ирээдүйд татварын нэмэгдлийг бий болгож, хэрэглээ, хуримтлал, хөрөнгө оруулалтын шийдвэрт сөргөөр нөлөөлдөг (Ricardian Equivalence буюу Рикардогийн эквивалент онол).

Үүнд татварын нөлөөлөл нь цэвэр татвар буурахад иргэдийн гар дээрх орлого нэмэгдэж, хэрэглээний зарцуулалт өсөж нийт эрэлт нэмэгддэг гэж Кейнсийн эдийн засагчид үздэг. Иймд эдийн засгийн хямралтай үед татвар бууруулах нь эрэлт талаас нь эдийн засгийг сэргээх арга болдог. Харин цэвэр татвар нэмэгдэх нь хэрэглээг бууруулж, улмаар эдийн засгийн өсөлтийг удаашруулдаг. Сонгодог эдийн засагчид цэвэр татвар нь хөдөлмөр эрхлэлтийн шийдвэр, хуримтлал, хөрөнгө оруулалт, бүтээмжийг тодорхойлдог гэж үздэг. Өндөр татвар нь ажиллах, хадгалах, хөрөнгө оруулах хүслийг бууруулж, улмаар эдийн засгийн урт хугацааны өсөлт, үр ашигт сөргөөр нөлөөлдөг (Keynes, 1936).

Үүнээс авч үзэхэд эдийн засгийн онолууд засгийн газрын зарлага, цэвэр татварын үр нөлөөг олон талаас тайлбарладаг байна. Тиймээс Монгол Улсад гадаад шокууд нь (түүхий эдийн эрэлт, нийлүүлэлт, худалдааны гол түнш орнуудын эдийн засаг) дотоод макро эдийн засгийн хувьсагчдад хэрхэн нөлөөлдөг талаар судалж үзэх шаардлагатай болох юм. Энэ нь гадаад шокуудын нөлөө ямар хугацааны дараа хэрхэн нөлөөлөх, нөлөө нь ихэссэн, буурсан зэргийг судлахад бид загвар болон загварт орох хувьсагчдаа оновчтой сонгох шаардлагатай болох болно. Мөн дотоод засгийн газрын хэрэглээ болон татвар бусад макро хувьсагчдад хэрхэн нөлөөлдөг болохыг загварчлах болно.

Гадаад шокуудын нөлөө нь хөгжиж буй улсуудын эдийн засгийн мөчлөгийг бий болгодог гэсэн баримтыг шинжилсэн олон судалгааны ажлууд байдаг. Үүнд Fernandez, Schmitt-Grohe ба Uribe (2017) нарын хийсэн 138 улсын судалгаанд түүхий эдийн бүтээгдэхүүний үнэ дотоодын эдийн засгийн мөчлөгийг дунджаар 33 хувь тайлбарлаж байна гэсэн байдаг. Энэхүү судалгаанаас харвал түүхий эдийн нийлүүлэлтийн шок хөгжиж буй улсуудад ихээхэн нөлөөлдөг болохыг харж болно. Мөн Ratti Vespignani (2015) судалгаанд дэлхийн (Federal Reserve Bank of Dallas for the G40 countries) бодлогын хүүгийн түвшин нь дэлхийн үйлдвэрлэл, үнэ, газрын тосны үнийн өсөлтөд ихээхэн нөлөө үзүүлдэг. Дэлхийн зах зээл дээрх бодлогын хүүгийн өсөлт нь дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ, дэлхийн үйлдвэрлэлийн бууралттай хамааралтай гэсэн байна.

Тэгвэл эдгээр эмпирик судалгаануудад дурдагдсан үр дүнгүүд болон гадаад шокын нөлөө Монгол Улсын макро хувьсагчдад хэрхэн нөлөөлөх бэ? Мөн Засгийн газрын хэрэглээ болон татвар дотоод макро хувьсагчдад

хэрхэн нөлөөлдөг вэ? гэсэн асуулт мөн гарч ирэх юм. Судалгааны загварын онцлогоос шалтгаалан бид гадаад болон дотоод шокуудын цаг хугацааны нөлөөг харуулах, бие биедээ хэрхэн нөлөөлж байгааг үнэлэх зорилготой дээрх хоёр асуултад хариулт олохыг зорих болно. Энэ судалгааны гол зорилго нь энэ харилцан хамаарлыг судлахад оршино.

Эконометрик шинжилгээнд бие биедээ харилцан хамааралтай шокуудын динамик нөлөөг загварчилдаг Вектор авторегресс (VAR) загварыг ихэвчлэн ашигладаг. VAR загвар нь олон төрөл байдаг бөгөөд энэхүү судалгаанд Dungey et al (2014), Dungey et al (2020) нар дээр үндэслэн Doojav et al. (2023) нар болон Souza and Fry-McKibbin (2021), Victor ба Davaajargal (2023) нарын тодорхойлсонтой адил Structural VAR загвараар загварчлахыг зорив.

## 2. Судлагдсан байдал

Structural vector autoregressive (SVAR) загварыг төсвийн бодлогын хариу арга хэмжээний үр нөлөөг судлахад өргөн ашигладаг. SVAR загвар ашигласан судалгаануудын ихэнх нь төсвийн бодлогын ерөнхий үзүүлэлтүүдэд төвлөрч, өөр өөр үржүүлэгчийн хэмжээг болон чиглэлийг тооцоолохыг зорьдог. Ихэнх тохиолдолд энэ нь Засгийн газрын зарцуулалт эсвэл орлого (татварын түвшнийг илэрхийлдэг үзүүлэлт) өөрчлөгдөхөд ДНБ эсвэл бусад макро хувьсагчдад хэрхэн хариу үйлдэл үзүүлж байгааг харуулдаг. Гэхдээ зарим судалгаанууд нь бусад төсвийн хувьсагч (жишээлбэл, орлогын албан татварын хувь хэмжээ) дээр төвлөрсөн байдаг.

SVAR загварын гол сорилт нь бүтцийн шинжтэй төсвийн бодлогын шокыг хэрхэн тодорхойлох вэ гэдэгт оршдог. Өөрөөр хэлбэл, төсвийн хувьсагч дахь гаднын (экзоген) нөлөөг дотоод (эндоген) нөлөөнөөс хэрхэн ялгаж салгах вэ гэдэг асуудал юм. Янз бүрийн арга зүйг ашиглах нь төсвийн үржвэрийн хэмжээг маш өөрөөр тооцоход хүргэдэг тул сонгосон арга зүй нь үр дүнд ихээхэн нөлөө үзүүлдэг. Эмпирик судалгаанд хамгийн өргөн хэрэглэгддэг арга зүйд Blanchard-Perotti (2002) аргыг ашигладаг бөгөөд энэхүү судалгаанд түүний аргачлалыг ашиглахыг зорьсон. Доорх хэсэгт Монгол Улсад хийгдсэн бидний сэдэвтэй холбогдолтой эмпирик судалгаануудыг авч үзнэ.

Gan-ochir Doojav (2022) судалгаанд хөгжиж буй, түүхий эд экспортлогч эдийн засагтай (Монгол Улс) улсад COVID-19-ийн макро эдийн засгийн үр нөлөө, шилжих механизмыг улирлын өгөгдөлд Бэйсийн бүтцийн вектор авторегресс (BVAR) загварыг ашиглан судалсан. Судалгааны зорилго нь COVID-19-ийн хил дамнансан нөлөөг олж илрүүлэх. Судалгаагаар БНХАУ-ын ДНБ болон зэсийн үнийн шок 2020 оны 1-р улирлын бодит ДНБ-ий уналтын тавны гурав болон тавны нэгийг тус

тус эзэлж байна. 2020 оны 2-р улирлаас 2021 оны 1-р улирал хүртэл ажиглагдсан сэргэлт нь гадаад эерэг шоктой холбоотой. Гэхдээ эдийн засагт зээлийн болон хөдөлмөрийн зах зээлийн тасалдал үргэлжилсээр байна.

Gan-Ochir, Davaajargal ба Elbegjargal (2022) нарын түүхий эд экспортлогч хөгжиж буй (Монгол Улс) улсад Глобал мөнгөний нийлүүлэлт, түүхий эдийн зах зээлийн шокын дамжих нөлөөг 2000-2022 он хүртэлх улирлын өгөгдөл дээр Бүтцийн вектор авторегресс (SVAR) загвар ашиглан үнэлсэн. Судалгаанд түүхий эдийн болон олон улсын санхүүгийн зах зээлийн өсөлт, уналтын мөчлөг нь эдийн засагт бизнесийн болон санхүүгийн мөчлөгийг бий болгодог гэдэг үр дүн гаргасан. Гадаад шокууд нь дотоодын үйлдвэрлэл, бодит ханш, зээлийн хүүгийн хэлбэлзлийн тус тус 30, 45, 60 хувийг бүрдүүлж байна. Түүхий эдийн эрэлтийн шок нь түүхий эдийн нийлүүлэлтийн шокоос илүү дотоодын эдийн засгийн мөчлөгт илүү тогтвортой бөгөөд хүчтэй нөлөө үзүүлдэг гэсэн байна.

Victor ба Davaajargal (2023) нарын судалгаанд Монгол Улсын эдийн засагт төсвийн бодлого болон гадаад түүхий эдийн үнийн шок хоорондын нөлөөллийг харуулсан байна. Түүхий эдийн зах зээлийн савлагаатай шинж чанараас хамааралтай эдийн засагт хийсэн дүн шинжилгээний үр дүнд Монгол Улсын төсвийн бодлого нь гадаад түүхий эдийн шокоос мөчлөг сөрсөн байдлаар хариу үйлдэл үзүүлдэг бөгөөд энэ нь ихэвчлэн Засгийн газрын зардлыг оновчтой тохируулах замаар, бага хэмжээгээр орлогодоо нөлөөлөх байдлаар илэрдэг байна. Энэхүү мөчлөг сөрсөн байр суурь нь эдийн засгийн онолын хүрээнд нийцтэй бөгөөд улсын бодит үйлдвэрлэлд тогтворжуулах үүрэг гүйцэтгэдэг байна. Дээрх судлагдсан байдлуудад тулгуурлаж загвараа хөгжүүлсэн бөгөөд бидний судалгааны ажлын онцлогт тохируулан зарим хувьсагчдыг өөрчлөх, шинэлэг байдлыг харгалзан үзэж загварыг хөгжүүлсэн болно.

### 3. Өгөгдөл болон хувьсагчдын тайлбар

Энэхүү судалгаанд Gan-Ochir (2022) судалгаанд авч үзсэн гадаад 4, дотоод 6 хувьсагчтай SVAR загварын аргачлалтай адил хувьсагчдыг рекурсив байдлаар шокуудыг тодорхойлсон бөгөөд судалгаанд гадаад 3, дотоод 6 хувьсагчдыг загварын зохицол, судлагдсан байдал зэргийг үндэс болгож дараалуулж загварын тавилыг бий болгосон. Мөн Blanchard ба Perroti (2002) нарын адил цэвэр татвар болон засгийн газрын хэрэглээг тооцож оруулсан. Судалгаанд 2005 оны 1-р улирлаас 2024 оны 4-р улирал хүртэлх улирлын өгөгдөл дээр шинжилгээ хийсэн. Хувьсагчдын тайлбарыг (хүснэгт 3.1.1)-с харж болно.

Хүснэгт 3.1.1. Хувьсагчдын тайлбар

	Нэр	Тайлбар
Гадаад хувьсагчид	$Csp_t$	Хятадын гангийн үйлдвэрлэл (тонн), ARIMA X13 ашиглаж улирлын тохируулга хийсэн, өсөлтөөр.
	$Pc_t$	Монгол Улсын экспортын голлох бүтээгдэхүүнүүд болох боловсруулаагүй нефть, нүүрс, төмрийн хүдэр, зэсийн баяжмал, боловсруулаагүй алт гэсэн 5 бүтээгдэхүүний бодит үнийн индекс. Дэлхийн банкны Pink sheet дата сангаас түүхий эдийн үнийг авч, экспортын хэмжээгээр жинлэж, АНУ-ын FRED-н хүүгээр инфляцийн тохируулга хийсэн, өсөлтөөр.
	$Yw_t$	Монгол Улстай гадаад худалдаа хийдэг 28 улсын ам.доллаароор илэрхийлэгдэх бодит дотоодын нийт бүтээгдэхүүн. Гаалийн ерөнхий газрын дата сангаас экспортын мэдээллийг авч экспортын жинг тооцоход ашигласан. ДНБ-ий мэдээллийг World Bank (Global Economic Monitor)-аас авч, улирлын тохируулга хийсэн, өсөлтөөр.
Дотоод хувьсагчид	$Rsx_t$	Монгол Улсын экспортын голлох бүтээгдэхүүн болох боловсруулаагүй нефть, нүүрс, төмрийн хүдэр, зэсийн баяжмал, боловсруулаагүй алт гэсэн 5 бүтээгдэхүүний экспортын ам.доллаароор илэрхийлэгдэх хэмжээ. Гаалийн ерөнхий газрын мэдээллийн сангаас тоон өгөгдлийг авсан. АНУ-ын FRED-н хүүгээр инфляцийн тохируулга хийж бодит экспорт руу хөрвүүлсэн, ARIMA X13 ашиглаж улирлын тохируулга хийсэн.
	$T_t$	Татварын болон татварын бус орлого (нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн)-оос хүүгийн төлбөр, цэвэр зээл, урсгал шилжүүлэг (урсгал шилжүүлэг ба хүүгийн төлбөр)-ийг хасаж цэвэр татвар гарна. Инфляцийн тохируулга хийж, ARIMA X13 ашиглаж улирлын тохируулга хийсэн, өсөлтөөр. YCX-ны дата сан.
	$G_t$	Эцсийн ашиглалтын аргаар тооцсон 2015 оны бодит дотоодын нийт бүтээгдэхүүний төрийн байгууллагын хэрэглээ болон хөрөнгийн нийт хуримтлалын нийлбэр засгийн газрын хэрэглээ болно. ARIMA X13 ашиглаж улирлын тохируулга хийсэн, өсөлтөөр. YCX-ны дата сан.
	$Y_t$	Монгол Улсын 2015 оноор зэрэгцүүлсэн ДНБ, ARIMA X13 ашиглаж улирлын тохируулга хийсэн, өсөлтөөр. YCX-ны дата сан.
	$Cpi_t$	Монгол Улсын инфляцын түвшин. Монгол банкны статистикийн сарын бюллетень.
	$Ir_t$	Тухайн сард олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү. Монгол банкны статистикийн сарын бюллетень.
	$R_t$	Төгрөгийн нэрлэсэн бодит үйлчилж буй ханш, өсөлтөөр. YCX-ны дата сан.

Тэмдэглэл: Судлаачийн тооцоолол.


**Хүснэгт 3.1.1. Хувьсагчдын тайлбар-т зээлийн хүү болон инфляцийн түвшинээс бусад бүх хувьсагчдыг загварт жилийн өсөлтөөр оруулж, улирлын нөлөөтэй хувьсагчдын нөлөөг арилгаж суурин (stationary) болгов. Бүх хувьсагчдыг жилийн өсөлтөөр оруулсан нь загварын тайлбарыг нэгдсэн байдлаар хийх, хувьсагчдын бүтцийн шокуудын хамаарлыг танихад хялбар болгож байна.**

График 3.1.2. Хувьсагчдын дескриптив статистик




Тэмдэглэл: Хувьсагчид нь хугацааны цувааны өгөгдөл тул улирлын нөлөөг арилгаж, логарифм авсан.

Хүснэгт 3.1.3 Хятадын гангийн үйлдвэрлэл болон Бодит ДНБ динамик



Тэмдэглэл: Тоон өгөгдлүүд нь логарифм авсан хэлбэрт илэрхийлэгдсэн бөгөөд хэмжээс нь нормчлогдсон. Бодит ДНБ зүүн тэнхлэг, Хятадын гангийн үйлдвэрлэл нь баруун тэнхлэг. Сүүдэрлэсэн хэсэг нь Монголын эдийн засагт болж байсан хямралын он жилүүдийг харуулна.

График 3.1.4 Түүхий эдийн бодит үнэ болон Бодит ДНБ өсөлтөөр динамик



Тэмдэглэл: Тоон өгөгдлүүд нь логарифм өсөлт хэлбэрт илэрхийлэгдсэн бөгөөд хэмжээс нь нормчлогдсон. Бодит ДНБ зүүн тэнхлэг, түүхий эдийн бодит үнэ нь баруун тэнхлэг. Сүүдэрлэсэн хэсэг нь Монголын эдийн засагт болж байсан хямралын он жилүүдийг харуулна.

Дээрх хоёр графикаас дэлхийн түүхий эдийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт болон манай улсын ДНБ хоёрын харилцан хамаарлыг харж болно.

Үүнд: Цэвэр татвар болон засгийн газрын хэрэглээг Blanchard ба Perotti (2002), Markus et al. (2010), Anne

et al. (2019) нарын тодорхойлсонтой адил засгийн газрын хэрэглээг төрийн байгууллагын хэрэглээ болон хөрөнгийн нийт хуримтлалын нийлбэрээр авч, цэвэр татварыг татварын болон татварын бус орлогоос хүүгийн төлбөр, цэвэр зээл, татаас ба шилжүүлэгийг хасаж тооцов.

**Хүснэгт 3.1.5. Гадаад болон дотоод хувьсагчдын корреляцийн коэффициент**

Хувьсагчид	Корреляцийн коэффициент		
	Хятадын гангийн эрэлт	Түүхий эдийн бодит үнэ	Гадаад ДНБ
Хятадын гангийн эрэлт	1.00	0.47	0.94
Түүхий эдийн бодит үнэ	0.47	1.00	0.49
Гадаад ДНБ	0.94	0.49	1.00
Түүхий эдийн бодит экспорт	0.82	0.51	0.93
Цэвэр татвар	0.63	0.43	0.79
Засгийн газрын хэрэглээ	0.84	0.53	0.95
Дотоод ДНБ	0.95	0.42	0.98
Инфляци	-0.32	0.08	-0.29
Хүүгийн түвшин	-0.82	-0.65	-0.76
Бодит валютын ханш	0.16	0.20	0.14

**Тэмдэглэл:** Улирлын өгөгдөл дээр тооцсон энгийн корреляцийн коэффициент

Манай Улсын сүүлийн 20 жилийн хугацаанд засгийн газрын хэрэглээ болон цэвэр татварын ДНБ-д эзлэх бодит хувь өссөн трендтэй байгаа боловч өндөр хэлбэлзэлтэй байгааг харж болно. Цэвэр татварын хувьд татварын орлого цаг хугацааны турш тасралтгүй өсж ирсэн бөгөөд үүнд ААНОАТ, НӨАТ, АМНАТ-ын орлого нийт орлогын 53 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд сүүлийн 3 жилд огцом өссөн байгааг харж болно. Харин Засгийн газрын хэрэглээнд хөрөнгийн хуримтлал өндөр өсөлттэй байна.

Blanchard ба Perotti (2002) нарын тодорхойлсноор татвар, засгийн газрын хэрэглээгээр дамжиж улмаар эдийн засгийн бусад хувьсагчдад нөлөөлнө. Цэвэр татвар нь эдийн засгаас орж ирэх нийт татварын орлогоос хүүгийн төлбөр болон татаас ба шилжүүлгийг хассан дүн болно. Энэ нь төсвийн орлогын цэвэр хэмжээг харуулдаг. Мөн засгийн газрын хэрэглээ нь эцсийн ашиглалтын аргаар тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний төрийн байгууллагын хэрэглээ болон хөрөнгийн нийт хуримтлалын нийлбэр болно. Төрийн байгууллагын хэрэглээ нь бараа, үйлчилгээний урсгал зардал (цалин, төрийн үйлчилгээ г.м) болох бөгөөд хөрөнгийн нийт хуримтлал нь капитал зарцуулалт буюу урт хугацаанд оруулсан хөрөнгө оруулалт, түүний хуримтлал (дэд бүтэц, тоног төхөөрөмж г.м)-ыг харуулна. Засгийн газрын хэрэглээ нь бараа, үйлчилгээний шууд бодит эрэлтийг илэрхийлдэг бөгөөд энэ нь эдийн засгийн

гарцад нөлөөлнө гэж үздэг. Тиймээс бид засгийн газрын хэрэглээ болон цэвэр татварыг Blanchard ба Perotti (2002), Markus et al (2010), Anne et al (2019) нарын тодорхойлсонтой адил загварт оруулсан (хүснэгт 3.1.5). Засгийн газрын хэрэглээ нь эцсийн ашиглалтын аргаар тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний төрийн байгууллагын хэрэглээ болон хөрөнгийн нийт хуримтлалын нийлбэр болно. Төрийн байгууллагын хэрэглээ нь бараа, үйлчилгээний урсгал зардал (цалин, төрийн үйлчилгээ г.м) болох бөгөөд хөрөнгийн нийт хуримтлал нь капитал зарцуулалт буюу урт хугацаанд оруулсан хөрөнгө оруулалт, түүний хуримтлал (дэд бүтэц, тоног төхөөрөмж г.м)-ыг харуулна. Засгийн газрын хэрэглээ нь бараа, үйлчилгээний шууд бодит эрэлтийг илэрхийлдэг бөгөөд энэ нь эдийн засгийн гарцад нөлөөлнө гэж үздэг. Тиймээс бид засгийн газрын хэрэглээ болон цэвэр татварыг Blanchard ба Perotti (2002), Markus et al (2010), Anne et al (2019) нарын тодорхойлсонтой адил загварт оруулсан.

**Хүснэгт 3.1.6. Цэвэр татвар болон засгийн газрын хэрэглээний тодорхойлолт**

	Цэвэр татвар	Засгийн газрын хэрэглээ
<b>Blanchard ба Perotti (2002)</b>	Хувь хүний орлогын татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, шууд бус бизнесийн татвар болон татварын бус хуримтлал, нийгмийн даатгалын шимтгэл болон татварын бус орлогын нийлбэр багтана. Үүнээс цэвэр шилжүүлгийн төлбөр болон Засгийн газраас төлсөн цэвэр хүүгийн төлбөрийг хасна.	Бараа, үйлчилгээний урсгал зардал болон хөрөнгийн хуримтлал гэж тодорхойлогддог.
<b>Markus et al. (2010)</b>	Шилжүүлгийн дараах хүүгийн бус засгийн газрын нийт орлогоор тодорхойлно.	Засгийн газрын эцсийн хэрэглээний зардал болон нийт хөрөнгө оруулалтын нийлбэрээр тодорхойлогддог.
<b>Anne et al. (2019)</b>	Татварын болон татварын бус нийт орлогоос шилжүүлэг, хүүгийн төлбөрийг хасаж тооцно.	Шилжүүлгийг тооцохгүйгээр засгийн газрын хэрэглээ, засгийн газрын хөрөнгө оруулалтын нийлбэрээр тодорхойлогддог.

**Тэмдэглэл:** Дээрх 3 судалгаанд тооцсон цэвэр татвар болон засгийн газрын хэрэглээний тайлбарыг харуулав.

## 4. Судалгааны арга зүй

Энэхүү судалгаа нь сонгогдсон гадаад болон дотоод макро эдийн засгийн өгөгдөлд Structural Vector Autoregressive (SVAR) загварыг үнэлсэн болно. VAR загвар нь өргөтгөлөөсөө шалтгаалж олон төрлөөр үнэлж болох бөгөөд эдийн засгийн шинжилгээнд олон тооны хугацааны цувааны (time series) хувьсагчдын динамик хамаарлыг эдийн засаг математик, статистикийн аргаар ашиглаж олоход хэрэглэгддэг загвар юм.

### 4.1 Загвар

SVAR загвар нь хувьсагчдийн  $K$  хэмжээст векторын дараах бүтцийн VAR(p) тэгшитгэл (1) авч үзье:

$$A_0 Y_t = A_1 Y_{t-1} + \dots + A_p Y_{t-p} + u_t \quad (1)$$

энд  $A_0$  диагональ дээр нэгж утгууд байхаар нормчлогдсон дан бус матриц бөгөөд  $Y_t$ -д агуулагдах хувьсагчдын хоорондын нэгэн зэрэг харилцан хамаарлыг нэгтгэн харуулна.  $A_1, \dots$ , ба  $A_p$  нь  $Y_t$ -д агуулагдах хувьсагчдын хоорондын хоцрогдсон (lagged) хамаарлын бүтцийн параметрууд юм.  $E_t(\epsilon_t \epsilon_t') = D$  ба  $E_t(\epsilon_t \epsilon_{t+s}') = 0$ , бүх  $s \neq 0$  үед, бүтцийн шокын цуваа хамааралгүй байдлыг илтгэнэ.  $D$  нь бүтцийн эвдрэл (disturbances)-ийг агуулсан диагональ матриц байна.

Загварын дата өгөгдөлд 2005-2024 он хүртэлх улирлын дата байх бөгөөд  $Y_t$  нь нийт 10 хувьсагч (гадаад 3 хувьсагч болон дотоод 7 хувьсагч) агуулсан байна. Гадаад хувьсагч нарт Dungey et al (2014) нарын загварчилсантай адил Хятадын гангийн үйлдвэрлэл, бодит түүхий эдийн үнэ болон худалдааны гол түнш орнуудын бодит ДНБ. Эдгээр гадаад шокуудыг дотоод эдийн засаг руу оруулж ирэх суваг нь түүхий эдийн экспорт байх болно.

Мөн цэвэр татвар болон засгийн газрын хэрэглээг Blanchard ба Perroti (2022), Anne et al. (2019) нарын тооцсонтой адил татварын болон татварын бус орлого (нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн)-оос хүүгийн төлбөр, цэвэр зээл, татаас ба шилжүүлэг (урсгал шилжүүлэг ба хүүгийн төлбөр)-ийг хасаж цэвэр татварыг тооцов. Дотоодын нийт бүтээгдэхүүний төрийн байгууллагын хэрэглээ болон хөрөнгийн нийт хуримтлалын нийлбэрээр засгийн газрын хэрэглээг тооцсон.

Бусад дотоод хувьсагчид (ДНБ, инфляци, зээлийн хүү, валютын ханш)-ыг Dungey et al. (2014), Gan-Ochir et al (2023), Victor ба Davaajargal (2023) дагуу тооцож рекурсив (recursive) дараалалд оруулж сонгосон. Дээрх хувьсагчдын дараалалд Blanchard ба Perroti (2002) нарын тодорхойлсонтой адил цэвэр татвар, засгийн газрын хэрэглээ болон ДНБ гэсэн дарааллаар нэмж

оруулсан болно.

SVAR загвар дахь бүтцийн шокын тодорхойлолтыг Dungey et al. (2020) болон Blanchard ба Perroti (2002) нарын тодорхойлсонтой адил тэгшитгэл (2) харуулав.

$$A_0 Y_t = \begin{pmatrix} 1 & 0 & 0 & 0 & 0 & 0 & 0 & 0 & 0 & 0 \\ a_{2,1} & 1 & 0 & 0 & 0 & 0 & 0 & 0 & 0 & 0 \\ a_{3,1} & a_{3,2} & 1 & 0 & 0 & 0 & 0 & 0 & 0 & 0 \\ a_{4,1} & a_{4,2} & a_{4,3} & 1 & 0 & 0 & 0 & 0 & 0 & 0 \\ a_{5,1} & a_{5,2} & a_{5,3} & a_{5,4} & 1 & 0 & 0 & 0 & 0 & 0 \\ a_{6,1} & a_{6,2} & a_{6,3} & a_{6,4} & a_{6,5} & 1 & 0 & 0 & 0 & 0 \\ a_{7,1} & a_{7,2} & a_{7,3} & a_{7,4} & a_{7,5} & a_{7,6} & 1 & 0 & 0 & 0 \\ 0 & a_{8,2} & 0 & 0 & a_{8,5} & a_{8,6} & a_{8,7} & 1 & 0 & 0 \\ 0 & a_{9,2} & 0 & 0 & a_{9,5} & a_{9,6} & a_{9,7} & a_{9,8} & 1 & 0 \\ a_{10,1} & a_{10,2} & a_{10,3} & a_{10,4} & a_{10,5} & a_{10,6} & a_{10,7} & a_{10,8} & a_{10,9} & 1 \end{pmatrix} \begin{pmatrix} csp_t \\ pc_t \\ uw_t \\ r_sx_t \\ t_t \\ g_t \\ y_t \\ cpi_t \\ ir_t \\ r_t \end{pmatrix} \quad (2)$$

$A_t$ -ийн доод гурвалжин матриц нь VAR системийн рекурсив байдлаар тодорхойлогдоно. Мөн дата өгөгдөлд  $A_1$  болон  $A_p$  матрицад хамаарах 1-р хоцролтоор (lag) дамжуулан тодорхойлох хязгаарлалт мөн адил дээрх дараалалтай адил рекурсив хэлбэртэй матриц байна.

VAR загвар дахь хувьсагчдын ерөнхий эрэмбийн тухайд ихэнх экзоген хувьсагчдыг эхэнд эндоген хувьсагчдыг сүүлд байрлуулна. Жижиг нээлттэй эдийн засаг дахь хувьсагчдын хоорондын хамаарал, түүхий эд экспортлогч эдийн засагт зориулсан Кейнсийн шинэ загварууд онолын үндэс болгон ашиглаж байна. Ерөнхий дарааллыг  $Y_t =$  гэж тохируулан [csp, pc, uw, t, g, y, cpi, ir, r] гэж оруулсан. Dungey et al. (2013, 2020) нарын судалгааны дагуу түүхий эдийн эрэлт нь БНХАУ-ын нөөцийн эрэлт (гангийн үйлдвэрлэл) болж эрэлтийг төлөөлөхөд ашигладаг хэмжигдэхүйц хувьсагч (проху) болж байна. Мөн түүхий эдийн үнэ нь түүхий эдийн нийлүүлэлтийг төлөөлөх хувьсагч болно. Мөн засгийн газрын хэрэглээ болон цэвэр татварыг Blanchard ба Perroti (2002), Markus et al (2010), Anne et al (2019) нарын тодорхойлсонтой адил загварт оруулсан.

VAR загварт оновчтой хоцрогдлын зэргийг тодорхойлох нь хамгийн чухал хэсэг юм. Ихэвчлэн бид хоцрогдлын зэргийг бусад хоцрогдлын зэргүүдтэй харьцуулах байдлаар авдаг. Үүнд үдсэн хоёр арга байна: тэгшитгэл хоорондох хязгаарлалт, мэдээллийн шалгуурын арга (info criteria) (AIC, SIC, HQIC) ашиглах. Мэдээллийн шалгуурын аргыг ашиглахдаа VAR загвараа үнэлсний дараа хоцрогдлын зэргийг нийтлэг хэрэглэгддэг AIC, SIC, HQIC зэрэг 3 шалгуураар шалгаж хамгийн бага байгаа хоцрогдлын зэргийг авах замаар олдог. Энэ мэдээллийн шалгуурууд нь хоорондоо төстэй нэг зарчим дээр үндэслэж байгаа боловч торгуул нь хэр чанга байх вэ гэдгээрээ ялгаатай байдаг.  $P$  тухайн загварын авторегрессив хэсэг бөгөөд хамааран хувьсагчийн хоцроосон утгууд хэр урт байгааг харуулна.  $Q$  гэдэг нь тухайн загварын MA хэсэг буюу

алдааны хэсгийн өнгөрсөн үеийн хоцрогдлын утгууд хэр урт байгааг заана. Үүнд мэдээллийн шалгуурыг хамгийн бага байлгах  $p$  болон  $q$ -ийн утгыг олох юм. Үүнд 3 шалгуур нь торгуулаарай ялгаатай байдаг. Энэ нь загварт үнэлэгдэх ёстой хувьсагчийн тоо нэмэгдэх тусам (гаднаас загварт хувьсагч нэмэх нь) мэдээллийн шалгуур нь өсөж байгаа торгуулийг бидэнд өгөх ч нөгөө талдаа алдааны вариацийг бууруулах сонголтыг бидэнд өгч байгаа юм.

Ийнхүү загварын хоцролтын утгыг шалгахад  $lag=1$  өгч байсан бөгөөд загварын найдвартай (robust) байдлыг харгалзан үзэж  $lag=2$  хэсгийн үнэлгээг хавсралт хэсэгт харуулав.

Хугацааны цувааны хувьсагчдын хувьд хувьсагчдын суурин байдал чухал байдаг. Зээлийн хүү болон инфляцаас бусад бүх хувьсагчдын жилийн өсөлтийг авч суурин болгосон бөгөөд хавсралт хэсэгт дэлгэрэнгүй харуулав.

## 5. Загварын үнэлгээний үр дүн

Энэ хэсэгт дотоод эдийн засагт түүхий эдийн бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлтийн шок болон цэвэр татвар, засгийн газрын хэрэглээний шокуудын нөлөөг авч үзэх болно. Үүнд хятадын гангийн үйлдвэрлэлийг эрэлтийн шок, түүхий эдийн үнийг (нүүрс, зэс, төмрийн хүдэр, алт, газрын тос) нийлүүлэлтийн шок, төсвийн үзүүлэлтийг цэвэр татвар болон засгийн газрын хэрэглээгээр авч үзэв. Хариу үйлдлийн функц нь 20 улирал (5 жил)-ын хугацааг харуулна.

**Хавсралт:** График 1.1.-т түүхий эдийн эрэлтэд үзүүлэх дотоод эдийн засгийн хариу үйлдэл (impulse response)-ийг харуулж байна (95 хувийн итгэх интервал).

Хятадын гангийн үйлдвэрлэлийн шок 1 хувь өсөхөд түүхий эдийн бодит үнэ, гадаад гарц, түүхий эдийн экспорт, цэвэр татвар, ДНБ, инфляци, валютын бодит ханш өсөж байна. Түүхий эдийн бодит үнэ 4 улирлын дараа оргил цэгтээ 1.5 хувьд хүрч байна. Харин дотоод хувьсагчдын хувьд суурь түвшнээс экспорт 4 улирлын дараа 1.6 хувьд хүрч, цэвэр татвар 1.7 хувьд хүрч байгаа бөгөөд түүхий эдийн эрэлтийн нөлөө 20 улирлын дараа ч нөлөөтэй байгааг харж болно. Энэ эрэлтээр дамжин татварын орлого өсөж байгааг харуулна. Харин засгийн газрын хэрэглээ болон хүүгийн түвшин бага зэрэг буурч байна. Мөн дотоод эдийн засгийн өсөлт 7 улирлын дараа 0.5 хувьд дээд цэгтээ хүрч байгаа бөгөөд мөн адил эдийн засагт үзүүлэх нөлөө нь тууштай байна. Инфляци болон валютын ханшийн хувьд хүчтэй нөлөө үзүүлж байгаа бөгөөд 8 улирлын дараа дээд цэгтээ хүрч нөлөө нь үргэлжилж байна. Түүхий эдийн эрэлтийн шок өсөхөд валютын ханш чангарч байгаа бөгөөд Dunge

et al. (2014) судалгааны үр дүнтэй адил, Gan-Ochir et al. (2023) судалгааны үр дүнгээс өөр гарч байна. Үүнээс авч үзвэл түүхий эдийн эрэлтийн шок манай улсад хүчтэй нөлөө үзүүлж байгаа бөгөөд экспорт, татварын орлого, эдийн засаг өсөж улмаар инфляци болон валютын ханшид эерэг нөлөөлж байна.

**Хавсралт:** График 1.2.-т түүхий эдийн нийлүүлэлтэд үзүүлэх дотоод эдийн засгийн хариу үйлдэл (impulse response)-ийг харуулж байна (95 хувийн итгэх интервал).

Түүхий эдийн нийлүүлэлтийн шок 1 хувь өсөхөд Хятадын гангийн үйлдвэрлэл, гадаад гарц буурч байна. Дотоод эдийн засагт түүхий эдийн экспорт, татварын орлого өсөж 4 улирлын дараа тус тус 0.9, 1.1 хувь болж дээд цэгтээ хүрч нөлөө нь буурч байна. Үүнтэй адил засгийн газрын хэрэглээ өсөж байгаа бөгөөд 5 улирлын дараа 1.1 хувьд дээд цэгтээ нөлөө нь хадгалагдаж байна. Энэ нь түүхий эдийн нийлүүлэлтийн шок төсвийн давхар нөлөөг үзүүлж байгаа бөгөөд түүхий эдийн үнийн өсөлтөөр өдөөгдсөн татварын орлогын өсөлт, засгийн газрын хэрэглээний өсөлт хамт өсөж байгаа нь бизнесийн мөчлөгийн дагуу явагдаж байгааг харуулж байна. Энэ нь Victor ба Davaajargal (2023) нарын судалгааны үр дүнгээс өөр байгаа бөгөөд манай судалгааны үр дүнд бизнесийн мөчлөгийн дагуу төсвийн бодлого явагдаж байгааг харуулж байна. Мөн эдийн засгийн өсөлт 5 улирлын дараа 0.1 орчим хувьд хүрч өсөж, нөлөө нь буурч байна. Инфляцийн түвшин түүхий эдийн нийлүүлэлтийн шокиг дагаж өсөж байгаа бөгөөд 5 улирлын дараа хамгийн өндөр нөлөөг үзүүлж байна. Валютын ханш чангарч байгаа бөгөөд 6 улирлын дараа хамгийн өндөр нөлөөг үзүүлж байна. Хүүгийн түвшин урт хугацаанд буурч байна. Үүнээс авч үзэхэд, түүхий эдийн нийлүүлэлтийн шок нь манай улсад эерэг нөлөө үзүүлж байгаа бөгөөд төсвийн бодлого тэлж эдийн засаг халах үзэгдлийг авч ирж байна.

**Хавсралт:** График 1.3.-т цэвэр татварын шоконд үзүүлэх дотоод эдийн засгийн хариу үйлдэл (impulse response)-ийг харуулж байна (95 хувийн итгэх интервал).

Цэвэр татварын шок 1 хувь өсөхөд дотоод эдийн засагт, засгийн газрын хэрэглээ өсөж 2-4 улирлын дараа 0.4 хувьд хүрч нөлөө нь өсөж байна. Энэ нь мөн адил бизнесийн мөчлөгийн дагуу явагдаж байгааг харж болно. Эдийн засгийн өсөлт бага зэрэг нэмэгдэж урт хугацаанд хадгалагдаж байна. Инфляцийг бууруулж байгаа бөгөөд 4 улирлын дараа 0.2 хувьд хүрч нөлөө нь тууштай хадгалагдаж байна. Энэ нь Blanchard ба Perroti (2002) нарын үр дүнтэй адил татварын шок нь инфляцийг бууруулж буй нөлөөтэй адил байгаа ч засгийн газрын хэрэглээ болон ДНБ өсөж байгаа нь тохирохгүй байна. Энэ нь манай улсын төсвийн бодлого мөчлөг дагадаг байдлаас хамааралтай байж

болзошгүй байна. Мөн хүүгийн түвшин буурч, валютын ханшид нөлөөгүй байна.

**Хавсралт:** График 1.4.-т Засгийн газрын хэрэглээний шоконд үзүүлэх дотоод эдийн засгийн хариу үйлдэл (impulse response)-ийг харуулж байна (95 хувийн итгэх интервал).

Засгийн газрын хэрэглээний шок 1 хувь өсөхөд дотоод эдийн засагт гарц, инфляци болон хүүгийн түвшин өсөж байна. Эдийн засгийн өсөлтөд богино хугацаанд 0.06 хувь өсгөж байгаа бөгөөд Blanchard ба Perroti (2002) нарын үр дүнтэй адил байгаа ч төсвийн үржүүлэгч манай улсад хамаагүй бага байна. Мөн инфляцид урт хугацаанд бага зэрэг өсгөх нөлөө үзүүлж, нөлөө нь хадгалагдаж байна. Өмнөх 3 шокоос ялгаатай нь, хүүгийн түвшин урт хугацаанд өсөж байгаа бөгөөд валютын ханш суларч 8 улирлын дараа 1.1 хувийн дээд хэмжээнд хүрч хадгалагдаж байгаа нь засгийн газрын хэрэглээ нэмэгдсэнээр хүүгийн зардал өсөж, валютын ханш суларч шахан гаргах үзэгдэл (crowding-out effect) явагдаж байгааг дэмжиж байна. Үүнээс авч үзвэл, засгийн газрын хэрэглээ нь эдийн засгийн өсөлтийг богино хугацаанд идэвхжүүлж байгаа хэдий ч инфляци, хүүгийн түвшинг урт хугацаанд нэмэгдүүлж, валютын ханшийг сулруулах нөлөөг үзүүлж байна.

График 5.1.1-т Вариацийн задаргаа (variance decomposition)-г харуулж байгаа бөгөөд, түүхий эдийн эрэлт, нийлүүлэлт болон худалдааны гол түнш орнуудын

ДНБ дотоод эдийн засгийн хувьсагчдад үзүүлэх нөлөөний хөдөлгөөнийг харуулж байна.

Вариацийн задаргаа нь шокуудын сонгогдсон гадаад хувьсагчдын хөдөлгөөнийг хэрхэн тайлбарлаж байгааг харуулна. Үүнээс харвал, гадаад шокууд (нь Монгол Улсын эдийн засагт өндөр нөлөөг урт хугацаанд үзүүлж байгааг харж болно. Түүхий эдийн зах зээлийн шок дотоодын эдийн засгийн 32 хувь (гадаад гарцуудын шок нэмэгдэвэл 63 хувь)-ийг тайлбарлаж байна (30 улирлын дараа). Энэ нь Gan-Ochir et al. (2023) нарын судалгааны үр дүнтэй ойролцоо байгаа бол Dungy et al. (2013) судалгааны үр дүнгээс бага байна (Австрали Улсын эдийн засаг). Мөн эдийн засгийн өсөлтөд түүхий эдийн нийлүүлэлтийн шок давамгайл нөлөө үзүүлж байна. Татварын орлого болон засгийн газрын хэрэглээ тус бүр 27, 35 хувийг бүрдүүлж байна. Инфляцийн хувьд гадаад шокууд 45 хувийг эзэлж байна. Мөн Валютын ханшийн 44 хувийг гадаад шок бүрдүүлж байгаа бөгөөд түүхий эдийн нийлүүлэлтийн шок гол хэлбэлзлийг тайлбарлаж байна. Харин хүүгийн түвшний 13 хувийг гадаад шок бүрдүүлж байна. Ерөнхий байдлаар түүхий эдийн эрэлтийн шок манай улсын эдийн засагт илүү нөлөө үзүүлж байна.


## 5.2 Загварын найдвартай байдал

Вектор авторегресс загвартай ажиллаж байх үед загварын найдвартай байдлыг (robustness) шалгах нь чухал байдаг. Ихэвчлэн хоцролтын (lag) утгыг өөрчлөх байдлаар авч үздэг. Бид үндсэн загвартаа хоцролтын утгыг  $j = 1$  дээр дурдсанаар өгсөн. Харин загварын найдвартай (robust) байдлыг харгалзан хоцролтын утгыг  $j = 2$  гэж үнэлж үр дүнг харьцуулав.

Хоёр загварыг харьцуулж үзэхэд хариу үйлдлийн функц хэсэгт ач холбогдолтой өөрчлөлт байгаагүй бөгөөд ерөнхий чиглэл болон өөрчлөлт адил байна. Харин жижиг өөрчлөлт нь, хариу үйлдлийн функц хэсэгт түүхий эдийн нийлүүлэлтийн шок дотоод эдийн засагт урт хугацаанд хадгалагдаж байсан бөгөөд засгийн газрын хэрэглээний шокын нөлөө үндсэн загвараас бага зэргийн багасаж орж ирсэн байна. Мөн вариацийн задаргаа хэсэгт гадаад шокуудын нөлөө инфляци дээр үндсэн загвараас бага хэсгийг бүрдүүлж (үндсэн загварт 51 хувь – 38 хувь болж буурсан) байгаагаар ялгаатай байв. Харин татвар болон эдийн засгийн өсөлт дээр гадаад шокын нөлөө бага зэрэг нэмэгдэж орж ирсэн байна.

Ерөнхий загварын найдвартай (robust) байдалд харьцуулсан анализ хийж үзэхэд хоцролтын утганд үзүүлэх ялгаатай байдал байхгүй байна.

**График 5.1.1. Дотоод хувьсагчдын вариацийн задаргаа**



**Тэмдэглэл:** Csp – Хятадын гангийн үйлдвэрлэл; Pc – Түүхий эдийн бодит үнэ; Fy – Гадаад бодит ДНБ; T – Цэвэр татвар; G – Засгийн газрын хэрэглээ; Y – Бодит ДНБ; CrI – Инфляци; Ig – Хүүгийн түвшин; R – Валютын бодит ханш

**Тэмдэглэл:** SVAR(1) загвар ( $j=1$ )

### 5.3 Загварт суурилсан төсөөлөл

Дэлхийн түүхий эдийн зах зээл болон Монгол Улсын төсвийн эдийн засагт үзүүлэх нөлөөг загварт суурилж

таамаглахад 2-4 улирлын дараа дараах үр дүнгүүд гарч болохоор байна.

#### 5.3.1. Бэлхийн түүхий эдийн зах зээл болон монгол улсын нэгдсэн төсвийн эдийн засагт үзүүлэх нөлөө: хувилбарт тооцоолол

##### Сценари 1:

**БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн уналт, аж үйлдвэржилтийн салбарын үйлдвэрлэл суларч байна => Гангийн үйлдвэрлэл 10 хувиар унах** (Trading economics – forecast 2026 онд БНХАУ-ын гангийн үйлдвэрлэл 81.5 сая тонн буюу энэ оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 10.4 хувь буурах)

- Түүхий эдийн экспорт (суурь утгаас): **-16 хувь**
- Татварын орлого (суурь утгаас): **-10.3 хувь**
- Засгийн газрын хэрэглээ (суурь утгаас): 3.1 хувь
- Бодит ДНБ (суурь утгаас): **-1.49 хувь**
- Инфляц (суурь утгаас): **-1.1 нэгж хувь**
- Зээлийн хүү (суурь утгаас): 0.4 нэгж хувь
- Бодит ханш (суурь утгаас): **-2.9 хувь**

##### Сценари 2:

**Глобал эрэлт буурч байна, нийлүүлэлтийн өрсөлдөөн нэмэгдэж байна, эрчим хүчний шилжилт, геополитикийн тодорхой бус байдал, тарифын дайн => Түүхий эдийн үнэ 10 хувиар буурах** (нүүрсний үнэ 98.6\$/tp жилийн дотор 44 хувь, 1 баррель газрын тос \$66 орчим жилийн дотор 34 хувь)

- Түүхий эдийн экспорт (суурь утгаас): **-9.3 хувь**
- Татварын орлого (суурь утгаас): **-9.05 хувь**
- Засгийн газрын хэрэглээ (суурь утгаас): **-9.8 хувь**
- Бодит ДНБ (суурь утгаас): **-0.6 хувь**
- Инфляц (суурь утгаас): **-3.4/-1.2 нэгж хувь**
- Зээлийн хүү (суурь утгаас): 0.4 нэгж хувь
- Бодит ханш (суурь утгаас): **-8.95 хувь**

##### Сценари 3:

**Түүхий эдийн үнийн бууралт, татварын орлогын тасалдал, төсвийн алдагдал => татварын орлого 10 хувь буурах** (2024-2025 оны 4 сард төсвийн орлого 13 хувь буурсан)

- Засгийн газрын хэрэглээ (суурь утгаас): **-4 хувь**
- Бодит ДНБ (суурь утгаас): **-0.7 хувь**
- Инфляц (суурь утгаас): 0.7 нэгж хувь
- Зээлийн хүү (суурь утгаас): 0.23
- Бодит ханш (суурь утгаас): ~

##### Сценари 4:

**Төсвийн орлогыг дагаж => Засгийн газрын хэрэглээ 10 хувь буурах** (алдагдалгүй төсвийн дагуу дагаж бууруулах ёстой ч 2024-2025 оны 4 сард төсвийн зарлага 9.8 хувь өссөн байна)

- Бодит ДНБ (суурь утгаас): **-0.5 хувь**
- Инфляц (суурь утгаас): **-0.9 хувь**
- Зээлийн хүү (суурь утгаас): ~ (дунд хугацаанд+ 3-5 жил)
- Бодит ханш (суурь утгаас): 1.9

##### Сценари 5:

**Хамтын нөлөө (1+2+3)** (2016-2017 оны хооронд бодит ханш 15 хувь суларч байсан, 2025 оны 4 сард түүхий эдийн экспорт 16 хувь буурсан байна)

- Түүхий эдийн экспорт (суурь утгаас): **-25.3 хувь**
- Татварын орлого (суурь утгаас): **-19.35 хувь** (одоогийн 13 хувиар буурвал жилийн эцэст 3.8 их наяд – ДНБ 4.2 хувь, 19 хувиар буурвал 5.7 их наяд – ДНБ 6.3 хувь)
- Засгийн газрын хэрэглээ (суурь утгаас): **-10.7 хувь** (10.7 хувиар буурахад 3.2 их наяд төгрөгөөр буурна. ДНБ 3.6 хувь)
- Бодит ДНБ (суурь утгаас): **-2.79 хувь**
- Инфляц (суурь утгаас): **-1.1 нэгж хувь**
- Зээлийн хүү (суурь утгаас): **1.13 нэгж хувь**
- Бодит ханш (суурь утгаас): **-11.85 хувь**

**Сценари 1.** БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн уналт, аж үйлдвэржилтийн салбарын үйлдвэрлэл суларч байна => Гангийн үйлдвэрлэл 10 хувиар унах (Trading economics – forecast 2026 онд БНХАУ-ын гангийн үйлдвэрлэл 81.5 сая тонн буюу энэ оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 10.4 хувь буурах)

- Түүхий эдийн экспорт (суурь утгаас): -16 хувь
- Татварын орлого (суурь утгаас): -10.3 хувь
- Засгийн газрын хэрэглээ (суурь утгаас): 3.1 хувь
- Бодит ДНБ (суурь утгаас): -1.49 хувь
- Инфляц (суурь утгаас): -1.1 нэгж хувь
- Зээлийн хүү (суурь утгаас): 0.4 нэгж хувь
- Бодит ханш (суурь утгаас): -2.9 хувь

**Сценари 2.** Глобал эрэлт буурч байна, нийлүүлэлтийн өрсөлдөөн нэмэгдэж байна, эрчим хүчний шилжилт, геополитикийн тодорхой бус байдал, тарифын дайн => Түүхий эдийн үнэ 10 хувиар буурах (2025 оны 4-р сарын байдлаар нүүрсний үнэ өмнөх оноос 98.6\$/tp жилийн дотор 44 хувь, 1 баррель газрын тос \$66 орчим жилийн дотор 34 хувь (World bank, commodity market – pink sheet))

- Түүхий эдийн экспорт (суурь утгаас): -9.3 хувь
- Татварын орлого (суурь утгаас): -9.05 хувь
- Засгийн газрын хэрэглээ (суурь утгаас): -9.8 хувь

- Бодит ДНБ (суурь утгаас): -0.6 хувь
- Инфляц (суурь утгаас): -1.2 нэгж хувь
- Зээлийн хүү (суурь утгаас): 0.4 нэгж хувь
- Бодит ханш (суурь утгаас): -8.95 хувь

**Сценари 3.** Түүхий эдийн үнийн бууралт, татварын орлогын тасалдал, төсвийн алдагдал => татварын орлого 10 хувь буурах

(2024-2025 оны 4 сард төсвийн орлого 13 хувь буурсан)

- Засгийн газрын хэрэглээ (суурь утгаас): -4 хувь
- Бодит ДНБ (суурь утгаас): -0.7 хувь
- Инфляц (суурь утгаас): 0.7 нэгж хувь
- Зээлийн хүү (суурь утгаас): 0.23
- Бодит ханш (суурь утгаас): ~

**Сценари 4.** Төсвийн орлогыг дагаж => Засгийн газрын хэрэглээ 10 хувь буурах (алдагдалгүй төсвийн дагуу дагаж бууруулах ёстой ч 2024-2025 оны 4 сард төсвийн зарлага 9.8 хувь өссөн байна)

- Бодит ДНБ (суурь утгаас): -0.5 хувь
- Инфляц (суурь утгаас): -0.9 хувь
- Зээлийн хүү (суурь утгаас): ~ (дунд хугацаанд+ 3-5 жил)
- Бодит ханш (суурь утгаас): 1.9

Шахан гаргах нөлөө үзүүлж байж болзошгүй.

**Сценари 5. Хамтын нөлөө (1+2+3)**

(2016-2017 оны хооронд бодит ханш 15 хувь суларч байсан, 2025 оны 4 сард түүхий эдийн экспорт 16 хувь буурсан байна)

- Түүхий эдийн экспорт (суурь утгаас): -25.3 хувь
- Татварын орлого (суурь утгаас): -19.35 хувь (2025 оны 4 сарын байдлаар тооцсон 13 хувиар буурвал жилийн дараа 3.8 их наяд – ДНБ 4.2 хувь, 19 хувиар буурвал 5.7 их наяд – ДНБ 6.3 хувь)
- Засгийн газрын хэрэглээ (суурь утгаас): -10.7 хувь (10.7 хувиар буурахад 3.2 их наяд төгрөгөөр буурна. ДНБ 3.6 хувь)

- Бодит ДНБ (суурь утгаас): -2.79 хувь
- Инфляц (суурь утгаас): -1.6 нэгж хувь
- Зээлийн хүү (суурь утгаас): 1.13 нэгж хувь
- Бодит ханш (суурь утгаас): -11.85 хувь

Гадаад эдийн засгийн нөхцөл байдал манай улсад ирэх 4 улирлын дараа суурь утгаас түүхий эдийн экспорт -25.3 хувиар, татварын орлого -19.35 хувиар, засгийн газрын хэрэглээ -10.7 хувиар, бодит ДНБ -2.79 хувиар, инфляци -1.6 нэгж хувиар, зээлийн хүү +1.13 нэгж хувиар, төгрөгийн бодит ханш -11.85 хувиар сулрах өөрчлөлт гарах боломжтой байна (энэхүү сценарио нь загварт суурилсан таамаглал болно).

**6.Дүгнэлт**

Энэхүү судалгааны ажлаар түүхий эдийн эрэлт, нийлүүлэлтийн шок болон төсвийн бодлогын шокын дотоод эдийн засагт үзүүлэх нөлөөг судлахыг зорьлоо. Бид түүхий эдийн зах зээл болон төсвийн шокын нөлөөг үнэлэх зорилгоор SVAR загварыг ашиглаж, гадаад 3 хувьсагч, дотоод 7 хувьсагчаас бүрдсэн байдлаар үнэлсэн.

Үүнээс голлох 3 үр дүн гарсан. Нэгдүгээрт, түүхий эдийн зах зээлийн шок эдийн засагт эерэг нөлөөтэй буюу гарц, түүхий эдийн экспорт, татвар, засгийн газрын хэрэглээ, инфляци өсөж, валютын ханш чангарч байна. Мөн эдгээр гадаад шокууд нь дотоод эдийн засгийн хэлбэлзлийн 27-63 хувийг тайлбарлаж байна. Үүний дотор эдийн засгийн өсөлтийн 63 хувийг, татвар болон засгийн газрын хэрэглээ тус бүр 27, 35 хувь, инфляцийн 45 хувь, валютын ханшийн 44 хувийг тайлбарлаж байна. Мөн түүхий эдийн эрэлт болон нийлүүлэлтийн эерэг шок нь эдийн засагт богино, дунд хугацаанд эерэг нөлөөтэй байна. Хоёрдугаарт, түүхий эдийн нийлүүлэлтийн шок төсөвт давхар нөлөөг үзүүлж байгаа бөгөөд түүхий эдийн шокын өсөлтөөр өдөөгдсөн татварын орлогын өсөлт засгийн газрын хэрэглээ давхар өсөж байгаа нь бизнесийн мөчлөгийн дагуу төсвийн бодлого

явагдаж байгааг харуулж байна. Гуравдугаарт, засгийн газрын хэрэглээний шокын өсөлт хүүгийн түвшинг өсгөж, валютын ханшийг сулруулж байна. Энэ нь дунд хугацаанд хүүгийн зардлыг нэмэгдүүлж шахан гаргах (crowding-out effect) нөлөө үзүүлж байгаа аргументийг дэмжиж байна.

Үүнээс авч үзэхэд судалгааны эхэнд тавигдсан хоёр асуулт болох түүхий эдийн зах зээлийн болон төсвийн шокын эдийн засагт үзүүлэх нөлөөг тодорхой хэмжээнд эмпирик судалгаагаар харуулахыг зорив.

**Зөвлөмж:** Манай улсын эдийн засгийн өсөлт, инфляци, валютын ханш болон татварын орлогын гадаад зах зээлээс хамааралтай байдал өндөр байгааг эмпирик судалгаагаар харуулав. Үүнд эдийн засгийн өсөлтийн 60 орчим хувийг гадаад шокууд бүрдүүлж байгаа бөгөөд бид гадаад шокын нөлөө дотоод эдийн засагт орж ирэхэд үлдсэн 40 хувийн дотоод арга хэрэгслээр оновчтой бодлого явуулж эдийн засгийг тогтворжуулах, гадаад шокыг шингээх арга хэмжээ авах, төсвийн бодлогын түүхий эдийн зах зээлийн мөчлөг дагасан байдлыг бууруулж, мөчлөг сөрсөн бодлого баримтлах нь манай улсын эдийн засгийг тогтвортой байлгах үндэслэл болно гэж үзэж байна.

**Ашигласан материал**

Anne,L., Arnaldur,. (2019) “The Effects of Fiscal Policy in Norway – A SVAR approach”, Finansdepartementet, Arbeidsnotat 2019/1.

Berkelmans, L., 2005. “Credit and monetary policy: An Australian SVAR”. Research Discussion Paper 2005-06, Reserve Bank of Australia.

Blanchard, O., Perotti, R. (2002). “An Empirical Characterization of the Dynamic Effects of Changes in Government Spending and Taxes on Output”. The Quarterly Journal of Economics, 117(4), 1329–1368.

Fernandez, A., Schmitt-Grohe, S., and Uribe, M. (2017). “World shocks, world prices, and business cycles: An empir-

ical investigation”, Journal of International Economics Volume 108, Supplement 1, May 2017, Pages S2-S14.

Fry-McKibbin, R., Souza, R., 2018. “Chinese resource demand or commodity price shocks: macroeconomic effects for an emerging market economy”. In: Crawford School of Public Policy. Australian National University. CAMA working paper, 45/2018.

Gan-Ochir, D. (2022). “Macroeconomic Effects of Covid-19 in a Commodity-Exporting Economy: Evidence from Mongolia, Emerging Markets Finance and Trade” Emerging Markets Finance and Trade, vol. 59, 2023.

Gan-Ochir,D., Davaajargal,L., and Elbegjargal,E. (2022). “Effects of global liquidity and commodity market shocks in a

commodity-exporting developing economy”, Journal of commodity markets 30 (2023) 100332.

Lawson, J., Rees, D., 2008. “A sectoral model of the Australian economy”. Research Discussion Paper 2008-01, Reserve Bank of Australia.

Mardi, D., Fry-McKibbin, R., Linehan, V., 2014. “Chinese resource demand and the natural resource supplier”. Appl. Econ. 46 (2), 167–178.

Markus, K., Jacopo, C., Sebastian, H., (2010). "Transmission of government spending shocks in the euro area: Time variation and driving forces". Working Paper Series 1219, European Central Bank.


Ratti, R.A., Vespignani, J., (2015). “Commodity prices and BRIC and G3 liquidity: a SFAVEC approach”. J. Bank. Finance 53, 18–33.

Souza, R., and Fry-McKibbin, R., (2021). “Global liquidity and commodity market interactions: Macroeconomic effects on a commodity exporting emerging market”, International Review of Economics and Finance, vol. 76, pp. 781-800.

Victor, P., Davaajargal, L., (2023). “External Commodity Shocks and the Insulating Role of Fiscal Policy on Real Output: Evidence from a Commodity-Exporting Economy”, Crawford School of Public Policy. Australian National University. CAMA working paper, 57/2023.


### 5.1 Загварын хариу үйлдлийн функц

**График 1.1. Түүхий эдийн эрэлтийн шок ( $u_{sc,t}$ )**




Тэмдэглэл: Тэмдэглэл: SVAR(1) загвар ( $j=1$ )

**График 1.2. Түүхий эдийн нийлүүлэлтийн шок ( $u_{pc,t}$ )**




Тэмдэглэл: Тэмдэглэл: SVAR(1) загвар ( $j=1$ )

**График 1.3. Цэвэр татварын шок ( $u_{t,p}$ )**



Тэмдэглэл: SVAR(1) загвар ( $j=1$ )

**График 1.4. Засгийн газрын хэрэглээний шок ( $u_{g,t}$ )**



Тэмдэглэл: SVAR(1) загвар ( $j=1$ )



# 02



## ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ, УРАМШУУЛЛЫН БОДЛОГО



### СУДЛААЧИЙН ҮГ



**Олонбаяр  
ЭРДЭМБАЯР**

СУДЛААЧ

"Шинэ сэргэлт,  
Инновацын  
хөтөлбөр"

Email: erdembayar@nrpa.gov.mn  
Утас: 70116838



**Өнөрсайхан  
БАЯСГАЛАН**

ТӨСЛИЙН МЕНЕЖЕР

"Шинэ сэргэлт,  
Инновацын  
хөтөлбөр"

Email: bayasgalan@nrpa.gov.mn  
Утас: 70116838

Энэхүү судалгааны ажлаар Монгол Улсын татварын орчин, хэрэгжиж буй хөнгөлөлт, урамшууллын бодлогыг олон улстай харьцуулан дүн шинжилгээ хийлээ. Судалгааны үр дүнгээс харахад манай улсын татварын хувь хэмжээ болон татварын ачаалал олон улстай харьцуулахад дундаж түвшнээс бага байна. Мөн хэрэгжиж буй хөнгөлөлт, урамшууллын бодлого нь эдийн засгийн ач холбогдол бүхий салбаруудад бага дэмжлэг үзүүлж байгаа бөгөөд уул уурхай дагнасан, худалдааны салбарт давамгайлж байна. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт татварын хууль тогтоомжийг шинэчилж, боловсронгуй болгох талаар тусгасан. Үүний хүрээнд манай улсын татварын хөнгөлөлт, урамшууллын бодлогыг хөгжиж байгаа улсуудын жишигт нийцүүлэн эдийн засгийн тусгай бүсүүд, тэргүүлэх салбарууд болон төсөлд суурилсан арга хэлбэрээр хөгжүүлэх талаар санал зөвлөмж боловсруулав.


# 1. ТАТВАРЫН ОРЧНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ

## 1.1. Монгол Улсын татварын орчин

Монгол Улсад 1990 оноос шинэ үеийн татварын тогтолцооны суурь тавигдсан бөгөөд нийт 3 удаа татварын шинэчлэл хийгджээ. Эхний үе шат нь 1990 оны эхээр “Шинэ үеийн татварын тогтолцооны суурь үе” (онцгой албан татвар, НӨАТ анх нэвтрүүлсэн)-ийг хамарна. Хоёр дахь үе шат нь “Дөрвөн 10-ын татварын шинэчлэл” (ОАТ, НДШ, НӨАТ) бөгөөд уул уурхайн

салбарын эдийн засагт гүйцэтгэх үүрэг томорч 4 голлох татварыг 10 хувь болгож өөрчилсөн үе билээ. Сүүлийн татварын шинэчлэл нь 2019 оны “Татварын багц шинэчлэл” (ААНОАТ, ХХОАТ, НӨАТ) юм. Эдгээр үеүдэд нийгэм эдийн засгийн бодлогыг татварын шинэчлэлтэй хослуулан авч хэрэгжүүлсэн нь нийгэм, эдийн засгийн өсөлтөд тодорхой хэмжээнд нөлөөлсөөр ирсэн байна (график 1.1.1).

График 1.1.1. Татварын бодлого



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Монгол Улсын “Татварын тухай хууль”-д татварыг зөвхөн Улсын Их Хурал татварын хуулиар бий болгох, тогтоох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй гэж заасан байдаг.

### Монгол Улсад татвар гэж:

- Хууль тогтоомжийн дагуу аливаа этгээдийн орлого, хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээнд тодорхой хугацаанд тогтоосон хувь, хэмжээгээр ногдуулж, хариу төлбөргүйгээр төсөвт төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгийг хэлнэ гэж заасан байдаг бөгөөд нийт 13 татварын нэр төрөл байдаг байна.

### Төлбөр:

- Төрийн өмчийн газар, газрын хэвлий, байгалийн баялаг, ой, ургамал, рашаан, ашигт малтмал, газрын тосны нөөц, агаар, ус, хөрс ашигласны,

бохирдуулсны, ан амьтан агнасны төлөө аливаа этгээдээс авч төсөвт төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгө гэж заасан байдаг бөгөөд 14 төрлийн төлбөр байна.

### Хураамж:

- Төрийн байгууллагаас аливаа этгээдэд хууль тогтоомжийн дагуу үйлчилгээ үзүүлсний төлөө тэднээс тухай бүр авч төсөвт төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгө гэж заасан бөгөөд 3 төрлийн хураамж байдаг байна.

Монгол Улсад татварын хөнгөлөлт, чөлөөлөлт олон улстай харьцуулахад багагүй байдаг бөгөөд ХХОАТ тухай хуулийн 22, 23 дугаар зүйлд 11 хөнгөлөлт, 7 чөлөөлөлт байна. ААНОАТ тухай хуулийн 21, 22 дугаар зүйлд 21 хөнгөлөлт, 14 чөлөөлөлт байна. НӨАТ тухай хуулийн

13 дугаар зүйлд 29 бараа, 20 үйлчилгээ чөлөөлөгдсөн байдаг. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлд 25 бараа чөлөөлөгдсөн байдаг байна. Эдгээр хөнгөлөлт, чөлөөлөлт нь Дэлхийн улс орнуудын стандарт бараа, үйлчилгээ байхаас гадна

нэмэлтээр оруулсан бараа, үйлчилгээнүүд байна. Монгол Улсын төсвийн орлогоос Улсын төсөвт 5 татвар, 7 төлбөр, 1 хураамж байгаа. Аймаг, нийслэлийн төсөвт 4 татвар, 2 төлбөр, 1 хураамж мөн сум, дүүргийн төсөвт 5 татвар, 6 төлбөр, 4 хураамж байна (зураг 1.1.2).


**Зураг 1.1.2. Улсын төсөв**

	 <b>Улсын төсөв</b>	 <b>Аймаг, нийслэлийн төсөв</b>	 <b>Сум, дүүргийн төсөв</b>
 <b>Тоо хэмжээ</b>	<b>5 татвар, 7 төлбөр, 1 хураамж</b>	<b>4 татвар, 2 төлбөр, 1 хураамж</b>	<b>5 татвар, 6 төлбөр, 4 хураамж</b>
 <b>Татварын төрөл</b>	<ul style="list-style-type: none"> <li>✓ ААНОАТ-60%</li> <li>✓ НӨАТ</li> <li>✓ Онцгой албан татвар</li> <li>✓ Гаалийн албан татвар</li> <li>✓ Авто бензин, дизелийн түлшний албан татвар</li> <li>✓ Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр</li> <li>✓ Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр</li> <li>✓ Агаарын бохирдлын төлбөр</li> <li>✓ Ус бохирдуулсны төлбөр</li> <li>✓ Газрын тосны нөөц ашигласны төлбөр 70%</li> <li>✓ Газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр 70%</li> <li>✓ Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг ашигласны үр шимийн төлбөр</li> <li>✓ Улсын тэмдэгтийн хураамж</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ ААНОАТ-40%</li> <li>✓ Нийслэл хотын албан татвар</li> <li>✓ Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар</li> <li>✓ Өв залгамжлал, бэлэглэлийн албан татвар</li> <li>✓ Газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 20%</li> <li>✓ Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр</li> <li>✓ Улсын тэмдэгтийн хураамж</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ ХХОАТ</li> <li>✓ Галт зэвсгийн албан татвар</li> <li>✓ Малын тоо толгойн албан татвар</li> <li>✓ Үл хөдлөх хөрөнгийн албан татвар</li> <li>✓ Нохой, муурын албан татвар</li> <li>✓ Газрын төлбөр</li> <li>✓ Байгалийн ургамал ашигласны төлбөр</li> <li>✓ Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр</li> <li>✓ Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр</li> <li>✓ Хүн амын унд, ахуйн хэрэгцээний зориулалтаар ус, рашаан ашигласны төлбөр</li> <li>✓ Газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр</li> <li>✓ Улсын тэмдэгтийн хураамж</li> <li>✓ Хог хаягдлын үйлчилгээний хураамж</li> <li>✓ Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж</li> <li>✓ Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж</li> </ul>

Эх сурвалж: Төсвийн тухай хууль

Улс орны хэмжээнд татвар, төлбөр, хураамжаар Улсын төсвийн орлогыг бүрдүүлж нөгөө талдаа төсвийн зарцуулалт (хөрөнгө оруулалт) хийдэг. Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг харвал (график 1.1.3) 2007 онд тэнцвэржүүлсэн орлого 1.9 их наяд байсан бөгөөд 2020 онд 9.5 их наяд болж өссөн бөгөөд 2024 оны гүйцэтгэлээр 29.6 их наяд төгрөг болсон байна. Мөн 2020 оноос 2024 оны хооронд орлого 3.1 дахин өссөн бол нэрлэсэн ДНБ 2.1 дахин өссөн байна.


**График 1.1.3. Улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлого**



Эх сурвалж: ҮСХ

Татварын орлогын төрлөөр авч үзвэл орлогын албан татвар хамгийн өндөр өссөн бөгөөд 2017 оноос хойш 5.6 дахин, НДШ 3.6 дахин, НӨАТ 3.6 дахин, бусад татвар 6.8 дахин, онцгой албан татвар 2.1 дахин, гаалийн татвар 3.5 дахин тус бүр өссөн байна.


**График 1.1.4. Татварын орлогын төрөл**



Эх сурвалж: ҮСХ

Харин төсвийн нийт зарлага талд урсгал зардал 2017 онд 7 их наядаас 2024 онд 22.4 наяд болж 3.2 дахин өссөн бөгөөд урсгал зардал дотор татаас ба урсгал шилжүүлэг хамгийн их өссөн байна. Мөн хөрөнгийн зардал 5 дахин өссөн байгааг (график 1.1.5)-аас харж болно.


**График 1.1.5. Улсын төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн**



Эх сурвалж: ҮСХ

Харин ДНБ-д төсвийн тэнцвэржүүлсэн орлогын эзлэх хувь 2020 онд 25.3 хувь байсан бол 2024 онд 37 хувь болж өссөн. Мөн төсвийн нийт зарлагын эзлэх хувь 2020 онд 37.1 хувь байсан бол 2024 онд 38 хувь болж өссөн байна.

**График 1.1.6. ДНБ-д эзлэх төсвийн орлого ба зарлагын хувь**




Эх сурвалж: ҮСХ


Олон улсын “The Heritage” сангаас гаргадаг эдийн засгийн эрх чөлөөний индексийн татварын ачаалал үзүүлэлтээр Монгол Улс 2024 онд 84 гэж гарсан бөгөөд энэ нь дэлхийн дундаж түвшнээс бага зэрэг бага татварын дарамттай улс гэж гарсан байна. Энэхүү

индекс тооцдог татварын дарамтыг хамгийн өндөр ААНОАТ хувь болон татварын нийт орлогын ДНБ эзлэх хувь гэсэн голлох 2 үзүүлэлтээр хэмжиж гаргадаг байна (график 1.1.7).

**График 1.1.7. Татварын дарамт**




Эх сурвалж: Index of economic freedom, 2024



Олон улсын татварын дундаж хувь хэмжээ НДШ / байгууллага/ 15.3 хувь, НДШ /хувь хүн/ 9 хувь, ААНОАТ 22.7 хувь, ХХОАТ 28.9 хувь байна. Доорх (график 1.1.8)-оос харвал Монгол Улсын татварын хувь хэмжээ дундаж байгааг харж болно. Мөн НӨАТ-ын хувьд “Global VAT compliance”-аас гаргасан хувь хэмжээнээс тооцож үзвэл 149 орноос 106 орон

НӨАТ-ын хувь, хэмжээг тодорхой хувиар тогтоож өгсөн бөгөөд дундаж нь 17% (16.95) байна. Бусад улс орнууд бараа бүтээгдэхүүний онцлогт тохируулан хувь хэмжээг ялгаатай байдлаар тогтоосон байна. Энэ нь Монгол Улсын НӨАТ хувь хэмжээний хувьд дэлхийн дунджаас бага байгааг харуулж байна (график 1.1.8).


График 1.1.8. Татварын дарамт



Олон улсын татварын дундаж хувь



НӨАТ-ЫН ХУВЬ ХЭМЖЭЭ, УЛСУУДААР



Эх сурвалж: Index of economic freedom, 2024

## 1.2 Нэмэгдсэн өртгийн албан татвар

Ихэнх улс орнууд нэмэгдсэн өртгийн албан татварыг (НӨАТ) шууд бус татварын хэлбэрээр ашигладаг бөгөөд бараа, үйлчилгээгээр дамжуулан хэрэглэгчид төлдөг. Энэхүү татварыг анх улсын төсвийн орлого бүрдүүлэх, бүртгэлжүүлэх зорилгоор нэвтрүүлж эхэлсэн байдаг бөгөөд бүх нийтээр тэгш үйлчлэх зарчимд суурилдаг. Ихэнх улс орнуудын түгээмэл ашиглагддаг хэлбэр нь "босго" бөгөөд босгоос доош орлогод сайн дурын үндсэн дээр бүртгүүлэх, дээш орлоготой ААН заавал бүртгүүлэх байдлаар оролцдог. НӨАТ-ын орлого нь борлуулалтын орлого өндөр ААН-үүдээс бүрддэг тул НӨАТ-ын босго гэсэн санаа гарч ирсэн байна. Үүнээс үүдэж оновчтой босгын хэмжээг тогтоох нь дараах 3 хүчин зүйлээс хамаарна (TARC, 2019).

- Дагаж мөрдөх зардал (compliance cost)
- Татварын суурь (tax base),
- ААН-үүдийн хариу үйлдэл (bunching)

Дээрх гурван хүчин зүйлд дагаж мөрдөх зардалд тухайн татварын хууль, дүрэм журам, бүртгэл үүсгэж татвар төлөх гэх мэт зохицуулалтын зардал үүсдэг. Мөн босгыг

өндөр болгосноор татварын бааз суурь буурч, эсрэгээр бууруулснаар татварын бааз суурь өснө гэж үздэг. Босгыг хэт өндөр тогтоовол доогуур орлоготой ААН-үүд орлогын өсөлтөө хязгаарлах зан үйл гаргах, эсвэл задалж (bunching) босго орлогын доогуур орох хандлагатай болдог байна. Тиймээс дээрх гурван хүчин зүйлийг харгалзан оновчтой хэмжээг тогтоох нь зүйтэй байна.

Монгол Улсад НӨАТ-ын тухай хуулийн 5.2-т босго нь борлуулалтын орлогын хэмжээ 50 сая ба түүнээс дээш төгрөгт хүрч, албан татвар ногдуулан суутган авч, төсөвт төвлөрүүлэх үүрэг бүхий этгээд албан татвар суутган төлөгч байна гэж заасан байдаг. Мөн НӨАТ-ын босго улс орнуудад ихэвчлэн өндөр байдаг байна (TARC, 2019). Жишээ нь (хүснэгт 1.2.1) Австрали Улсын НӨАТ-ын хувь 10, нийт төсвийн орлогын 13 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд босго нь 70,000 AUD буюу 44,282 доллар байна. Казакстан Улсын НӨАТ-ын хувь 12, нийт төсвийн орлогын 21 хувь, босго нь 61,269,000 KZT буюу 122,318 доллар байна. Манай улсын НӨАТ-ын хувь 10 хувь, төсвийн орлогын 20 хувь, босго нь 50 сая төгрөг буюу 14,493 доллар байна. Энэ нь бусад улстай харьцуулахад доогуур байгааг харуулж байна. Харин

Узбекистан Улсын НӨАТ-ын хувь 12, төсвийн орлогод эзлэх хувь 20 байгаа бол босго орлогыг тогтоож өгөөгүй байдаг. Энэ нь бараа бүтээгдэхүүн борлуулах, худалдахад босго харгалзахгүй бүгд НӨАТ-ын системд бүртгүүлж татвар төлөх ёстой болно. Гэхдээ татварын урамшуулал/буцаалт (бүртгүүлж татвараа төлсний урамшуулал) нь зорилтот бүлгээс хамаарч өөр өөрөөр тогтоодог. Жишээ нь гадаадын жуулчин бол төлсөн татварынхаа 90 хувийг буцааж авах боломжтой байна. Үүнээс харвал улс орон болгон НӨАТ-ын суурь систем дээр өөрийн бодлого болон онцлогоос хамаарч зохицуулалтын өөрчлөлтүүдийг ашиглаж татварын системийг хэрэгжүүлж байна.

### Хүснэгт 1.2.1. НӨАТ-ын босго, улсуудаар

Улс	Төсвийн орлогод эзлэх хувь	Хувь	Босго	Доллар
Австрали	13%	10%	70,000 AUD	44,282
Шинэ-Зелланд	30%	15%	60,000 NZD	34,446
Их Британи	21%	20%	85,000 GBP	110,015
Казакстан	21%	12%	61,260,000 KZT	122,318
Монгол	20%	10%	50,000,000 MNT	14,493
Узбекистан	20%	12%	Байхгүй	

Эх сурвалж: TARC, Revenue Statistics in Asia and the Pacific

## 2. ЭДИЙН ЗАСГИЙН ТУСГАЙ БҮС

### 2.1 Чөлөөт бүс

Монгол Улсын Их Хурал “Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тухай үзэл баримтлал”<sup>1</sup>-ыг 1995 онд баталж чөлөөт бүс байгуулах үндэслэл, онцлог зарчим, утгвар нөхцөл, баримтлах шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон. 2002 онд анхны “Чөлөөт бүсийн тухайн хууль”-ийг баталсан бөгөөд Алтанбулаг, Цагааннуур, Замын-Үүд чөлөөт бүсүүдийг байгуулж, тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн боловч сонгодог утгаар хөгжүүлж чадаагүй байна.

Олон улсад эдийн засгийн тусгай бүс (Special Economic Zone)<sup>2</sup> гэх нэршилтэй энэ бүсүүдэд бизнесийн болон худалдааны хууль тогтоомж нь улсын бусад хэсгээс ялгаатай үйлчилдэг. Эдийн засгийн тусгай бүсүүд нь дараах онцлогтой. Үүнд:

- Газар зүйн хувьд хязгаарлагдмал.
- Олон компаниуд үйл ажиллагаа явуулдаг.
- Бүсийн тусгай удирдлага, захиргаатай.
- Засгийн газрын бодлогоор дэмжиж буй тусгай зохицуулалтын дэглэмтэй.
- Гаалийн хялбаршуулсан журам, татварын хөнгөлөлттэй.

Эдийн засгийн тусгай бүсүүдийг стратегийн зорилт, үйл ажиллагаанаас нь шалтгаалан олон төрлөөр байгуулдаг бөгөөд гол зорилго нь гадаадын хөрөнгө оруулалтыг татах, экспортыг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжихийн зэрэгцээ шинэ ажлын байруудыг олноор бий болгох юм. Товчхондоо газар нутгийн байршлыг оновчтой тодорхойлж, хүн ам, ажиллах хүч, зах зээлийн судалгааг нарийвчлан хийсний үндсэн дээр хөрөнгө оруулагчдад таатай бөгөөд тогтвортой нөхцөлийг санал болгож, бизнес эрхлэхэд ээлтэй орчныг бүрдүүлснээр энэхүү зорилгодоо хүрч чаддаг.

Зарим төрлийн эдийн засгийн тусгай бүсүүдийг дурдвал:

- **Худалдааны чөлөөт бүс** Free Trade zones (FTZ) – Барааг гаалийн горимд оруулахгүйгээр импортлох, хадгалах, экспортлох боломжтой бүс нутаг
- **Экспортын боловсруулалтын бүс** Export Processing Zones (EPZ) - Экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд чиглэсэн бүсүүд нь ихэвчлэн татварын хөнгөлөлт, гаалийн хялбаршуулсан журмыг дагадаг.
- **Эдийн засгийн чөлөөт бүс** Free economic zone (FEZ) Гадаадын хөрөнгө оруулалтыг татах, эдийн засгийн идэвхжилийг нэмэгдүүлэхэд чиглэсэн эдийн засгийн тусгай зохицуулалт бүхий өргөн бүс нутаг
- **Аж үйлдвэрийн парк, эдлэн газар** Industrial Parks/Estates (IE) - Үйлдвэрлэлийн болон бусад аж үйлдвэрийн үйл ажиллагааг дэд бүтэц, байгууламжаар хангасан аж үйлдвэрийг хөгжүүлэх зориулалттай бүсүүд
- **Чөлөөт боомт** Free Ports – Гаалийн оролцоогүйгээр барааг буулгах, хадгалах, буцаан экспортлох боломжтой портууд
- **Гаалийн баталгаат боомтууд** Bonded Logistics Parks (BLP) - Транзит бараанд гаалийн хөнгөлөлт үзүүлдэг логистик, агуулахын зориулалттай газар нутаг
- **Хотын аж ахуйн нэгжийн бүс** Urban Enterprise Zone - Татварын хөнгөлөлт болон бусад хөнгөлөлт үзүүлэх замаар эдийн засгийн хүндрэлтэй бүс нутгийг сэргээхэд чиглэсэн хот суурин газрын бүсүүд юм.

Эдийн засгийн тусгай бүсийн дээрх олон төрөлтэй харьцуулан үзэхэд манай улсын чөлөөт бүсүүд нь худалдааны чөлөөт бүсийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд бид эдийн засгийн тусгай бүс гэх ойлголтыг олон улсын түвшинд нь авч үзэх зайлшгүй шаардлага гарч байна.

<sup>1</sup> Монгол Улсын Их Хурлын 1995 оны 87 дугаар тогтоол

<sup>2</sup> documents1.worldbank.org/curated/en/316931512640011812/pdf/P154708-12-07-2017-1512640006382.pdf


## 2.2 Эдийн засгийн тусгай бүсүүд – Олон улсын туршлага

### Казахстан улс

Казахстан Улс эдийн засгаа газрын тос, хий, металл зэрэг байгалийн баялгийн хамаарлаас багасган илүү төрөлжүүлэх стратегийн нэг хэсэг болгон эдийн засгийн тусгай

бүсүүдийг идэвхтэй хөгжүүлж байна. 2025 оны байдлаар тус улсад хөрөнгө оруулалт татах, аж үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох зорилгоор 14 тусгай бүс ажиллаж байна.

Зураг 2.2.1. Казахстан улсын эдийн засгийн тусгай бүсүүд



Эх сурвалж: Kazakh Invest National Company

Казахстан Улсын Аж үйлдвэр, барилгын сайд Канат Шарлапаевын дурдсан мэдээлэлд (2024 оны 5 дугаар сард) тухайн бүсүүдийг байгуулснаар нийт 16,9 тэрбум ам.долларын 354 төсөл хөтөлбөр хэрэгжиж байгаа бөгөөд 25,500 гаруй хүнийг ажлын байраар хангажээ. Үүний дээр 6.5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтыг татаж, улсын төсөвт 984.3 сая ам.долларын татварын орлогыг бүрдүүлсэн байна. Мөн 2001 оноос хойш үйлдвэрлэлийн хэмжээ 18.9 тэрбум ам.долларт хүрч 1.3 тэрбум ам.долларын бүтээгдэхүүнийг экспортолсон байна.<sup>3</sup>

Казахстан Улс эдийн засгийн тусгай бүсүүдийг байгуулахдаа зорилго, зорилтыг нарийн тодорхойлж тусгайлсан бодлогоор дэмжих хугацааг зарлаж өгснөөр тогтвортой байдлыг хангаж гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлж чадсан байна.

Хүснэгт 2.2.2. Казахстан Улсын эдийн засгийн тусгай бүсүүдийн зорилго, үйл ажиллагаа

Нэр	Зорилго	Эхэлсэн он	Дуусах он
Астана – Шинэ хот	Өндөр технологийн үйлдвэрүүд болон орчин үеийн дэд бүтцийн хөгжлийг дэмжих	2001.06.29	2027
Астана – Технополис	Инновацийн хөгжил, өндөр технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх	2017.11.24	2042
Хоргос – Зүүн хаалга	Хятад, Төв Ази, Ойрхи Дорнодыг холбосон ложистикийн гол зангилаа	2011.11.29	2035
Хоргос ОУ-ын хамтын ажиллагаа	Казахстан, БНХАУ-ын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг дэмжинэ.	2017.10.06	2041
Павлодар	Металлурги, металл боловсруулалтад	2011.11.29	2036
Химийн парк Тараз	Дэвшилтэт технологи ашиглан химийн үйлдвэрлэлийн шинэ байгууламжуудыг хөгжүүлэх	2012.11.13	2037
Сарыарка	Өндөр технологийн үйлдвэрлэлд чиглэсэн "Металлурги-металл боловсруулах" аж үйлдвэрийн парк багтана.	2011.11.24	2036

Эх сурвалж: Kazakh Invest National Company

<sup>3</sup><https://astanatimes.com/2024/05/kazakhstan-prioritizes-development-of-special-economic-industrial-zones/>

Эдийн засгийн тусгай бүсийн татварын болон татварын бус дэмжлэгийг авахын тулд хуулийн этгээд нь дараах шаардлагыг хангасан байх ёстой.

Үүнд:

- Эдийн засгийн тусгай бүсийн нутаг дэвсгэр дэх татварын албанд бүртгүүлсэн байх.
- Тухайн бүсийн нутаг дэвсгэрийн хилээс гадуур салбар нэгжгүй байх.
- Онцгой нөхцөл: "Инновац технологийн парк"-д үйл ажиллагаа явуулагч нь нутаг дэвсгэрээс гадуур байршиж болно.
- Тухайн нутаг дэвсгэр дэх тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагааны шаардлага хангасан үйл ажиллагааг гүйцэтгэх ёстой.<sup>4</sup>

Эдийн засгийн тусгай бүсүүдэд үйлчилдэг нийтлэг татварын хөнгөлөлт, чөлөөлөлт нь:

- ААНОАТ: 100% хөнгөлнө (тодорхой нөхцөлөөр).
- НӨАТ: 0% (Эдийн засгийн тусгай бүсийн зорилгод нийцсэн үйл ажиллагааны явцад ашигласан бараа

бүтээгдэхүүн, эсвэл Засгийн газраас тогтоосон барааны жагсаалтад багтсан бараа бүтээгдэхүүний худалдан авалтад).

- Газрын албан татвар, газар ашигласны төлбөр: 0%.
- Үл хөдлөх хөрөнгийн татвар: 0%.
- Нийгмийн татвар: 100% хөнгөлнө ("Технологийн парк"-д зориулсан тусгай нөхцөлтэй).

Тухайн бүсийн хөнгөлөлттэй татвар ба хураамжийн нөхцөлд хамрагдах хугацаа нь мөн төслүүдийн ангилал, өртгөөс хамаарна.

- А ангилал - төслийн өртөг 3,000,000 MCI<sup>5</sup> хүртэл (6,7 сая USD): 7 жилийн хугацаатай.
- В ангилал - төслийн өртөг 3,000,000 MCI (6,7 сая USD) -аас 14,500,000 MCI (32,4 сая USD) хүртэл: 15 жилийн хугацаатай.
- С ангилал - төслийн өртөг 14,500,000 MCI-ээс дээш (32,4 сая USD): 25 жилийн хугацаатай хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдана.

## БНХАУ

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын эдийн засгийн тусгай бүсүүд 1970-аад оны сүүлчээс хойш тус улсын эдийн засгийн хурдацтай хөгжилд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн. Дэн Сяопины эдийн засгийн шинэчлэлийн бодлогын дагуу 1980 онд Шэньжэнь, Жухай, Шантоу (Гуандун муж), Шямэнь (Фужянь муж) зэрэг хотуудад анхны эдийн засгийн тусгай бүсүүдийг байгуулсан бөгөөд одоо хөгжиж буй орнуудын үлгэрлэн дуурайдаг загвар болоод байна. Хятад улс эдийн засгийн тусгай бүсүүдийг олон төрлөөр сонгодог загвараар хөгжүүлж чадсан бөгөөд газар нутгийн байршил, өрсөлдөх давуу тал, тэргүүлэх чиглэлийн бодлоготой уялдуулан хөгжүүлж, үйл ажиллагаа явуулдаг. Бүсүүдийн төрлийг дурдвал:

1. **Эдийн засгийн тусгай бүсүүд** - Special economic zones
2. **Эдийн засаг, технологийн хөгжлийн бүсүүд** - Economic and technological development zones
3. **Өндөр технологи үйлдвэрийн хөгжлийн бүсүүд** - High-tech industrial development zones
4. **Нисэх онгоцны буудал ба боомтын эдийн засгийн бүсүүд** - Airport and port economic zones
5. **Гаалийн хяналтын тусгай бүсүүд** - Special customs supervision zones
  - **Худалдааны чөлөөт бүс** - Free Trade Zones (FTZs)

- **Худалдааны тусгай бүс** - Bonded Zones
- **Худалдааны бүсийн логистик парк** - Bonded Logistical Parks
- **Гаалийн боомтын бүсүүд** - Bonded Port Zones
- **Экспортын боловсруулалтын бүсүүд** - Export Processing Zones (EPZs)
- **Хил дамнансан аж үйлдвэрийн паркууд** - Cross-Border Industrial Parks
- **Цогцолбор худалдааны тусгай бүсүүд** - Comprehensive Bonded Zones

Хамгийн анхны эдийн засгийн тусгай бүс болох Шэньжэнь бүс нь загас агнуурын жижиг тосгоноос хөл хөдөлгөөн ихтэй метрополис хот болон хөгжиж, технологи, санхүү, логистикийн дэлхийн төв болон өөрчлөгдсөн. Энэ бүс нь зах зээлийг хөгжүүлэхэд чиглэсэн шинэчлэлийн бодлогын туршилтын талбар болж чадсан бөгөөд нээлттэй хаалганы бодлогыг хэрэгжүүлж гадаадын хөрөнгө оруулалттай компаниудыг үйлдвэрлэл, судалгаа хөгжүүлэлтийн төв байгуулах нөхцөлөөр хангасан. 1980 онд 327.5 км.кв талбай бүхий энэхүү бүс нь 2010 онд 2020 км.кв талбайтай бүтэн хот болон хөгжжээ.

<sup>4</sup><https://taxsummaries.pwc.com/kazakhstan/>

<sup>5</sup> MCI - Monthly calculation index



**Зураг 2.2.3. Шэньжэнь эдийн засгийн тусгай бүсийн гучин жилийн өөрчлөлт**



Эх сурвалж: Shenzhen SEZ

Тухайн бүсийн хөгжил нийгэм, эдийн засагт асар их нөлөөг үзүүлж чадсан.

- **Эдийн засгийн хөгжил:** Шэньжэнь хотын ДНБ асар хурдацтай өсөж, Хятадын хамгийн баян хотуудын нэг болсон. Хотын нэг хүнд ногдох ДНБ 1979-2019 онд 33,000% гаруй хувиар өсжээ.
- **Технологи ба инновац:** Huawei, Tencent, DJI зэрэг томоохон технологийн компаниуд байрладаг. Тус хот нь инновац, өндөр технологийн үйлдвэрлэлээр алдартай бөгөөд судалгаа, хөгжүүлэлтэд ихээхэн хөрөнгө оруулалт хийдэг.
- **Санхүүгийн үйлчилгээ:** Шэньжэний хөрөнгийн бирж нь Хятадын санхүүгийн тэргүүлэх төв юм.
- **Логистик ба тээвэрлэлт:** Энэ хотод дэлхийн нийлүүлэлтийн сүлжээнд чухал үүрэг гүйцэтгэдэг дэлхийн хамгийн ачаалалтай чингэлэг боомтууд байрладаг.

Шэньжэнь дахь татварын хөнгөлөлтүүд нь өндөр технологи, судалгаа, хөгжүүлэлт, дэвшилтэт үйлдвэрлэлийн салбарт бизнес эрхлэгчдийг татах, дэмжих зорилготой бөгөөд өндөр технологийн аж ахуй нэгж, компанийн шалгуур үзүүлэлтийг нарийвчлан зааж өгдөг. Үүнд:

- **Байгуулагдсан огноо:** Хятад Улсад компаниар бүртгүүлээд нэг жилээс илүү хугацаанд үйл ажиллагаа явуулсан байх
- **Оюуны өмч:** Компани нь үндсэн бүтээгдэхүүн, үйлчилгээндээ гол туслах үүрэг гүйцэтгэдэг оюуны өмчийн эрхийг эзэмших ёстой.
- **Үндсэн технологи:** Компанийн үндсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний үндсэн технологи нь төрөөс дэмждэг өндөр технологийн салбарт багтах ёстой.
- **Шинжлэх ухаан, техникийн боловсон хүчин:** Компанийн нийт ажилчдын 10-аас доошгүй хувь нь судалгаа, хөгжүүлэлт (R&D) болон холбогдох технологийн шинэчлэлийн үйл ажиллагаанд оролцдог байх
- **Судалгаа, хөгжүүлэлтийн зардлууд:** Нийт судалгаа, хөгжүүлэлтийн зардлын борлуулалтын орлогод эзлэх хувь нь тодорхой босгыг хангасан байх ёстой. (3%-5%)
- **Өндөр технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээний орлого:** Компанийн нийт орлогын 60-аас доошгүй хувь нь өндөр технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээнээс бүрдэх ёстой.
- **Инновацийн чадвар:** Компани нь бие даасан инновацийн чадавхыг харуулах ёстой бөгөөд үүнийг холбогдох шалгуурын дагуу үнэлнэ.

- **Бусад дагах журам:** Компани нь гэрчилгээ олгохоос өмнөх нэг жилийн дотор аюулгүй байдлын томоохон осол, чанарын осол, байгаль орчны ноцтой зөрчилгүй байх ёстой.

Тухайн бүсэд үйл ажиллагаа эрхлэгч аж ахуй нэгжүүд дээрх шалгуурыг хангаснаар татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, татварын бус дэмжлэгийг эдэлдэг. Жишээ нь:

- **ААНОАТ :** Өндөр технологийн аж ахуйн нэгжүүд болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд (FIEs) нь 15%-ийн ААНОАТ төлдөг / стандарт татвар – 25%/
- **Татвараас чөлөөлөх:** Үйлдвэрлэл эрхэлж буй компаниуд болон өндөр технологийн аж ахуйн нэгжүүд 3-5 жилийн хугацаанд татвараас чөлөөлөгдөж болно.

Шэньжэнь хотод үйл ажиллагаа явуулж буй гадаадын банкууд мөн таван жилийн хугацаанд татвараас чөлөөлөгддөг.

- **(НӨАТ) болон тарифын чөлөөлөлт:** Эцсийн бүтээгдэхүүнд ашигласан импортын

материалыг НӨАТ болон тарифаас чөлөөлсөн нь үйлдвэрлэлийн өртгийг бууруулахад тусалдаг.

- **Судалгаа, хөгжүүлэлтийн урамшуулал:** Инновац, технологийн дэвшлийг дэмжих судалгаа, хөгжлийн зардалд нэмэлт татварын хөнгөлөлт үзүүлэх боломжтой.
- **Буцалтгүй тусламж, татаас:** Засгийн газар бизнес эрхлэгчид, ялангуяа инновац, өндөр технологийн үйлдвэрлэлд хамрагдсан бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор төрөл бүрийн буцалтгүй тусламж, татаас санал болгодог.

Хятад Улсад эдийн засгийн тусгай бүс 7, худалдааны чөлөөт бүс 21, Өндөр технологийн аж үйлдвэрийн хөгжлийн бүсүүд 168 болон бусад төрлийн тусгай дэглэмтэй жижиг бүсүүд тоо томшгүй олноор үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр бүсүүд байгуулагдсан цагаасаа хойш үйлдвэржилт, хөдөө аж ахуйн шинэчлэл, хотжилтыг хурдасган Хятадын ДНБ-ий 22%, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 45%, экспортын 60%-ыг бүрдүүлж 30 гаруй сая ажлын байр бий болгосон гэх тооцоолол хийгдэж байсан.<sup>6</sup>


## Узбекистан Улс

Узбекистан Улсын “URGUT” эдийн засгийн тусгай бүс (ЭЗТБ)-ийн үйлдвэрлэл, ажиллах хүч, экспорт, хөрөнгө оруулалт болон татварын орчин зэрэг чөлөөт бүсийг бий болгоход шаардагдах суурь нөхцөлүүдийг сүүлийн 5 жилийн хугацаанд эрчимтэй хөгжүүлж байна. Тус ЭЗТБ-ийг Узбекистан Улсын Ерөнхийлөгч 2016 оны 10 дугаар сард байгуулах санаачилгыг гаргаж 2017 оны 1 дүгээр сарын 12-нд байгуулсан байна.

### Ерөнхий мэдээлэл:

- Эдийн засгийн чөлөөт бүсийн нийт газар нутгийн хэмжээ 1902.5 га
- Нийт үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо “97”
- Жилийн 620 сая ам. долларын үйлдвэрлэл явуулдаг
- Жилийн 150 сая долларын экспорт хийдэг
- “URGUT” ЭЗЧБ 600,000 хүн ам, 12,617 ажлын байртай
- Хөрөнгө оруулалтын хэмжээнээс хамаарч татварын чөлөөлөлтөд хамрагдана

### Зураг 2.2.4. Узбекистан Улсын эдийн засгийн тусгай бүсүүд



Эх сурвалж: URGUT Free Economic Zone

### “URGUT” ЭЗЧБ-ийг байгуулсан үйл явцыг харуулбал:

- 2018 онд эхний 16 компани үйл ажиллагаагаа эхэлсэн.
- 2019 онд үйл ажиллагаа явуулж буй компанийн тоо 36 хүрч экспортын хэмжээ 30 сая ам. долларт хүрсэн.
- 2020 онд цар тахлын үед компаниуд хүнд нөхцөл

<sup>6</sup> <https://www.worldbank.org/content/dam/Worldbank/Event/Africa/Investing%20in%20Africa%20Forum/2015/investing-in-africa-forum-chinas-special-economic-zone.pdf>

байдалд орж 5 сарын хугацаанд үйл ажиллагаа тасалдсан.

- 2021 онд “URGUT” ЭЗЧБ-ийн захирлыг нэгэн зэрэг Самарканд мужийн захирагчийн аж үйлдвэрийн хөгжлийн асуудал хариуцсан орлогчоор томилсон.
- 2021 онд ЭЗЧБ-ийн үйл ажиллагаа өргөжиж бусад 12 хот болон Самарканд хотын бүсүүдэд салбар компани байгуулсан.
- 2022 онд үйл ажиллагаа явуулж буй төсөл, хөтөлбөр 161 хүрч, экспорт 120 сая ам. долларт хүрсэн.
- 2023.01 сард үйл ажиллагаа өргөжиж Кашкадарьяа бүс нутагт салбар компаниуд байгуулагдав.
- 2024 онд жилийн үйлдвэрлэлийн хэмжээ 620 сая ам. долларт хүрч, экспорт 150 сая ам. долларт хүрсэн байна.

Тус ЭЗЧБ-д үйл ажиллагаа явуулах төслийн сонгон шалгаруулалтыг бизнес эрхлэгчдэд хялбар, нээлттэй байх зарчмыг баримталж дараах байдлаар явуулж байна.

#### Төслийн сонгон шалгаруулалт

1. Бизнес төлөвлөгөө боловсруулах
2. “URGUT” ЭЗЧБ-ийн захиргааны зөвшөөрөл авах (10 хоногт)
3. Бүс нутгийн захиргаа газар эзэмшүүлэх үйл явцыг зохион байгуулах
4. E-AUKSION.UZ -т 30 хоногийн дотор сонгогдсон газар байрших
5. “URGUT” ЭЗЧБ-ийн захиргааны дүгнэлт (Хөрөнгө Оруулалтын хэлцэл, ЭЗЧБ оролцогч статус, газар хуваарилалт г.м) гарах.

Ийнхүү аливаа төсөл хөтөлбөр тус бүсэд үйл ажиллагаа явуулахад сар хүрэхгүй хугацаанд зөвшөөрлөө авч үйл ажиллагаагаа явуулахад бэлэн болж байна. Мөн тус бүсийн дэд бүтэц, хууль эрх

зүйн орчны зохицуулалтыг Засгийн газараас сайн зохицуулж өгч байгаа нь бизнес эрхлэгчид болон хөрөнгө оруулагчдыг татах нэг нөхцөл болж байна.

Мөн татварын орчны хувьд тус бүс нь гадаад болон дотоодын хөрөнгө оруулагчдад ээлтэй байдлаар хөнгөлөлт, чөлөөлөлтүүдийг олгодог бөгөөд гэрээ, хэлцлийг тухайн хөрөнгө оруулалтын хэмжээ, төрлөөс хамаарч уян хатан байхаар зохицуулалт хийдэг байна. Тус бүсэд дараах татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг мөрддөг байна.

#### Татварын орчин:

- 100 хувь дэд бүтэцтэй холбогдсон (ус, газ, цахилгаан г.м)
- Газрын татвар - 0%
- Ус ашиглах татвар - 0%
- Өмчийн татвар - 0%
- Тоног төхөөрөмж импортлоход гаалийн хураамж - 0%
- Орлогын татвар (3 сая доллароос дээш 3-10 жилийн хугацаатай) - 0%
- Түүхий эд импортын НӨАТ-ын төлөлтийг 120 өдөр хойшлуулдаг

Дээр дурдсанаар хөрөнгө оруулалтыг дэмжих, татварын ачааллыг бууруулах зохицуулалтыг бүрдүүлж өгсөн байна. Тухайн бүс нутаг нь үйл ажиллагаагаа явуулж эхлээд 8 жил болж байгаа бөгөөд энэ хугацаанд үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтын хэмжээ сүүлийн жилүүдэд хурдацтай өсөж байна. Мөн ажиллах хүчний 70 гаруй хувийг дотоодоос авч, 20 гаруй хувийг гаднаас авч ажиллуулдаг байна. Ингэснээр дотоодод ажлын байр бий болгож, үйлдвэрлэлийг нэмэгдүүлж гадагшаа экспорт хийх байдлаар тус улсын эдийн засгийг нэмэгдүүлж, хөнгөн, хүнд үйлдвэрлэлийг хурдтай төрөлжүүлэн хөгжүүлж байна.

## 3. МОНГОЛ УЛСАД ХЭРЭГЖИЖ БУЙ ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ, УРАМШУУЛЛЫН БОДЛОГО

### 3.1 Монгол Улсад одоо мөрдөгдөж буй татварын хөнгөлөлт, урамшууллын орчныг судлах нь

Энэ хэсэгт Монгол Улсад хэрэгжиж буй татварын хөнгөлөлт, урамшууллын орчны талаар дээрх

судлагдсан хэсэгт тулгуурлан шинжилгээ хийсэн бөгөөд олон улстай харьцуулж, дүгнэлт, санал зөвлөмжийг боловсруулав.

Татварын хууль тогтоомжийн хүрээнд ерөнхий болон нийтлэг хөнгөлөлт, урамшууллын хамрах

хүрээг тогтоодог бөгөөд энэ нь хууль ёсны бүх бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагч нарыг хамарч, ил тод, нээлттэй, шударга байх зарчимд тулгуурладаг. Эдгээр урамшуулал нь тодорхой салбар эсвэл бүс нутагт чиглэхээс илүү хүн амд өргөн хүрээнд үйлчлэх бөгөөд эдийн засгийн өсөлтийг дэмжиж, бизнесийн орчныг сайжруулж нийгмийн тэгш байдлыг хангах зорилготой.

Олон улсад нийтлэг ашигладаг тусгайлсан татварын хөнгөлөлт, урамшууллыг дараах 5 чиглэлд хувааж болно. Үүнд:

- Бүсчилсэн хөгжлийн урамшуулал
- Чөлөөт бүсийн урамшуулал
- Тэргүүлэх салбарын урамшуулал
- Үйлдвэр, технологийн паркийн урамшуулал
- Төслөөс хамаарсан урамшуулал

Бүсчилсэн хөгжлийн урамшуулал нь ерөнхий хуулиас гадна бусад бодлогын баримт бичигтэй уялдан бүс нутгийн хөгжлийг дэмжихэд чиглэнэ. Эдгээр урамшуулал нь зорилтот бүс нутагт хөрөнгө оруулалтыг татах, ажлын байрыг бий болгож дэд бүтцийг сайжруулах зорилготой. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд Монгол Улсыг Хангайн, Баруун, Хойд, Зүүн, Говийн, Улаанбаатарын бүс гэсэн бүсчлэлийн тогтолцоогоор хөгжүүлэх зорилтыг тавьсан<sup>1</sup>.

Бүсчилсэн хөгжлийн зорилтод тухайн бүс нутгийн онцлогт тохируулан чөлөөт бүсүүдийг хөгжүүлэх зорилтууд багтсан. Чөлөөт бүсийн урамшуулал нь тухайн бүсэд үйл ажиллагаа явуулж буй бүртгэлтэй, шаардлага хангасан ААН-д үйлчилнэ.

Олон улсад эдийн засгийн тусгай бүсүүдийг судалгаа шинжилгээнд үндэслэн, зөв төлөвлөж үйл ажиллагааг удирдаж чадсанаар эдийн засгийг өсөлтийг сайжруулж чаддаг гэж үздэг.

Үүнээс гадна улс орнууд өөрсдийн онцлог, харьцангуй давуу талд тохируулан гаргасан тэргүүлэх салбаруудыг баталж, эдийн засгийг авч явах гол салбаруудын өрсөлдөх чадварыг дэмжсэн татварын хөнгөлөлт, урамшууллын бодлогыг хэрэгжүүлдэг. Жишээ нь: Бахрейн Улс эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг эрэмбэлж, эдийн засгийг төрөлжүүлэх хөрөнгө оруулалтад ээлтэй шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлж өндөр хөгжилтэй улс болж хөгжиж чадсан байна. Тус улсын нэрлэсэн ДНБ 2003 онд 11 тэрбум ам.доллар байсан бол 2023 онд 46 тэрбум ам.доллар болж өсжээ. Засгийн газраас баталсан стратегийн тэргүүлэх салбарууд нь санхүүгийн үйлчилгээ, мэдээлэл, харилцаа холбоо, технологи, үйлдвэрлэл, логистик болон аялал жуулчлал байна.

Үүнтэй адил үйлдвэр, технологийг дэмжих тусгайлсан урамшуулал бий. Алсын хараа 2050, Шинэ сэргэлтийн бодлого зэрэг бодлогын баримт бичгүүдэд “нэмүү өртөг шингэсэн хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, дотоодын бүтээн байгуулалтын хэрэгцээг хангаж, экспортыг нэмэгдүүлэх” зорилтууд туссан бөгөөд тухайн зорилтод хүрэхийн тулд эрх зүйн орчныг бүрдүүлж, татварын дэмжлэг үзүүлэх шаардлагатай байдаг. Манай улсад 2022 онд Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийг баталсан бөгөөд зарим төрлийн татварын дэмжлэгийг тусгаж өгсөн.

Олон улсад хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны төрөл, төслөөс хамаарч төсөлд суурилсан урамшууллыг татварын болон татварын бус арга хэрэгслээр дамжуулан хэрэгжүүлдэг. Тиймээс бид манай улсад эдгээр 5 чиглэл болон ерөнхий хуульд туссан татварын болон татварын бус хөнгөлөлт, чөлөөлөлтийн төрлүүдийг нэгдсэн байдлаар судалж доорх байдлаар (хүснэгт 3.1.1) харуулав. Дараагийн дэд бүлгүүдэд Монгол Улсад хэрэгжиж буй эдийн засгийн тэргүүлэх салбар, чөлөөт бүс, үйлдвэрлэл технологийн парк болон төсөлд суурилсан татварын урамшууллын орчныг танилцуулав.

График 3.1.1. Монгол Улсад одоо мөрдөгдөж буй татварын хөнгөлөлт урамшууллын орчин

Хөнгөлөлт, урамшууллын орчин	Төрөл	Тонго төхөөрөмж импортлоход НӨАТ-ын хөнгөлөлт/0 хувь	Барилга байгууламж барихад НӨАТ-ын хөнгөлөлт	Гаалийн албан татвараас чөлөөлөх	ААНОАТ-ын хөнгөлөлт/0 хувь	Суутган татварын хөнгөлөлт	Тогтворжуулалтын гэрчилгээ	Элэгдэлтийн зардлыг түргэвчилсэн аргаар тооцох	Алдагдлыг хасаж тооцох	Газрын төлбөр (хуваарилалт)	Хөрөнгийн татвар	Хөрөнгө оруулалтын татварын хөнгөлөлт
		Ерөнхий/нийтлэг урамшуулал	✓	✓	✓	✓	✓	✗	✓	✓	✓	✗
Бүсчилсэн хөгжлийн урамшуулал	✓	✗	✓	✓	✓	✗	✗	✗	✗	✗	✗	✗
Чөлөөт бүсийн урамшуулал	✓	✓	✓	✓	✓	✓	✗	✗	✓	✓	✓	✓
Тэргүүлэх салбарын урамшуулал	✓	✗	✓	✓	✓	✗	✗	✗	✗	✓	✗	✗
Төслөөс хамаарсан урамшуулал	✓	✗	✓	✓	✓	✗	✗	✗	✗	✗	✗	✗
Үйлдвэр технологийн паркийн урамшуулал	✓	✓	✓	✓	✗	✗	✓	✗	✗	✓	✗	✗

Тайлбар: Байгаа ✓ Байгүй ✗

Тэмдэглэл: Тухайн хөнгөлөлт урамшуулал нь өгөгдсөн төрөлд байгаа эсэх.

<sup>1</sup> Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал



График 3.1.2. Монгол Улсад одоо мөрдөгдөж буй татварын хөнгөлөлт урамшууллын орчин (хуулийн заалт)

Төрөл	Татварын дэмжлэг										Татварын бус дэмжлэг				
	Тоног төхөөрөмж импортлоход НӨАТ-ын хөнгөлөлт/0 хувь/хойшлуулах	Барилга байгууламж барихад НӨАТ-ын хөнгөлөлт	Гаалийн албан татвараас чөлөөлөх	ААНОАТ-ын хөнгөлөлт/0 хувь	Сүүтгэн татварын хөнгөлөлт	Тогтворжуулалтын гэрчилгээ	Элэгдэллийн зардлыг түргэвчилсэн аргаар тооцох	Алдагдлыг хасаж тооцох	Газрын төлбөр	Хөрөнгийн татвар	ХО-ын татварын хөнгөлөлт	Наг цонхны үйлчилгээ	Визний нөхцөл	Гадаадаас авах ажиллах хүчний тоог нэмэх, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх	Батлан даалт
Ерөнхий/нийтлэг урамшуулал	ХОТХ 11.1.2 Гэрчилгээгээр тогворжуулж болно	ХОТХ 11.1.2 Гэрчилгээгээр тогворжуулж болно	ХОТХ 11.1.1 Гэрчилгээгээр тогворжуулж болно	ХОТХ 11.1.2 ААНОАТХ 22.5 дахь зүйлд салбар, хувь хэмжээ заасан.	-	ХОТХ 6.2	ХОТХ 11.1.3	ХОТХ 11.1.4	-	-	-	ХОТХ 9.2.9	ХОТХ 12.1.5	ХОТХ 12.1.3 (салбар заасан)	ХОТХ 12.1.4 (салбар)
Бүсчилсэн хөгжлийн урамшуулал	ГТТТХ 40.8	-	ГТТТХ 38.1.26 (ТТ, барилгын материал)	ААНОАТХ 22.5.22	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Чөлөөт бүсийн урамшуулал	ЧБТХ 16.1.1	ЧБТХ 16.5.2 (НӨАТ-аас бус УХЭХ-ийн татвараас чөлөөлнө) УХАТХ 7.1.5	ЧБТХ 16.1.1 (Чөлөөт бусад гадаас импортоор оруулсан бараа)	ААНОАТХ 22.5.7, 22.5.8 (салбар - хөрөнгө оруулалтын хэмжээ - 50% тэнцэх орлогыг)	ЧБТХ-н 16.1.7 ЧБ-д үйлдвэрлэсэн, борлуулсан БАУ, нд НӨАТ ногдохгүй	-	-	ААНОАТХ 19.10	ЧБТХ 23.1-23.3 (худалдаа, аялал, жуулчлал, зочид буудал, дэд бүтэц, тээвэр) ГТТХ 8.1.12	ЧБТХ 16.5.2 (УХЭХ-ийн татвараас чөлөөлнө)	ААНОАТХ 22.5.7-8	ЧБТХ-н 9.2	ЧБТХ-н 11.1 Хөрш - 30 хоног, бусад олон улсын гэрээний дагуу	-	-
Тэргүүлэх салбарын урамшуулал	ХОТХ 11.2.1,2,3 ГТТТХ 40.2,5,6	-	ГТТТХ 38.1.4,16,17,18, ГТТТХ 40.2	ААНОАТХ 22.5.4,10,12,13	-	-	-	-	ГТТХ 8.1.10-11	-	-	-	-	-	-
Төсөлд суурилсан урамшуулал	ГТТТХ 40.2, 40.8	-	ГТТТХ 40.2	ААНОАТХ 22.5.22 (төслийн жагсаалтыг УИХ батална)	-	-	-	-	-	-	-	-	-	ХОТХ 12.1.3	ХОТХ 12.1.4
Үйлдвэр технологийн паркийн урамшуулал	ХОТХ 11.2.2, ГТТТХ 40.4	УХАТХ 7.3	ГТТТХ 38.1.20 (үндсэн хөрөнгөд ашигласан ТТ, материал) ГТТТХ 40.4	-	-	ҮТПЭЗБТХ 19.1.9 (ХОТХ-д заасны дагуу)	-	-	ГТТХ 8.1.9 ГТТХ 8.1.3	УХХТХ 7.3	-	-	-	ҮТПЭЗБТХ 16.1.7	-

Тэмдэглэл: Тухайн хөнгөлөлт урамшуулал нь өгөгдсөн төрөлд байгаа эсэх.

Тэмдэглэл: ГТТТХ - Гаалийн тариф гаалийн татварын тухай хууль; ЧБТХ - Чөлөөт бүсийн тухай хууль; ҮТПЭЗБТХ - Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль; УХЭХТХ - Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль; ХОТХ - Хөрөнгө оруулалтын тухай хууль; ААНОАТХ - Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль; ГТТХ - Газрын төлбөрийн тухай хууль; НӨАТХ - Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль.

### 3.2 Эдийн засгийн тэргүүлэх салбарын татварын орчин

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 83 дугаар тогтоолоор байгаа 9 салбарыг заасан бөгөөд 32 дэд салбарыг багтааж байна. Эдгээр тэргүүлэх салбаруудад хөрөнгө оруулалтын хууль, газрын төлбөрийн хууль, аж ахуй нэгжийн орлогын албан татварын хууль зэрэг хуулиудад салбар дурдаж хөнгөлөлт, чөлөөлөлтийг олгож байна (хүснэгт 3.2). Эдгээр тэргүүлэх салбаруудыг хууль болгонд тусгайлан бичиж өгч байгаа нь нэгдсэн утгаар тэргүүлэх салбар гэж харахад төвөгтэй болж байгаа бөгөөд тэргүүлэх салбарыг шинэчлэн тодорхойлж, салбаруудын хөгжлийг тусгайлан бодлогоор дэмжих шаардлагатай гэж харагдаж байна.

### 3.3 Төсөлд суурилсан татварын орчин

Манай улсад төсөлд суурилсан хөрөнгө оруулалтын одоогийн орчинд Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40.2 болон 40.8, ААНОАТ тухай хуулийн 22.5.22, ХОТХ-н 12.1.3 болон 12.1.4-т төсөлд суурилсан татварын хөнгөлөлт, урамшууллыг заасан байдаг. ГТТТХ-д томоохон төсөл, арга хэмжээний бүтээн байгуулалтын ажилд зориулан импортоор

оруулж байгаа техник, тоног төхөөрөмж, түүний их бүрдлийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын төлөх хугацааг сунгах, эсхүл уг татварыг хэсэгчлэн төлүүлэх шийдвэрийг ЗГ гаргаж болно гэж заасан. Мөн ААНОАТ-ын тухай хуульд 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш хэрэгжүүлэх бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд заасан импортыг орлох, экспортыг дэмжих төслийн үндсэн үйл ажиллагааны орлогод ногдох албан татварыг орлого олж эхэлсний дараагийн тайлант хугацаанаас эхлэн 5 жилийн хугацаанд 90 хувиар хөнгөлнө гэж заасан. Мөн ХОТХ-д дэд бүтэц, үйлдвэрлэл, шинжлэх ухаан, боловсролын салбарын бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний тоо, хэмжээг нэмэгдүүлэх, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх, холбогдох зөвшөөрлийг хөнгөлөлттэй горимоор олгох болон инновацын төслийг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, экспортод чиглэсэн инновацын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн санхүүжилтэд батлан даалт гаргах гэж заасан байна. Эдгээрээс харахад манай улс төсөл хөтөлбөрт суурилсан татварын орчин голлох хуулиуд дээр тусгагдсан байна. Боловсронгуй болгох саналууд:

- Төсөлд суурилсан хөрөнгө оруулалтын гэрээний хэлэлцээрийг Засгийн газар ба хөрөнгө

График 3.2.1 Эдийн засгийн тэргүүлэх салбарын татварын орчин

Одоогийн нөхцөл байдал				
Засгийн газрын 2008 оны 83 дугаар тогтоолын хавсралт	Хөрөнгө оруулалтын тухай хууль	Газрын төлбөрийн тухай хууль	Гаалийн тариф, татварын тухай	Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль
Хөдөө аж ахуй	барилгын материал, газрын тос, хөдөө аж ахуйн боловсруулах болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэр барих	Алслагдсан суурин газар, орон нутаг өндөр технологийн үйлдвэрлэл явуулах	Цахилгаан эрчим хүчний 5 мегаваттаас дээш, эсхүл дулааны эрчим хүчний 1.5 мегаваттаас дээш хүчин чадалтай эх үүсвэр барих,	үр тариа, төмс, хүнсний ногоо
Аж үйлдвэр				сүү
Цахилгаан, хий үйлдвэрлэл, нийтийн аж ахуй, барилга				жимс, жимсгэнэ
Аялал, жуулчлал				тэжээл, тэжээлийн ургамал
Эрүүл мэнд, биеийн тамир	нано, био болон инновацийн технологи агуулсан бүтээгдэхүүний үйлдвэр барих болон соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор, парк, дэд бүтэц барих;	Чөлөөт бүсэд худалдаа, аялал жуулчлал, зочид буудлын үйлчилгээ	40.6.Ашигт малтмал баяжуулах, боловсруулах замаар нэмүү өртөг шингэсэн, ашигт малтмалын баяжмал, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх техник, тоног төхөөрөмж	эрчимжсэн тахианы аж ахуйд үйлдвэрлэсэн мах, махан бүтээгдэхүүн.
Боловсрол, шинжлэх ухаан				
Мэдээлэл, харилцаа холбоо				
Хөнгөн үйлдвэр				
Уул уурхай, олборлолт	эрчим хүчний үйлдвэр болон төмөр зам барих.			
Татварын орчин				
ААНОАТ-аас хөнгөлөх журам баталсан ч хүчингүй болсон	импортолсон техник, тоног төхөөрөмжийг барилга угсралтын ажлын хугацаанд гаалийн албан татвараас чөлөөлж, нэмэгдсэн өртгийн албан татварыг "0" хүртэлх хувь, хэмжээгээр ногдуулж болно	Газрыг эзэмшиж, ашигласны төлбөрөөс чөлөөлнө	Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын төлөх хугацааг 2/4 жил хүртэл хугацаагаар сунгах, эсхүл уг татварыг 2/4 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэх	Үйлдвэрлэсэн буюу тариалсан аж ахуйн нэгжийн зөвхөн тухайн бүтээгдэхүүнээс олсон орлогод ногдох албан татварыг 50 хувиар хөнгөлнө.

оруулагчийн хооронд хөрөнгө оруулалтын хэлцэл хийж нөхцөлүүдийг тохиролцоо боломжийг нээлттэй, ил тод байлгах шаардлагатай байна. Тухайн шаардлага хангасан хөрөнгө оруулагч тухайн асуудал хариуцсан захиргааны байгууллагад төслийн санал ирүүлж, холбогдох газар нь шаардлага хангасан эсэхийг хянаж, гэрээ хэлэлцээрийн нөхцөлүүдийг тогтворжуулалтын гэрээ, хөрөнгө оруулалтын гэрээ, тусгайлсан гэрээ зэргээр хэлэлцэж нөхцөлүүдийг баталж олгох ёстой юм. Төсөл, хөтөлбөрүүд нь шаардлага хангасан тохиолдолд тогтворжуулалтын гэрээ, хөрөнгө оруулалтын гэрээг заавал байгуулах хуулийн заалттай болох.

- Төсөлд суурилсан хөрөнгө оруулалтыг тогтворжуулалтын гэрээ байгуулах, хөрөнгө оруулалтын хэлэлцээ байгуулах тусгайлсан нөхцөлүүдийг илүү тодорхой болгох.
- Эдгээр гэрээ, хэлэлцээрүүдийг хуульд заасан журмаар байгуулсны дараа хуулийн хариуцлага ногдуулдаг өнгөрсөн жишгийг арилгах арга хэмжээ авах.

### 3.4 Үйлдвэрлэл, технологийн паркийн татварын орчин

Манай улсад үйлдвэрлэл, технологийн паркийн татварын хөнгөлөлт, урамшууллын орчинд ХОТХ,

ҮХЭХАТТХ, ҮТПЭБТХ болон ГТГТТХуульд тодорхой татварын хөнгөлөлт, урамшууллууд туссан байдаг. Үйлдвэрлэл, технологийн паркуудыг хөгжүүлж, нэмүү өртөг бий болгохын тулд үйл ажиллагаа явуулах давуу талыг эрх зүйн орчноор бий болгож, сайжруулах шаардлагатай. Одоо төрөөс үзүүлж буй татварын дэмжлэгийн хувьд гааль болон НОАТ-ыг 4 жилээр хойшлуулж, газрын төлбөрийг 10 жилээр чөлөөлөн, үл хөдлөх хөрөнгийн татварыг эхний 5 жилд 100%, дараагийн 5 жилд 50%-аар чөлөөлөх заалттай. Гэвч эргээр хөнгөлөлт, чөлөөлөлт нь хөрөнгө оруулалтыг татах хүч болж чадахгүй байна. Үүнтэй зэрэгцээд татварын бус дэмжлэгийг үзүүлж, илүү боловсронгуй болгох шаардлага үүсэж байна.

Үүнд:

- Эзэмших эрхийн хүрээнд ашиглалтын эрх олгох.
- Дэвшилтэт технологид таатай хөрөнгө оруулалтын орчин бүрдүүлэх.
- Программ хангамжийн хөгжүүлэлт, ШУТ (R&D) болон дизайнтай холбоотой үйл ажиллагаанаас олсон ашиг орлогыг ..... оны ..... сарын .... -ийг хүртэл орлогын болон аж ахуйн нэгжийн татвараас чөлөөлнө.
- Зөвхөн TDZ-д (Технологийн хөгжлийн бүс) үйлдвэрлэсэн программ хангамжийн борлуулалт .....оны.....сарын..... -ийг хүртэл



НӨАТ-аас чөлөөлөгдөнө. Үүнд системийн удирдлага, өгөгдлийн удирдлага, бизнесийн хэрэглээ, төрөл бүрийн салбар, интернэт, гар утас, цэргийн удирдлагын систем зэрэг программ хангамжууд хамаарна.

- ТХБ-д ажиллаж буй ШУТ-ийн салбарын ажилтнуудын цалингийн ОАТ-ыг ..... оны ..... сарын ..... -ийг шаталсан байдлаар хөнгөлөх, уян хатан бодлого баримтлах.
- ТХБ-д хэрэгжүүлсэн ШУТ төслүүдийн үр дүнд боловсруулсан технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хөрөнгө оруулалтыг ТХБ-д хийх

боломжтой бөгөөд энэ нь үйл ажиллагаа эрхлэгч компанийн зөвшөөрөл, Төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр хийгдэнэ.

- ШУТ, дизайн болон программ хангамжийн хөгжүүлэлтийн төслүүдийн хүрээнд импортолсон бүтээгдэхүүнд гаалийн татварын чөлөөлөлт, холбогдох баримт бичигт тэмдэгтийн хураамжийн чөлөөлөлт үйлчлэх зэрэг зохицуулалтуудыг нэмэгдүүлэх нь аж үйлдвэр, технологи хөгжүүлэлтийг хурдасгах, хөгжлийг дэмжих чухал хөшүүрэг болно гэж үзэж байна.

### 3.5 Эдийн засгийн чөлөөт бүс

Монгол Улсад анх 2002 онд “Чөлөөт бүсийн тухай хууль” батлагдаж, 2015 онд шинэчлэн найруулсан. Үүнээс хойш 2021, 2022 онуудад тухайн хуульд нэмэлт өөрчлөлт орсон бөгөөд одоогийн эрх зүйн орчинд холбогдох бусад тогтоол, журмууд үйлчилж байна.

Чөлөөт бүс гэдэг нь гаалийн татвар болон бусад татварын хувьд гаалийн нутаг дэвсгэрийн гадна оршиж байгаад тооцогдох, аж ахуйн үйл ажиллагааны тусгай дэглэм бүхий Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэсгийг хэлнэ.

**Зураг 3.5.1. Монгол Улсын чөлөөт бүсүүд**



Тэмдэглэл: Тухайн хөнгөлөлт урамшуулал нь өгөгдсөн төрөлд байгаа эсэх.

Чөлөөт бүс байгуулах зорилго нь тухайн бүсэд эрх зүй, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлснээр иргэн, аж ахуйн нэгжийн экспорт, импортыг дэмжих, экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, худалдаа, үйлчилгээний шинэ салбар, аялал жуулчлал, хөрөнгө оруулалтыг татах, транзит тээвэр, логистикийг нэмэгдүүлэх, тэргүүний техник, технологийг нутагшуулах, худалдааг хөнгөвчлөх, бүс нутгийн хөгжлийг хурдасгах замаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд оршино.<sup>3</sup>

Чөлөөт бүсийн үйл ажиллагаа, стратеги төлөвлөлт бүхий хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газар баталж, бүсийн хот байгуулалт, дэд бүтэц, барилга байгууламжийн харилцааг холбогдох хуулиар зохицуулдаг. Гэвч одоогийн байдлаар байнгын үйл ажиллагаанд шилжээд 10 гаруй жилийг үдсэн Алтанбулаг чөлөөт бүсийн хөгжлийн төлөвлөгөө

<sup>7</sup>Чөлөөт бүсийн тухай хууль 3.1.1

<sup>8</sup>Чөлөөт бүсийн тухай хууль 4.1

эцэслэгдэн батлагдаагүй байна. 2025 оны 01 дүгээр сарын 08-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар Цагааннуур чөлөөт бүсийг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн төлөвлөгөөг баталсан.

Чөлөөт бүсийн тухай хуульд хөрөнгө оруулалтыг татах, шинэ технологийг нэвтрүүлэх, экспортыг дэмжих, аялал жуулчлал, үйлчилгээг хөгжүүлэх

зорилгоор хэд хэдэн тусгай дэглэмүүдийг тусгасан бөгөөд бүсэд үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, иргэнийг гаалийн татвар болон бусад татвараас хөнгөлөх, чөлөөлөх, шалган нэвтрүүлэх, бүртгэх, гаалийн хяналт тавих, чөлөөт бүсэд зорчих, хөдөлмөр эрхлэхэд хөнгөлөлттэй нөхцөл үзүүлэх талаар заасан тусгай зохицуулалттай.

Зураг 3.5.2. Чөлөөт бүсийн тусгай дэглэмүүд



## ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТУХАЙ ХУУЛЬ:

- Гаалийн тусгай дэглэм 10-р зүйл
  - Визийн тусгай дэглэм 11-р зүйл
  - Хөдөлмөр эрхлэлтийн тусгай дэглэм 15-р зүйл
  - Татварын тусгай дэглэм 16-р зүйл
  - Газрын төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлт 23-р зүйл
- ААНОАТ тухай хууль:
- ААНОАТ-ын хөнгөлөлт 22-р зүйл

ААНОАТ-ын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу чөлөөт бүсэд дараах татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үйлчилнэ.

- Чөлөөт бүсэд зориулсан дэд бүтцэд 500.0\$ (мянга) буюу түүнээс дээш хэмжээний хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн чөлөөт бүсээс олсон орлогод оруулсан хөрөнгө оруулалтын 50 хувьтай тэнцэх хэмжээний орлогод ногдох албан татвараас хөнгөлнө.
- Чөлөөт бүсэд агуулах, ачиж буулгах байгууламж, зочид буудал, аялал жуулчлалын цогцолбор, импортыг орлох болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахад 300.0\$ (мянга) буюу түүнээс дээш хэмжээний хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн чөлөөт бүсээс олсон орлогод оруулсан хөрөнгө оруулалтын 50 хувьтай тэнцэх хэмжээний орлогод ногдох албан татвараас хөнгөлнө.

Чөлөөт бүсийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг Монгол Улсын татварын орчинтой харьцуулан гаргасан жишээг доорх хүснэгтээр харуулав.<sup>4</sup>

Хүснэгт 3.5.3. Алтанбулаг чөлөөт бүсийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт

Татварын төрөл	Монгол Улс	Алтанбулаг чөлөөт бүс
Импортын татвар	5%	0%
НӨАТ (Нэмэгдсэн өртгийн албан татвар)	10%	0%
ХХОАТ (Хувь хүний орлогын албан татвар)	2%-10%	0%
ААНОАТ (Аж ахуйн нэгжийн орлогын АТ)	1%-10%	0%
Үл хөдлөх эд хөрөнгийн АТ	0.6%-2%	0%

Хүснэгт 3.5.4. Чөлөөт бүсийн НӨАТ, Импорт, Экспортын татвар

Худалдааны үйлдэл	Татварын нөхцөл
Гадаад улсаас "Алтанбулаг" чөлөөт бүс рүү импорт хийх	Импортын татвар – 0%, НӨАТ – 0%, ОАТ – 0%
"Алтанбулаг" чөлөөт бүсээс гадаад орон руу экспорт хийх	Экспортын татвар – 0%, НӨАТ – 0%
"Алтанбулаг" чөлөөт бүсээс Монгол Улсын нутаг дэвсгэр рүү оруулах	Гаалийн татвар – 0%, НӨАТ – 0%
Зорчигчийн худалдаанд 3.0 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй бараа	Гаалийн татвар – 0%, НӨАТ – 0%
Монгол Улсаас "Алтанбулаг" чөлөөт бүс рүү импорт хийх	Импортын татвар – 0%, НӨАТ – 0%, Монголын бараа бүтээгдэхүүн – НӨАТ 0%

<sup>4</sup> <https://altanbulag.gov.mn/>



Чөлөөт бүсэд үйлчилж буй татварын хөнгөлөлт, чөлөөлөлт нь олон улсын жишгийн дагуу хэрэгжиж байгаа ч тухайн бүсийн хөгжил, эдийн засагт үзүүлж буй нөлөөг үнэлэхэд зөвхөн татварын бодлогоор дэмжих нь хангалтгүй байна.

#### Хүснэгт 3.5.5. Чөлөөт бүсүүдийн өнөөгийн байдал

Чөлөөт бүс	Хөрөнгө оруулалт	Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө	Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын гүйцэтгэл	Бүртгэлтэй ААН	Үйл ажиллагаа явуулж буй ААН
Алтанбулаг	34.5 тэрбум /Улсын төсөв/	463 сая /2023 он/ 6.44 тэрбум төгрөг төвлөрүүлсэн. /2008-2023 оны хооронд/	334.1 сая /2023 он/	129	31
Цагаан нуур	1.9 тэрбум /Улсын төсөв/	2023 оны 6 дугаар сарын 6-нд Цагааннуур чөлөөт бүсийн нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулсан.		67	3
Замын үүд	17.4 тэрбум /Улсын төсөв/ 94.5 сая доллар /Гадаад зээл, тусламж/ 8.3 тэрбум /ААН-ын ХО/	2024.03.19-ний өдөр Хятадын Төрийн зөвлөл Хятад-Монголын эдийн засгийн хамтын ажиллагааны бус байгуулахыг албан ёсоор зөвшөөрсөн. 2025 оны III улиралд багтаан Хамтын ажиллагааны бүсийн үйл ажиллагааг эхлүүлнэ.		81	9

Чөлөөт бүсүүдэд улсын төсөв болон гадаадын зээл тусламжаар хөрөнгө оруулалт хийж, дэд бүтцийг хөгжүүлэх ажлууд хийгдэж байгаа ч бүртгэлтэй болон үйл ажиллагаа эрхэлж буй ААН-ын тоог харьцуулахад бизнес эрхлэх таатай орчин бүрдээгүй байгаа нь тодорхой харагдаж байна.

Иймээс одоогийн эдийн засгийн чөлөөт бүсийн үр ашгийг хэмжих бодит хэмжүүрийг олон улсын жишгийн дагуу тодорхойлж, үйл ажиллагаа явуулж буй чөлөөт бүсүүдийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэн цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг системтэй төлөвлөж бодлогоор дэмжих шаардлагатай байна.

Эрх зүйн зохицуулалтын хувьд татварын болон татварын бус дэмжлэгийг тодорхой тусгаж өгсөн ч бүсийг дагасан хотжилт, дэд бүтэц, бүтээн байгуулалт, хүн ам болон ажиллах хүчний хомсдолоос үүдэн цаашид хөгжих нөхцөл хомс байна. Үүнээс үзэхэд чөлөөт бүсийг байгуулахдаа олон улсын жишгийн дагуу бүсийн техник эдийн засгийн үндэслэл, тогтвортой байдал, үндэсний хөгжлийн зорилтод нийцэж байгаа эсэхийг баталгаажуулсан судалгаа, үнэлгээг нарийвчлан хийж, оновчтой шийдвэр гаргах нь чухал байна.

Хүн ам, дэд бүтцийн нягтаршилтай нийслэл хот, дэд төвүүд болон бусад томоохон хот, аймгийн төвүүдэд тусгайлсан чиглэлийн чөлөөт бүсийг байгуулах талаар судалгааг нарийвчлан хийх шаардлагатай.

Олон улсад татварын хөнгөлөлт, урамшууллын бодлого нь улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийг тодорхойлох гол арга хэрэгсэл болдог. Улс орон болгон татварын ерөнхий хуультай бөгөөд түүнээс салаалан бүсчилсэн хөгжил, чөлөөт бүс, тэргүүлэх салбар, төсөл хөтөлбөр болон үйлдвэрлэл технологийн парк хэлбэрээр татварын хөнгөлөлт, урамшууллын бодлого хэрэгжүүлж байна.

Манай судалгаагаар эдийн засгийн чөлөөт бүсийн татварын хөнгөлөлт, урамшууллын орчин бусад төрлүүдтэй харьцуулахад харьцангуй боломжийн төрөлд орж байна. Харин анхаарах ёстой асуудал нь дэд бүтцийн хөрөнгө оруулалт бөгөөд, үйл ажиллагаа эрхлэх суурь дэд бүтэцгүйгээс болж одоо байгаа үндсэн 3 чөлөөт бүсэд ААН, хөрөнгө оруулагчдын сонирхлыг бууруулж байна. Мөн чөлөөт бүсэд хөрөнгө оруулалтын татварын хөнгөлөлтийг нэмж оруулан дараах байдлаар урамшуулах нь зүйтэй байна. Чөлөөт бүсэд оруулсан хөрөнгө оруулалтын тодорхой хувийг татвар ногдох орлогоос хасдаг хэмжээ болон хувийг нэмэгдүүлэх нь үр ашигтай. Санал болгож буй хувилбар:

- Чөлөөт бүсийн дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийсэн бол хөрөнгө оруулалт хийсэн дүнгийн 50 хувь байгааг нэмэгдүүлж 60-80 хувь болгох, (ААНОАТ тухай хуулийн 20.5.7-8). Төсөл, хөтөлбөрт оруулсан хөрөнгө оруулалтын үнийн дүнгийн 50 хувь байгааг 70 хувь болгож татвар ногдох орлогоос хасах.
- Чөлөөт бүсийн захиргаа, удирдлагын хэлбэрийг хууль эрх зүйн хүрээнд тодорхой болгож, олон улсын жишгийн дагуу бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж, тухайн бүсийн дүрэм журмын хэрэгжилтийг хангадаг нэг захиргааны (аймаг, сумын статус) байгууллагатай болгох.

## 4. Дүгнэлт

Олон улсад үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх, эдийн засгийн тогтвортой, тэгш өсөлтийг дэмжих, хөрөнгө оруулалт татах, ажлын байр нэмэгдүүлэх хүрээнд голлон ашигладаг нэг хэлбэр нь эдийн засгийн чөлөөт бүсүүдийн төрлүүдийг ашиглан хөгжүүлэх байдал онцлох ач холбогдолтой байна. Бид энэхүү судалгаагаар манай эдийн засгийн чөлөөт бүсүүдийн төрлүүдийг хөгжүүлэхэд тулгамдаж буй татвар болон татварын бус хөнгөлөлт, урамшууллын бодлогыг судалж доорх (хүснэгт 4.1) санал, зөвлөмжийг тусгав.

Манай улсын хувьд татварын хөнгөлөлт, урамшууллын бодлогын хэрэгжилтийг олон улстай харьцуулахад сул байгаа хэдий ч хөгжиж буй орны хувьд тодорхой чиглэлд татварын хөнгөлөлт, урамшууллын бодлогыг хуулийн заалт болгон оруулсан байдаг. Харин хуулийн дээрх заалт хэрхэн хэрэгжиж, үр дүнгээ өгч байгаа тал дээр анхаарах шаардлагатай байна. Тиймээс бид одоо байгаа дээр дурдсан татварын хөнгөлөлт, урамшууллын бодлогын хэрэгжилтийг бодитоор нэмэгдүүлэхийн тулд 3-р хэсэгт буй нэмэлт хөнгөлөлт, урамшууллын арга хэрэгслийг дурдсан.

**Хүснэгт 4.1** Боловсруулсан саналын үр дүнд дараах өөрчлөлтүүд гарна

Татварын орчин												
Төрөл	Тоног төхөөрөмж импортлоход НӨАТ-ын хөнгөлөлт/0 хувь	Барилга байгууламж барихад НӨАТ-ын хөнгөлөлт	Гаалийн албан татвараас чөлөөлөх	ААНОАТ-ын хөнгөлөлт/0 хувь	Суутган татварын хөнгөлөлт	Тогтворжуулалтын гэрчилгээ	Элэгдэлдлийн зардлыг түргэвчилсэн аргаар тооцох	Алдагдлыг хасаж тооцох	Газрын төлбөр (хуваарилалт)	Хөрөнгийн татвар	Хөрөнгө оруулалтын татварын хөнгөлөлт	Оноо
Ерөнхий/нийтлэг урамшуулал	✓	✓	✓	✓	✗	✓	✓	✓	✗	✗	✗	7 -> 7
Бүсчилсэн хөгжлийн урамшуулал	✓	✗	✓	✓	✗	✗	✗	✗	✗	✗	+	3 -> 4
Чөлөөт бүсийн урамшуулал	✓	✓	✓	✓	✓	✗	✗	✓	✓	✓	✓	9 -> 9
Тэргүүлэх салбарын урамшуулал	✓	+	✓	✓	✗	✗	+	✗	✓	✗	+	4 -> 7
Төслөөс хамаарсан урамшуулал	✓	+	✓	✓	✗	+	✗	✗	✗	✗	+	3 -> 5
Үйлдвэр технологийн паркийн урамшуулал	+	✓	✓	+	✗	✓	+	✗	✓	✗	+	4 -> 8

Тайлбар: Нэмэлтээр оруулж буй саналыг нэмэх тэмдэгээр оруулав.

**Хүснэгт 4.2** Монгол Улсад одоо мөрдөгдөж буй татварын хөнгөлөлт, урамшууллын орчинд нэмэлт санал оруулах хуулийн заалт

Төрөл	Татварын дэмжлэг										Татварын бүс дэмжлэг				
	Тоног төхөөрөмж импортлоход НӨАТ-ын хөнгөлөлт/0 хувь/хойшуулах	Барилга байгууламж барихад НӨАТ-ын хөнгөлөлт	Гаалийн албан татвараас чөлөөлөх	ААНОАТ-ын хөнгөлөлт/0 хувь	Суутган татварын хөнгөлөлт	Тогтворжуулалтын гэрчилгээ	Элэгдэлдлийн зардлыг түргэвчилсэн аргаар тооцох	Алдагдлыг хасаж тооцох	Газрын төлбөр	Хөрөнгийн татвар	ХО-ын татварын хөнгөлөлт	Нэг цонхны үйлчилгээ	Визийн нөхцөл	Гадаадаас авах ажиллах хүчний тоог нэмэх, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх	Батлан даалт
Ерөнхий/нийтлэг урамшуулал	ХОТХ 11.1.2 Гэрчилгээгээр тогворжуулж болно	ХОТХ 11.1.2 Гэрчилгээгээр тогворжуулж болно	ХОТХ 11.1.1 Гэрчилгээгээр тогворжуулж болно	ХОТХ 11.1.2 ААНОАТХ 22.5 дахь зүйлд салбар, хувь хэмжээ заасан.	-	ХОТХ 6.2	ХОТХ 11.1.3	ХОТХ 11.1.4	-	-	-	ХОТХ 9.2.9	ХОТХ 12.1.5	ХОТХ 12.1.3 (салбар заасан)	ХОТХ 12.1.4 (салбар)
Бүсчилсэн хөгжлийн урамшуулал	ГТТХ 40.8	-	ГТТХ 38.1.26 (ТТ, барилгын материал)	ААНОАТХ 22.5.22	-	-	-	-	-	6	-	-	-	-	-
Чөлөөт бүсийн урамшуулал	ЧБТХ 16.1.1	ЧБТХ 16.5.2 (НӨАТ-аас бүс УХЭХ-ийн татвараас чөлөөлнө) УХХАТХ 7.1.5	ЧБТХ 16.1.1 (Чөлөөт бүсэд гаднаас импортоор оруулсан бараа)	ААНОАТХ 22.5.7, 22.5.8 (салбар-хөрөнгө оруулалтын хэмжээ - 50% тэнцэх орлогыг)	ЧБТХ-н 16.1.7 ЧБ-д үйлдвэрлэсэн, борлуулсан БАУ-нд НӨАТ ногдохгүй	-	-	ААНОАТХ 19.10	ЧБТХ 23.1-23.3 (худалдаа, даяал жуулчлал, зочид буудал, дэд бүтэц, тээвэр) ГТТХ 8.1.12	ААНОАТХ 22.5.7-8	ЧБТХ-н 9.2	ЧБТХ-н 11.1 Хөрш - 30 хоног, бусад олон улсын гэрээний дагуу	-	-	
Тэргүүлэх салбарын урамшуулал	ХОТХ 11.2.1, 2, 3 ГТТХ 40.2, 5, 6	1	ГТТХ 38.1.4, 16, 17, 18, ГТТХ 40.2	ААНОАТХ 22.5.4, 10, 12, 13	-	-	4	-	ГТХ 8.1.10-11	7	-	-	-	-	
Төсөлд суурилсан урамшуулал	ГТТХ 40.2, 40.8	2	ГТТХ 40.2	ААНОАТХ 22.5.22 (төслийн жагсаалтыг УИХ батална)	-	ХОТХ-н 16.3.1	-	-	-	8	-	-	ХОТХ 12.1.3	ХОТХ 12.1.4	
Үйлдвэр технологийн паркийн урамшуулал	ХОТХ 11.2.2, ГТТХ 38.1.20, 40.4	УХХАТХ 7.3	ГТТХ 38.1.20 (үндсэн хөрөнгө, ашигласан ТТ, материал) ГТТХ 40.4	3	-	ҮТПЭЗБТХ 19.1.9 (ХОТХ-д заасны дагуу)	5	-	ГТХ 8.1.9 ГТХ 8.1.3	9	УХХТХ 7.3	-	-	ҮТПЭЗБТХ 16.1.7	-

Тэмдэглэл: ГТТХ - Гаалийн тариф гаалийн татварын тухай хууль; ЧБТХ - Чөлөөт бүсийн тухай хууль; ҮТПЭЗБТХ - Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль; УХХАТХ - Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль; ХОТХ - Хөрөнгө оруулалтын тухай хууль; ААНОАТХ - Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль; ГТХ - Газрын төлбөрийн тухай хууль; НӨАТХ - Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль.



Мөн одоо мөрдөгдөж буй татварын хөнгөлөлт, урамшууллын орчинд нэмэлт санал оруулах хуулийн заалтыг (хүснэгт 4.2)-т тусгав. Үүнд:

- 1 болон 2 дугаар заалт: ҮХЭХАТХ-ийн 7.3-т “Үйлдвэрлэл, технологийн паркийн нутаг дэвсгэр дэх” гэсний ард “ХОТХ-н 11.2-т заасан тэргүүлэх салбарт болон Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40.8-д заасан төсөл хөтөлбөрийн хүрээнд баригдсан” гэж нэмэх,
- 3 дугаар заалт: ААНОАТХ-ийн 22 дугаар зүйлд нэмэлтээр “22.5.23. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу паркт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг (эхний 2 жил 100 хувь, дараагийн 3 жил 50 хувь) чөлөөлнө” гэж нэмэх,
- 4 болон 5 дугаар заалт: ААНОАТХ-ийн 17 дугаар зүйлд нэмэлтээр “17.7. Үйлдвэрлэл технологийн паркийн нэгж болон тэргүүлэх салбарын хөрөнгө оруулагчийн үйл ажиллагааны үндсэн хөрөнгийн элэгдлийг стандарт элэгдлийн хэмжээнээс хоёр дахин өндөр хувь хэмжээгээр таван жилийн хугацаанд тооцох, эсвэл түргэвчилсэн аргаар тооцох

бөгөөд эдгээрээс татвар төлөгчид илүү ашигтай хувилбарыг сонгож хэрэглэх эрхтэй байна” гэж нэмэх,

- 6, 7, 8 болон 9 дүгээр заалт: ААНОАТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.5.7-д дэд бүтцэд гэсний дараа “болон бүсчилсэн хөгжил, тэргүүлэх салбар, төсөл хөтөлбөр, үйлдвэрлэл технологийн паркт” гэж нэмэх,
- Түүнчлэн “Энэ хуульд заасан аж ахуйн нэгжийн орлогын албан татварын болон хөрөнгө оруулалтын татварын хөнгөлөлтийн аль ашигтайг татвар төлөгч сонгож болно.” гэсэн агуулгыг нэмэлтээр тусгах.

Ингэснээр одоо мөрдөгдөж буй татварын хөнгөлөлт, урамшууллын орчин илүү хүртээмжтэй, хөрөнгө оруулагчид болон бизнес эрхлэгчдэд таатай байдлаар хэрэгжих боломжтой байна. Бидний санал болгож буй эдийн засгийн чөлөөт бүсүүд, тэргүүлэх салбарууд болон төсөлд суурилсан татварын хөнгөлөлт, урамшууллын төрлүүд нь зөвхөн нэг л суурь нөхцөл бөгөөд бусад хууль эрх зүй, дэд бүтэц, хүн амын суурьшилт зэрэг хүчин зүйлсийг давхар сайжруулах хэрэгтэй бөгөөд энэ талаар илүү нарийн судалгаа хийх шаардлагатай байна.

## Эх сурвалж

ADB (Asian Development Bank). 2015. “Asian Economic Integration Report 2015. How Can Special Economic Zones Catalyze Economic Development” Manila, The Philippines.

Astana Times. 2024. “Kazakhstan prioritizes development of special economic, industrial zones”. Astana.

China Development Bank. 2022. “The development experience of China’s special economic zones, and practice of free zones”.

IISD (International Institute For Sustainable Development). 2025. “The global minimum tax and special economic zones. Policy brief”. International Institute for Sustainable Development Publishing, Manitoba, Canada.

MIDA (Malaysian Investment Development Authority). 2023. “Special tax incentive (relocation). Manufacturing sector”.

Organization for Economic Co-operation and Development (OECD). 2024. “Revenue Statistics in Asia and the Pacific 2024: Tax Revenue Buoyancy in Asia”. OECD Publishing, Paris, <https://doi.org/10.1787/>

e4681bfa-en

PwC (Price Water House Coopers). 2025. “Kazakhstan tax services and publications”.

Schneider Group. 2024. “Tax incentives in Kazakhstan”.

South Carolina Department of Commerce. 2019. “Manufacturing incentives”.

TARC (Tax Administration Research Centre). 2019. “On VAT Thresholds. Modelling Tax Policy and Compliance Workshop Exeter”.

The Heritage Foundation. 2025. “Index of economic freedom”.

UNCTAD (United Nations Conference On Trade and Development). 2021. “Handbook on special economic zones in Africa. Towards economic diversification across the continent”.

World Bank Group. 2017. “Special economic zones. An operational review of their impacts”. Washington, DC: World Bank.

Бүсчилсэн Хөгжлийн Үндэсний Хүрээлэн. 2025. “Бүсчилсэн хөгжил. Монгол улсын хөгжлийн шинэ загвар”. Mongolian Economy Publishing, Ulaanbaatar.



03



## СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ДУУДЛАГА ХУДАЛДАА - АУКЦИОН

### СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭКСПОРТ



СУДЛААЧИЙН ҮГ



Оюунтуяагийн  
БАДРАЛ

АХЛАХ ШИНЖЭЭЧ

"Шинэ сэргэлт инновацийн  
хөтөлбөр"

Email: badral@nrpa.gov.mn

Утас: 70116838

Монгол Улсын эдийн засгийн тогтвортой хөгжил, иргэдийн амьдралын чанар, бизнесийн өрсөлдөх чадварын үндэс суурь нь найдвартай, тогтвортой эрчим хүчний хангамжаар баталгааждаг. Өнөөгийн байдлаар манай улсын эрчим хүчний салбар олон талын сорилт бэрхшээлтэй тулгарч байна. Эрчим хүчний хэрэглээ жил бүр өсөн нэмэгдэж, үйлдвэрлэлийн дотоодын хүчин чадал хязгаарлагдмал байгаагаас импортын хамаарал нэмэгдэж байна. Түүнчлэн системийн тогтвортой байдал, дэд бүтцийн хуучрал, шинэ хөрөнгө оруулалтын хэрэгцээ, технологийн хоцрогдол, эрчим хүчний үнэ тарифын бодлогын асуудлууд хурцаар тавигдаж байна.

Дэлхий нийтийн уур амьсгалын өөрчлөлтийн сорилт, сэргээгдэх эрчим хүчний хөгжлийн хандлага Монгол Улсад шинэ боломжийг авчирч байгаа ч энэхүү шилжилтийг бодлого, зохион байгуулалт, санхүүжилт, техник технологийн чадамжаар дэмжих зайлшгүй шаардлагатай. Сэргээгдэх эрчим хүчийг үр ашигтай, зохистой хэмжээнд нэмэгдүүлэх, эрчим хүчний хэмнэлт, үр ашигт суурилсан эдийн засгийг хөгжүүлэх нь ойрын ирээдүйн тэргүүлэх зорилтуудын нэг болж байна.

Эрчим хүчний салбарын өнөөгийн тулгамдсан асуудлыг амжилттай даван туулахын тулд цогц, шинжлэх ухаанч төлөвлөлт, бодлогын уян хатан зохицуулалт, төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг татах оновчтой орчныг бүрдүүлэх шаардлагатай байна. Түүнчлэн, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, системийн уян хатан, найдвартай байдлыг хангах нь урт хугацааны хөгжлийн үндэс суурийг бүрдүүлнэ.

Монголын эрчим хүчний салбарын тулгамдсан асуудлуудыг олон талаас нь хөндөж, боломжит гарц, бодлогын санал, технологийн дэвшилтэт шийдлүүдийг уншигч танд танилцуулахыг зорьж байна. Салбарын ирээдүйн хөгжилд хувь нэмрээ оруулахад мэргэжлийн хэлэлцүүлэг, судалгааны ажлууд улам өргөжиж, үр дүн нь бодлого, шийдвэр гаргалтад шууд тусгалаа олно гэдэгт итгэлтэй байна.

# СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТӨСӨЛ ШАЛГАРУУЛАЛТ

## 1. Нөхцөл байдал

Монгол Улсын “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр” зэрэг бодлогын баримт бичгүүдэд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хөгжүүлэх зорилтуудыг тусгасан. Мөн түүнчлэн Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилгод 2030 он гэхэд сэргээгдэх эрчим хүчийг ашигласнаар 2.97 сая тонн нүүрсхүчлийн хийг бууруулахаар тусгасан байдаг. Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэн хөгжүүлснээр дотоодын хэрэгцээг хангах, экспортын бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, эдийн засгийг солонгоруулах гэх мэт олон талын ач холбогдолтой. Манай улсад Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль анх 2007 онд батлагдсан. Хууль батлагдсан үеэс хойш хувийн хэвшлийн нарны нийт 90МВт суурилагдсан хүчин чадалтай 9 эх үүсвэр, салхины нийт 155 МВт суурилагдсан хүчин чадалтай 3 эх үүсвэр ашиглалтанд орсон.

Эрчим хүчний зохицуулах хороо /ЭХЗХ/-ны тайланд тусгагдсанаар 2024 оны байдлаар ДЦС, ДС барих нийт 15,659 МВт хүчин чадал бүхий 28 тусгай зөвшөөрөл, СЭХ-ний 1,111 МВт хүчин чадал бүхий 25 тусгай зөвшөөрөл байна. Шинэ эх үүсвэр барих зөвшөөрлийн хэмжээ 16,770 МВт-д хүрсэн хэдий ч бүтээн байгуулалтын ажлыг тогтоосон хугацаандаа гүйцэтгэж системд эрчим хүч нийлүүлж байгаа хэмжээ хангалтгүй байсаар байна.

Салхин цахилгаан станц				
№	Станцын нэр	Компани	Хүчин чадал	Тариф /ам.цент кВт.ц/
1	Салхит СЦС	Клин Энержи ХХК	50МВт	9.5
2	Цэцийн СЦС	Клин Энержи Ази ХХК	50МВт	9.4
3	Шанд СЦС	Сайншанд салхин парь ХХК	50МВт	9.5
Нарны цахилгаан станц				
1	Нар НЦС	Солар Пауэр интернэшнл ХХК	10 МВт	16.5
2	Моннаран НЦС	Эвридэй ферм ХХК	10 МВт	17.3
3	Гэгээн НЦС	Нарантээг ХХК	15 МВт	15.3
4	Сүмбэр НЦС	И Эс Би Солар Энержи ХХК	10 МВт	17.3
5	Бөхөг НЦС	Тэнүүн гэрэл констракшн ХХК	15 МВт	16.2
6	Говь НЦС	Дезерт Солар Пауэр Вуан ХХК	30 МВт	14.2

Эх сурвалж: www.parliament.mn

### Хүснэгт 1. ДЦС, шугам сүлжээ, дэд станц барих тусгай зөвшөөрөл 2024 он

№	Зориулалт	Тоо	Хүчин чадал (МВт)
1	Нэгдсэн сүлжээнд холбогдох	20	6,356
2	Экспортлох	2	9,240
3	Дулааны станц барих	2	63
4	Шугам, сүлжээ, дэд станц барих	4	-
<b>ДҮН</b>		28	15,659

### Хүснэгт 1. СЭХ-ний эх үүсвэр барих тусгай зөвшөөрөл

№	Төрөл	Тоо	Хүчин чадал (МВт)	Хуримтлуур
1	Нарны үүсгүүр	5	140	26/104
2	Салхины үүсгүүр	3	252	100.8/403.2
3	Ус, усан цэнэгт цахилгаан станц	8	413	
4	Био масс	3	61.4	
5	Эрчим хүч хуримтлуур	6	245	
<b>ДҮН</b>		25	1,111	245/712.8

Эх сурвалж: ЭХЗХ

2023 онд Монгол Улсын эрчим хүчний систем өвлийн оргил ачааллын үед 71 МВт-ын хүчин чадлын дутагдалд, 2024 онд 32 МВт-ын хүчин чадлын дутагдалд орж хязгаарлалт хийсэн байдаг. Эрчим хүчний хүчний хэрэглээ жилийн 6%-7% өсөлттэй байгаа нь шинэ эх үүсвэрүүдийг ашиглалтад оруулах хэрэгцээ шаардлага тулгарч байгааг харуулж байна.

Шинэ эх үүсвэрийг ашиглалтад оруулахдаа дэлхийн ихэнх улс орнууд эрчим хүчний эх үүсвэрийг аукционы буюу үнэ хаялцах дуудлага худалдааны зарчмаар сонгон шалгаруулж байна. Аукционы зарчмаар эх үүсвэрийг сонгон шалгаруулснаар дараах давуу тал болон эерэг үзүүлэлтүүд бий болдог.

## 1. Өрсөлдөөнт үнэ тогтох

Аукционоор дамжуулан хамгийн хямд үнийг санал болгосон төсөл сонгогддог тул эрчим хүчний системд нийлүүлэх үнэ буурч, эрчим хүч хэрэглэгчдэд хямд эрчим хүч хэрэглэх боломжийг бий болгодог. 2015-2024 оны хооронд нарны сэргээгдэх эрчим хүчний үйл ажиллагааны зардал нь 70%, салхин эх үүсвэрийн хувьд 40-50% хүртэл батарей хураагуурын үнэ 4-5 дахин буурсан байна.

## 2. Ил тод байдал ба зах зээлийн итгэлцэл

Аукционы процесс нь тодорхой дүрэм журмын дагуу хүний оролцооноос аль болох хамааралгүйгээр явагддаг тул хөрөнгө оруулагчид болон оролцогч байгууллагуудад шалгаруулалтын үр дүнд итгэх итгэлийг бий болгодог. Энэ нь эрчим хүчний салбарт хөрөнгө татах, төслийн хэрэгжилтийг хурдасгахад чухал ач холбогдолтой.

## 3. Оролцогч талуудыг нэмэгдүүлэх

Олон шат дамжлагыг дамжихгүй, ил тод нээлттэй байдал нь хувийн хэвшлийн оролцоог үлэмж ихээр нэмэгдүүлнэ. Энэ нь төрийн ачааллыг бууруулж, салбарт гадна болон дотоодын оролцоог бий болгоно.

## 4. Технологийн дэвшил, инновацыг дэмжих

Өрсөлдөөнт орчин нь салбарын тоног төхөөрөмж үйлдвэрлэгч, хөгжүүлэгч нарт шинэ технологи нэвтрүүлэхэд түлхэц болдог. Аукционд оролцогчид нь сүүлийн үеийн хямд өртөгтэй, өндөр бүтээмж бүхий технологийг илүү ихээр нэвтрүүлэн өрсөлдөнө.

Сэргээгдэх эрчим хүчний аукционыг хэрэгжүүлэх нь эрчим хүчний салбарт чухал түлхэц болох юм. Гэхдээ аукционыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд зохих хууль, дүрэм журам, эрх зүйн орчныг бүрдүүлэх, мөн техник технологи, дэд бүтцийг сайжруулах зэрэг олон талын бэлтгэл ажлууд шаардлагатай.

## 2. Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барих төсөл шалгаруулалтын журам

Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд 2019 онд өөрчлөлт орж СЭХ-ний шинэ эх үүсвэрийг төсөл шалгаруулалтын журмаар сонгон шалгаруулахаар болсон. 2020 оны Эрчим хүчний сайдын 100 дугаар тушаалаар "Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барих төсөл шалгаруулалтын журам" батлагдсан. Энэхүү журмын дагуу сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барих төслийг техникийн нөхцөл, эрчим хүч нийлүүлэх үнийн саналаар тус тус өрсөлдүүлэн сонгон шалгаруулахаар заасан. Сонгон шалгаруулалт нь дараах үе шаттай байна.

1. Төсөл шалгаруулалтын бэлтгэл үе шат;
2. Төсөл шалгаруулалтын ерөнхий нөхцөлийг зарлах үе шат;
3. Төсөл шалгаруулалтын урьдчилсан үнэлгээний үе шат;
4. Төслийг шалгаруулах үе шат;
5. Шалгарсан оролцогчтой хэлцэл хийж, гэрээ байгуулах үе шат.

Төсөл шалгаруулалтыг 9 хүний бүрэлдэхүүнтэй төсөл шалгаруулалтын хороог байгуулан зохион байгуулна. Тус хороо нь төслийг үнэлэх, шалгуур үзүүлэлтийг боловсруулах, төслийг шалгаруулах эрх үүрэгтэй байна. Сонгон шалгаруулалтын шат дамжлага болон төсөл

шалгарах хугацааг тооцон авч үзвэл сэргээгдэх эрчим хүчний нэг төсөл нь 2 шалгаруулалтын үе шаттайгаар нийт 70-110 хоног шаардагддаг байна.

Шалгаруулалтын үе шатууд	Шаардагдах хугацаа
Шалгаруулалтын урилга хүргүүлэх / зарлах	30 хоног
Шалгаруулалтын урьдчилсан үнэлгээ	20+20 хоног
Урьдчилсан үнэлгээний үр дүнг мэдэгдэх	5 хоног
Төслийг шалгаруулах	45+20 хоног
Шалгарсан төслийг оролцогчид мэдэгдэх	5 хоног

Төсөл шалгаруулалтын хороо урьдчилсан үнэлгээгээр өндөр хувь авсан эхний 10 хүртэл оролцогчийг эрэмбэлэн Эрчим хүчний яаманд хүргүүлэн дараагийн шатны шалгаруулалтад урина. Төслийг шалгаруулах үе шатанд төсөл шалгаруулалтын хороо төслийн техникийн болон санхүүгийн саналыг хүлээн авч техникийн саналыг эхэлж нээж үнэлнэ. Төслийн техникийн саналд 70 болон түүнээс дээш хувь авсан төслийн санхүүгийн саналыг нээж, үнэлгээ хийхээр заасан байдаг.

Оролцогчдын хувьд шалгаруулалтын 2 үе шатанд аль алинд нь дараах материалуудыг бүрдүүлэх шаардлагатай.

## I. Төслийн урьдчилсан үнэлгээний үе шатанд журамд зааснаар

**3.4.3.1.** төслийн нэр, суурилагдсан хүчин чадал, техник, технологийн шийдэл, төсөл хэрэгжүүлэх байршил, нэгдсэн сүлжээнд нийлүүлэх эрчим хүчний хэмжээ;

**3.4.3.2.** хуулийн этгээдийн гэрчилгээний баталгаажуулсан хуулбар, сүүлийн 3-5 жилийн аудитлагдсан санхүүгийн тайлангийн баталгаажуулсан хуулбар, туршлагын талаарх мэдээлэл;

**3.4.3.3.** төслийг үнэлэх шалгуур үзүүлэлт;

**3.4.3.4.** төсөл хэрэгжүүлэх баталгааны тухай;

**3.4.3.5.** ирүүлэх маягтын загвар;

**3.4.3.6.** төсөл хэрэгжүүлэх гэрээний ерөнхий нөхцөл;

**3.4.3.7.** эрчим хүч худалдах, худалдан авах гэрээний ерөнхий нөхцөл.

## II. Төслийг шалгаруулах үе шатанд журамд зааснаар

**3.6.1.1.** төслийн нэр, суурилагдсан хүчин чадал, техник, технологийн шийдэл, төсөл хэрэгжүүлэх байршил, нэгдсэн сүлжээнд нийлүүлэх эрчим хүчний хэмжээ;

**3.6.1.2.** санхүүгийн болон хүний нөөцийн чадавхын талаарх мэдээлэл, холбогдох зөвшөөрлүүд (тогтоосон маягтын дагуу);

**3.6.1.3.** үнийн санал (тогтоосны маягтын дагуу);

**3.6.1.4.** техникийн болон санхүүгийн санал боловсруулахад шаардлагатай мэдээлэл;


- 3.6.1.5.**техникийн болон санхүүгийн саналыг үнэлэх шалгуур үзүүлэлт;
- 3.6.1.6.**төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх нарийвчилсан төлөвлөгөө;
- 3.6.1.7.**төсөл хэрэгжүүлэх баталгааны тухай;
- 3.6.1.8.**төсөл шалгаруулалт хүчингүй болох нөхцөл;
- 3.6.1.9.**төсөл хэрэгжүүлэх гэрээний загвар;
- 3.6.1.10.**эрчим хүч худалдах, худалдан авах гэрээний загвар.
- 3.6.1.11.**санал нээхээс өмнө тодруулга өгөх тухай;
- 3.6.1.12.**төслийн санал хүлээн авах эцсийн хугацаа, хүлээн авах газар.

### Дүгнэлт

Одоо мөрдөгдөж буй сэргээгдэх эрчим хүчний төсөл шалгаруулалтын журам нь хүнээс бүрэн хамааралтай, цаг хугацаа их шаарддаг, бичиг баримт бүрдүүлэх гэх мэт олон шат дамжлагатай байна. Уг журмаар шалгаруулалтад оролцогч нар нь төслийн урьдчилсан үнэлгээний үе шат болон төслийг шалгаруулах үе шатанд техникийн нөхцөл голлон үнэлүүлж сүүлийн шатанд 70 хувийн босгыг давж байж үнийн саналын харьцуулалт хийгдэнэ. Энэ нь үнийн өрсөлдөөнд суурилсан сонгон шалгаруулалт болж чадахгүй байгаа юм.

### 3. Олон улсын сайн туршлагыг судлан нэвтрүүлэх нь

Дэлхийн улс орнууд өөрийн орны нөхцөл байдлаас шалтгаалан эрчим хүчний салбарын зорилт, бодлого, хэрэгжүүлэх арга зам нь өөр өөр байдаг. Манай улсын нөхцөл байдалтай ойролцоо улс орнуудыг судлан Казахстан улсын сэргээгдэх эрчим хүчний эрчим хүчний төсөл шалгаруулах дуудлага худалдааны загварыг онцлон судаллаа. Казахстан улс нь цаг агаарын нөхцөл, газар зүйн онцлог болон одоо ашиглагдаж буй эрчим хүчний эх үүсвэрүүдийн хувьд манай оронтой ижил төстэй талууд их юм. 2023 оны байдлаар нийт эх үүсвэрийн 70% нүүрс, 9% Газ, 22% сэргээгдэх эх үүсвэрүүд эзэлж байна.



Казахстан улсын Эрчим Хүчний Яам нь 5 жилийн хөгжлийн төлөвлөгөө, эрчим хүчний суурилагдсан хүчин чадлын 5-7 жилийн төсөөллийг бэлтгэн холбогдох арга хэжмээ болон дагалдах төлөвлөгөөнүүдийг батлан хэрэгжүүлдэг.

#### ЭРЧИМ ХҮЧНИЙ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

**КАЗАХСТАН УЛСЫН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ 2050**

- 2050 онд нийт эрчим хүчний үйлдвэрлэлийн 50% СЭХ-ний эх үүсвэр байна

**КАЗАХСТАН УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ**

- Хөгжлийн төлөвлөгөө 2023-2027
- ЭХ-ний СХЧ-ын төсөөлөл 2025-2031
- Аукцион төлөвлөгөө 2023, 2024-2027
- Аукцион төлөвлөгөө батлах 2025



График проведения аукционов торгов на 2023 год

Дата торга	Зона ЕЭС	Область	ЕЭС	Тип торга	Объем максимальной установленной мощности, МВт	Валовая установленная мощность, МВт	Требования к дате подачи заявок и заключения договоров	Финансовое обеспечение обязательств по условиям аукциона (млн тенге)	Объемы обязательств по условиям аукциона (млн кВтч)	Валовая установленная мощность, МВт	Валовая установленная мощность, МВт
31 августа 2023 года	Северо- и Южно-Казахстанская	Восточная	ГЭС	20	41,23	41,23	60 месяцев с даты заключения договора	2 000 тенге/кВтч	10 000 тенге/кВтч	10 000 тенге/кВтч	10 000 тенге/кВтч
1 сентября 2023 года	Северо- и Южно-Казахстанская	Восточная	ГЭС	200	41,23	41,23	60 месяцев с даты заключения договора	2 000 тенге/кВтч	10 000 тенге/кВтч	10 000 тенге/кВтч	10 000 тенге/кВтч

План проведения аукционов торгов на 2024-2027 годы

Дата торга	Зона ЕЭС	Область	ЕЭС	Тип торга	Объем максимальной установленной мощности, МВт	Валовая установленная мощность, МВт	Требования к дате подачи заявок и заключения договоров	Финансовое обеспечение обязательств по условиям аукциона (млн тенге)	Объемы обязательств по условиям аукциона (млн кВтч)	Валовая установленная мощность, МВт	Валовая установленная мощность, МВт
Март 2024 года	Северо- и Южно-Казахстанская	Восточная	ГЭС	30	41,23	41,23	60 месяцев с даты заключения договора	2 000 тенге/кВтч	10 000 тенге/кВтч	10 000 тенге/кВтч	10 000 тенге/кВтч
Март 2025 года	Северо- и Южно-Казахстанская	Восточная	ГЭС	30	41,23	41,23	60 месяцев с даты заключения договора	2 000 тенге/кВтч	10 000 тенге/кВтч	10 000 тенге/кВтч	10 000 тенге/кВтч

Эх сурвалж: www.gov.kz | www.gov.kz

2018 оноос сэргээгдэх эрчим хүчний бүхий л эх үүсвэрүүдийг дуудлага худалдааны үнээр өрсөлдүүлэх буюу аукционы зарчмаар сонгон шалгаруулалт зохион байгуулж байна. Эрчим Хүчний Яам нь 2023, 2024-2027 оны сэргээгдэх эрчим хүчний аукцион зарлах хуваарийг урьдчилан батлан бэлтгэсэн байдаг. Аукцион зарлах тухайн жилд Эрчим хүчний яам аукционы жилийн төлөвлөгөөг дахин баталгаажуулан байршлын нарийвчлалтайгаар баталгаажуулдаг. Дуудлага худалдаанд оролцогч нар нь энэхүү төлөвлөгөөг үндэслэн байршил, эх үүсвэрийн хүчин чадлын хэмжээ, дуудлага худалдааны үнэ хаялцах тааз үнийн хүрээнд дуудлага худалдаанд оролцдог.



**"КАЗАХСТАНЫ ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ОПЕРАТОР" ХК**

- ДУУДЛАГА ХУДАЛДААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
- АУКЦИОНЫ СИСТЕМНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАРИУЦАХ
- ЯЛАГЧИЙГ ТОДРУУЛАХ



**"КАЗАХСТАНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ СҮЛЖЭЭНИЙ ОПЕРАТОР" ХК**

- АУКЦИОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ ДАГУУ ЦДАШ БЭЛТГЭХ
- СИСТЕМНИЙ ТОГТВОРЖИЛТЫГ ХАНГАХ



**"СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТӨЛБӨР ТООЦООНЫ САНХҮҮГИЙН ТӨВ"**

- ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ОРОЛЦОГЧДЫН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, БАТАЛГААНЫ ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛАХ
- ЯЛАГЧ БОЛСОН КОМПАНИЙ ЭРЧИМ ХҮЧ ХУДАЛДАХ ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ БАЙГУУЛНА
- ЭРЧИМ ХҮЧНИЙ ХУДАЛДААГ ХАРИУЦНА.

Хараат бус хөндлөнгийн баг гарган дуудлага худалдааны явцад хяналтыг хэрэгжүүлдэг байна.

Оролцогчдын тоог их байлгах үүднээс дуудлага худалдаанд бүртгүүлэхэд бүрдүүлэх материалын шаардлагыг хамгийн бага түвшинд баталсан байдаг. 499 МВт-аас бага хүчин чадлын төсөлд оролцох үед бүрдүүлэх материал нь байгууллагын гэрчилгээ, захирлыг томилсон тушаал, хэрвээ төлөөлөгч оролцох бол итгэмжлэл гэсэн энгийн анхан шатны материалуудыг бүрдүүлдэг.

**АУКЦИОНД ОРОЛЦОГЧ**

**I. СИСТЕМД БҮРТГҮҮЛЭХ**

- www.korem.kz бүртгүүлнэ.
- Шаардлагатай мэдээллийг оруулах
  - Байгууллагын гэрчилгээ
  - Байгууллагын дүрэм
  - Гүйцэтгэх захиралыг томилсон шийдвэр
  - Толоологчийн итгэмжлэл
- **ӨРГӨДӨЛ ГАРГАХ**
  - Оролцогчийн нэр
  - Цахилгаан эрчим хүчний үнэ (НОАТ-гүй, арын бутархай орон -с ихгүй )
  - Суурилагдсан хүчин чадал Хамгийн бага зөвшөөрөгдөх суурилагдсан хүчин чадал
  - Сэргээгдэх эрчим хүчний байгууламж барих газар болон цахилгаан сүлжээнд холбох цэг (байхгүй байж болно)
  - Санхүүгийн баталгааны төрөл, хэмжээ

Харин 499 МВт-аас дээш хүчин чадал бүхий төсөлд оролцох үед нэмэлтээр 100 МВт-аас дээш чадалтай төсөл хэрэгжүүлсэн туршлагыг нотлох баримт бичиг шаарддаг. Бүртгэл баталгаажсаны дараа системд өргөдөл гарган дуудлага худалдаанд оролцох эрхийг авна. Уг өргөдөлд байгууллагын нэр, оролцох хүчин чадлын дээд болон доод хэмжээ, санхүүгийн баталгааг бүрдүүлэн өгнө.

Хамгийн гол нөхцөл бол баталгааны барьцаа байршуулан оролцох юм. Дуудлага худалдаанд оролцох эрхийн баталгааг бүх оролцогч нар авах шаардлагатай байдаг. Харин дуудлага худалдааны ялагч нь цахилгаан эрчим хүч нийлүүлэх, худалдах, худалдан авах гэрээ байгуулна. Энэхүү гэрээний хамтаар ялагчаар тодорсон байгууллага нь эрчим хүчний эх үүсвэрийг төслийн бүтээн байгуулах хугацаанд ашиглалтад оруулах, цахилгаан эрчим хүчийг заасан хугацаанд системд нийлүүлэх хариуцлагын баталгааг шинэчлэн байршуулдаг. 2018-2024 оны хооронд дуудлага худалдааны ялагч болсон ердөө 2 байгууллага шаардлага хангаагүйн улмаас баталгааны барьцааг "Сэргээгдэх эрчим хүчний төлбөр тооцооны санхүүгийн төв" шилжүүлэн авсан гэсэн мэдээг "КОРЕМ" ХК-ийн талаас өгсөн.

### III. САНХҮҮГИЙН БАТАЛГАА

- Оролцогч санхүүгийн баталгааг "Сэргээгдэх Эрчим Хүчний Төлбөр Тооцооны Санхүүгийн Төв" ХХК-д ирүүлнэ.
- "Сэргээгдэх Эрчим Хүчний Төлбөр Тооцооны Санхүүгийн Төв" ХХК дуудлага худалдаа эхлэхээс доод тал нь 2 цагийн өмнө санхүүгийн баталгааг бүрдүүлсэн байх ёстой.
- Энэхүү мэдээлэл нь нууцлалтай бөгөөд гуравдагч этгээдэд задруулахыг хориглоно.
- Зохион байгуулагч дуудлага худалдаа эхлэхээс 30 минутын өмнө оролцогчдын санхүүгийн баталгааны дүнг системд бүртгэнэ.

### Хүснэгт 1. Гарчиг

Эх үүсвэрийн төрөл	Бүтээн байгуулах хугацаа/сар	ЦЭХ-ний ХХА гэрээний хугацаа/жил	Аукционд оролцох баталгаа кВт/ам.доллар	ЦЭХ-ХХА гэрээний баталгаа кВт/ам.доллар
Салхи	36	20	4	20
Нар	24	20	4	20
Ус	60	20	4	20
Био	36	20	10	20


Дуудлага худалдааны төслийн шалгаруулалтад оролцож буй байгууллагууд нь сонгогдсон төсөл дээр үндсэн 30 минутын дотор үнэ хаялцан ялагч тодордог. Хэрвээ 30 минут дууссаны дараа 5 минутын дотор дахин бага үнийн санал гарч ирэх бол уг систем 5 минут автоматаар сунгагдан үргэлжилдэг байна (Зураг 1).

**Зураг 1. Аукционы сонгон шалгаруулах үйл явцын бүрдүүвч**



2018 онд анх 1000 МВт-ын сэргээгдэх эрчим хүчний 20 төслийг шалгаруулахаар зарласан. Эх үүсвэрийн төрлөөр ангилан үзвэл, салхин эх үүсвэр 620 МВт, нарны эх үүсвэр 290 МВт, усан цахилгаан станц 75 МВт, Био станц 15 МВт-ын хэмжээтэй байна. Оролцсон оролцогчдын ирүүлсэн санал нь 3422 МВт-д хүрч зарласан хэмжээнээс даруй 3 дахин их хэмжээний бүтээн байгуулалт хийж боломж байгааг оролцогч байгууллагууд илэрхийлсэн байна. Харин 2024 онд 1270 МВт-ын сэргээгдэх эрчим хүчний 18 төслийг шалгаруулахаар зарласан. Үүнд салхин эх үүсвэр 700 МВт, нарны эх үүсвэр 160 МВт, усан цахилгаан станц 400 МВт, Био станц 10 МВт-ын хэмжээтэй тус тус зарласан байна (Зураг 2).

**Зураг 2. 2018 – 2024 оны хооронд зохион байгуулсан аукционы системийн үр дүн**



2024 онд 18 аукционы төсөлд оролцогчдын ирүүлсэн санал нь 6175 МВт-д хүрч зарласан хэмжээнээс даруй 4.9 дахин их хэмжээний нөөц боломж байгааг оролцогч байгууллагууд илэрхийлсэн байна. 2024 онд дуудлага худалдааны үйл ажиллагаанд нийт гадна болон дотоодын 59 байгууллага оролцсон. Энэ үнэ хаялцах дуудлага худалдааны бүрэн автомат системийг хэрэгжүүлснээр хувийн хэвшлийн оролцоо эрс нэмэгдсэн байна. Дуудлага худалдааны үр дүнд эрчим хүчний системд нийлүүлэх үнэ жил ирэх бүр буурсаар байгаа эерэг үзүүлэлт гарчээ.

**Хүснэгт 1. 2018 болон 2024 онд зохион байгуулсан аукционы үнийн дүнгийн харьцуулалт**

СЭХ төрөл	АУКЦИОН ҮР ДҮН 2018 ОН			АУКЦИОН ҮР ДҮН 2024 ОН		
	Тааз үнэ / ам.доллар цент/кВт.ц/	Шалгарсан үнэ / ам.доллар цент/кВт.ц/	Үнийн бууралт /хувиар/	Тааз үнэ / ам.доллар цент/кВт.ц/	Шалгарсан үнэ / ам.доллар цент/кВт.ц/	Үнийн бууралт / хувиар/
Салхи	6.58	5.04	23%	4.94	1.54	69%
Нар	10.04	5.22	48%	7.55	3.1	59%
Ус	4.85	3.71	23%	8.99	1.74	80%

Оролцогчид нь 2018 онд тааз үнээс 23-48% доогуур үнийн санал өгч шалгарч байсан бол 2024 онд оролцогчдын тоо нэмэгдсэнээр үнийн өрсөлдөөн улам ихсэж тааз үнээс 59-80% хүртэл бага үнийн санал өгч шалгарсан байна. Жилээс жилд сэргээгдэх эрчим хүчний хөгжил хурдацтай хөгжихийн зэрэгцээ бүтээн байгуулалтын болон ашиглалтын зардал буурсаар байгаа нь сэргээгдэх эрчим хүчний өртгийг бууруулах боломжийг бүрдүүлж байна.

#### 4. Судалгааны үр дүн, дүгнэлт

Монгол Улсад сэргээгдэх эрчим хүчний төсөл шалгаруулах дуудлага худалдааны журмыг хэрэгжүүлснээр төслүүдийн сонгон шалгаруулалтын үе шатыг багасгах, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, шалгаруулалтын үйл явцыг хүнээс хамааралтай байдлыг бууруулах мөн сэргээгдэх эрчим хүчний төслүүд дээр хуримтлагдсан хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэх гарц шийдэл болох боломжтой юм. Тухайлбал дуудлага худалдаа явуулж зах зээлийн доод үнийг тогтоосны дараа тусгай зөвшөөрөлтэй боловч эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ байгуулж чадаагүй гацсан байгаа төслүүдэд доод үнийн гэрээний саналыг тавих, мөн үйл ажиллагаа явуулж байгаа төслүүдтэй дахин хэлэлцээрт орж үнэ тарифыг бууруулах боломж бүрдэнэ. Нөгөө талаар одоо хэрэгжиж байгаа төслүүд дээр өргөтгөл хийж үнийг одоогийн олон улсын үнэ өртөгт бууруулж хүргэх боломж байгааг энэ туршлагаас харж болно. Улмаар оргил ачааллыг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс цэнэгт хураагуур ашиглан хангах томоохон төслүүдийг хэрэгжүүлэхдээ олон улсын хөгжлийн байгууллагын сэргээгдэх эрчим хүчний хөнгөлөлттэй санхүүжилтийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай хамт татах нь уламжлалт нүүрсний эх үүсвэрээс ч дутахгүй өрсөлдөх чадвартай байж болохыг сүүлийн үеийн аукцион буюу үнэ хаялцах дуудлага худалдааны үр дүн харуулж байна.

Үе шат	Монгол Улс / хугацаа/	Шалгарсан үнэ / ам.доллар цент/кВт.ц/
Төслийг зарлах	30 хоног	90 хоног
Шалгаруулалтын зохион байгуулах	Хорооны 9 гишүүн	Аукционы программ
Шалгаруулалтын эхний үе шат	20-40 хоног	30 мин+5 мин сунгах
Шалгаруулалтын эцсийн шат	45-65 хоног	
Нийт шалгаруулалтын хугацаа	85-105 хоног	30 мин+5 мин сунгах

# СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭКСПОРТ

## Удиртгал

21-р зуунд хүн төрөлхтөн хөгжлийн шинэ эринд хөл тавьж, технологийн асар хурдацтай хувьсал өөрчлөлт дэлхий даяар өрнөж байна. Хиймэл оюун ухаан, дижиталчлал, цахилгаанжуулалт, цэвэр технологи, автоматжуулалт зэрэг шинэ шийдлүүд нь нийгмийн бүхий л хүрээнд нэвтэрч, улс орнуудын эдийн засгийн суурь бүтэц, хөгжлийн загваруудыг эрс өөрчилж байна. Энэ бүх өөрчлөлт, шинэчлэлийн төв нь эрчим хүч болж байна.

Эрчим хүч нь зөвхөн үйлдвэрлэл, тээвэр, хэрэглээний системд төдийгүй улс орны эрх ашиг, аюулгүй байдал, эдийн засгийн тэсвэртэй байдлыг тодорхойлогч стратегийн салбар болон хувирсан. Цахилгаангүйгээр дата төв, робот техник, цахилгаан тээврийн хэрэгсэл, хагас дамжуулагч, хиймэл оюун ухаан зэрэг шинэ эринд шаардлагатай ямар ч технологи үйл ажиллагаа явуулж чадахгүй. Улс орнуудын дижитал шилжилт, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх бодлого, үйлдвэрлэлийн

нүүрстөрөгчийг бууруулах зэрэг нь эрчим хүчний эрэлт, хэрэглээний бүтэц, хандлагад гүнзгий, урт хугацааны өөрчлөлт авчирч байна.

Өнөөдөр хөгжингүй орнуудад сэргээгдэх эх үүсвэр, ногоон устөрөгч, ухаалаг цахилгаан сүлжээ, хуримтлуурын систем зэрэг инновацлаг шийдэлд тэргүүн байр суурь эзэлж, эрчим хүчээр зөвхөн хангах биш, экспортоор улс орныхоо өрсөлдөх чадварыг бүрдүүлэхээр зорьж байгаа. Харин хөгжиж буй орнууд цахилгаан эрчим хүчний хамрах хүрээг өргөжүүлэх, найдвартай сүлжээтэй болох, цэвэр технологид хөрөнгө оруулалт татах сорилтуудтай тулгарч байна. Тиймээс нийгэм, эдийн засаг, инновацын бүхий л шатанд эрчим хүчний үүрэг шинэ түвшинд гарч, зөвхөн хангамжийн асуудал биш, харин өрсөлдөх чадвар, тогтвортой хөгжлийн баталгаа болж байгааг энэхүү дугаартаа хөндөж байна. Энергийн шинэ тэнцвэр, ногоон шилжилт, технологийн эрчим хүч нь ирээдүйд улс орнуудын байр суурь, хамтын ажиллагааны дүр төрхийг тодорхойлох болно. Жишээлбэл:

### • Аж үйлдвэрлэлийн автоматжуулалт:

Аж үйлдвэрийн 4-р хувьсгалын хүрээнд уламжлалт үйлдвэрийн үйл явц роботжуулалт руу шилжиж, хүний оролцоо багасаж, автомат машин, хиймэл оюун ухаан давамгайлж байна. 2023 онд International Federation of Robotics (IFR)-ийн бэлтгэн гаргасан World Robotics 2023 тайланд дурдсанаар дэлхий даяар суурилуулсан аж үйлдвэрийн роботын тоо 3.9 саяд хүрчээ. Энэхүү автоматжуулалт жилд дунджаар 13%-ийн өсөлттэй байгаа нь тогтвортой, өндөр хүчин чадалтай цахилгаан хангамж шаардаж байна.



### • Цахилгаан тээврийн хэрэгслийн хөгжил:

IEA бэлтгэн гаргасан Global Outlook 2024 тайланд дурдснаар сүүлийн 5 жилийн хугацаанд жилд дунджаар цахилгаан автомашины борлуулалт 40–50%-ийн өсөлттэй гарсан. 2024 онд дэлхий даяар 20 сая гаруй цахилгаан машин замын хөдөлгөөнд оролцож байгаа бөгөөд 2030 он гэхэд энэ тоо 140 саяд хүрэх төлөвтэй. 2023 онд нийт 14 сая цахилгаан авто машин борлуулсан. Нэг цахилгаан машин жилд 3,000–6,000 кВт.ц цахилгаан хэрэглэдэг тул нийтийн



хэрэгцээнд эрчим хүчний эрэлт үлэмж нэмэгдэж байна.

### • Дата төвүүдийн хөгжил:

2023 оны статистик мэдээгээр дэлхий даяар нийт 8000–8500 дата төв ажиллаж байна. Программ хангамж, клауд технологи, хиймэл оюун ухаанд суурилсан томоохон дата төвүүд нь өнөө цагт хамгийн эрэлттэй, стратегийн төсөл болоод байна. Дата төвүүд дэлхийн цахилгаан хэрэглээний 2–3%-ийг ашиглаж байгаа бол 2030 он гэхэд 7–10% хүртэл хэрэглээтэй болох төлөвтэй байна. Нэг дата төв нь жилд дунджаар 120–430 сая кВт.ц цахилгаан хэрэглэдэг.



### • Өрхийн цахилгаан хэрэглээний өсөлт:

Нийт цахилгаан хэрэглээний 25 орчим хувийн өрх гэрийн хэрэглээ эзэлдэг. Сарын дундаж хэрэглээ нь 290–330 кВт.ц байгаа бол хөгжингүй орнуудын хувьд 300–800 хүртэл кВт.ц, хэрэглээний жилийн өсөлт дэлхийн улс орнуудын хувьд дунджаар 2.5–3 хувьтай байгаа бол Монгол Улсын өрхийн цахилгаан хэрэглээний өсөлт 5–6 хувьтай байна. Орчин цагийн өрхийн хэрэглээ нь улам ухаалаг хэрэглээнд шилжиж, утас, зурагт, хөргөгч, автомат системтэй ахуйн цахилгаан суурьтай хэрэглээний төхөөрөмжүүд өдөр тутмын амьдралд илүү ихээр нэвтрэх болсон.

• **Томоохон бүтээн байгуулалт, хөгжүүлэлт:**

Улс орнууд үндэсний хөгжлийн бодлогодоо газрын ховор элемент, уул уурхай, ногоон устөрөгч, AI платформ, чип үйлдвэрлэл, дата платформ, ган үйлдвэрлэл зэрэг эрчим хүч ихээр хэрэглэдэг төслүүдийг түлхүү тусгаж байна.

Дэлхий дахинд техникийн үсрэнгүй хөгжил нь эрчим хүчний хангамжийг урьд өмнөхөөс илүү нарийн,


хүртээмжтэй, найдвартай болгох шаардлагыг тавьж байгаа. Энэхүү өөрчлөлт нь зөвхөн үйлдвэрлэл төдийгүй нийгмийн бүхий л түвшинд цахилгаан эрчим хүчний эрэлт огцом нэмэгдэх шалтгаан болж байгаа бөгөөд үүнийг дагаад сэргээгдэх эрчим хүч, хуримтлуурын систем, дамжуулах сүлжээ, бүс нутгийн хамтын ажиллагаа урьдынхаас илүү ач холбогдолтой болж байна.

**1. Монгол улс дэлхийн эрчим хүчний системд хувь нэмэр оруулах боломж:**

Дэлхийн улс орнуудын өмнө тулгарч буй гол сорилтуудын нэг нь уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах юм. Тийм ч учраас НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц болох “Парисын хэлэлцээр”, “Нэг Зеро-2050” зэрэг олон улсын уур амьсгалын зорилтуудад улс орнууд нэгдэн, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг эрс нэмэгдүүлэх чиглэл баримтлахаар болсон. Энэхүү шилжилтийн гол тулгуур нь зөвхөн дотоодын үйлдвэрлэл бус, бүс нутгийн эрчим хүчний интеграцчилал, улс дамнасан эрчим хүчний экспорт-импортын системийг бүрдүүлэх явдал болж байна.

Дэлхий дахинд сэргээгдэх эрчим хүчний хэрэглээний өсөлт зөвхөн технологийн дэвшлээр хязгаарлагдахгүй, харин газарзүйн боломж, дэд бүтэц, зах зээлийн хүртээмж, зохицуулалтын уялдаанаас хамаарч байгаа юм. Сэргээгдэх эрчим хүчний хөгжлийг хязгаарлагч гол хүчин зүйлүүдийн нэг нь газар нутгийн хязгаарлагдмал байдал бөгөөд хотжилт өндөртэй, газар бага орнууд цэвэр эрчим хүч үйлдвэрлэх бус, харин импортлох хэрэгцээтэй нүүр тулгарч байна. Жишээлбэл, Япон, БНСУ, Сингапур, Герман зэрэг улс орнууд дотооддоо нар, салхины цахилгаан үйлдвэрлэх боломж муутай тул өөр улсуудаас цэвэр эрчим хүч худалдан авах, “ногоон эрчим хүч импортлогч” болох стратеги баримталж эхэлжээ.

Эдгээр өөрчлөлтүүдийн дунд Монгол Улс дэлхийн эрчим хүчний шинэ шилжилтийн эрэн үед “цэвэр эрчим хүч экспортлогч” стратегийн байр суурийг өөртөө бий болгох бүрэн боломжтой. Монгол Улс нь дэлхийд ховор тохиох өргөн уудам газар нутагтай, хүний гар хүрээгүй байгальтай, өндөр нарны цацрагийн эрчим болон жигд салхитай бүс нутгуудаар баялаг.



Судалгаагаар Монгол Улсын нийт боломжит сэргээгдэх эрчим хүчний нөөц ойролцоогоор 2600 ГВт бөгөөд үүнээс нарны нөөц 1500+ ГВт, салхины нөөц 1100 ГВт байна гэж үздэг.

2019 онд Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр хийгдсэн NAPS (Northeast Asia Power System Interconnection) төслийн хүрээнд хийсэн судалгаагаар Монгол Улсын экспортлох боломжтой сэргээгдэх эрчим хүчний нөөцийн хэмжээг дараах байдлаар тодорхойлсон:

- Салхины эрчим хүч 191 ГВт
- Нарны эрчим хүч 1166 ГВт

Эдгээр бүсүүд нь голчлон Өмнөговь, Дорноговь, Сүхбаатар зэрэг говийн бүс нутгуудад байршдаг бөгөөд энэ нь БНХАУ-тай хил залгаа, экспортын дэд бүтцийг хөгжүүлэхэд логистикийн хувьд таатай нөхцөл болж байна.

Цэвэр эрчим хүчний экспортын энэ боломж зөвхөн эрчим хүч борлуулах энгийн загвараар хязгаарлагдахгүй бөгөөд дараах олон улсын эдийн засгийн механизмуудтай уялддаг:

- Нүүрстөрөгчийн кредит (carbon credit): Цэвэр эрчим хүч экспортлогч улс нь CO<sub>2</sub> ялгаруулалтаа багасгаж буй орныг төлөөлөн "эрх" худалдан борлуулах боломжтой.
- Цэвэр эрчим хүчний баталгаажуулалт (Green Certificate): Импортлогч орнуудын хувьд эрчим хүчний эх үүсвэрийг нотлон гэрчилгээ авах шаардлага гардаг.
- Ногоон устөрөгч үйлдвэрлэл: Нар, салхиар ус электролиз хийж “ногоон устөрөгч” үйлдвэрлэх, улмаар химийн болон тээврийн салбарт экспортлох шинэ салбар хөгжүүлж болно.

Монгол Улсын хувьд сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг зөвхөн дотоод хэрэглээнд чиглүүлэхээс илүүтэйгээр бүс нутгийн хэмжээнд чиглэсэн экспортын стратегид төвлөрөх нь илүү өгөөжтэй. Ийнхүү зөвхөн байгалийн нөөцөөрөө төдийгүй газар зүйн байрлал, бүс нутгийн дэд бүтцийн уулзварын хувьд дэлхийн эрчим хүчний системд цэвэр эрчим хүч нийлүүлэгч, тогтвортой хөгжлийн жишиг орон болох бүрэн суурь, чадавхтай гэдгийг дээрх судалгаа, олон улсын чиг хандлага тодорхойлсон.

## 2. Эдийн засгийн өгөөж:

Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчний нөөц бол зөвхөн олон улсад өгсөн амлалтын хүрээнд бус харин эдийн засгийн өндөр өгөөжтэй, олон улсын зах зээлд шууд гарах боломж бүхий стратегийн баялаг юм. СЭХ-ний экспорт нь цахилгаан эрчим хүчний борлуулалтаас гадна олон чиглэлээр шууд болон шууд бус эдийн засгийн ашиг өгдөг бөгөөд дараах үндсэн хувилбаруудыг авч үзэж болно:

### 1. Дамжуулах шугамын хураамжийн орлого (Transmission charges)

Монгол Улсаар дамжин өнгөрөх эсвэл экспортын эрчим хүчийг улсын хил дээр холбож дамжуулахад хураамж авах боломжтой. Энэ төрлийн орлого нь сүлжээний дэд бүтцийн ашиглалтын зардлыг нөхөхөөс гадна төсөвт тогтмол эх үүсвэр болно.

- Жишээ тооцоо:
  - 5 ГВт хүчин чадалтай HVDC шугамаар жилд дунджаар 30 ТВт.ц эрчим хүч экспортолбол,
  - Дамжуулалтын дундаж хураамж: 0.01–0.02 USD/кВт.ц байвал,
  - Жилийн орлого: 300–600 сая ам.доллар.

### 2. Газрын төлбөр ба дэд бүтэц ашигласны төлбөр

Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрүүд нь олон арван мянган га талбайг хамардаг ба энэхүү газрыг ашигласны төлбөрийг төр, орон нутгийн төсөвт оруулж болно. 1 МВт хүчин чадалтай нарны станцад дунджаар 2 га, салхины станцад 0.5 га газар шаарддаг. Жишээлбэл, 10 ГВт салхины станц 5000 га, 10 ГВт нарны станц 20,000 га нийт 25,000 га. 1 га тутамд жилд 20,000–50,000₮ түрээсийн орлого олох боломжтой. Жилийн газрын төлбөрийн орлого 0.5–1.2 тэрбум төгрөг (150–350 мянган ам.доллар) болно.

### 3. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (Corporate income tax)

Цэвэр эрчим хүчний экспортын бизнес нь олон тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт, ашиг орлоготой томоохон төслүүдийг бий болгоно. Нэг МВт хүчин чадалтай нарны станцын CAPEX дунджаар 800–1000 мянган ам.доллар байгаа бөгөөд 5 ГВт СЭХ станцын нийт хөрөнгө оруулалт: 4–5 тэрбум ам.доллар болно.

- Борлуулалтын орлого: 1.5 тэрбум ам.доллар/жил
- Монгол Улсын ААНОАТ-т жилийн 15–50 сая ам.долларыг улсад төвлөрүүлнэ.

Энд дурдсан тооцоо нь жишиг тооцоо бөгөөд бодит үр өгөөж нь тариф, гэрээний нөхцөл, зохицуулалтаас хамаарч өөрчлөгдөнө.

### 4. Нүүрстөрөгчийн кредитийн орлого (Carbon credits revenue)

Монгол Улсын СЭХ-ээр үйлдвэрлэсэн 1 МВт.ц эрчим хүч нь ойролцоогоор 0.9–1.0 тонн CO<sub>2</sub> ялгаруулалтыг хэмнэнэ

гэж тооцдог. 1 ТВт.ц ойролцоогоор 0.9–1.0 сая тонн CO<sub>2</sub> хэмнэлтийг бий болгоно. Карбон кредитийн зах зээлийн үнэ 2024 оны байдлаар хоёр талын гэрээний түвшинд: 5–30 USD/тонн. Хэрэв Монгол Улс жилд 10 ТВт.ц экспорт хийж, тонн тутмыг 15 ам.доллаар борлуулбал жилийн карбон кредитийн орлого 135–150 сая ам.долларт хүрэх боломжтой.

### 5. Шууд бус эдийн засгийн үр нөлөө

- Ажлын байрны нэмэгдэл: СЭХ төслүүдийн барилга, засвар, ашиглалттай холбоотойгоор мянга мянган байнгын болон түр ажлын байр бий болно.
- Орон нутгийн орлогын өсөлт: Газрын түрээс, орон нутгийн дэд бүтэц сайжрах, жижиг бизнесүүд (зууч, тээвэр, үйлчилгээ) хөгжих суурь болно.
- Гадаад валютын тогтвортой орлого: СЭХ экспорт нь олон төрлийн төр зэргээр байдлаас саяу урт хугацаанд доллар орлого болно.

## 3. Тулгамдаж буй асуудлууд

Монгол Улс сэргээгдэх эрчим хүчний экспортын стратегийг хэрэгжүүлэх явцдаа цогц дэд бүтэц, зохицуулалт, хөрөнгө оруулалтын орчны шинэчлэл шаардагдах олон талт асуудлуудтай тулгарч байна. Эдгээр асуудлуудыг зөв тодорхойлж, үе шаттай шийдвэрлэхгүйгээр бүс нутгийн эрчим хүчний сүлжээнд

### Тулгамдаж буй үндсэн асуудлууд

Дотоод сүлжээ	Төвлөрсөн бүтэцтэй одоогийн сүлжээ нь өндөр хүчин чадлын экспортын эрчим хүчийг найдвартай, уян хатан дамжуулахад тохиромжгүй.
Дамжуулах дэд бүтэц	Олон улсын экспортын HVDC шугамын зураглал, техник, байгаль орчны зөвшөөрөл, хөрөнгө оруулалтын загвар тодорхой бус.
Хөрөнгө оруулалтын орчин	Эрчим хүчний төсөлд гадаадын хөрөнгө оруулалт татах эрх зүйн орчин, шат дамжлага тодорхой бус. Хөрөнгө оруулагч хандах мэдээлэл, нэг цонхны платформ бүрэн хөгжөөгүй.
Зах зээлийн зохицуулалт	Эрчим хүч экспортлох, хил дамнан худалдаанд оролцох эрх зүйн зохицуулалт бүрдээгүй.
Төр хувийн хэвшлийн уялдаа	Бодлого, төсөл, хөрөнгө оруулалтын хуваарилалт болон төрийн агентлагуудын зохион байгуулалт уялдаа муу.
Байгаль орчны сорилт	Өмнөд бүсүүдэд СЭХ станцуудыг хөгжүүлэхэд экосистем, усны нөөцөд үзүүлэх нөлөөлөл нарийвчилсан үнэлгээ хийгдээгүй
Олон улсын хэлэлцээрийн ойлгомжгүй байдал	Бүс нутгийн хамтын ажиллагааны хүрээнд БНХАУ улстай хийх эрчим хүчний экспортын хэлэлцээрүүд шийдвэрлэх түвшинд хүрээгүй.
Хүний нөөц, чадавхын хязгаар	Эрчим хүчний салбар нь хүний нөөцийн дутагдалтай. Мөн экспортын сүлжээний найдвартай ажиллагаа, карбон кредитийн менежмент гэх мэт чиглэлээр үндэсний инженер, бодлого боловсруулагч дутмаг.

амжилттай нэгдэх боломжгүй байна.

Эдгээр тулгамдаж буй асуудлууд нь:

- Хөрөнгө оруулалтын тогтворгүй орчин үүсгэх
- БНХАУ болон бүс нутгийн бусад улс орнуудтай хамтын ажиллагааны тодорхой механизм, загвар үүсгэхэд хүндрэл учруула.

Иймээс дээрх асуудал тус бүрд зориулагдсан бодлогын шийдэл, институцийн арга хэмжээ, олон улсын хамтын ажиллагааны хүрээг тодорхойлох нь чухал юм.

## 4. Монгол улсын экспортын стратеги ба хэрэгжилтийн үндсэн нөхцөлүүд

Монгол Улс сэргээгдэх эрчим хүчний экспортын стратегиа амжилттай хэрэгжүүлэхийн тулд зөвхөн техникийн болон байгалийн нөөц бус, бодлого, институц, зах зээлийн бэлтгэл, хөрөнгө оруулалтын тогтолцоогоо цогцоор шинэчлэх шаардлагатай. Анхан шатны суурь судалгаа, нөөц тодорхой болсон ч бодит экспорт руу шилжихэд дараах голлох асуудлуудыг шийдвэрлэх төлөвлөгөө боловсруулах шаардлагатай байна.

### Үндсэн төлөвлөгөө

#### 1. Институцийн реформ ба нэгдсэн бодлого

- “Цэвэр эрчим хүчний экспортын үндэсний стратеги” батлах
- Сэргээгдэх эрчим хүчний экспортын асуудал хариуцсан байнгын бүтцийг бий болгох
- Олон улсын хэлэлцээр эхлүүлэх. Эхний ээлжид БНХАУ-тай хийгдсэн хамтран ажиллах санамжийг ажил хэрэг болгох

#### 2. Сүлжээ, дэд бүтцийн зураглал

- 500 кВ-ын дотоод HVAC сүлжээний мастер төлөвлөгөө боловсруулах
- Улаанбаатар-Өмнөговь-БНХАУ чиглэлд HVDC экспортын шугамын ТЭЗҮ, байгаль орчны үнэлгээ хийх
- Өмнөговьд төвлөрсөн сэргээгдэх эрчим хүчний бүсийг төлөвлөх

#### 3. Хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах

- Экспортод чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийг олон улсын жишгийн дагуу үнээр өрсөлдүүлэн ялагчдад холбогдох тусгай зөвшөөрөл болон эрхийг олгох.
- Эрчим хүчний худалдан авах гэрээний (PPA) жишиг нөхцөлийг олон улсын түвшинд шинэчлэх
- Гадаадын хөрөнгө оруулагчийг хамгаалах хоёр талт хэлэлцээрүүдийг шинэчлэх
- Эдийн засгийн чөлөөт бүс дотор татварын хөнгөлөлт, гаалийн уян хатан зохицуулалт бий болгох

#### 4. Эдийн засгийн шинэ загваруудыг бий болгох

- Карбон кредитийн бүртгэл, баталгаажуулалтын тогтолцоо нэвтрүүлэх

- Эрчим хүчний баталгаат эх үүсвэр (Green Certificate) бүхий экспортын механизмыг хуульчлах
- Сэргээгдэх эрчим хүчний экспортын орлогоос орон нутагт 2.5–5%-г төвлөрүүлэх “Орон нутгийн хуваарилалт”-ын механизмыг бүрдүүлэх.
- Сэргээгдэх эрчим хүчний хууль эрх зүйн орчинд экспортын нөхцөлийг зохицуулах хуулийг боловсруулах
- Монгол Улсыг бүс нутгийн “Clean Power Gateway” болгох зорилт дэвшүүлэн хамгийн хурдан шуурхай, цэвэр эрчим хүч нийлүүлэгч орон болгож байршлын давуу талаа эдийн засгийн шинэ загвар болгон хувиргах
- Ногоон дипломатын платформ – Уур амьсгалын зорилтыг хэрэгжүүлэгч улс орнуудтай сэргээгдэх эрчим хүчний гэрээ байгуулах

### 5. Олон улсын хамтын ажиллагаа, техник туслалцаа

- БНХАУ, Монгол Улс эрчим хүчний экспортын хамтарсан төлөвлөгөөг батлан ажлын хэсэг, хариуцсан нэгжийг байгуулан дэд бүтцийн бэлэн байдлыг хангах, бүтээн байгуулалтын ажлыг хөгжлийн бодлогод тусган хэрэгжүүлэхэд анхаарах
- АХБ, БНХАУ, БНСУ, Япон зэрэг түншүүдтэй хамтарсан хөрөнгө оруулалтын консорциум байгуулах

## 5. Дүгнэлт

Монгол Улс дэлхийн эрчим хүчний системийн шинэчлэл, ногоон шилжилтийн энэ үед цэвэр сэргээгдэх эрчим хүчний ханган нийлүүлэгч болох стратегийн онцгой боломжийг эдийн засгийн болон нийгмийн ашигтай нөхцөлөөр хэрэгжүүлэх гараан дээр байна. Дэлхийн улс орнууд нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулах, 2050 он гэхэд “нэт зеро” зорилтод хүрэх үүрэг хүлээсэн нь сэргээгдэх эрчим хүчний эрэлт, худалдааны цоо шинэ орчныг бүрдүүлж байна.

NAPSI төслийн хүрээнд хийгдсэн судалгаанууд болон эдийн засгийн үр өгөөжийг тооцсон тооцооллоос зөвхөн 5 ГВт-ын экспортын төсөл хэрэгжүүлсэнээр:

- Жилд 300–600 сая ам.долларын дамжуулалтын төлбөрийн орлого,
- 15–50 сая ам.долларын ААНОАТ,
- 135–150 сая ам.долларын карбон кредитийн орлого,
- Ажлын байр бий болгох боломжтойг харуулж байна.
- Гэсэн хэдий ч энэ боломжийг бодит эдийн засгийн өгөөж болгон хувиргахын тулд дараах түлхүүр асуудлуудыг цогцоор нь шийдвэрлэх шаардлагатай хэвээр байна.
- БНХАУ-тай олон удаагийн төрийн дээд хэмжээний айлчлал хийн тодорхой асуудлуудыг хэлэлцсэн ч “Санамж бичиг”-ийн түвшнээс хэтрэхгүй байна.
- Дэд бүтэц, цахилгаан дамжуулах шугамын бэлэн

# 04



## БНХАУ-ЫН ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ТОЙМ



### СУДЛААЧИЙН ҮГ



#### Лхагваагийн ДАВААЖАРГАЛ

/Эдийн засгийн  
ухааны доктор/

ЗАХИРАЛ

"Шинэ сэргэлт  
инновацын хөтөлбөр"

Email: davaajargal@nrpa.gov.mn

Утас: 70116838

БНХАУ нь дэлхийн эрчим хүчний хамгийн том хэрэглэгч, эдийн засгийн дотоод нөөц боломж нэмэгдэх хэрээр тус орны эрчим хүчний хэрэгцээ тасралтгүй өсөж байна. 2024 оны тооцоогоор нийт суурилагдсан хүчин чадал 3,348.6 Гвт хүрч, жилдээ 10,086 тэрбум кВт/цаг цахилгаан хэрэглэсэн статистик тоо бий. БНХАУ нүүрстөрөгч бага ялгаруулах арга замаар эрчим хүч үйлдвэрлэх, цэвэр технологийг түлхүү ашиглан 2060 он гэхэд хүлэмжийн хийн ялгарлыг тэг болтол бууруулах зорилт тавьсан.

Өнгөрсөн жилүүдэд сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийн салбар нь хурдацтай хөгжиж, тэр дундаа ӨМӨЗО улсынхаа сэргээгдэх эрчим хүчний цөм бааз буюу "Цэнхэр далай" болох зорилт тавьсан. 2023 оны байдлаар нийт суурилагдсан хүчин чадлынх нь 15 хувийг салхин цахилгаан станц, 21 хувийг нарны цахилгаан станц эзэлж байна. Үүнийг 2022 онтой харьцуулахад, салхин цахилгаан станцын суурилагдсан хүчин чадал 21, нарных 55 хувиар тус тус өссөн үзүүлэлт гарчээ.

2014 онд Монгол Улс, БНХАУ-ын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа тогтоож, талууд эрчим хүчний салбарт хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан. Энэхүү санамж бичигт сэргээгдэх эрчим хүчний салбарт идэвхтэй хамтран ажиллах, "Азийн супер сүлжээ" төслийг идэвхтэй судалж хамтран ажиллах зорилт дэвшүүлсэн.

Иймд хөрш улсын эрчим хүчний систем, үйлдвэрлэлийн горим, хүчин чадал, салбарын хөгжлийн бодлого, чиг хандлагыг гүнзгийрүүлэн судлах шаардлага бий болсон бөгөөд үүний үр дүнд хоёр тал хамтран сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр бий болгох, хил дамнасан өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам байгуулах, дэд станцын техник, технологийн шийдлүүдийг тодорхойлох чиглэлээр бодит хамтын ажиллагааг эхлүүлэх зорилгоор энэхүү судалгааг боловсруулсан болно.

# БНХАУ-ЫН ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ТОЙМ СУДАЛГАА

## Судалгааны ажлын зорилго

Уг судалгааны ажлын зорилго нь БНХАУ болон манай улстай хил залгаа оршдог ӨвөрМонголын өөртөө засах орны цахилгаан эрчим хүчний салбарын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж ирээдүйд авч хэрэгжүүлэх бодлого төлөвлөлт, стратегийг судална. Судалгааны ажлын үр дүнд манай улс БНХАУ болон ӨМӨЗО-той цахилгаан эрчим хүчний салбарт хамтын ажиллагаа, хамтарсан төслүүд хэрэгжүүлэхэд оновчтой шийдлийг гаргах, төрийн нэгдмэл бодлого боловсруулахад санал зөвлөмж өгөхөд оршино.

## Судалгааны ажлын арга зүй

Судалгааны арга зүй нь БНХАУ болон ӨМӨЗО-ны

цахилгаан эрчим хүчний салбарын тоон мэдээлэл болон стратегийн бодлогын баримт бичиг, тус бүрийн XIV таван жилийн төлөвлөгөө, цахилгаан эрчим хүчний суурилагдсан хүчин чадал, үйлдвэрлэл, цахилгаан эрчим хүчний экспорт, импортын мэдээлэл, олон улсын худалдааны тариф дээр үндэслэн дүн шинжилгээ хийнэ. Энэхүү судалгааг хийхэд БНХАУ-ын төрийн байгууллагуудаас гаргасан тайлан мэдээнүүдийг ашиглав.

Үүнд:

- БНХАУ-ын Үндэсний хөгжил шинэтгэлийн хороо
- БНХАУ-ын Үндэсний статистикийн газар
- БНХАУ-ын Эрчим хүчний комисс
- БНХАУ-ын Гаалийн ерөнхий газар
- ӨМӨЗО-ы Статистикийн газар

## 1. БНХАУ-ЫН ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, СТРАТЕГИ

Энэхүү бүлэгт БНХАУ-ын цахилгаан эрчим хүчний салбарын өнөөгийн нөхцөл байдал болон стратеги төлөвлөгөөг авч үзнэ. Тухайн салбарын нийт суурилагдсан хүчин чадал, үйлдвэрлэл, эрчим хүчний хэрэглээний бүтэц, нэг хүнд ногдох эрчим хүчний хэрэглээ, цахилгаан эрчим хүчний экспорт болон импортын тоон мэдээлэл гэх мэт чухал тоон үзүүлэлтийг дурдах болно.

### 1.1. Эрчим хүчний салбарын стратеги

БНХАУ нь Эрчим хүчний салбартаа дөрвөн хөгжлийн чиглэлийг тодорхойлсон бөгөөд ногоон хөгжил, шинэ эх үүсвэрүүдийн байршлыг оновчлох, цөмийн энергийн аюулгүй байдал болон нүүрснээс хийн түлш гарган авах сайжруулахад анхаарах аж. Бодлогын баримт бичгээс харахад БНХАУ нь эрчим хүчний анхдагч эх үүсвэрийн бүтцэдээ уламжлалт хатуу түлшний эзлэх хувийг багасгаж, экологи байгаль орчинд ээлтэй ногоон технологи түлхүү ашиглахаар тусгасан байна. Улсын хойд хэсэг болон далайн эргийн дагуу нар салхины эрчим хүчийг түлхүү ашиглахаар байна. Эрчим хүчний нөөц газар зүйн тэгш бус хуваарилалтыг арилгаж улс даяар ухаалаг эрчим хүчний систем байгуулах зорилт

дэвшүүлсэн бөгөөд үүнийгээ хэрэгжүүлэх зорилгоор 2001 оноос эхлэн улсын баруун хэсэгт үйлдвэрлэсэн эрчим хүчийг зүүн эрэгт дамжуулан хэрэглэх төсөл эхлүүлсэн. Энэ нь зүүн эргийн нутгаа экологийн сүйрлээс аварч баруун муж өөртөө засах нутгийн эдийн засгийг дэмжих зорилготой. БНХАУ-ын XIV 5 жилийн төлөвлөгөөнд шинэ үеийн эрчим хүчний тогтолцоог

Зураг 1 БНХАУ-ын XIV Таван жилийн төлөвлөгөөнд тусгасан цэвэр эрчим хүчний бүтээн байгуулалт



бий болгох зорилтын хүрээнд дараах зорилгуудыг дэвшүүлсэн байна.

Үүнд:

1. Цэвэр эрчим хүчний томоохон баазууд бий болгох;
  2. Эргийн дагуух атомын цахилгаан станц байгуулах;
  3. Цахилгаан дамжуулах сүлжээний бүтээн байгуулалт;
  4. Эрчим хүчний системийн зохицуулалт хийх;
- Газрын тос, хий хадгалах, тээвэрлэх хүчин чадлаа нэмэгдүүлэх.

## 1.2. Цахилгаан эрчим хүчний суурилагдсан хүчин чадал

БНХАУ нь цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлдэг бөгөөд эрчим хүчний салбарын цахилгаан эрчим хүчний 2019-2024 оны суурилагдсан хүчин чадлын хэмжээг эх үүсгэврийн төрлөөр Хүснэгт 1-д үзүүлэв.


**Хүснэгт 1** БНХАУ-ын эрчим хүчний системийн суурилагдсан хүчин чадал (2019-2024 он)

Д/д	Суурилагдсан хүчин чадал (ГВт)	2019	2020	2021	2022	2023	2024
1	Нийт	2,010.7	2,200.6	2,376.9	2,564.1	2,853.4	3,348.6
2	УЦС	356.4	370.2	390.9	413.5	421.3	436.0
3	ДЦС	1,190.6	1,245.2	1,296.8	1,332.4	1,378.8	1,444.5
4	АЦС	48.7	49.9	53.3	55.5	56.8	60.8
5	СЦС	210.1	281.5	328.5	365.4	412.8	520.7
6	НЦС	204.7	253.4	306.6	392.6	557.6	886.7
7	Бусад	0.2	0.4	0.9	4.6	26.0	0.1

Эх сурвалж: Эрчим хүчний комисс

2019 онд тус улсын цахилгаан эрчим хүчний системийн суурилагдсан хүчин чадал 2,010.7 ГВт байсан бол 2024 онд 3,348.6 ГВт болж өмнөх жилээс 14.6 хувиар өссөн үзүүлэлттэй гарсан. Сүүлийн таван жилийн хугацаанд

**График 1** БНХАУ-ын цахилгаан эрчим хүчний суурилагдсан хүчин чадлын жилийн өсөлт (2019-2024)




Эх сурвалж: Эрчим хүчний комисс

нарны цахилгаан станц (НЦС) болон салхин цахилгаан станц (СЦС) зэрэг сэргээгдэх эрчим хүчний чадлын хувь хэмжээ нийт системийн хувьд эзлэх хувь хэмжээ эрчимтэй нэмэгдсэн (График 1).

2024 онд нарны цахилгаан станц (НЦС)-ын суурилагдсан хүчин чадал 886.7 ГВт-д хүрсэн нь өмнөх оноос 45.2 хувиар нэмэгдэж, сүүлийн таван жилийн дундаж өсөлт жилийн 33.6 хувьд хүрсэн байна. Салхин цахилгаан станц (СЦС)-ын суурилагдсан хүчин чадал 520.7 ГВт-д хүрсэн нь өмнөх оноос 18 хувиар өсөж, сүүлийн таван жилийн дундаж өсөлт жилийн 19.6 хувьд хүрсэн байна. Эрчим хүчний системийн суурилагдсан хүчин чадлын 43 орчим хувийг уламжлалт ДЦС-ууд бүрдүүлж байна. Хатуу түлшээр ажилладаг ДЦС-уудад хөрөнгө оруулалт хийхгүй гэсэн боловч ДЦС-ын суурилагдсан хүчин чадал жилд дунджаар 4 хувиар өсөж, дотооддоо хөрөнгө оруулалт хийсээр байгаа нь харагдаж байна. 2024 оны нийт үйлдвэрлэлийн хүчин чадлын 43.1 хувийг (1444.4 ГВт) нүүрсэн, 13 хувийг (435.9 ГВт) усан, 26.5 хувь орчмыг (886.6 ГВт) нарны, 15.5 хувийг (520.7 ГВт) салхины эх үүсвэрээс хангасан байна. 1991 оноос АЦС нь түлшний бүтцийн нэг хэсэг болон орж ирсэн бөгөөд одоогийн байдлаар 2 хувийг (60.8 ГВт) эзэлж байна (График 2).

**График 2** Цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн эх үүсвэрийн бүтэц (2024 он)




Эх сурвалж: Эрчим хүчний комисс

Тус улсын цахилгаан эрчим хүчний системийн суурилагдсан хүчин чадал болон өсөлтийг 2013-2024 оны хооронд мөн авч үзэв. 2014 онд суурилагдсан хүчин чадал 1,370.2 ГВт байсан бөгөөд 2024 онд 1,978.4 ГВт-аар буюу 144 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Сүүлийн арван жилийн хугацаанд хамгийн бага өсөлттэй жил 2019 байсан бөгөөд үүнд БНХАУ-ын агаар хөрсний бохирдол хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд нөлөөлсөн. Ковид-19

цар тахал дэгдсэнээр 2021-2022 онуудад уг салбарын хөрөнгө оруулалт буурч суурилагдсан хүчин чадлын өсөлт удааширсан боловч 2024 онд цахилгаан эрчим хүчний салбарын суурилагдсан хүчин чадал огцом өссөн үзүүлэлттэй байна (График 3).

**График 3 БНХАУ-ын эрчим хүчний системийн суурилагдсан хүчин чадал болон жилийн өсөлтийн хувь (2013-2024 он)**



Эх сурвалж: Эрчим хүчний комисс

**Хүснэгт 2 Нэг хүнд ногдох цахилгаан эрчим хүчний хэрэглээ/ кВт.ц/хүн (2017-2024 он)**

2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024
4,721	5,098	5,318	5,5013	6,043	6,266	6,266	6,703

Эх сурвалж: Үндэсний статистикийн газар

Хятадын эрчим хүчний хэрэглээг нэг хүнд ноогдох цахилгаан эрчим хүчний индексийн мэдээллээр дүгнэн авч үзэх хэрэгтэй. Хөгжингүй орнууд болох АНУ-ын нэг хүнд ногдох цахилгааны жилийн хэрэглээ 12,000 кВт.ц/хүн орчим, Өмнөд Солонгос 11,000 кВт.ц/хүн байна. Харин Хятадын уг үзүүлэлт 2024 онд 6,703 кВт.ц/хүн байгааг Хүснэгт 2-с харж болно. Цаашид эдийн засгийн өсөлт тогтмол байх зэргээс үл хамаарах цахилгааны хэрэглээ өсөх хандлагатай байна.

### 1.3. Цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээний бүтэц

Мөн тус улсын эрчим хүчний системийн үйлдвэрлэлийн хэмжээ 2024 онд өмнөх оноос 6.7 хувиар өсөн 10,086,881 ГВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэжээ. Хүснэгт 3-д БНХАУ-ын цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн хэмжээг 2020 оноос 2024 он хүртэлх хугацааг хамруулан үзүүлэв.

**Хүснэгт 3 Цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн хэмжээ, хэрэглээ (2020 – 2024 он)**

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024
Цахилгаан үйлдвэрлэлийн хэмжээ (ГВт.ц)	7,779,060	8,534,248	8,848,712	9,456,442	10,086,881
Эх үүсвэр: ДЦС	5,330,248	5,805,868	5,888,795	6,265,740	6,374,260
УЦС	1,355,209	1,338,999	1,352,195	1,285,848	1,425,682
Бусад эх үүсвэр	1,093,603	1,389,381	1,607,722	1,904,854	2,286,939
Цахилгааны хэрэглээ (ГВт.ц)	7,762,017	8,520,010	8,835,762	9,224,100	-

Эх сурвалж: Эрчим хүчний комисс

Нүүрс болон усан цахилгаан станцууд тус улсын эрчим хүчний үйлдвэрлэлийн түлшний бүтцийн хамгийн том хоёр бүрэлдэхүүн хэсэг болохыг Хүснэгт 3-аас харж болно. XIII таван жилийн төлөвлөгөөний эдийн засгийг зүүнээс баруун зүгт шилжүүлж, өмнөд нутгийн усны эх үүсвэрийг хойд нутагт урсгах мега төслүүдийн бодлогын хүрээнд УЦС олноор ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй байна.

2023 оны жилийн эцсийн байдлаар БНХАУ-ын цэнэг хураагуурын суурилагдсан хүчин чадал 31,100 МВт-д хүрч өмнөх оноос 260 хувиар өссөн байна. Шинэ эрчим хүчний үүсвэртэй цэнэг хураагуурын суурилагдсан хүчин чадлын хэмжээгээр Гуандун муж, Өвөр Монголын Өөртөө Засах Орон (ӨМӨЗО), Шинжан Уйгарын Өөртөө Засах Орон (ШУӨЗО) тэргүүлж байгаа бөгөөд 2023 онд тус бүр 8, 7, 9 сая кВт.ц эрчим хүч үйлдвэрлэсэн байна. Шинэ эрчим хүчний эх үүсвэртэй цэнэг хураагуурыг төрлөөр авч үзэхэд 97.4 хувийг литиум батарей эзэлж байна.

**Хүснэгт 4 Шинэ эрчим хүчний эх үүсвэртэй цэнэг хураагуурын хэмжээгээр тэргүүлэх мужууд (2023 он)**

№	Мужууд	Суурилагдсан хүчин чадал МВт	Үйлдвэрлэсэн эрчим хүч сая кВт.ц
1	Гуандун	3,980	8.02
2	ӨМӨЗО	3,540	7.1
3	ШУӨЗО	3,090	9.52
4	Ганьсу	2,930	6.73
5	Хунан	2,660	5.31

Эрчим хүчний комиссын 2023 оны жилийн эцсийн тайлан

2018 - 2022 онуудын цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээ, экспорт, болон импортын хэмжээний тэнцэл, цахилгаан дамжуулалт, түгээлтийн алдагдлын дэлгэрэнгүй мэдээллийг Хүснэгт 5 - д үзүүлэв. 2022 онд БНХАУ нийт 8,848,712 ГВт.ц цахилгаан эрчим хүч



**График 4 Шинэ эрчим хүчний эх үүсвэртэй цэнэг хураагуурын төрөл (2023 он)**



Эрчим хүчний комиссын 2023 оны жилийн эцсийн тайлан

Үйлдвэрлэсэн бөгөөд үйлдвэрлэсэн хэмжээг эх үүсвэрээр нь харахад 66.5 хувийг (5,888.8 ТВт.ц) дулааны цахилгаан станцаас, 15.3 хувийг (1352.0 ТВт.ц) усан цахилгаан станцаас, 8.6 хувийг (762.7 ТВт.ц) салхин цахилгаан станцаас, 4.7 хувийг (414.2 ТВт.ц) нарны цахилгаан станцаас, 4.7 хувийг (417.8 ТВт.ц) атомын цахилгаан

станцаас үйлдвэрлэсэн байна. Мөн 2022 онд 7,100 ГВт.ц цахилгаан эрчим хүчийг импортоор авч, 20,100 ГВт.ц цахилгаан эрчим хүчийг экспортолсон байна.

Нийт цахилгаан эрчим хүчний хэрэглээний хэмжээг нийт үйлдвэрлэлийг хэмжээ дээр импортоор авсан хэмжээг нэмж, экспортын хэмжээг хасаж тооцдог. 2022 оны цахилгаан эрчим хүчний хэрэглээний нийт хэмжээг цахилгаан эрчим хүч ашигласан эдийн засгийн салбараар харахад үйлдвэрлэлийн салбар 65 хувийг (5,741.2 ТВт.ц), өрхийн цахилгаан хэрэглээ 15.8 хувийг (1,393.6 ТВт.ц), бөөний болон жижиглэнгийн худалдаа, орон сууц, нийтийн хоолны үйлдвэрлэлийн салбар 4.6 хувийг (404.3 ТВт.ц), тээвэр, агуулах, шуудангийн үйлдвэрлэлийн салбар 2.3 хувийг (204.1 ТВт.ц), бусад салбарууд 10 хувийг (883.6 ТВт.ц) тус тус эзэлж байна.

БНХАУ-ын цахилгаан эрчим хүч үйлдвэрлэлтийн хэмжээ сүүлийн таван жил тогтмол өссөний зэрэгцээ цахилгаан дамжуулалт, түгээлтийн алдагдлын хувь хэмжээ буурсан байна. 2022 оны статистик мэдээллээр дамжуулалт, түгээлтийн алдагдал 306,300 ГВт.ц-т хүрч нийт үйлдвэрлэсэн цахилгааны эрчим хүчний 3.5 хувьд хүрсэн ч цахилгаан дамжуулалт, түгээлтийн алдагдлын хувь 2018 онд 4.7 хувьтай байжээ.

**Хүснэгт 5 БНХАУ-ын цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээ, экспорт, болон импортын хэмжээний тэнцэл, дамжуулалт ба түгээлтийн алдагдал (2017-2022 он)**

Д/д	Цахилгаан эрчим хүч (ГВт.ц)	2018	2019	2020	2021	2022
1	Цахилгаан үйлдвэрлэл	7,166,130	7,503,430	7,779,060	8,534,250	8,848,712
2	Усан цахилгаан станцаас үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүч	1,231,790	1,304,440	1,355,210	1,339,000	1,352,212
3	Дулааны цахилгаан станцаас үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүч	5,096,320	5,220,150	5,330,250	5,805,870	5,888,800
4	Атомын цахилгаан станцаас үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүч	294,360	348,350	366,250	407,520	417,800
5	Салхин цахилгаан станцаас үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүч	365,970	406,030	466,470	656,100	762,700
6	Нарны цахилгаан станцаас үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүч	576,670	207,670	243,840	311,520	414,200
7	Цахилгаан эрчим хүчний импортын хэмжээ	5,690	4,860	4,750	5,940	7,100
8	Цахилгаан эрчим хүчний экспортын хэмжээ	20,910	21,650	21,790	20,180	20,100
<b>Нийт цахилгааны хэрэглээ = Нийт үйлдвэрлэл + импорт - экспорт</b>		<b>7,150,820</b>	<b>7,486,610</b>	<b>7,762,020</b>	<b>8,520,010</b>	<b>8,835,800</b>
1	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, мал аж ахуй, загасны аж ахуйн салбар	124,250	133,620	142,210	159,650	175,700
2	Үйлдвэрийн салбар	4,909,490	5,069,830	5,235,340	5,662,230	5,741,200
3	Барилгын салбар	88,780	99,120	101,110	113,290	109,100
4	Тээвэр, агуулах, шуудангийн үйлдвэрлэл	160,850	175,230	175,100	199,300	204,100
5	Бөөний болон жижиглэнгийн худалдаа, орон байр, нийтийн хоолны үйлдвэрлэл	290,040	318,710	316,900	386,960	404,300
6	Бусад салбарын цахилгаан хэрэглээ	571,650	626,380	651,700	770,680	807,700
7	Ахуйн цахилгаан эрчим хүчний хэрэглээ	1,005,760	1,063,720	1,139,650	1,227,890	1,393,600
8	Цахилгаан дамжуулалт, түгээлтийн алдагдал	335,170	333,010	323,350	325,610	306,300

Эх сурвалж: Үндэсний статистикийн газар

## 1.4. Мужуудын цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээ, бие даах чадварын зэрэг

2024 онд цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлт болон дамжуулалтаар Хятадын 31 муж, өөртөө засах орнуудаас тэргүүлж буй таван бүс нь ӨвөрМонголын Өөртөө Засах Орон (ӨМӨЗО), Гуандун, Жянсу, Шаньдун, мужууд, Шинжан Уйгарын Өөртөө Засах Орон (ШУӨЗО) байв. 2023 оны статистик тоо мэдээллээр, цахилгаан эрчим хүчний хэрэглээгээр Гуандун, Шаньдун, Жянсу, Хэбэй мужууд, ӨМӨЗО тэргүүлж байна.

### Хүснэгт 6

Цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлт болон дамжуулалтын хэмжээгээр тэргүүлэх мужууд /2024 он/

	Мужууд	ГВт.ц
1	ӨМӨЗО	834,400
2	Гуандун	735,451
3	Жянсу	680,737
4	Шаньдун	677,325
5	ШУӨЗО	547,802

### Хүснэгт 7

Цахилгаан эрчим хүчний хэрэглээний хэмжээгээр тэргүүлэх мужууд /2023 он/

	Мужууд	ГВт.ц
1	Гуандун	850,200
2	Шаньдун	796,600
3	Жянсу	783,300
4	Хэбэй	475,700
5	ӨМӨЗО	482,300


Эх сурвалж: Үндэсний статистикийн газар

Хятадын мужуудын цахилгаан эрчим хүчээр өөрийгөө хангах, бие даах чадварын зэргийг 2023 оны эхний хагасын байдлаар авч үзье. Уг зэргийг мужийн нийт үйлдвэрлэсэн болон хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний тоо хэмжээгээр тооцдог.

$$\text{Мужийн зэрэглэл} = \frac{\text{Нийт үйлдвэрлэл}}{\text{Нийт хэрэглээ}} \times 100\%$$

БНХАУ-ын өөртөө засах орон, мужуудын цахилгаан эрчим хүчээр өөрийгөө хангах, бие даах чадварын зэргийг Зураг 1 - д үзүүлэв. Юньнань мужийн цахилгаан эрчим хүчээр өөрийгөө хангах зэрэг улсын хэмжээнд хамгийн өндөр буюу 181.5%, удаах Нинся 181.3%, Өвөрмонгол 149% байна. Бээжин хот цахилгаан эрчим хүчээр өөрийгөө хангах зэрэг хамгийн бага буюу 40.1%, түүний дараагаар Шанхай хот 54.7%-тай бичигдэж байна. Үүнээс харахад, дөрвөн томоохон хотын бие даах чадварын зэрэг бүгд харьцангуй доогуур, мөн Жэян, Гуандун, Жянсу, Шаньдун зэрэг эдийн засгийн өндөр хөгжилтэй мужууд дангаараа хангалттай хэмжээний цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж чадахгүй, бусад мужуудаас цахилгаан эрчим хүч авдаг байна.

## Зураг 2 БНХАУ-ын өөртөө засах орон, мужуудын цахилгаан эрчим хүчний бие даах чадварын зэрэг




Эх сурвалж: Baidu


## 1.5. Цахилгаан эрчим хүчний экспорт, импортын хэмжээ, тариф

2023 онд БНХАУ-аас нийт 22,104 ГВт.ц цахилгаан эрчим хүчийг долоон улс руу экспортолсон ба цахилгаан эрчим хүчний экспортын орлого 1.7 тэрбум ам.долларт хүрсэн байна. Үүнээс хамгийн их хэмжээгээр 12,204 ГВт.ц цахилгаан эрчим хүчийг Хонг Конг улс руу, 5,290 ГВт.ц цахилгаан эрчим хүчийг Макао улс руу экспортолсон. Манай улс 2023 онд БНХАУ-аас 1,525.7 ГВт.ц цахилгаан эрчим хүчийг 132.1 сая ам.доллороор худалдан авсан байна. БНХАУ-аас цахилгаан эрчим хүч худалдаж авдаг улс орнууд дунджаар 1 квт/ц цахилгаан эрчим хүчийг 8.1 центээр худалдаж авдаг бол манай улс 1 квт/ц цахилгаан эрчим хүчийг 8.7 центээр худалдаж авдаг байна

## График 5 БНХАУ-ын цахилгаан эрчим хүчний экспортын хэмжээ /2023 он/




**График 6** БНХАУ-ын цахилгаан эрчим хүчний экспортын орлого /2023 он/



Эх сурвалж: Гаалийн статистик

2023 онд БНХАУ нь Хонгконг, Хойд Солонгос, Лаос, Мьянмар, ОХУ зэрэг таван улсаас 5018 ГВт.ц цахилгаан эрчим хүчийг 197 сая ам.доллаароор худалдан авсан. Үүнээс ОХУ-аас хамгийн их хэмжээгээр буюу 3262 ГВт.ц цахилгаан эрчим хүчийг 1 квт/ц 4.4 центээр худалдаж авсан байна. Харин Лаос улсаас нэгж үнэ хамгийн их буюу 1 квт/ц цахилгаан эрчим хүчийг 6.8 центээр, харин Мьянмар улсаас нэгж үнэ хамгийн хямд буюу 1 квт/ц цахилгаан эрчим хүчийг 2.5 центээр худалдаж авдаг байна.

**График 7** БНХАУ-ын цахилгаан эрчим хүчний экспортын хэмжээ /2023 он/



**График 8** БНХАУ-ын цахилгаан эрчим хүчний импортын орлого /2023 он/



Эх сурвалж: Гаалийн статистик

БНХАУ-аас экспортолж буй 271600 БТКУС кодтой цахилгаан эрчим хүчинд ногдуулж буй импорт гаалийн тарифын шинэчлэгдсэн мэдээллийг Хүснэгт 8-д харьцуулан харуулав. Эдгээр цахилгаан эрчим хүч худалдан авч буй бүх орнууд Дэлхийн худалдааны байгууллагын гишүүд орон бөгөөд талууд хоорондоо таатай нөхцөлөөр (Most favored nation) худалдаа хийдэг байна. Хонгконг, Макао, Мьянмар зэрэг улсууд Хятад улсаас цахилгаан эрчим хүч худалдан авахад импортын тариф төлөхгүй байдлаар талууд хоорондоо гэрээ хийжээ. Хойд Солонгос, Лаос, Монгол зэрэг улсууд анхлан Хятад улсаас цахилгаан эрчим хүч худалдан авахад 5 хувийн импортын тариф төлөх гэрээ байгуулсан боловч Хойд Солонгос, Лаос зэрэг улс Хятад улстай чөлөөт худалдааны хэлэлцээр, хөнгөлөлттэй тарифын хэлэлцээр байгуулан импортын тарифын хэмжээг тэг болгосон байна. Вьетнам улс мөн 1 хувийн импортын тариф батлан хөнгөлттэй тариф эдэлснээр цахилгаан эрчим хүчний экспортод импортын тариф төлдөггүй юм байна.

**Хүснэгт 8** БНХАУ-аас экспортолж буй 271600 БТКУС кодтой цахилгаан эрчим хүчинд ногдуулж буй импорт гаалийн тариф

Улс орон	MFN	Тогтоосон импортын тариф	Ad Valorem Equivalent	Хөнгөлөлттэй тариф	Одоо мөрдөгдөж буй тариф	Шинэчлэгдсэн огноо
Хонгконг	+	0%	0%		0%	2022
Хойд Солонгос	+	5%	5%	Хөнгөлөлттэй тариф	0%	2022
Лаос	+	5%		Хөнгөлөлттэй тариф	0%	2021
Макао	+	0%	0%		0%	2022
Монгол	+	5%	5%		5%	2017
Мьянмар	+	0%			0%	2017
Вьетнам	+	1%	1%	Хөнгөлөлттэй тариф	0%	2022

Эх сурвалж: Market access map

БНХАУ-ын худалдан авч буй 271600 БТКУС кодтой цахилгаан эрчим хүчний импортод бусад улс орнуудын ногдуулж буй гаалийн тарифын шинэчлэгдсэн мэдээллийг Хүснэгт 9 – д харьцуулан харуулав. Дэлхийн худалдааны байгууллагын гишүүд орон учир талууд

хоорондоо таатай нөхцөлөөр (Most favored nation) худалдаа хийдэг байна. Хоёр орны хооронд байгуулсан худалдааны гэрээний дагуу Хятад улс цахилгаан эрчим хүч худалдан авахдаа бусад улсад гаалийн татвар төлдөггүй байна.

**Хүснэгт 9 БНХАУ-ын худалдан авч буй 271600 БТКУС кодтой цахилгаан эрчим хүчний импортод бусад улс орнуудын ногдуулж буй гаалийн тарифын мэдээлэл**

Улс орон	MFN	Тогтоосон импортын тариф	Ad Valerum Equivalent	Хөнгөлөлттэй тариф	Одоо мөрдөгдөж буй тариф	Шинэчлэгдсэн огноо
Хонконг	+	0%	0%		0%	2022
Хойд Солонгос	+	0%	0%		0%	2022
Лаос	+	0%	0%		0%	2022
Мьянмар	+	0%	0%		0%	2022
ОХУ	+	0%	0%		0%	2022
Мьянмар	+	0%			0%	2017
Вьетнам	+	1%	1%	Хөнгөлөлттэй тариф	0%	2022

Эх сурвалж: Market access map

## 2. ӨМӨЗО-НЫ ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАР

### 2.1. Товч танилцуулга

ӨвөрМонголын цахилгаан эрчим хүч (Inner Mongolia Grid) компани нь 1991 онд байгуулагдсан, ӨМӨЗО-ны засгийн газрын шууд харьяалалд хамаардаг цахилгаан эрчим хүчний аж ахуй нэгж бөгөөд 36 нэгж салбартай, 36,000 ажилтантай. Тус компани нь “ӨвөрМонголын баруун цахилгаан шугам сүлжээ компани Мэнгши” компаниар үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлтийн үйл ажиллагааг явуулдаг. Мэнгши компани нь өөртөө засах орны баруун бүсийн Хөххот, Бугат, Баяннуур, Ухай, Ордос, Зүүнгар, Алшаа, Улаанцав, Шилийн гол зэрэг нутгуудын цахилгаан эрчим хүчний хангамж, үйлдвэрлэлийг хариуцан ажилладаг. ӨМӨЗО-ны баруун хэсгийн 6000 кВт-аас дээш хүчин чадалтай эрчим хүч үйлдвэрлэх төхөөрөмжийн суурилагдсан хүчин чадал 126.8 ГВт, цахилгаан үйлдвэрлэх хүчин чадал 496.6 тэрбум кВт.ц байв. Үүнээс үзвэл, ӨМӨЗО-ны нийт суурилагдсан хүчин чадал болон үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчний 75 орчим хувийн баруун бүс нутагт (Хөххот, Бугат, Баяннуур, Ухай, Ордос) үйлдвэрлэжээ. Мөн баруун хэсэг оргил ачааллын үед 40.3 сая КВ.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх чадамжтай. Зураг 3-д ӨвөрМонголын Өөртөө Засах Орны цахилгаан дамжуулах сүлжээний бүтцийг харуулж байгаа бөгөөд зурагт үзүүлж буй цайвар ногоон хэсгийг МэнгШи компани хариуцдаг, тод ногоон хэсгийг МэнгДунг компани хариуцдаг бүс нутаг юм.

**Зураг 3 ӨвөрМонголын Өөртөө Засах Орны цахилгаан шугам сүлжээ**



Эх сурвалж: Baidu

ӨвөрМонголын зүүн бүсийн цахилгаан эрчим хүчний МэнгДунг компани нь Төрийн цахилгаан сүлжээ корпорац (State Grid)-ын мэдэлд байдаг ба 2009 онд байгуулагдсан. МэнгДунг нь нутгийн зүүн хэсэг болох Хөлөнбуйр, Хянган, Байшинт, Улаанхад аймгуудын нутагт үйл ажиллагаа явуулдаг байна. Харин өөртөө засах орны зүүн бүсийн эрчим хүч үйлдвэрлэх

тоног төхөөрөмжийн суурилагдсан хүчин чадал 41.2 ГВт, цахилгаан үйлдвэрлэх хүчин чадал 149.2 тэрбум кВт.ц-д хүрч байв. Мөн оргил ачааллын үед 8.3 сая КВ.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх чадамжтай.

**Зураг 4** ӨвөрМонгол өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамууд



Эх сурвалж: Baidu

ӨМӨЗО-ны баруун бүсийн эрчим хүчний сүлжээ нь “гурван хэвтээ, дөрвөн босоо” 500кВ-ын, зүүн бүсийн сүлжээ нь “таван хэвтээ, нэг босоо” 500кВ-ын үндсэн цахилгаан дамжуулах агаарын шугамуудаар системийнхээ үндсэн бүтцийг бүрдүүлдэг. Эдгээр хоёр компани нь хэт өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамаар нар, салхины эх үүсвэрээр үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчээ Бээжин, Тяньжин хотууд, Хэбэй, Шаньси, Шандун мужууд руу дамжуулдаг. Зураг 4 – д ӨМӨЗО-ны хэт өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамуудыг үзүүлэв.

## 2.2. ӨМӨЗО-ны эрчим хүчний салбарын стратеги, хөгжлийн зорилт

XIII 5 жилийн төлөвлөгөөний жилүүдэд буюу 2016-2020 оны үед цахилгаан эрчим хүчний өсөлтийн хурд төлөвлөж байснаас давж хэрэглээний бодит өсөлт жилд 8.9%-д хүрч хангамж, нийлүүлэлтийн хангалтгүй байдал үүссэн. Энэ нь нүүрсээр ажиллах цахилгаан станцын ашиглалтад орох хугацааг төрөөс хатуу хянасантай холбоотой. ӨМӨЗО-ны баруун бүсийн цахилгаан эрчим хүчний жилийн дундаж өсөлт 6%-д хүрч 2025 он гэхэд тус

бүсэд цахилгаан эрчим хүчний ачаалал ойролцоогоор 47.5 сая кВт болно гэж тооцоолжээ.

ӨМӨЗО нь Хятад улсын эрчим хүч дамжуулах үйлдвэрлэх хамгийн том бааз бөгөөд цэвэр эрчим хүчний нөөцөөр баялаг. Салхи, нарны эрчим хүч болон бусад технологиудыг хөгжүүлэх хүчин чадал нь 6 тэрбум кВт-с давсан бөгөөд Хятадын зүүн хойд, хойд, төв хэсгийн эрчим хүчний аюулгүй байдлыг хангах чухал үүрэг хариуцлагатай бүс нутаг гэж өөрсдийгөө үзэж байна. 2030 он гэхэд тус өөртөө засах орон эрчим хүчний шинэ системийн бүтээн байгуулалтад ихээхэн ахиц дэвшилт гаргаж суурилагдсан хүчин чадал 300 ГВт-аас давуулах ба нар, салхи болон бусад сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийг эрчим хүчний гол эх үүсвэр болгон хөгжүүлнэ.

ӨМӨЗО-ны XIV 5 жилийн төлөвлөгөөнд (2021-2025 он) системийн суурилагдсан хүчин чадлыг 271 ГВт хүртэл нэмэгдүүлэх (2022 онд 168.1 ГВт) ба үүнээс нүүрсээр ажилладаг цахилгаан станцын чадлыг 133 ГВт болгоно. 2025 он гэхэд шинэ, сэргээгдэх эрчим хүчний суурилагдсан хүчин чадал 135 ГВт-д хүргэх бөгөөд үүний 89 ГВт нь салхи, 45 ГВт нь нар, 0.6 ГВт нарны ДЦС, 0.8 ГВт биомассын ДЦС болгоно. Ингэснээр нүүрсхүчлийн хийн ялгаруулалтыг 2030 оноос өмнө жил бүр 200 сая тонноор бууруулж чадна. Бүс нутгийн буюу бусад мужуудад түгээсэн цахилгаан эрчим хүчний хэмжээ 78 ГВт-д хүрсэн бөгөөд үүний 50%-г шинэ, сэргээгдэх эрчим хүчээр бүрдүүлэхийг зорьж байна. Мөн цахилгаан түгээх шугамын алдагдлыг 3.5%-с доош байлгана. Тус мужийн одоогийн нэг хүнд ногдох цахилгаан эрчим хүчний хэрэглээ 555 кВт.ц байгаа бөгөөд үүнийг нэмэгдүүлж 900 кВт.ц болгох, мөн 40 орчин мянган цэнэглэх станцуудыг барьж байгуулахыг зорьж байна. Дунд болон урт хугацаанд спот гүйлгээг нэмэгдүүлэх эрчим хүчний зах зээлийн загварыг бий болгох мөн 2025 он гэхэд нийт цахилгаан эрчим хүчний хэрэглээний 50%-г ахуйн хэрэглээнд төвлөрүүлэхийг зорьж байна.

Өөртөө засах орон нь Хятад улсын эрчим хүч дамжуулах үйлдвэрлэх хамгийн том бааз бөгөөд цэвэр эрчим хүчний нөөцөөр баялаг. Салхи, нарны эрчим хүч болон бусад технологиудыг хөгжүүлэх хүчин чадал нь 6 тэрбум кВт-с давсан бөгөөд зүүн хойд Хятад, зүүн Хятад, зүүн Хятад, төв Хятад, өмнөд Хятадын эрчим хүчний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг хариуцлагатай бүс нутаг гэж өөрсдийгөө үзэж байна. 2030 он гэхэд тус өөртөө засах орон эрчим хүчний шинэ системийн бүтээн байгуулалтад ихээхэн ахиц дэвшилт гаргаж суурилагдсан хүчин чадал 300 ГВт-аас давуулах ба салхи, нар болон бусад сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийг эрчим хүчний гол эх үүсвэр болгон хөгжүүлнэ. Үүнээс шинэ, сэргээгдэх эрчим хүчний суурилагдсан хүчин чадал 2025 он гэхэд 150 ГВт, 2030

**Хүснэгт 10** ӨМӨЗО-ны XIV 5 жилийн төлөвлөгөөнд тусгасан эрчим хүчний салбарын зарим зорилтууд

	Үзүүлэлт	Нэгж	2020	2025	Өсөлтийн хувь
<b>Ханган нийлүүлэлт</b>	Эрчим хүч үйлдвэрлэх цогц хүчин чадал	100 сая тонн стандартын нүүрс	7.68	8.18	1.3%
	Нүүрсний үйлдвэрлэл	тэрбум тонн	10	10.5	1%
	Түүхий газрын тосны үйлдвэрлэл	арван мянган тонн	119	123	0.7%
	Байгалийн хийн үйлдвэрлэл	100 сая шоо метр	277	333	3.8%
	Цахилгааны суурилагдсан хүчин чадал	тэрбум квт.ц	1.46	2.71	13.2%
<b>Хэрэглээ</b>	Нийт цахилгааны хэрэглээ	тэрбум квт.ц	3900	5220	6%
<b>Бүтэц</b>	Чулуужсан бус эрчим хүчний хэрэглээний эзлэх хувь	%	11.2	>18	[>6.8]
	Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээний эзлэх хувь	%	21.1	35	[13.9]
	Чулуужсан бус эрчим хүчний суурилагдсан хүчин чадлын эзлэх хувь	%	36.1	>50	[>13.9]
	Чулуужсан бус эрчим хүчний үйлдвэрлэлийн эзлэх хувь	%	17.3	30	[12.7]

он гэхэл 300 ГВт-д хүрэхээр, сэргээгдэх эх үүсвэрээр үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүч 2025 он гэхэд 300 ГВт, 2030 он гэхэд 600 ГВт-д хүрэхээр төлөвлөсөн байна.

Мөн сэргээгдэх эх үүсвэрээр үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчний бусад муж руу хийх дамжуулалт 2025 он гэхэд 100 ГВт, 2030 он гэхэд 300 ГВт-д хүрэхээр зорилт тавьжээ.

	Нүүрсний хэрэглээний эзлэх хувь	%	82	74.1	[-7.9]
	Цахилгаан эрчим хүчний терминалын хэрэглээний эзлэх хувь	%	28	32	[4]
<b>Үр ашиг</b>	CO2 ялгаруулалт багассан байдал	%	-	-	Улсын зорилгод хүрэх
	Нүүрснээс эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах нэгж нүүрсний хэрэглээ	грамм стандарт нүүрс	321	305	[-16]
<b>Инноваци</b>	Эрчим хүчний хөрөнгө оруулалтанд R&D-н эзлэх хувь	%	0.9	1.5	[0.6]
<b>Иргэдийн амьдрал</b>	Нэг хүнд ногдох цахилгаан эрчим хүчний хэрэглээ	кВт.ц/хүн	555	900	10.2%
	Байгалийн хий дамжуулах хоолойн эзлэх хувь (хошуу мужууд)	%	38	66	[28]
	Цэвэр эх үүсвэртэй халаалтын эзлэх хувь	%	-	80	-

**Хүснэгт 11** ӨМӨЗО-ны сэргээгдэх эрчим хүчний зорилтууд

Зорилтууд	2025 он	2030 он
Сэргээгдэх эрчим хүчний суурилагдсан хүчин чадал	150 ГВт	300 ГВт
Сэргээгдэх эх үүсвэрээр үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүч	300 ГВт.ц	600 ГВт.ц
Сэргээгдэх эх үүсвэрээр үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчний бусад муж руу хийх дамжуулалт	100 ГВт.ц	200 ГВт.ц

**2.3. ӨМӨЗО-ны цахилгаан эрчим хүчний суурилагдсан хүчин чадал, хэрэглээний бүтэц**

2018-2023 оны байдлаар ӨМӨЗО-ны эрчим хүчний системийн 6000 кВт-аас дээш суурилагдсан хүчин чадлыг Хүснэгт 12-д үзүүлэв. Суурилагдсан хүчин чадал 2018 онд 123 ГВт байснаас 2023 онд 214.3 ГВт болон өссөн. Мөн сан цэнэгт цахилгаан станц, хуримтлуурын төслүүд идэвхтэй өрнөж 2.29 ГВт батарей хуримтлуурын төсөл хэрэгжүүлжээ. Харин энэ хугацаанд усан цахилгаан станцын хүчин чадлыг нэмэгдүүлээгүй байна.


Нийт суурилагдсан хүчин чадлын 55.1 хувийг Дулааны цахилгаан станц, 32.4 хувийг салхин цахилгаан станц, 10.2 хувийг нарны станц, 1.1 хувийг усан цахилгаан станц, 1.1 хувийг бусад эх үүсвэрүүд тус тус эзэлж байна. ӨМӨЗО-ны Статистикийн хорооноос гаргадаг тоон мэдээллээс үзэхэд, 2023 онд нийт 762,990 ГВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэсэн бөгөөд үүний 77.9 хувийг (594,010 ГВт.ц) дулааны цахилгаан станцаас, 17.8 хувийг (135,460 ГВт.ц) салхин цахилгаан станцаас, 3.8 хувийг (29,050 ГВт.ц) нарны цахилгаан станцаас, 0.6 хувийг (4,470 ГВт.ц) нарны цахилгаан станцаас тус тус үйлдвэрлэн авсан байна.



**Хүснэгт 11** Хүснэгт 12. ӨМӨЗО-ны цахилгаан эрчим хүчний суурилагдсан хүчин чадал (2018-2023 он)

№	Ангилал	2018	2019	2020	2021	2022	2023
1	Суурилагдсан хүчин чадал (ГВт)	123	130.13	145.87	154.03	168.11	214.3
2	УЦС	2.38	2.38	2.38	2.38	2.38	2.38
3	УУЦС					1.18	
4	ДЦС		87.18	93.88	98.28	104.96	118.2
5	АЦС						-
6	СЦС	28.68	30.06	37.85	39.93	45.64	69.54
7	НЦС		10.5	11.76	13.41	14.78	21.9
8	Бусад (Биомасс, хуримтлуур гэх мэт)					0.35	2.29

**График 9** ӨМӨЗО-ы цахилгаан эрчим хүчний дотоодын хэрэглээ болон дамжуулалт (2023 он)



Хүснэгт 7 дээр дурдсанчлан, ӨМӨЗО дангаараа 2023 онд 482,300 ГВт.ц цахилгаан эрчим хүч дотооддоо хэрэглэсэн бол нийт үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчний 40 гаруй хувь буюу 280,690 ГВт.ц эрчим хүчийг зэргэлдээ мужуудад дамжуулсан. Эдгээр дамжуулсан цахилгаан эрчим хүчийг хүрсэн бүсээр харахад Хойд Хятад 63%, Зүүн Хойд 31%, Зүүн Хятад 4%, Баруун Хойд 1%, Монгол улс руу 1%-г тус тус түгээжээ.

## Дүгнэлт

- БНХАУ-ын цахилгаан эрчим хүчний салбарын үйлдвэрлэл болон суурилагдсан хүчин чадлын хэмжээ жилд ойролцоогоор 10-11 хувийн өсөлттэй байна. Уламжлалт хатуу түлшээр ажиллах дулааны цахилгаан станцад хөрөнгө оруулахгүй тухай мэдэгдсэн боловч дотооддоо шинэ төслүүд хэрэгжүүлсээр байна.
- Хятадын мужуудын цахилгаан эрчим хүчээр өөрийгөө хангах, бие даах чадварын зэргийг авч үзвэл нутгийн зүүн болон зүүн өмнөд мужуудад эрчим хүчний хэрэглээ өндөр боловч бусад бүсүүдээс ялангуяа Шинжаны, ӨМӨЗО зэрэг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр үйлдвэрлэсэн цахилгаанаас авч хэрэглэх нь өссөөр байна.
- ӨМӨЗО-ны цахилгаан эрчим хүчний салбарын тоон мэдээлэл, стратеги төлөвлөлтийн хувьд шинэ, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр үйлдвэрлэсэн цахилгаанаа Хятадын зүүн болон зүүн хойд мужууд руу хэт өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамаар түгээж байна. Усан болон усан цэнэгт, батарей хураагуурын төслүүд сүүлийн хоёр жил эрчимтэй хэрэгжиж байгаагаас гадна 2023 жилийн эцсийн байдлаар шинэ төрлийн энергийн эх үүсвэр болох устөрөгчийн төсөл хөтөлбөрүүдэд 1,322 тэрбум юанийн хөрөнгө оруулалт хийсэн байна. 2023 онд цахилгаан, дулаан үйлдвэрлэлт, ханган нийлүүлэлтийн судалгаа хөгжүүлэлт (R&D) -д 271 сая юань зарцуулсан байна.
- БНХАУ-ын Гансу мужид Говийн элсэн цөлд элс, давсны хуримтлууртай нарны цамхагт дулааны станцын “Dunhuang” төслийг хэрэгжүүлж хот суурин газрыг цахилгаан, дулаанаар хангаж байна. Dunhuang нарны цамхагт дулааны станц нь 100 МВт суурилагдсан хүчин чадалтай бөгөөд нэг өдөрт 2.3 сая кВт эрчим хүч үйлдвэрлэдэг. Уг төслийн барилга угсралтын ажил 2 жил үргэлжилсэн бөгөөд нийт хөрөнгө оруулалтад 400 сая ам.доллар зарцуулсан. Ийм төрлийн төслийг туршлагыг сайтар судалж манай улсын говийн бүсийн аймаг, сумуудад хэрэгжүүлэх бүрэн боломжтой юм.



# 05



## ЭСТОНИ УЛСЫН ЦАХИМ ЗАСАГЛАЛЫН ХӨГЖИЛ



### СУДЛААЧИЙН ҮГ



#### Лхагвагийн ДАВААЖАРГАЛ

/Эдийн засгийн  
ухааны доктор/

ЗАХИРАЛ

"Шинэ сэргэлт  
инновацийн хөтөлбөр"

Email: [davaajargal@nrpa.gov.mn](mailto:davaajargal@nrpa.gov.mn)

Утас: 70116838

Дижитал улс болох шийдвэрийг Эстони Улс нэг өдөр гаргасан ч, энэхүү зорилтыг хэрэгжүүлэх үйл явц нь тууштай, тасралтгүй өрнөж ирсэн байна. Тус улсын Засгийн газар дижитал шилжилтийг эхний ээлжид төрийн үйлчилгээний түвшинд эхлүүлж, дараа нь нийгмийн үйлчилгээ, бизнесийн орчинд хэрэгжүүлснээр өнөөгийн өндөр амжилтад хүрчээ.

Өнөөдөр Эстонийн иргэд төрийн үйлчилгээ авах, сургалтад хамрагдах, эмнэлгийн тусламж хүртэх зэрэг бүхий л нийгмийн үйлчилгээг цахимаар хялбархан авч, дижитал сэтгэлгээтэй шинэ үеийг төлөвшүүлж байна. Энэхүү шилжилтийн явцад тус улс алдаа оноог туулж, чухал сургамж авсан хэдий ч хамгийн гол нь "залгамж халаа"-тай, тасралтгүй үргэлжилсэн бодлоготой байж чаджээ.

Монгол Улсын хувьд Эстони Улсын зөвлөх үйлчилгээний дэмжлэгтэйгээр Улсын их хурлаас цахим хөгжлийг дэмжсэн дөрвөн хуулийг баталж, "ХУР" болон "ДАН" системүүдийг шинэчилсэн. Мөн төрийн үйлчилгээний нэгдсэн систем болох "E-Mongolia"-г амжилттай нэвтрүүлсэн ба түүний хамгийн сүүлийн 4.0 хувилбарт 1200 гаруй төрийн үйлчилгээ багтаад байна.

Цаашид Монгол Улсын "ХУР" мэдээлэл солилцооны системийг Эстонийн "X-Road" загварт нийцүүлэн сайжруулах, "Personal Government" буюу хувь хүнд чиглэсэн төрийн бодлогын үзэл баримтлалыг нутагшуулах, мөн их өгөгдөл, хиймэл оюун ухаан, шинжлэх ухаанд суурилсан өндөр технологийг хөгжүүлэх чиглэлээр судалгаа, шинжилгээг эрчимжүүлэх шаардлагатай. Үүний тулд төрийн зарим мэдээллийг ил тод, олон нийтэд нээлттэй болгох зэрэг ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.

# ЭСТОНИ УЛСЫН ЦАХИМ ЗАСАГЛАЛЫН ХӨГЖИЛ

## Эдийн засаг

Эстони Улс нь Скандинавын орнууд, ялангуяа Финланд, Шведтэй нягт харилцаатай бөгөөд 2004 онд Европын Холбоо болон НАТО-гийн гишүүн улс болсон. 1991 онд Зөвлөлт Холбоот Улс задрах үед тус улсын эдийн засаг 130 сая евротой тэнцэхүйц байсан. Харин 2024 онд дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 43.5 тэрбум ам доллар, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 31,855 ам.долларт хүржээ. Дотоодын нийт бүтээгдэхүүний 70 орчим хувийг үйлчилгээний салбар, 25 хувийг аж үйлдвэрлэл, 5 хувийг хөдөө, аж ахуй, уул уурхайн салбар тус тус бүрдүүлдэг. Үйлчилгээний салбарт нийт ажиллах хүчний 60 гаруй хувь ажилладаг ба мэдээллийн технологийн (IT) салбарын ажиллагсад нь дотоодын нийт бүтээгдэхүүний 10 гаруй хувийг бүрдүүлдэг байна.

Худалдааны гол түнш орнууд – Финланд, Швед, Латви, Герман улс, АНУ, Хятад. Гадаад худалдааны эргэлт 2024 онд 38.1 тэрбум евро, үүнээс экспорт 17.4 тэрбум евро, импорт 20.7 тэрбум евро байв. 2024 онд Эстони Улсын экспортын гол бүтээгдэхүүн нь харилцаа холбоо, холбооны хэрэгсэл (1.05 тэрбум евро), суудлын автомашин (828 сая евро), модон бүтээгдэхүүн (379 сая евро), угсармал барилга байгууламж (357 сая евро) байв. Импортын гол бүтээгдэхүүн суудлын автомашин (1.7 тэрбум евро), боловсруулсан газрын тосны бүтээгдэхүүн (983 сая евро), харилцаа холбооны хэрэгсэл (751 сая евро), эм, эмийн бүтээгдэхүүн (644 сая евро), цахилгаан (516 сая евро) байв.

Уул, уурхай, хөдөө аж ахуйн салбарууд дотоодын нийт бүтээгдэхүүний ердөө 1 хувийг тус бүр бүрдүүлдэг. Уул уурхайн хувьд гол төлөв шатдаг занар, шохойн чулуу, элс, хайрга зэрэг үйлдвэрийн ашигт малтмал олборлодог. Аж үйлдвэрийн тэргүүлэх салбарууд нь химийн үйлдвэрлэл, тоног төхөөрөмж, целлюлоз цаас, мод модны аж ахуй юм. Мөн НҮБ-ын Хүний хөгжлийн индексээр 0.899 үзүүлэлттэй буюу дэлхийн 193 орноос 31 дүгээр байранд эрэмбэлэгддэг.



## Цахим засаглалын хөгжил

Эстони улс нь хэдий 1.3 сая хүн амтай ч, өөрийн сул талаа давуу тал болгон хувиргаж цахим шилжилтээр дэлхийд тэргүүлдэг билээ. 1960-аад оноос нийслэл Таллин хот нь Зөвлөлт Холбоот Улсын Кибернетик (цахим аюулгүй байдал)-ийн хүрээлэн байгуулагдсан учир мэдээллийн технологийн хүний нөөцийг бэлтгэх суурь бааз аль хэдийн тавигдсан байв. 1994 онд Эстони Улсын Парламентын цахимжуулах бодлогын анхны төсөлд гарын үсэг зурсан бөгөөд 1990-ээд оны дундуур хэрэгжүүлсэн “Барын үсрэлт” төслийн үр дүнд мэдээллийн технологийн (IT) салбарыг эрчимтэй хөгжүүлж чадсан төдийгүй, цахим засаглалын хувьд Европ дахь хамгийн дэвшилтэт улс болж, эдийн засгийн тэргүүлэх салбараа болгосон. 2002, 2009 онуудад хоёр ч удаа тус бүр 100 мянган иргэнийг хамруулсан, интернэт, компьютерын хэрэглээнд сургах хөтөлбөр хэрэгжүүлсэн.

2000 оноос төрийн цахим үйлчилгээнүүдийг нэвтрүүлж эхэлсэн байна ба Засгийн газар E-Cabinet болж, цаасгүй хуралдаж, сайдууд холбогдох материалуудтай цахимаар танилцан, саналаа хаанаас л бол хаанаас илгээх болжээ. Засгийн газрын гишүүд хурал эхлэхээс өмнө материалуудтай танилцсан байдаг тул засгийн хурлын шийдвэрүүд 5-10 минутын дотор гардаг байна. E-Tax Board системийг мөн 2000 онд танилцуулж, хүмүүс татвараа цахимаар мэдүүлэх болжээ. Одоо энэ улсын татварын харилцааны 99 хувь нь цахимаар явж, хүмүүс татвараа 5 минутад мэдүүлж, татварын буцаалтаа 5 хоногт эргүүлж авдаг. Төрийн үйлчилгээ цахим хэлбэрт шилжсэнээр НӨАТ-ын мэдүүлэг бөглөхөд 68 минут зарцуулдаг байсан нь 7 минут, татварын тайланг 78 минут боловсруулдаг

1990

**MASS DIGITAL LITERACY TRAININGS****Цахим ур чадварыг нэмэгдүүлэх олон нийтийн сургалтууд**

Иргэдийнхээ цахим ур чадварыг дээшлүүлэх зорилгоор олон төрлийн хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлж ирсэн бөгөөд эдгээр нь бүх насны болон нийгмийн бүлгүүдийг хамарсан. Эдгээр хөтөлбөрүүд нь боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоог дэмжих үндсэн зорилготой байв.

**DIGITAL MINDED LEADERSHIP****Цахим сэтгэлгээтэй манлайлал**

Дижитал сэтгэлгээтэй манлайлал нь технологийн боломжийг бүрэн ашиглаж, төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, ил тод, үр дүнтэй болгоход чиглэсэн цогц хандлага юм.

**LEGISLATIVE FRAMEWORK****Эрх зүйн зохицуулалтын хүрээ**

Энэхүү бүтэц нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн салбаруудыг тусгаарлан, тэдгээрийн харилцан хяналт, тэнцвэрийг хангах зорилготой.

2000

**ID-CARD****Цахим үнэмлэх**

Иргэний үнэмлэх дээр суурилсан цахим таних системийг амжилттай хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг цахимжуулах, иргэдийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилготой.

**X-ROAD®**

Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын мэдээллийн системүүдийг аюулгүй, найдвартай, үр ашигтай холбох зорилготой нээлттэй эхийн программ хангамжийн шийдэл бөгөөд тус улсын цахим засаглалын гол тулгуур юм.

**DIGITAL SIGNATURE****Цахим гарын үсэг**

Энэхүү систем нь иргэд, оршин суугчид, цахим оршин суугчид (e-residents) болон байгууллагуудын хувьд хууль ёсны хүчинтэй, найдвартай, хялбар хэрэгсэл болж байна.

**ONLINE TAX DECLARATION****Цахим татварын тайлан**

Эстони Улс 2000 онд цахим татварын систем болох e-Tax Board-ийг нэвтрүүлсэн нь тухайн үедээ дэлхийд анхдагчдын нэг байв. Энэ системийн тусламжтайгаар иргэд татварын тайлангаа цахимаар, хурдан бөгөөд хялбар гаргах боломжтой болсон бөгөөд өнөөдөр Эстонийн оршин суугчдын 99% нь орлогоо цахимаар тайлагнадаг.

**I-VOTING****Сонгуулийн цахим санал хураалт**

Эстоничууд хотын захиргаа, үндэсний болон Европын парламентын сонгуульд цахим үнэмлэх эсвэл Mobile-ID SIM карт ашиглан онлайнор санал өгөх боломжтой. 2019 онд болсон сонгуулиар нийт сонгогчдын 46.7 хувь нь онлайнор санал өгсөн байна.

2010

**E-RESIDENCY****Цахим оршин суух эрх**

Эстони Улс 2014 онд дэлхийд анх удаа цахим оршин суугчийн (e-Residency) хөтөлбөрийг эхлүүлсэн бөгөөд энэ нь хилийн зааггүй, цахим нийгмийг бий болгох зорилготой юм. Энэхүү хөтөлбөр нь дэлхийн өнцөг булан бүрээс иргэдийг Эстонийн цахим орчинд нэгдэж, бизнес эрхлэх, төрийн үйлчилгээнд хандах боломжийг олгодог.

**DATA EMBASSY****Өгөгдлийн Элчин Сайдын Яам**

Эстони Улс 2017 онд Люксембургт дэлхийн анхны "Өгөгдлийн Элчин Сайдын Яам" (Data Embassy)-ыг байгуулсан нь улсынхаа мэдээллийн аюулгүй байдал, дижитал тасралтгүй байдлыг хангах зорилготой шинэлэг шийдэл юм. Энэхүү өгөгдлийн элчин сайдын яам нь уламжлалт дипломат төлөөлөгчийн газар биш бөгөөд харин Эстонийн засгийн газрын үүлэн дэх өргөтгөл бөгөөд улсын хилээс гадна байрлах серверийн нөөцүүдийг эзэмшдэг.



## KICK-OFF: PROACTIVE GOVERNMENT

### Идэвхтэй Засаглал

Шинэ төрлийн төрийн үйлчилгээний загварыг хэрэгжүүлж эхэлсэн нь иргэдийн амьдралын үйл явдлуудтай холбоотой төрийн үйлчилгээг автоматаар, иргэний оролцоогүйгээр хүргэх зорилготой.



## AI STRATEGY

### Хиймэл оюун ухааны стратеги

Засгийн газрын Тамгын газар болон Мэдээллийн технологийн албаны даргын (CIO) удирдлага дор мэргэжлийн ажлын багийг байгуулсан. Энэхүү ажлын баг 2019 оны тавдугаар сард үндэсний хиймэл оюун ухааны стратегийн талаар тайлан гаргасан бөгөөд уг тайланд төрийн байгууллагууд болон өргөн хүрээний эдийн засгийн салбаруудад хиймэл оюун ухааны шийдлүүдийг хэрхэн нэвтрүүлж, хөгжүүлэх талаар тусгасан болно.

2020



## PERSONAL GOVERNMENT

### Хувь хүний засаглал

Энэ нь иргэдийг олон байгууллагаар явж, өөрсдөө өргөдөл гаргах шаардлагагүй болгож, төрийн үйлчилгээг нэг цэгээс, нэг үйлдлээр авах боломжийг бүрдүүлдэг.



## 10 UNICORNS

Эстони Улс нь 10 "unicorn" буюу нэг тэрбум ам.доллараас дээш үнэлгээтэй гарааны компани төрүүлсэн бөгөөд энэ нь дэлхийд хүн амын тоонд харьцуулсан хамгийн өндөр үзүүлэлт юм. 1.4 сая хүн амтай Эстонид нэг "unicorn" компани 131,973 хүнд ногдож байна.



## 130+ PUBLIC SECTOR AI USE CASES

### 130+ Төрийн байгууллагуудын (AI) хэрэглээ

Эстони Улс нь 2019 оноос хойш төрийн байгууллагууддаа 130 гаруй хиймэл оюун ухааны (AI) төсөл амжилттай хэрэгжүүлж, дижитал засаглалын тэргүүлэгч орон болжээ. Эдгээр AI шийдлүүд нь төрийн үйлчилгээг илүү үр ашигтай, хүртээмжтэй, иргэдэд чиглэсэн болгоход чиглэгдсэн юм.



## 99% SERVICES ONLINE

### 99% цахим үйлчилгээ

Иргэдэд төрийн үйлчилгээг хэзээ ч, хаанаас ч авах боломжийг олгож, "0% бюрократ, 100% дижитал" уриатайгаар хэрэгжүүлж байна. иргэдэд чиглэсэн болгоход чиглэгдсэн юм.

байсан нь 10 минут болох зэргээр иргэд, төрийн байгууллагын үргүй хөдөлмөр, цаг зарцуулалтыг багасгаж, хүнд суртлыг арилгахад чухал нэмэр оруулсан байна.

2002 оноос иргэн бүр ID Card буюу цахим үнэмлэхтэй, үүний хамт иргэн бүр өөрийн гэсэн албан ёсны имэйлтэй болжээ. Энэ имэйлээр засгийн газраас мэдээлэл илгээнэ. 2002 онд Эстони E-Kool буюу цахим сургуулийн үйлчилгээ хэрэгжиж эхэлсэн нь цахим хэрэглээг эрс нэмэгдүүлсэн биз. Сурагчид,

эцэг эхчүүд дүнгээ интернэтээр үздэг, багш гэрийн даалгавраа өгдөг, шалгалт, чөлөө авахтай холбоотой бүх л мэдээлэл цахимжсан байна.

i-Voting 2005 оноос нэвтэрч сонгуулийг цахимаар өгдөг болж нийт иргэдийнх нь 44 гаруй хувь нь сонгуулиа цахимаар өгдөг байна. 2007 онд E-Police нэвтэрч, цагдаа автомашины дугаараар жолооч болон машины бүх мэдээллийг шалгадаг, 2008 онд E-Health нэвтэрч, иргэдийн эрүүл мэндийн түүх онлайнд тавигддаг болжээ. Эмчид үзүүлсний дараа эмийн санд



цахим үнэмлэхээ уншуулаад л жорын дагуу эмнүүдээ авчихна. Ийм дэвшилтэт үйлчилгээнүүдийн ачаар иргэд нь энд тэнд оочерлож зогсохоо, хэн нэгэн албан тушаалтныг царайчлахаа больж, улс даяараа асар их цаг ба цаас хэмнэж, үр дүнд нь илүү аз жаргалтай амьдрах болжээ.

Эстоничуудын чухалчлан захиж байгаагаар бол, цахим засаглалыг хөгжүүлэхэд:

1. Бодлого, стратеги
2. Дэд бүтэц, технологи
3. Иргэдийг цахим хэрэглэнд сургах гэсэн гурван зүйлийг анхаарах хэрэгтэй.

Цахим засаглал гэхээр шууд технологи л бодогддог, үүнд л их хөрөнгө оруулах ёстой юм шиг санадаг хандлага хаа ч байдаг. Хамгийн түрүүнд технологийг тавьчихаар урт хугацаанд тогтвортой байж чаддаггүй, технологи бол хүрэх газар биш, харин зам юм шүү гэдгийг Эстоничууд сануулж байна.

## Эстони улсын туршлагаас Манай улсад хэрэгжүүлж болох арга хэмжээний саналууд

### 1. Монгол Улсын төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системийг Эстони Улсын мэдээлэл солилцооны систем “X-Road”-ийн жишигт хүргэж, сайжруулалт хийх хэрэгтэй.

“X-Road” мэдээлэл солилцооны системд нийт 1,015 байгууллага, яам, агентлагууд бүртгэлтэй байдаг ба үүнээс 15% нь төрийн байгууллага, 77% нь хувийн хэвшил, 5% нь ашгийн бус байгууллага, 3%-ийг мэдээлэл солилцохоор холбогдсон бусад орны байгууллага байна. X-Road систем нь мэдээлэл солилцоходоо төвлөрсөн бус тархсан бүтэцтэй буюу бусад байгууллагын мэдээллийг өөрийн системд төвлөрүүлэн хадгалдаггүй тул тус системд бүртгүүлсэн иргэн, хуулийн этгээд өөрийн мэдээллийн эзэн байж чаддаг. “ХУР” систем нь хувийн байгууллагуудыг системдээ хангалттай нэгтгэж чадаагүй бөгөөд төрийн байгууллага хооронд мэдээлэл солилцох (G2G) зорилготой. Гэсэн хэдий ч Архив, албан хөтлөлтийн тухай хуульд цаасан баримт бичгийг цахим бичигтэй дүйцүүлэн оруулсан өөрчлөлтийг төрийн байгууллагууд мэдэхгүй, мөрдөхгүй байгаагаас цахимаар мэдээлэл солилцоход хүндрэлтэй хэвээр байна. Мөн “ХУР” систем нь мэдээлэл солилцоходоо төвлөрсөн, тархсан бүтцийг хослуулан ашигладаг бөгөөд энэ нь мэдээлэл солилцоход нэгдсэн стандарт байдаггүйгээс E-Mongolia төв дээр мэдээллийг татаж, цуглуулан интеграцижилж, цааш дамжуулах шаардлагатай болдог. Тодорхой төрийн байгууллагууд болон хувийн хэвшил өөрсдийн мэдээллийн эзэн байх, бусдад хуваан эзэмших эрхийг олгохыг хүсдэггүй тул нэгдсэн стандарт гаргаж, төвлөрсөн системт нөхцөл байдлыг тархаах хэрэгтэй байна.

### 2. Их өгөгдөл, хиймэл оюун ухаан, шинжлэх ухаанд суурилсан өндөр технологийг хөгжүүлэхэд судалгаа шинжилгээ хийхийн тулд төрд буй зарим мэдээллийг ил тод, олон нийтэд нээлттэй тавих шаардлагатай.

Монгол Улсад статистик мэдээллийг Үндэсний статистикийн хороо болон Open Data Lab-аас авч ашигладаг. Гэсэн хэдий ч бизнес эрхлэгчид, судлаачид их өгөгдлийн шинжилгээ хийхэд нээлттэй их өгөгдөл байдаггүй. Жишээлбэл, Улаанбаатар хотын нийтийн тээврийн зорчилт хөдөлгөөнд дүн шинжилгээ хийхэд автобусны карт даралтын мэдээллийг Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газарт албан хүсэлт илгээж, зөвшөөрөл авсны дараагаар Улаанбаатар Смарт Карт ХХК-аас авах боломжтой болдог. Тус өгөгдөл нь хувь хүний эмзэг мэдээлэл агуулаагүй байдаг тул нээлттэй болгосноор их сургуулийн профессор болон бусад судлаачид үүнд зорчилт хөдөлгөөний шинжилгээ хийх, оновчтой маршрутыг тодорхойлох, санал зөвлөмж хүргэх, бодолго боловсруулагчдын ажилд хяналт тавих зэрэг олон эерэг нөлөөтэй. Бусад мэдээллийн хувьд ил тод байж болох мэдээллийн ангилал гарган хувь хүний эмзэг мэдээлэл агуулсан хэсгийг арилгах, танигдахгүй болгон олон нийтэд нээлттэй болгох нь судалгаа, шинжилгээ хийхэд нөр их нөлөө үзүүлэх, цаашлаад иргэн, хуулийн этгээдийн төрд итгэх итгэлийг нэмэгдүүлнэ.

### 3. ЦХИХХ яам, Эстони Улсын И-Засаглалын академитай хамтран цахимжилтийн 2 дахь түвшний хамтын ажиллагааны төсөл болох дижитал орчин дахь танилт, нэвтрэлтийг сайжруулахын тулд e-ID төслийг эхлүүлэх.

2023 оны 9 дүгээр сард Эстони Улсын И-Засаглалын академитай цахимжилтийн 2 дахь түвшний хамтын ажиллагааг эхлүүлж, иргэн бүрд тоон гарын үсгийг түгээх, бизнесийн зөвшөөрлийг цахимжуулж, И-Бизнес шийдлийг боловсруулж Эстони улсын сайн туршлага “Цахим оршин суугч” платформыг нэвтрүүлэхээр харилцан тохирсон. Гэвч 2024 онд Монгол Улсын Их Хурлын сонгууль зохион байгуулагдаж, ЦХИХХ яамны сайд, төсөл хариуцаж буй албан хаагчид солигдсон тул төслийн 2 дахь үе шат зогсож, хойшилсон байна. “e-ID upgrade” төсөл нь иргэн, хуулийн этгээд цахимаар ямарваа нэг үйлчилгээ авахын тулд өөрийгөө мөн гэдгийг батлах үйлчилгээг Монгол Улсын иргэн бүрд нэвтрүүлэх төсөл юм. Төслийн санхүүжилтийг Европын Сэргээн Босголт, Хөгжлийн банкнаас гаргаж байгаа ба санхүүжилттэй холбоотой аливаа асуудал байгаа эсэхийг ЦХИХХ яамнаас тодруулж төслийн ажлыг яаралтай эхлүүлэх шаардлагатай байна.

### 4. Эстони Улсын Таллин хот дахь TalTech технологийн их сургуульд мэдээлэл, технологийн (IT) чиглэлээр

**магистрын түвшинд боловсон хүчин бэлтгэх, сурах боломжийг бүрдүүлэх.**

**5. Төрийн үйлчилгээг цахимжуулах ажлыг эрчимжүүлэх, дуусах тодорхой хугацаа тавих.**

**6. “Е-Монгол Академи УТҮГ”-ын үйлчилгээг бусад улс орнуудад сурталчилж, сургалт хийх, борлуулах. Энэ хүрээнд тодорхой улс орнуудын жагсаалтыг гаргаж томоохон айлчлалуудыг Гадаад Харилцааны яамнаас хариуцаж, Элчин сайдын яамнууд хөрөнгө оруулалт татах, “E-Mongolia”-г сурталчлах ажлыг зохион байгуулах.**

НҮБ-ын гишүүн орнуудын цахим засаглалын хөгжлийн төлөв байдлыг харуулдаг “Цахим засаглалын хөгжлийн индекс (EGDI)”-ээр 2024 онд 193 орноос Эстони Улс 2-т, Монгол улс 46-д эрэмбэлэгдсэн байна. Монгол Улс 2022 онд энэхүү тайланд 74-т бичигдэж байсан бол богино хугацаанд 28 байраар урагшилсан нь бусад улс орнуудад энэ чиглэлээр сургалт хийх, үйлчилгээгээ борлуулах бүрэн нөөц боломж байгааг харуулж байна. Жишээлбэл, Эстони

улсын иргэд цахим үйлчилгээг ихэвчлэн суурин болон зөөврийн компьютероор дамжуулан авдаг ба тус улсын И-Засаглалын Академи гар утасны аппликейшн гаргахаар ажиллаж байна. Монгол Улсад гар утсаар дамжуулан төрийн үйлчилгээг цахимаар хүргэж буй тул Эстони улсад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх боломжтой. Мөн EGDI индексээр манай улсаас доогуурт бичигдэж буй бусад улс оронд зөвлөх үйлчилгээ үзүүлэх бүрэн боломжтой.

**7. “Personal Government” үзэл баримтлалыг Монголд нутагшуулах, хөгжлийн бодлогод тусгах.**

**8. Unicorn төрүүлэх, дэмжих хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудлыг судлах, хэрэгжүүлэх.**

Эстони улс гарааны бизнесийг бий болгоход дэмжлэг тусалцаа үзүүлсээр 2005 оноос хойш нийтдээ 10 юникорн компанийг амжилттай байгуулж чаджээ. Тиймээс Эстони улсыг “Европ тивийн Цахиурын хөндий” гэж нэрлэдэг бөгөөд тус улсын юникорн компанийг бойжуулах туршлагаас сайтар судлах хэрэгтэй.

06



## ИРЭЭДҮЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ БА АЖЛЫН БАЙРНЫ ШИЛЖИЛТ



### СУДЛААЧИЙН ҮГ



**Цэрэн-Очирын  
ДОЛГОРМАА**

СУДЛААЧ

"Зөвлөлийн үйл  
ажиллагааны  
хөтөлбөр"

Email: [dolgormaa@nrpa.gov.mn](mailto:dolgormaa@nrpa.gov.mn)

Утас: 70116838



**Батцэнгэлийн  
ОЮУНДЭЛГЭР**

СУДЛААЧ

"Шинэ сэргэлт  
инновацийн  
хөтөлбөр"

Email: [oyundelger@nrpa.gov.mn](mailto:oyundelger@nrpa.gov.mn)

Утас: 70116838

Дэлхийн Эдийн Засгийн Форумын (WEF) гаргасан судалгаанд хөдөлмөрийн зах зээлийн чиг хандлагыг тодорхойлон нөлөөлөгч хүчин зүйлс болон ажил эрхлэгчдийн тоон мэдээлэлд үндэслэн олон талын дүн шинжилгээ хийжээ.

Судалгааны үр дүнд ойрын 5-10 жилд эрэлттэй байх мэргэжил, үр чадваруудыг нарийвчлан тодорхойлсон бөгөөд энэхүү мэдээлэл нь байгууллагын удирдлагад болон хүний нөөцийн стратегийг төлөвлөхөд дэмжлэг болох зорилготой.

Мөн судалгаанаас харахад хөдөлмөрийн зах зээлд ажил олгогчид шинэ ажилтан сонгохдоо зөвхөн эзэмшсэн мэргэжил төдийгүй, шаардлагатай үр чадваруудыг илүүтэйгээр анхаарч буй хандлага эрчимтэй нэмэгдэж байгааг онцолжээ. Энэ нь боловсрол, сургалтын хөтөлбөрүүдийг шинэ цагийн шаардлагад нийцүүлэн үр чадварт суурилсан байдлаар шинэчлэх шаардлагыг улам бүр нэмэгдүүлж байна.

# ИРЭЭДҮЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ БА АЖЛЫН БАЙРНЫ ШИЛЖИЛТ

## Оршил

Сүүлийн арван жилд дэлхийн эдийн засаг, ажиллах хүчний бүтэц огцом хувьсаж, технологийн хурдацтай хөгжил, хиймэл оюун ухаан, уур амьсгалын өөрчлөлт, нийгмийн тогтолцооны өөрчлөлт зэргээс шалтгаалан “ажлын байр” гэдэг ойлголт улам бүр шинэлэг, уян хатан, ур чадвар төвтэй болж хувирсаар байна.

Дэлхийн эдийн засгийн форумын (WEF) сүүлийн судалгаагаар хиймэл оюун ухаан (AI), их өгөгдөл (Big Data), машин сургалт зэрэг технологийн чиглэлийн мэргэжлүүд ирэх таван жилийн хугацаанд хамгийн эрэлттэй хэвээр байна гэжээ. Үүнээс мэдээлэл, харилцаа холбооны салбар энэ өөрчлөлтийг тэргүүлж байна.

Хөдөлмөрийн зах зээл эрчимтэй өөрчлөгдөж буй энэ үед улс орнууд технологи, ногоон шилжилт, хүн ам зүйн өөрчлөлт зэрэг макро чиг хандлагад нийцсэн хүний нөөцийн бодлогыг оновчтой тодорхойлох шаардлагатай байна.

## Олон улсын эрэлттэй мэргэжлийн чиг хандлага

Дэлхийн Эдийн Засгийн Форум (WEF)-аас 2025 оны 4-р сард танилцуулсан “Ирээдүйн ажлын тайлан 2025” нь дэлхийн 800 гаруй компани, 27 салбарын 14 сая ажилтны мэдээлэлд үндэслэн ойрын таван жилд аль мэргэжил хамгийн эрэлттэй байх, аль нь устах эрсдэлтэй болохыг тодорхойлжээ. 2030 он гэхэд дэлхий даяар 170 сая ажлын байр шинээр бий болох төлөвтэй ба автоматжуулалт, технологийн дэвшлийн нөлөөгөөр 92 сая ажлын байр устах эрсдэлтэй тулгарч байгаа юм. Үүний үр дүнд нийт 78 сая ажлын байр нь “цэвэр өсөлт” буюу шинэ боломжуудыг илэрхийлж байна. Түүнчлэн 2025 он гэхэд дэлхийн нийт ажилтнуудын 40 гаруй хувь нь ур чадвараа шинэчлэх, дахин суралцах шаардлагатай болохыг Дэлхийн Эдийн Засгийн Форумын тайланд онцолсон байна.

**Эх сурвалж:** “Ирээдүйн ажлын тайлан 2025” (WEF)

## Олон улсын хөдөлмөрийн зах зээлийг өөрчилж буй чиг хандлагууд

### Эрүүл мэндийн салбарын чиг хандлага

Ковид-19 цар тахал нь зөвхөн дэлхийн эдийн засгийг хямраагаад зогсохгүй, эрүүл мэндийн тогтолцооны цогц чадвар, тогтвортой байдлыг шалгасан томоохон сорилт боллоо. Энэ үед эмч, сувилагч, халдвар судлаач зэрэг эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн үүрэг, үнэ цэнэ олон нийтийн анхаарлын төвд орж, дэлхийн улс орнуудын эрүүл мэндийн салбарын боловсон хүчний эрэлт эрс нэмэгдсэн. Цар тахлын туршлагаас харахад эрүүл мэндийн тогтолцоог зөвхөн эмчилгээ, оношлогоонд төвлөрүүлэх бус, урьдчилан сэргийлэх, халдвар хяналт, хямралын менежмент, сэтгэлзүйн дэмжлэг зэрэг олон талт хүчин чадал бүхий тогтвортой бүтэцтэй болгох нь чухал болохыг харууллаа.

Ийм нөхцөлд:

- Эмч, сувилагч, олон нийтийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийг тогтмол сургах, чадавхжуулах,
- Эрүүл мэндийн дэд бүтцийг дижиталжуулах, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих,
- Салбар дундын уялдаа холбоог бэхжүүлэх зэрэг чиглэл нь ирээдүйн эрүүл мэндийн бодлогын тулгуур чиглэл болох хандлагатай байна

### Геополитикийн эрсдэл ба хөдөлмөрийн зах зээлийн шилжилт

Сүүлийн жилүүдэд дэлхийн геополитикийн хурцадмал байдал хөдөлмөрийн зах зээлд шууд болон шууд бус олон талын нөлөө үзүүлж эхэллээ. Олон улсын худалдаа, хамтын ажиллагаанд гарч буй саад бэрхшээл нь нийлүүлэлтийн сүлжээг тасалдуулж, үйлдвэрлэлийн салбар дахь ажлын байрны тогтвортой байдалд эрсдэл учруулж байна. Түүнчлэн эдгээр геополитикийн зөрчилдөөн нь тээвэр, түүхий эд, эрчим хүчний үнэ өсөхөд нөлөөлж, улмаар амьжиргааны өртөг нэмэгдэх хандлагыг үүсгэж байна. Энэхүү тодорхой бус нөхцөл байдал нь компаниуд болон хөрөнгө оруулагчдын хувьд глобал бус, орон нутгийн төвлөрсөн стратеги хэрэгжүүлэх сонирхлыг нэмэгдүүлж, орон нутгийн үйлдвэрлэл, ажлын байр бий болгох чиглэл рүү түлхэж болзошгүй байна. Энэ нь нэг талаас дотоодын эдийн засгийн чадамжийг нэмэгдүүлэх эерэг талтай ч, нөгөө талаас гадаад хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтын урсгалд



сөргөөр нөлөөлөх эрсдэлийг дагуулж байна. Ийм нөхцөлд хөдөлмөрийн зах зээлийн бодлого нь:

- Геополитикийн эрсдэлийг харгалзсан салбарын олон төрөлжилт бүхий бүтцийг дэмжих,
- Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийг дотоодын хөрөнгө оруулалтад уялдуулах,
- Ажлын байрны уян хатан байдал, дасан зохицох чадварыг нэмэгдүүлэх

#### Уур амьсгалын өөрчлөлт ба ногоон ажлын байрны өсөлт

Дэлхийн цаг уурын өөрчлөлт нь эдийн засгийн бүх салбарт тогтвортой, уур амьсгалд дасан зохицсон хөгжлийн загвар руу шилжих шаардлагыг улам бүр хурцатгаж байна. Энэхүү шилжилт нь зөвхөн хүрээлэн буй орчны асуудал бус, хөдөлмөрийн зах зээлд шинэ боломж, шаардлага, сорилт бий болгож буй өргөн хүрээтэй өөрчлөлт юм.

Цар тахлын дараах үеэс эхлэн дэлхий даяар ногоон эдийн засгийн шилжилтэд зориулан 1.8 их наяд ам.долларын хөрөнгө оруулалт хийгдсэн нь төр, хувийн хэвшлийн нэгдсэн хариу арга хэмжээг харуулж байна. Үүний үр дүнд 2030 он гэхэд 30 сая орчим шинэ “ногоон” ажлын байр бий болно гэсэн тооцооллыг олон улсын байгууллагууд гаргаад байна.

Тухайлбал, сэргээгдэх эрчим хүчний инженер, байгаль орчны зөвлөх, ногоон барилгын мэргэжилтэн, инноваци технологи хөгжүүлэгч зэрэг мэргэжлүүдийн эрэлт эрс нэмэгдэж байна. Энэ нь боловсрол, мэргэжлийн сургалтын тогтолцоонд ногоон ур чадварыг түлхүү хөгжүүлэх, салбар дамнасан шилжилтийг дэмжих бодлого шаардлагатай болсныг илтгэнэ.

Ийм нөхцөлд хөдөлмөрийн зах зээлийн бодлого:

- Ногоон шилжилтэд нийцсэн ур чадварын зураглал гаргах,
- Төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлж, ногоон хөрөнгө оруулалтыг дэмжих,
- Байгальд ээлтэй технологийн сургалт, дахин сургах хөтөлбөрийг өргөжүүлэх чиглэлд хөгжих шаардлагатай байна.

#### Технологийн дэвшил ба хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлт

Орчин үед ажлын байрыг техник, технологигүйгээр төсөөлөхийн аргагүй болсон. Их өгөгдөл (Big Data), үүлэн тооцоолол (Cloud Computing), хиймэл оюун ухаан (AI) зэрэг дэвшилтэт технологийн шилжилт нь бүх салбарт хурдацтай өрнөж, хөдөлмөрийн зах зээлд шинэ шаардлагуудыг бий болгож байна. Дэлхийн бизнесийн байгууллагуудын 75 хувь нь ойрын таван жилд дээрх технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр төлөвлөж байгаа бол нийт бизнесийн 86 хувь нь дижитал платформ болон аппликейшн ашиглах хандлагатай байна гэж Дэлхийн Эдийн

Засгийн Форум онцолжээ. Энэхүү шилжилт нь зөвхөн техник технологи нэвтрүүлэхээс гадна ажлын байрны шинж чанарыг өөрчилж, шинэ ур чадвар, дижитал чадамж шаардаж байна.

Энэ нөхцөлд хөдөлмөрийн зах зээлийн бодлого дараах чиглэлд анхаарах шаардлагатай:

- Дижитал ур чадварын сургалт, дахин сургалтын хөтөлбөрийг өргөжүүлэх,
- Мэдээллийн технологийн суурь боловсролыг бүх шатанд бэхжүүлэх,
- Технологид суурилсан ажлын байруудыг дэмжих татвар, урамшууллын бодлого хэрэгжүүлэх.

#### Салбаруудын технологийн шилжилтийн чиг хандлага

Салбарын түвшинд авч үзвэл электрон, химийн үйлдвэрлэл болон дэвшилтэт материалын үйлдвэрүүд технологийн шинэчлэлд хамгийн идэвхтэй хандаж, шинэ технологи нэвтрүүлэх өндөр төлөвлөгөөтэй байна. Энэ нь эрчимтэй инновац шаарддаг, өндөр нарийвчлалтай үйлдвэрлэлийн орчинд автоматжуулалт, хиймэл оюун ухаан, робот технологи түлхүү нэвтэрч буйн илрэл юм.

Харин эсрэгээрээ, хөдөлмөр, халамжийн үйлчилгээ, нийгмийн даатгал, тэтгэврийн систем, үл хөдлөх хөрөнгийн салбарууд технологийн шинэчлэл, дижитал шилжилтэд харьцангуй бага хувиар оролцож буй нь анхаарал татаж байна. Энэ нь нэг талаас хууль, зохицуулалтын онцлог, нөгөө талаас салбарын дотоод бүтэц, дижитал чадавхийн сул түвшинтэй холбоотой байж болох юм.

Ийм нөхцөлд:

- Технологийн шилжилтээс хоцорч буй салбаруудад дэмжлэг үзүүлэх,
- Дижитал суурь дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх,
- Хүний нөөцийн чадавх бэхжүүлэх зорилгот сургалт, шилжилтийн хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлага урган гарч байна.

#### Ногоон шилжилт ба шинэ ажлын байрны хэтийн төлөв

Ногоон шилжилтийн хүрээнд сэргээгдэх эрчим хүч, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахтай холбоотой салбаруудад одоогоор харьцангуй цөөн ажилтан ажиллаж байгаа хэдий ч ойрын ирээдүйд эдгээр салбарууд хурдацтай тэлж, ажлын байрны эрэлт эрс нэмэгдэх хандлагатай байна. Энэ нь дэлхийн улс орнуудын уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг амлалтууд, ногоон хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж байгаатай шууд холбоотой.

Тухайлбал, дараах мэргэжлүүд ирэх жилүүдэд хамгийн эрэлттэйг тооцогдож байна:

- Сэргээгдэх эрчим хүчний инженер,
- Нарны эрчим хүчний системийн суурилуулагч,

- Эрчим хүчний системийн инженер,
- Ногоон барилгын мэргэжилтэн,
- Байгаль орчны хяналт-шинжилгээний ажилтан гэх мэт.

### Боловсролын салбарын хөдөлмөрийн зах зээлийн хэтийн төлөв

2023-2027 онуудад боловсролын салбарт ажлын байрны тоо 10 хувиар буюу нийт гурван саяар нэмэгдэх төлөвтэй байгаа нь багш нар, ялангуяа мэргэжлийн болон их, дээд сургуулийн багш нарын эрэлтийг улам нэмэгдэнэ гэдгийг харуулж байна. Гэсэн хэдий ч технологийн хурдтай хөгжлийн улмаас

боловсролын салбарт үндсэн өөрчлөлтүүд гарч, сургалтын арга зүй, багшлах орчин болон мэдлэг, ур чадварын шаардлага шинэчлэгдэх тул салбарын ажилтнууд нь эдгээр чиг хандлагыг урьдчилан судалж, шуурхай дасан зохицох стратеги төлөвлөгөөтэй байх нь нэн чухал юм. Иймд:

- Боловсролын ажилтнуудын мэргэжлийн хөгжлийг тасралтгүй хангах,
- Технологид суурилсан сургалтын шинэ аргачлал, контентг нэвтрүүлэх,
- Хэрэгцээт ур чадварын судалгаа хийх,
- Урьдчилан бэлтгэлтэй, уян хатан хандлагатай байдал бий болгох чухал гэж үзэж байна.

Эх сурвалж: World Economic Forum, Future of Jobs Survey 2023


### Ур чадварын хэтийн төлөв

2023 оны судалгаагаар ур чадварын өөрчлөлтийн түвшин дахин шинэчлэгдэж, ойрын таван жилд 44 хувь байх магадлалтай гэж дүгнэжээ. Энэ нь цар тахлын үеийн хурдацтай дижитал шилжилт, шинэ технологийн шилжилтүүд бага зэрэг тогтворжиж, зарим салбарын уян хатан байдал сайжирсныг илтгэж байна.

Эх сурвалж: World Economic Forum, Future of Jobs Survey 2023

### Дэлхийн ур чадварын өрсөлдөөний индекс

Зураг 1. Дэлхийн ур чадварын өрсөлдөх чадварын индекс (2023) (The global talent competitiveness index)



Зураг 2. Хүний хөгжлийн индекс (2023) (Human Development Index UNDP)

Countries	Index	Global rank
	0.920	17
	0.800	80
	0.915	19
	0.925	17
	0.875	45
	<b>0.788</b>	<b>90</b>

Монгол Улсын Хүний хөгжлийн индекс (HDI) нь дэлхийд **0.788** оноотойгоор 2023 онд 191 орноос 90-р байрт жагссан байна.

Зураг 3. Хүний нөөцийн индекс (2020) (Human Capital Index UNDP)

Countries	Index	Global rank
	0.92	17
	0.75	50
	0.88	15
	0.85	20
	0.78	40
	<b>0.60</b>	<b>67</b>

Монгол Улсын Хүний нөөцийн индекс (HCI) нь дэлхийд **0.60** оноотойгоор 2020 онд 174 орноос 67-р байрт жагссан байна.

**Зураг 4. Хүний нөөцийн ашиглалтын индекс (2020)**  
(Utilized adjusted Human Capital Index – UHCI)

**0.36-0.45** (2023)

Монгол Улсын хүний капиталын төлөвшил (боловсрол+эрүүл мэнд) хөгжиж байгаа хэдий ч хөдөлмөрийн ашиглалт хоцрогдсон байгааг харуулж байна. Энэ нь **дутуу ажил эрхлэлт, ур чадвар таарахгүй, эсвэл чанартай ажилд орох боломжгүй байгааг** илтгэнэ.

Эх сурвалж: World Bank group

## Олон улсын өрсөлдөх чадварын индекс

**Зураг 5. Эдийн засгийн үзүүлэлт**

Countries	Index
	3
	18
	21
	42
	43
	54

**Зураг 6. Бизнесийн үр ашиг**

Countries	Index
	2
	16
	28
	31
	51
	62

**Зураг 7. Засгийн газрын үр ашиг**

Countries	Index
	2
	18
	20
	21
	42
	53

**Зураг 8. Дэд бүтэц**

Countries	Index
	4
	23
	32
	39
	49
	64

Эх сурвалж: International Institute for Management Development  
World competitiveness booklet 2024

## Ажлын байрны хэтийн төлөв

Технологийн дэвшил болон макро эдийн засаг, нийгмийн чиг хандлагууд ойрын таван жилд шинэ ажлын байруудыг бий болгохын зэрэгцээ одоо байгаа зарим ажлын байрны хэрэгцээ, шаардлагыг бууруулах хандлагатай байна. Ийм өөрчлөлт нь хөдөлмөрийн зах зээлийг эргэлтэд оруулж, ажлын байр болон ажиллах хүчнийг дахин хуваарилахад хүргэнэ.

Дэлхийн хөдөлмөрийн зах зээлийн 673 сая ажилтны өгөгдөлд тулгуурласан 2023-2027 оны судалгаагаар нийт хөдөлмөрийн зах зээлд 23 хувийн бүтцийн өөрчлөлт гарах төлөвтэй байна. Үүний дүнд:

- 83 сая ажлын байр устаж үгүй болохоор,
- 69 сая ажлын байр шинээр бий болох хүлээлттэй байгаа нь нийт 152 сая ажлын байранд өөрчлөлт гарах тооцоо юм.

Ийнхүү ажлын байрны тоо 14 саяаар буурах боловч бүтцийн хувьд томоохон шилжилт хийгдэх нь тодорхой байна. Энэ өөрчлөлт нь хөдөлмөрийн зах зээлд шинэ ур чадвар, дасан зохицох чадвар шаардлагатай болж буйг илтгэнэ.

Эх сурвалж: World Economic Forum, Future of Jobs Survey 2023;  
International Labor Organization, ILOSTAT

## Хиймэл оюун ухаан, Технологийн зарим үзүүлэлтүүд

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын мэдээллийн технологи (MT) болон хиймэл оюун ухааны (ХОУ) салбарт дараах ахиц дэвшил гарсан байна.

### Индексүүд

Цахим засаглалын хөгжлийн индекс

**46/193**  
(2024)

Цахим үйлчилгээний индекс

2020	0.53
2022	0.63
2024	0.82

AI government readiness index

**109/193**  
(2023)

Кибер аюулгүй байдлын индекс

2024 онд 17 байр урагшилж, "бэжиж буй" түвшинд үнэлэгдсэн

**Зураг 9. Олон улсын инновацийн индекс (2024)**  
(International Innovation Index)

Countries	Index	Global rank
	62.4	3
	25.7	79
	54.1	13
	61.2	4
	27.6	72
	52.3	16
	<b>28.7</b>	<b>68</b>

Олон улсын инновацийн индексээр Монгол Улс дэлхийн **132** орноос **28.7** индексээр 68 дугаар байр эзэлж байна.

**Зураг 10. Судалгаа хөгжүүлэлтэд зарцуулсан индекс (2011)**  
(Research and development expenditure)

Countries	Index	Global rank
	3.46	3
	0.13	72
	3.3	7
	1.75	20
	<b>0.1</b>	<b>74</b>

Судалгаа хөгжүүлэлтэд зарцуулсан төсвийн индексээр Монгол Улс 78 орноос 0.1 индексээр **74** дугаарт эрэмбэлэгдэж байна.

**Зураг 11. Өндөр технологийн бүтээгдэхүүн экспортолсон байдал (2022)**  
(High tech exports)

Countries	Million USD	Global rank
	166,435.57	4
	4,589.17	37
	83,102.74	11
	94,102.98	8
	18.15	101
	2285.85	45
	<b>51.11</b>	<b>87</b>

БНХАУ дэлхийн 138 орноос хамгийн их хэмжээний буюу 769 тэрбум ам.долларын өртөг бүхий өндөр технологийн бүтээгдэхүүн экспортолсон. Манай улс **51 сая ам.доллар бүхий өндөр технологийн бүтээгдэхүүн экспортолсон** байна.

**Эх сурвалж:** International Institute for Management Development World competitiveness booklet 2024

## Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн чиг хандлага болон эрэлттэй мэргэжил

Манай улсын ажиллах хүчний статистик үзүүлэлтийг 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар авч үзвэл хөдөлмөрийн насны хүн амын зах зээл дэх оролцоо буюу Монгол Улсын нийт хөдөлмөрийн насны 2.1 сая хүний 57.6 хувь нь хөдөлмөрийн зах зээлд оролцож, үлдсэн хувийг ажиллах хүчнээс гадуурх хүн ам эзэлж байна. Хөдөлмөрийн зах зээлийн нийлүүлэлтийн нэг үзүүлэлт нь гарцаагүй их, дээд сургууль төгсөгчид юм.

Их, дээд боловсролын сургалтын байгууллагын 2023-2024 оны төгсөгчдийн статистик мэдээллийг үзвэл нийт 23,314 оюутан төгссөнөөс бизнес, удирдахуй, хууль, эрх зүйн чиглэлээр 30.9 хувь, эрүүл мэнд, нийгмийн халамжийн чиглэлээр 19.1 хувь, боловсролын чиглэлээр 15.2 хувь буюу хамгийн их оюутан төгссөн байна. Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн 45.4 хувь нь дотоодын хөрөнгө оруулалттай компанид, 25.2 хувь нь төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагад, 12.1 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлж байна.

**Эх сурвалж:** Ажиллах хүчний судалгаа 2023 оны 4 дүгээр улирал

**Хүснэгт 1. Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын 2023/2024 оны хичээлийн жилийн мэдээ**


Д/Д	Ерөнхий чиглэл	Нийт суралцагчид	Хувиар
1.	<b>Боловсрол</b>	<b>18,053</b>	<b>15.2</b>
2.	Урлаг, хүмүүнлэг	10,950	7.5
3.	Нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүй	9,001	6.2
4.	<b>Бизнес, удирдахуй, хууль, эрх зүй</b>	<b>41,008</b>	<b>30.9</b>
5.	Байгалийн шинжлэх ухаан, математик, статистик	3,434	2.4
6.	Мэдээлэл, харилцааны технологи	7000	4.8
7.	<b>Инженер, үйлдвэрлэл, барилга угсралт</b>	<b>18,184</b>	<b>12.5</b>
8.	Хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэлэг	2229	1.5
9.	<b>Эрүүл мэнд, нийгмийн халамж</b>	<b>26,058</b>	<b>19.9</b>
10.	Үйлчилгээ	6,252	4.3
11.	Бусад	3,098	2.1
<b>Нийт суралцагчид</b>		<b>145,267</b>	<b>100.0</b>

**Эх сурвалж:** Боловсрол, шинжлэх ухааны яам 2023/2024 оны хичээлийн жилийн мэдээ

### Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт талаас:

Ажлын байрны эрэлтийн чиг хандлага, бүтцийн шилжилтийг эдийн засгийн салбараар Уул уурхай, олборлолт, Боловсруулах салбар зэрэг эдийн засгийн салбаруудад ажлын байрны эрэлт өсөх хандлагатай байхад ХАА, ой, загас агнуур болон Тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбаруудад ажлын байрны эрэлт буурах хандлагатай байна гэсэн үр дүн гарсан байна.

**График 1. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн чиг хандлага /салбараар/**



### Хөдөлмөрийн зах зээлийн нийлүүлэлт талаас:

Ажиллах хүчний нийлүүлэлтэд 30-34 насны залуучууд болон 40, түүнээс дээш насны ажиллах хүчний эзлэх хувийн жин өсөх хандлагатай байхад 15-29 насны залуучуудын эзлэх хувийн жин буурах хандлагатай гэсэн үр дүн гарсан байна. Мөн их, дээд сургууль төгсөгчдийн өнөөгийн хандлагыг тодорхойлсон байна. Бүтцийн шилжилтэд гарч байгаа өөрчлөлтөөс харахад инженер, хууль эрх зүй зэрэг мэргэжил эзэмшиж төгсөх хандлага өсөж байхад нийгмийн болон үйлчилгээ чиглэлийн мэргэжил эзэмшиж төгсөх хандлага буурсан байна. Манай улсын ажиллах хүчний нийлүүлэлт ерөнхийдөө өсөлттэй байсан хэдий ч сүүлийн жилүүдэд буурах хандлагатай байна гэсэн үр дүн гарсан байна.

**График 2. Төгсөгчдийн мэргэжлийн чиг хандлага**



Эх сурвалж: Хөдөлмөрийн зах зээлийн тойм мэдээ (2023 оны 11-р сар), Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

## Монгол Улсын ур чадварын эрэлт

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтээс “Монгол Улсын ур чадварын эрэлт-2022” судалгаагаар ур чадварын зөрүү буюу ажил олгогчдод хэрэгцээтэй байгаа болон ажилтнуудын эзэмшсэн ур чадварын хооронд зөрүү үүссэнийг харуулсан байна. Тус судалгаагаар ур чадварын зөрүү хамгийн их тулгардаг дараах ажил үйлчилгээг тодорхойлсон байна. Үүнд:

- Судалгаа, хөгжүүлэлт
- Программ хангамж
- Маркетинг, борлуулалт
- Мэдээлэл, технологийн үйлчилгээ
- Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт
- Инженерийн үйлчилгээ

Ажил олгогчдын хамгийн их үнэлдэг ур чадвар буюу хамгийн эрэлттэй дараах ур чадваруудыг тодорхойлсон байна. Үүнд:

- Ажлын ёс зүй
- Харилцааны ур чадвар
- Техникийн өндөр ур чадвар

- Багаар ажиллах ур чадвар
- Идэвх санаачилга
- Суралцах ур чадвар

Харин ажил олгогчдын зүгээс ажиллах хүчинд хамгийн их дутагдалтай байгаа ур чадвараар дараах ур чадваруудыг тодорхойлжээ. Үүнд:

- Идэвх санаачилга
- Ажлын ёс зүй
- Суралцах ур чадвар
- Харилцааны ур чадвар
- Багаар ажиллах ур чадвар
- Өөрийгөө удирдах ур чадвар

Дээрх судалгаанаас харахад их, дээд сургууль төгсөгчид болон албан хаагчдын технологийн ур чадварыг сайжруулах сургалтын хөтөлбөрийг бий болгох шаардлага үүсэж байна.

Эх сурвалж: “Монгол Улсын ур чадварын эрэлт-2022”

## Дүгнэлт

Ногоон шилжилт, технологийн хурдацтай хөгжил, макро эдийн засгийн бүтэц, чиг хандлагын өөрчлөлт нь хөдөлмөрийн зах зээлд урт хугацааны өөрчлөлт авчирч байна. Монгол Улс дэлхийн хөдөлмөрийн чиг хандлагад нийцсэн, чадавхжсан, өрсөлдөх чадвар бүхий хүний нөөц бэлтгэх, түүнийг дэмжих сургалт, хөгжлийн тогтолцоог шинэчлэн бүрдүүлэх шаардлагатай тулгарч байна. Энэ хүрээнд дараах тэргүүлэх чиглэлд анхаарах нь зүйтэй:

- Боловсролын шинэчлэл: STEM чиглэлийн мэдлэг, өгөгдөлд суурилсан сэтгэлгээ, гадаад хэлний хэрэглээг хослуулсан боловсролын хөтөлбөрийг өргөжүүлэх;

- Мэргэжлийн болон ур чадварын сургалтын тогтолцоо: Цахим болон танхим хосолсон сургалт, богино хугацааны практик хөтөлбөр, олон улсад хүлээн зөвшөөрөгдөх үнэлгээ, гэрчилгээний системийг нэвтрүүлэх;
- Залуусыг олон улсын хөдөлмөрийн зах зээлд бэлтгэх: Мэдээллийн технологи, эрүүл мэнд, сэргээгдэх эрчим хүч зэрэг өндөр эрэлттэй салбарт “export-ready” буюу гадаад зах зээлд ажиллах чадамжтай боловсон хүчнийг системтэйгээр бэлтгэх;
- Төр-хувийн хэвшлийн түншлэл: Их, дээд сургууль болон ажил олгогчдын хамтын ажиллагаанд суурилсан тэтгэлэг, дадлага, хамтарсан сургалтын платформуудыг хөгжүүлэх.

07



## ОРОН СУУЦНЫ САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦООГ ТӨРӨЛЖҮҮЛЭН ХӨГЖҮҮЛЭХ ЗАГВАР



### СУДЛААЧИЙН ҮГ



#### Дашдорж ЗОРИГТ

/Хуулийн ухааны доктор/

ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ

“Эдийн засгийн  
хөгжлийн төв” -  
УТҮГ

Email: zorigt@nrpa.gov.mn

Утас: 70116838



#### Гүнчин БАТ-ОРШИХ

ЗАХИРАЛ

“Судалгаа  
шинжилгээний  
хөтөлбөр”

Email: bat-orshikh@nrpa.gov.mn

Утас: 70116838



#### Ганбат ГҮНДАЛАЙ

АХЛАХ  
МЭРГЭЖИЛТЭН

“Судалгаа  
шинжилгээний  
хөтөлбөр”

Email: gundalai@nrpa.gov.mn

Утас: 70116838

Орлогод нийцсэн, тохилог орон сууцаар иргэдийг хангах нь Монгол Улсын нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлын нэг хэвээр байна. Одоогийн байдлаар Улаанбаатар хотын нийт өрхийн талаас илүү хувь нь, аймгийн төвүүдийн 70 гаруй хувь нь орчин үеийн инженерийн дэд бүтэц, шугам сүлжээнд холбогдоогүй гэр, байшин хороололд амьдарч байна. 2013 оноос хойш Монгол Улсын Засгийн газар, Монголбанкнаас хэрэгжүүлж буй орон сууцны ипотекийн санхүүжилттэй зээлийн хөтөлбөрийн хүрээнд 130 гаруй мянган өрх тохилог орон сууцтай болжээ. Гэсэн хэдий ч өсөн нэмэгдэж буй хотжилт, орон сууцны үнийн хэт их өсөлт, санхүүгийн хязгаарлагдмал байдал түүнчлэн зорилтот бүлгийг орон сууцжуулах болон орон сууцны ипотекийн санхүүжилттэй зээлийн хүртээмжтэй бус байдал зэрэг асуудлууд орон сууцны ипотекийн зах зээлийн тогтолцоог шинэчлэх, төрөлжүүлэн хөгжүүлэх шаардлагатай илтгэж байна.

Энэхүү тулгамдаж байгаа асуудлын хүрээнд тус төвөөс “Орон сууцны зах зээлийн санхүүжилтийн тогтолцоог төрөлжүүлэх нь” судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. Тус судалгаагаар орон сууцны ипотекийн зах зээлийн ололт, амжилтуудыг бататгаж, сайжруулах чухал асуудлуудыг тодорхойлж, олон улсын сайн туршлага, олон улсын хөгжлийн байгууллагууд болон бусад судалгаанд үндэслэн энэхүү судалгааг боловсруулж, тодорхой саналуудыг дэвшүүлсэн болно. Үүнд: орон сууцны ипотекийн зах зээлийн санхүүжилтийн тогтолцоог төрөлжүүлэх, орон сууцны санхүүжилтийн корпорац, ипотекийн зээлийн батлан даалтын сан, орон сууцны хадгаламжийн банк зэрэг шинэ бүтцийг бий болгох, орон сууцны ипотекийн санхүүжилттэй зээлийг бага, дунд орлоготой өрхүүдэд илүү оновчтой, ил тод чиглүүлж олгох зэргийг тодорхойлсон.

Монгол Улсад илүү хүртээмжтэй, тогтвортой, зах зээлийн зарчимд нийцсэн орон сууцны санхүүжилтийн тогтолцоог бий болгоход энэхүү судалгааны тайлан нь бодлого боловсруулагчид, санхүүгийн байгууллагууд болон хөгжлийн түнш байгууллагуудад эх сурвалж, гарын авлага болно гэдэгт найдаж байна. Энэхүү судалгаанд хамтран ажилласан Монголбанк, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Үндэсний баялгийн сан, орон сууцны үндэсний хорооны ажлын алба, Сангийн яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар зэрэг байгууллагад талархал илэрхийлье.

# ГАРЧИГ

<b>ӨМНӨХ ҮГ</b>	<b>73</b>
<b>Удиртгал</b>	<b>75</b>
<b>1. ОРОН СУУЦНЫ ИПОТЕКИЙН САНХҮҮЖИЛТТЭЙ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ</b>	<b>76</b>
1.1. Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн өнөөгийн тогтолцоо	76
1.2. Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн үр дүн	77
1.3. Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн үр өгөөж	78
<b>2. ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД</b>	<b>79</b>
2.1. Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр	79
2.2. Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн хэрэгцээ шаардлага	79
2.3. Банкны хөрвөх чадварын эрсдэл: Урт хугацаат зээл ба богино хугацаат хадгаламж	81
2.4. Орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамрагдсан иргэдийн орлогын байдал	81
2.5. Орон сууцны үнийн өсөлт	82
2.6. Амины болон нам давхрын орон сууцны зээлийн хүртээмжгүй байдал	84
2.7. Орон сууцны ипотекийн санхүүжилттэй зээл олголтын нийгэмд үзүүлэх үр нөлөө	84
<b>3. ОРОН СУУЦНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦООГ ТӨРӨЛЖҮҮЛЭН, ХӨГЖҮҮЛЭХ ЗАГВАР</b>	<b>85</b>
3.1. Дэлхийн банкны зөвлөмж	86
3.2. Германы Шпаркассэ банкны Олон улсын хамтын ажиллагааны сангийн зөвлөмж	87
3.3. Орон сууцны зах зээлийн асуудлаар манай орны судлаачдын зөвлөмж	88
3.4. Орон сууцны ипотекийн зах зээлийн санхүүжилтийн тогтолцоог төрөлжүүлэх загвар (Эдийн засгийн хөгжлийн төвийн санал)	88
3.4.1. Орон сууцны санхүүжилтийн корпорац байгуулах	89
3.4.2. Ипотекийн зээлийн батлан даалтын сан байгуулах	90
3.4.3. Орон сууцны ипотекийн төрөлжсөн банк байгуулах	90
3.4.4. Орон сууцны ипотекийн төрөлжсөн банкны бүтээгдэхүүн	92
3.5. Зорилтот бүлгийг тодорхойлох	93
3.6. Амины орон сууц барих стандарт, санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх	95
<b>4. ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Төрөлжсөн ипотекийн банк</b>	<b>96</b>
4.1. Герман Улсын орон сууцны хуримтлалын тогтолцоо	96
4.2. Казахстан Улсын төрийн дэмжлэгтэй ипотекийн зээлийн тогтолцоо (Отбасы банк)	98
<b>5. ОРОН СУУЦНЫ НИЙЛҮҮЛЭЛТ</b>	<b>100</b>
5.1. Орон сууцны нийлүүлэлтийн боломж (2025-2032 он)	100
5.2. Нийслэлийн Орон сууцны корпорац, Төрийн орон сууцны корпорацын үүргийг өргөжүүлэх санал	103
<b>Дүгнэлт</b>	<b>104</b>

# ОРОН СУУЦНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦООГ ШИНЭЧЛЭХ САНАЛ

## Удиртгал

Хүртгэмжтэй, зах зээлийн зарчимд нийцсэн, тогтвортой, үр ашигтай орон сууцны санхүүжилтийн тогтолцоог орлогод нийцсэн орон сууцжуулалтын нийлүүлэлтийн тогтолцоотой уялдуулан хэрэгжүүлснээр өрхүүд үл хөдлөх хөрөнгөд хөрөнгө оруулалт хийх боломжийг бүрдүүлж, улмаар барилгажилт бүтээн байгуулалт идэвхжиж улс орны эдийн засгийн өсөлтийг дэмждэг. Мөн орон сууцжуулалтын тогтолцоо дахь Засгийн газрын оролцоо нь орон сууцны зах зээлийн гажуудлыг засах, тэгш, хүртгэмжтэй байдлыг хангах, орон сууцны зах зээлийн тогтвортой байдлыг зохицуулах зэрэгт төвлөрдөг.


Монгол Улсад иргэдийг орон сууцаар хангах хүрээнд орон сууцны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, гэр хорооллыг дахин төлөвлөн орон сууцжуулах зэрэг зорилтуудыг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон урт, дунд хугацааны төрийн бодлогын баримт бичгүүдэд тусган, шат дараатайгаар хэрэгжүүлэн ажиллаж ирсэн. Тухайлбал, 2008 онд Монгол Улсад үл хөдлөх хөрөнгө барьцаалан ипотекийн зээл олгох, эргэн төлүүлэх, хяналт тавих тухай Монголбанкны Ерөнхийлөгчийн 446 дугаар тушаалаар “Ипотекийн зээлийн үйл ажиллагааны журам”-ыг баталсан. Мөн ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгож, хөгжүүлэх асуудлын хүрээнд Монгол банк, Монгол Улсын Засгийн газар санамж бичиг байгуулж, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны 06 сарын 14-ний өдөр А-122 дугаар тушаалаар “Орон сууцны

ипотекийн зээлийн санхүүжилтийн журам”-ыг тус тус баталсан. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны 10-р сарын 25-ны өдрийн А-295 дугаар тушаалаар “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам”-ыг дахин шинэчлэн баталсан. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 369 дүгээр тогтоолоор агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулах зорилтыг хангах ажлын хүрээнд “Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн журам” батлагдсан ба шаардлага хангасан амины орон сууц худалдан авч болох тухай уг журамд тусгасан. Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 202 дугаар тогтоолоор 5 жилийн хугацаатай хэрэгжүүлэх “150,000 айл-орон сууц” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлүүлсэн.

Өнөөгийн байдлаар 10 их наяд гаруй төгрөгийн орон сууцны зээлийг орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилттэй хөтөлбөрийн хүрээнд олгосон ба 132 мянга гаруй өрх орон сууцтай болсон байна. Улаанбаатар хот, аймгийн төвүүдэд орчин үеийн инженерийн дэд бүтцэд холбогдоогүй гэр, байшин хороололд 409,290 өрх амьдарч байгаа ба 263,012 өрх нь Улаанбаатар хотын өрхүүд байна.

Орон сууцны ипотекийн санхүүжилттэй хөтөлбөрийн зээлийн санхүүжилт хангалттай бус учир зээлд хамрагдахад урт хугацааны дараалал үүсэж 36 сар хүртэл хүлээх болсон. Мөн орон сууцны үнийн огцом өсөлтийг тогтворжуулах, зорилтот бүлэг буюу бага, дунд орлоготой өрхүүдийн орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамрагдалтыг нэмэгдүүлэх, төрөөс бодлогоор орон сууцжуулалтыг дэмжих зэрэг зохицуулалт хийх асуудлууд тулгарч байна. Түүнчлэн, орон сууцны ипотекийн зах зээлийн тогтолцоог сайжруулах,

**Зураг 1. Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн (осхз) хөтөлбөрийн мэдээлэл**



төрөлжүүлэн хөгжүүлэх шаардлагатай байна.

Орон сууцны ипотекийн зах зээлийн тогтолцоог боловсронгуй болгох, хүртээмжийг нэмэгдүүлэх, төлбөрийн чадварт нийцсэн орон сууцжуулалтыг хэрэгжүүлэх, салбаруудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нэгдсэн бодлого зохицуулалтаар хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдаар ахлуулсан Үндэсний баялгийн сан, орон сууцжуулалтын Үндэсний хороо байгуулагдан

ажиллаж байна. Айл өрхүүдийг орлогод нийцсэн орон сууц худалдан авах боломжийг бүрдүүлэх, гэр хорооллын айл өрхүүд орчин үеийн инженерийн дэд бүтцэд холбогдсон амины орон сууцад амьдрах санхүүгийн тогтолцоог бий болгох, агаар, хөрс, орчны бохирдол, түгжрэлийг бууруулах зорилготой гэр хорооллын дахин төлөвлөлтийн бодлогыг уялдуулах тогтолцооны өөрчлөлтийг тус судалгаанд санал болгож байна.

# 1. ОРОН СУУЦНЫ ИПОТЕКИЙН САНХҮҮЖИЛТТЭЙ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ


## 1.1. Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн өнөөгийн тогтолцоо

Монголбанкны Ерөнхийлөгчийн 446 дугаар тушаалаар “Ипотекийн зээлийн үйл ажиллагааны журам”-ыг 2008 онд баталсан. 2013 оны 6-р сарын 14-ний өдөр А-122 дугаар Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар “Орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилтийн журам” батлагдсан. 2016 оны 10-р сарын 25-ны өдрийн А-295 дугаар Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар “Орон сууцны ипотекийн

санхүүжилтийн журам”-ыг дахин шинэчлэн баталсан. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 369 дүгээр тогтоолоор агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулах зорилтыг хангах ажлын хүрээнд “Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн журам” тус тус батлагдсан.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны А-295 дугаар тушаалаар баталсан “Орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилтийн журам”-ын дагуу зээлдэгч 150 сая төгрөг хүртэл орон сууцны хөнгөлөлттэй зээлийг

Зураг 2. Орон сууцны ипотекийн санхүүжилттэй хөтөлбөрийн тогтолцоо



Эх сурвалж: Монголбанк



жилийн 6% хүүтэй, урьдчилгаа төлбөр 30%, 30 жил хүртэл хугацаатай, нийт талбайн хэмжээ 80 м2-аас ихгүй орон сууц худалдан авч байна.

Энэхүү орон сууцны ипотекийн санхүүжилттэй хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн тогтолцоонд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ), Монголын Ипотекийн Корпорац (МИК), арилжааны банкууд, тусгай зориулалтын компани, зээлдэгч иргэд оролцож байна. 2024 оноос Хуримтлалын санд төвлөрсөн хөрөнгөөр орон сууцны хөнгөлөлттэй зээлийг мөн санхүүжүүлж эхэлсэн.

Монголбанк жилийн 2% хүүтэй хямд эх үүсвэрийг орон сууцны зээлд зориулж банкуудад хуваарилдаг бөгөөд банкууд өөрийн эх үүсвэртэй нийлүүлж 6% хүүтэй орон сууцны хөнгөлөлттэй зээлийг олгодог.

Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн 80% нь Монголбанкны эх үүсвэр, 20% нь арилжааны банкуудын өөрийн эх үүсвэр байдаг. Иргэдэд олгосон ипотекийн зээлүүдийг МИК багцлан худалдан авч Ипотекийн зээлээр баталгаажсан бонд (ИЗББ) гарган давуу эрхтэй ИЗББ Монголбанканд, энгийн эрхтэй ИЗББ арилжааны банкуудад худалддаг /Зураг 2/.

Орон сууцны ипотекийн санхүүжилттэй зээлийн хөтөлбөрийг Монголбанкнаас анх санхүүжилт хийсэнээс хойш ИЗББ-ын эргэн төлөлтөөр Монголбанк жил бүр арилжааны банкуудаар дамжуулан орон сууцны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийг бүрдүүлж байна. Монголбанкнаас 2013-2025 оны хооронд нийт 10 орчим их наяд төгрөгийн санхүүжилт хийсэн гэж Монголбанкнаас мэдээлдэг.

## 1.2. Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн үр дүн

**Нийт 10 орчим их наяд төгрөгийн орон сууцны зээлд 132 гаруй мянган өрх хамрагдсан.**

Орон сууцны ипотекийн санхүүжилттэй хөтөлбөрийн зээлээр нийт 132 гаруй мянган өрх орчин үеийн инженерийн дэд бүтэц, шугам сүлжээнд холбогдсон орон сууцтай болжээ. Нийт 10 орчим их наяд төгрөгийн зээл олгогдсон бөгөөд зээлдэгчдийн дундаж нас 36 байна.


Зураг 3



Эх сурвалж: Монголбанк

Улаанбаатар хотод тус зээлд хамрагдсан өрхүүдийн 63% нь орон сууцнаас орон сууцанд шилжсэн бол 37% нь гэр хорооллоос орон сууцанд шилжсэн байна. Харин орон нутагт зээл авсан өрхүүдийн 52% нь орон сууцнаас орон сууцанд шилжсэн бол 48% нь гэр хорооллоос орон сууцанд шилжсэн байна. /Зураг 4/.

Зураг 4.



Эх сурвалж: Монголбанк

Орон сууцны ипотекийн санхүүжилттэй хөтөлбөрийн зээлийн хүрээнд орон сууцны зээл авсан нийт зээлдэгчдийн өрхийн дундаж орлого 3 сая төгрөг байна. Хөтөлбөрийн зээлийн хугацаа 30 хүртэл жил бөгөөд нийт олгосон зээлийн дундаж хугацаа 18.4 жил байна. Зээлдэгч өрхүүдийн худалдан авсан орон сууц дундажаар 50м2 байна.

Зураг 5



Эх сурвалж: Монголбанк

### 1.3. Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн үр өгөөж

Иргэд орон сууцны ипотекийн санхүүжилттэй хөтөлбөрийн зээлд хамрагдсанаар нийт зээл төлөх хугацаанд 300 сая гаруй төгрөгийн хөнгөлөлтийг эдэлж байна.

Өнөөдөр манай улсад (i) арилжааны банкны орон сууцны зээл энгийн болон (ii) төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны ипотекийн санхүүжилттэй хөтөлбөрийн зээл гэсэн хоёр төрлийн орон сууцны зээлд иргэд хамрагдах боломжтой байна /Зураг 6/.

Зураг 6



Орон сууцны ипотекийн санхүүжилттэй хөтөлбөрийн зээл ба орон сууцны энгийн зээлийн (дунджаар 19.2% хувийн хүүтэй) сар бүрийн болон нийт зээлийн төлөлтийг жишээгээр харьцуулан Зураг 7-т үзүүлэв.

Жишээлбэл, 214 сая төгрөгийн орон сууцыг худалдаж авахаар 20 жилийн хугацаатайгаар, 150 сая төгрөгийн зээлд хамрагдахад сар бүрийн төлбөр нь 6%-ийн зээлд 1,075,700 төгрөг төлөх байхад, орон сууцны энгийн зээлд 2,454,380 төгрөг төлөх болж сарын төлбөрийн зөрүү маш өндөр байна. Тодруулбал, зээлдэгч нь 331.1 сая төгрөгийн хэмнэлтийг нийт зээлийн хугацаа 20 жилд бий болгож байгаа бөгөөд энэхүү хөнгөлөлттэй зээлийн бодлого нь иргэдийг орон сууцжуулахад төрөөс бодит дэмжлэг үзүүлж байгаагийн зэрэгцээ төдий хэмжээний санхүүгийн ачааллыг төр, тухайлбал Монголбанк хариуцаж байгаа гэсэн үг юм.

Зураг 7



## 2. ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД


### 2.1. Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр

Орон сууцны ипотекийн санхүүжилттэй хөтөлбөрийн зээлийн санхүүжилтийг бүрдүүлэх зорилгоор Монголбанкны зүгээс тогтмол санхүүжилт олгож байгаа.

Орон сууцны ипотекийн санхүүжилттэй хөтөлбөрийн зээлийн санхүүжилтийг жил бүр тогтвортой олгохын тулд Монголбанк эдгээр он жилүүдэд зардал гарган санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлж ирсэн. Нийт олгосон санхүүжилтийн бодлогын хүү болон арилжааны банкуудад олгож буй хөтөлбөрийн зээлийн 2% хүүгийн зөрүү нь олон улсын нягтлан бодох стандартын дагуу ирээдүйд алдагдал болж бүртгэгдэх эрсдэл байгаа.

Монголбанкнаас жил бүр олгосон буюу 2013 оноос 2025 оны нэгдүгээр улирал хүртэлх санхүүжилтийг зураг 8-аар дүрслэв. 2013 онд 790 тэрбум төгрөгийн санхүүжилттэйгээр орон сууцны ипотекийн санхүүжилттэй зээл олголт эхэлсэн ба 2014 онд 830 тэрбум төгрөг, 2021 онд 980 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус Монголбанкнаас хийжээ. Харин 2024 оноос эхлэн Хуримтлалын санд төвлөрсөн эх үүсвэрийг мөн нэмж олгосон бөгөөд нийт 1.4 их наяд гаруй төгрөгийн санхүүжилтийг 2024 онд орон сууцны ипотекийн санхүүжилттэй зээлд олгожээ /Зураг 8/.

**Зураг 8** Орон сууцны ипотекийн санхүүжилттэй хөтөлбөрийн эх үүсвэр



Эх сурвалж: Монголбанк

2024 оноос эхлэн Монголбанкны санхүүжилтээс гадна, Хуримтлалын санд төвлөрсөн 495 тэрбум төгрөгийг Монголбанканд тус хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэр болгон шилжүүлсэн. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн дагуу

Хуримтлалын сангийн хөрөнгийг бодлогын хүүгээс багагүй өгөөжтэйгөөр өсгөнө гэж заасан байдаг. Монголбанкнаас тогтоосон бодлогын хүү 2024 онд 10% байсан. Монголбанк дээрх (495 тэрбум төгрөг) эх үүсвэрийг 2%-ийн хүүтэй банкуудад 6%-ийн зээлийн эх үүсвэр болгон зээлдүүлсэн бөгөөд зөрүү нь нэмэлт алдагдал болох эрсдэл үүсэх эсвэл төсвөөс татаас олгох байдлаар шийдэгдэх боломжтой. Хуримтлалын сангийн санхүүжилт уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн компаниудын ногдол ашгаас шалтгаалан хэлбэлзэх бөгөөд зах зээлд тогтворгүй байдал үүсгэх эрсдэлтэй.

### 2.2. Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн хэрэгцээ шаардлага

Нийслэл Улаанбаатар хотын нийт өрхийн 50-иас дээш хувь нь орчин үеийн инженерийн дэд бүтэц, шугам сүлжээнд холбогдоогүй гэр, байшин хороололд амьдарч байна. Монгол Улсын нийт аймгийн төвүүдийн хэмжээнд (сум болон багийг оруулаагүй, зөвхөн аймгийн төвүүд) өрхүүдийн 70 орчим хувь нь орчин үеийн инженерийн дэд бүтэц, шугам сүлжээнд холбогдоогүй гэр, байшин хороололд мөн амьдарч байна.

# 56%

Нийслэл Улаанбаатар хотын өрхүүдийн 56% нь орчин үеийн инженерийн дэд бүтэц, шугам сүлжээнд холбогдоогүй гэр, байшин хороололд амьдарч байна. Сонгинохайрхан дүүрэгт энэ үзүүлэлт хамгийн өндөр буюу 73%-тай байна.

Монгол Улсын нийт аймгийн төвүүдийн (сум болон багийг оруулаагүй, зөвхөн аймгийн төвүүд) өрхүүдийн 71% нь орчин үеийн инженерийн дэд бүтэц, шугам сүлжээнд холбогдоогүй гэр, байшин хороололд амьдарч байна. Хөвсгөл аймагт энэ үзүүлэлт хамгийн өндөр буюу 85%-тай байна.

# 71%


Эх сурвалж: Монголбанк

УБ хотын 9 дүүргээс Сонгинохайрхан дүүрэгт орон сууцанд амьдардаггүй өрхийн тоо хамгийн өндөр хувьтай буюу тус дүүргийн нийт өрхийн 73% нь орчин үеийн инженерийн дэд бүтэц, шугам сүлжээнд холбогдоогүй орон сууцтай. Харин Хан-Уул болон

Зураг 9 Нийт өрхийн орон сууц өмчлөл (2024)

Нийт өрх: 996,911

Орон сууцгүй өрх: 700,341 буюу өрхийн 70%



409,290


УБ ХОТ БОЛОН АЙМГИЙН ТӨВ

УЛААНБААТАР ХОТЫН ОРОН СУУЦГҮЙ ӨРХ:



56%

АЙМГИЙН ТӨВИЙН ОРОН СУУЦГҮЙ ӨРХ:



71%

Тэмдэглэл: Судлаачийн тооцоолол

Баянгол дүүргүүдийн орчин үеийн инженерийн дэд бүтэц, шугам сүлжээнд холбогдоогүй орон сууцтай өрхийн хувь хамгийн бага буюу тус тус 43% болон 35% байна. Баянзүрх дүүрэг нь Нийслэлийн хамгийн олон хүн амтай дүүрэг ба нийт 127,621 өрхтэй, үүнээс 69,984 өрх орон сууцгүй буюу тус дүүргийн хүн амын 55%-ийг эзэлж байна.

Аймгийн төвүүдийн нийт өрхөд эзлэх орчин үеийн инженерийн дэд бүтэц, шугам сүлжээнд холбогдоогүй орон сууцтай өрхүүдийн хувь 71% байна. Хөвсгөл, Баян-Өлгий, Өмнөговь, Хэнтий болон Булган аймгууд хамгийн өндөр хувьтай буюу аймгийн төвийн өрхүүдийн 80-иас дээш хувь нь орчин үеийн инженерийн дэд бүтэц, шугам сүлжээнд холбогдоогүй орон сууцтай байна.


Баруун болон Хангайн бүсэд орчин үеийн инженерийн дэд бүтэц, шугам сүлжээнд холбогдоогүй орон сууцтай өрхийн эзлэх хувь хамгийн өндөр буюу тус тус нийт өрхийн 78% нь орчин үеийн инженерийн дэд бүтэц, шугам сүлжээнд холбогдоогүй орон сууцтай байна. Харин Төвийн бүсэд орон сууцгүй өрхийн хувь хамгийн бага буюу 59%-тай байна. Энэ нь тухайн бүс нутагт Дархан-Уул болон Төв аймаг багтдаг бөгөөд эдгээр аймгуудад ялангуяа Дархан-Уул аймагт орон сууцжуулалтын хувь өндөр байгаатай холбоотой.

Улаанбаатар хотын нийт өрхийн 50 гаруй хувь, аймгийн төвүүдийн 70 орчим хувь нь орчин үеийн

инженерийн дэд бүтэц, шугам сүлжээнд холбогдоогүй хороололд амьдарч байна.

Манай улсад жилд 17,000-20,000 өрх шинээр гэр бүл болдог статистик, тоон үзүүлэлт байдаг /Зураг 10/.

Зураг 10 Хүн амын тоо насны бүлгээр /2023/



Эх сурвалж: Монголбанк

Монголбанкны статистик мэдээгээр орон сууцны ипотекийн санхүүжилттэй хөтөлбөрийн зээлд хамрагдсан иргэдийн дундаж нас 36 байна.

2023 оны хүн амын насны бүтэц харуулсан зураг 10-т Монгол Улсын хүн амын 50% гаруй хувийг 30-аас доош насны залуучууд эзэлдэг нь харагдаж байна. Энэ нь ойрын 5-15 жилийн хугацаанд олон өрх шинээр

бий болох томоохон давлагааг харуулж байгаа бөгөөд эдгээр бүлэг нь орон сууц сууцны эрэлтийг огцом нэмэгдүүлэх төлөвтэй байна. Иймд хотжилтын түвшин нэмэгдэж байгаатай зэрэгцэн залуу гэр бүл, бага-дунд орлоготой бүлгийг төрөөс орон сууцны хүртээмжтэй бодлогыг хэрэгжүүлж дэмжих шаардлага илүү хурцаар тавигдана.



### 36 нас

Орон сууцны ипотекийн санхүүжилттэй зээлд хамрагдсан иргэдийн дундаж нас



### 30-аас

доош насны залуус  
Хүн амын 50 гаруй хувийг бүрдүүлж байна




### 5-15

жилийн хугацаанд олон өрх шинээр бий болох томоохон давлагааг харуулж байна

## 2.3. Банкны хөрвөх чадварын эрсдэл: Урт хугацаат зээл ба богино хугацаат хадгаламж

Банкууд урт хугацааны зээлийг (орон сууцны, гэх мэт) санхүүжүүлэхэд богино хугацаат хадгаламжийн эх үүсвэр ашиглахад үүсэж буй хугацааны зөрүүтэй байдлыг доорх зургаар дүрсэлсэн байна /Зураг 11/.

**Зураг 11** Банкуудын урт хугацааны зээлийн тодорхой хэсэг нь богино хугацааны хадгаламжаар санхүүждэг



Эх үүсвэр: Монголбанк

## 2.4. Орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамрагдсан иргэдийн орлогын байдал


Орон сууцны ипотекийн санхүүжилттэй зээлд хамрагдахад нарийн шалгуур үзүүлэлт байхгүй учир

бага орлоготой иргэд хамрагдахаас илүүтэй харьцангуй дунд, өндөр орлоготой өрхүүд 6%-ийн хөнгөлөлттэй зээлийн дийлэнхийг эзэлж байна.

Олон хүүхэдтэй, орлого багатай, залуу гэр бүл, өрх толгойлсон эмэгтэй, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг зорилгот бүлгийг дэмжих нарийн шалгуур үзүүлэлт нь “Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн журам”, “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам”-уудад тусгагдаагүй учир банкууд зээлийн эрсдэлээ нэгдүгээрт тавьж өндөр орлоготой, эрсдэл багатай өрхүүдэд 6%-ийн зээлийг илүү олгох хандлагатай байна. Харин бусад орны туршлагаар бол төрөөс үзүүлж буй ямар нэгэн татаастай хөтөлбөр, тэр дундаа орон сууцны хөнгөлөлттэй зээлийг зөвхөн зорилгот бүлэгт зориулан олгодог байна.

Зураг 12-оос харахад орон сууцны ипотекийн санхүүжилттэй хөтөлбөрийн зээлд дунд болон өндөр орлоготой өрхүүд дийлэнх хувийг эзэлж хамрагдсан байна.

**Зураг 12** 2024 оны байдлаар багцалсан ИЗББ-д зээлдэгчийн орлого



Тэмдэглэл: Судлаачийн тооцоолол

Монгол Улсын өрхийн дундаж орлого 2024 оны байдлаар 2.5 сая төгрөг байсан бөгөөд зураг 12-оос харахад нийт зээлдэгчдийн 40 орчим хувь нь 4 сая төгрөгөөс дээш орлоготой байна. Түүнчлэн, 2.5 сая төгрөгөөс дээш орлоготой зээлдэгчид 70%-ийг эзэлж байна. Харин нийт зээлдэгчдийн 30% орчим нь дунджаас доогуур болон бага орлоготой зээлдэгчид бүрдүүлж байна.

Олон улсын туршлагаас судлахад төрийн дэмжлэгтэй хөнгөлөлттэй орон сууцны зээлийг зөвхөн зорилтот бүлэгт эсвэл тодорхой бодлогоор (багш, эмч, сувилагч, эрдэмтэн судлаач, цэрэг дайчид гэх мэт) шалгуур үзүүлэлттэйгээр иргэдэд олгодог байна. Харин манай улсын хувьд


орон сууцны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилттэй хөтөлбөрт хамрагдахад нарийн шалгуур үзүүлэлт байхгүй буюу бүх иргэн тус хөтөлбөрийн хөнгөлөлттэй зээлд хамрагдах эрхтэй байна. Дээр дурдсанчлан, орон сууцны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилттэй хөтөлбөрт зориулан Монголбанкнаас маш хямд эх үүсвэрийг олгож байгаа бөгөөд энэ нь багагүй хэмжээний зардлыг бий болгож, Монголбанканд хуримтлагдсаар байгаа. Энэхүү их хэмжээний зардал гарган хэрэгжүүлж байгаа тус хөтөлбөрт бага, дунд орлоготой зорилтот бүлгүүд хамрагдаж чадахгүй харин дундаж ба түүнээс дээш орлоготой иргэд хамрагдаж байна.

## 2.5. Орон сууцны үнийн өсөлт

Олон улсад жишиг болгон хэрэглэдэг “орон сууц худалдан авах боломжит үнийн түвшин” буюу орон сууцны медиан үнэ болон өрхийн медиан орлогын зохистой харьцаа орон сууцны үнийн хөөргөдлөөс үүдэн алдагдсан байна. Орон сууцны дундаж үнийн өсөлтийг /Зураг 13/ харуулав.

2012 онд орон сууцны нэг метр квадратын үнэ 1.5 сая төгрөг байсан бол 2013 онд буюу орон сууцны ипотекийн санхүүжилттэй зээлийн хөтөлбөр эхэлснээс хойш орон сууцны үнэ өсөж 2014 онд 2.1 сая төгрөгт хүрч 40%-иар өссөн байна. 2015 оноос эхлэн орон сууцны

Зураг 13 Орон сууцны дундаж м.кв. үнэ



Эх сурвалж: ҮСХ

Зураг 14


### ОРОН СУУЦ: УЛААНБААТАР

192 КОМПАНИ → 428 БАЙР → 45,080 АЙЛЫН ОРОН СУУЦ


	0%-25%	26%-50%	51%-75%	76%-100%	НИЙТ
Хан-Уул	2,149	1,913	4,836	10,659	19,557
Баянзүрх	2,369	3,296	4,032	3,964	13,661
Сүхбаатар	844	1,311	1,839	1,308	5,302
Баянгол	181	1,126	813	1,664	3,784
Сонгинохайрхан	1,029		207	623	1,859
Чингэлтэй	216	100	311	210	837
Налайх			80		80
<b>НИЙТ</b>	<b>6,788</b>	<b>7,746</b>	<b>12,118</b>	<b>18,428</b>	<b>45,080</b>



#### ОРОН СУУЦНЫ ДУНДАЖ ҮНЭ, ДҮҮРГЭЭР:



#### БАРИЛГЫН АЖИЛ ҮРГЭЛЖЛЭХ ХУЦГАЦАА:



үнэ тогтворжиж бага зэрэг буусан бөгөөд 2015-2021 оны хооронд дунджаар 1.8 сая төгрөг байсан бол 2020 оны 10 дугаар сард жилийн 8% хүүтэй тус хөтөлбөрийн зээлийн хүүг 6% болгон бууруулсан нь орон сууцны үнийн өсөлтөд нөлөөлж 2022 оноос эхлэн КОВИДын дараагаас орон сууцны үнэ огцом өсжээ. Тухайлбал, 2021 онд орон сууцны 1м2-ийн дундаж үнэ 1.8 сая төгрөг байсан бол 2022 онд 3.2 сая төгрөгт хүрсэн буюу 80 орчим хувиар үнэ нэмэгдэж тасралтгүй өссөөр 2025 оны байдлаар 1м2 орон сууцны үнэ дунджаар 4.4 сая төгрөг болсон байна.

Баянгол дүүрэгт 1 метр квадрат орон сууцны дундаж үнэ хамгийн өндөр буюу 4.2 сая төгрөг, Хан-Уул дүүрэгт 4 сая төгрөг байна /Жич: 2024 оны судлаачийн тооцоолол/. Улаанбаатар хотын төвийн зургаан дүүргээс Сонгинохайрхан дүүрэгт орон сууцны 1 метр квадратын дундаж үнэ 2.8 сая төгрөг байна.

2024 оны байдлаар Улаанбаатар хотод нийт 428 блокийн 45,080 айлын орон сууцны төслийг хувийн хэвшлийнхэн барихаар төлөвлөж, барилгын ажлыг гүйцэтгэж байсан /Зураг 14/. Хамгийн их буюу 19,557 айлын орон сууцны төсөл Хан-Уул дүүрэгт хэрэгжиж байна. Орон сууцны дундаж 1 метр квадратын үнэ барилгын явцаас хамаарч 2.8 – 4 сая төгрөгийн хооронд хэлбэлзэж байгаа бөгөөд дундаж үнэ 3.7 сая төгрөг байна /Зураг 14/.

Олон улсын жишгээр орон сууцны медиан үнэ – өрхийн медиан орлогын зохистой харьцаа 3-аас бага бол орлогод нийцсэн буюу орон сууц худалдан авах боломжит үнийн түвшинд нийцсэн гэж үздэг. Энэхүү аргачлалыг UN Habitat, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагууд орон сууц худалдан авах боломжит үнийн түвшин тодорхойлох судалгаандаа өргөн ашигладаг байна.

$$\text{House price-to-income ratio} = \frac{\text{Median house price}}{\text{Median household income}}$$

Манай улсын хувьд энэ харьцаа 7.5 байгаа нь “severely unaffordable” буюу орон сууц худалдан авах орон сууц худалдан авах боломжит үнийн түвшний зохистой харьцаа ихээхэн алдагдсан байна /Зураг 15/.

Зураг 15

## МОНГОЛ УЛСЫН ОРОН СУУЦНЫ ҮНЭ ОРЛОГЫН ХАРЬЦАА



Орон сууцны медиан үнэ  
Өрхийн жилийн орлого

Орон сууцны үнэ

Өрхийн жилийн орлого

$$7.5 = \frac{225,000,000}{30,000,000} \text{ Төг. (2.5 сая * 12)}$$

ОЛОН УЛСЫН ҮНЭ  
ОРЛОГЫН ЗОХИСТ  
ХАРЬЦАА:  
**3.0-5.0**

ОЛОН УЛСЫН ОРОН СУУЦНЫ  
ҮНЭ ОРЛОГЫН ЗОХИСТ  
ХАРЬЦААГ ХАНГАСАН ОРОН  
СУУЦНЫ ҮНЭ:

**90 сая төгрөг  
150 сая төгрөг**

### ХҮЛЭЭЖ БУЙ ДАРАЛАЛ




Орон сууцны 6 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрт ирүүлсэн өргөдлийн тоо 40,000 давсан бөгөөд 2-3 жилийн хүлээлгийн хугацаа үүссэн байна. Орон сууцны ипотекийн санхүүжилттэй зээлийн хөтөлбөрийн хүрээнд жилд 3,000-9,000 иргэн 6%-ийн зээл авч байна. Монголбанк болон Хуримтлалын сангийн эх үүсвэр ойрын жилүүдэд тогтмол өсөхгүй. Харин манай улсад жилд 17,000-19,000 өрх шинээр гэр бүл болдог гэж үзвэл өргөдлийн тоо жил бүр нэмэгдэж энэхүү хүлээлгийн хугацаа улам ихсэхээр байна

## 2.6. Амины болон нам давхрын орон сууцны зээлийн хүртээмжгүй байдал

Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн хүрээнд барилгын салбар хөгжиж байгаа боловч амины орон сууцны болон нам давхрын орон сууцны цогц хорооллын төслүүд болон орлогод нийцсэн орон сууцжуулалт зэрэг бүтээгдэхүүн хөгжихгүй, зөвхөн өндөр давхрын орон сууцны төслүүдэд хөтөлбөрийн зээл олгогдож улмаар орон сууцны үнийн өсөлтийг хөөрөгдөж байна.

Орон сууцны ипотекийн санхүүжилттэй хөтөлбөрийн зээлээр сүүлийн 3 жилд дунджаар 9,500 өрх орон сууцны зээл авч байгаа ба 2024 онд 12,000 өрх тус зээлээр орон сууц худалдан авсан байна. Амины орон сууцны зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, нам давхрын орон сууцны цогц хорооллыг хөгжүүлэх нь гэр хороолол, агаарын бохирдлыг бууруулах, түгжрэлийг сааруулахад нэн тустай боловч амины орон сууцны зээл жилд дунджаар зөвхөн 400 орчим гарч байгаа бөгөөд 2023 онд 448 өрх амины орон сууцны зээл авчээ /Зураг 16/.

Зураг 16 Амины орон сууцанд олгосон зээл /сая ₮/



Эх сурвалж: Монголбанк

Амины болон нам давхрын орон сууцны төлөвлөлттэй хорооллуудыг хөгжүүлэх, бодлогын түвшинд зээлийн санхүүжилтийг нэмэгдүүлэх, гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслүүдийг идэвхжүүлэх нь Улаанбаатар хотын агаарын бохирдол, хэт төвлөрөл, авто замын түгжрэлийг бууруулах, хотын захын бүсүүдийн хөгжлийг дэмжихэд чухал хувь нэмэр оруулна.

## 2.7. Орон сууцны ипотекийн санхүүжилттэй зээл олголтын нийгэмд үзүүлэх үр нөлөө

Орон сууцны ипотекийн санхүүжилттэй хөтөлбөрийн зээлд хамрагдахад нарийн шалгуур үзүүлэлт заагаагүй буюу хөнгөлөлттэй зээлийг байршил тодорхойлж, тухайлбал гэр хорооллын дахин төлөвлөлт хийсэн байршилд онцгойлон олгодоггүй учир хотын төвийн хэсгүүдэд орон сууцны нягтаршил ихсэж, түгжрэл нэмэгдүүлж, агаарын бохирдол бууруулахад төдийлөн хувь нэмэр оруулаагүй байна.

Орон сууцны ипотекийн санхүүжилттэй хөтөлбөрийн хүрээнд зээл олголт хийгдсэн орон сууцны байршлуудыг газрын зураг дээр нягтаршлаар

нь дүрсэлбэл хотын төвийн хэсгүүдэд хамгийн их орон сууцны төслүүд хэрэгжиж өрхүүд орон сууцны зээл авсан байна /Зураг 17/.


Тод улаанаар утааны голомтуудыг тодруулсан байгаа ба орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн хэрэгжилт нь утааг бууруулах чиглэлд хэрэгжиж чадаагүйг харуулж байна. Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн хүрээнд барилгын салбар, орон сууцны бүтээн байгуулалт идэвхтэй өрнөсөн бөгөөд Улаанбаатар хотын баруун талаар 5 шар, зүүн талаар Офицеруудын ордон, хойд хэсэгт 32-ын тойрог, урд хэсэгт Яармаг, Зайсан байршилд орон сууцны төслүүд ихээр хэрэгжсэн байна. Улмаар Энхтайваны өргөн чөлөө, Яармаг, Зайсан зэрэг дулааны дэд бүтцийн шугам

даган орон сууцны нягтаршлыг нэмэгдүүлжээ.

Иймд орон сууцны ипотекийн санхүүжилттэй хөтөлбөрийн зээлийг хотын тогтвортой хөгжлийн зорилготой уялдуулан, байршилд суурилсан тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу гэр хорооллын дахин

төлөвлөлтийг дэмжихэд чиглүүлэх нь зүйтэй байна. Энэ нь Улаанбаатар хотын хүн амын хэт төвлөрлийг бууруулж, хотын оршин суугчдын амьдралын чанарыг дээшлүүлэхэд чухал алхам болно.

Зураг 17 Агаарын бохирдол 2025 оны 01 сар



Эх сурвалж: НЗДТГ

### 3. ОРОН СУУЦНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦООГ ТӨРӨЛЖҮҮЛЭН ХӨГЖҮҮЛЭХ ЗАГВАР

Монгол Улсын орон сууцны санхүүжилтийн тогтолцоог төрийн татаас, хөнгөлөлт, төсөвт ачаалалтай загвараас зах зээлийн зарчимд суурилсан, хүртээмжтэй, санхүүгийн хувьд тогтвортой тогтолцоо болон шинэчлэх, тогтолцоог төрөлжүүлэх шаардлагатай талаарх саналыг энэхүү гуравдугаар бүлэгт тусгалаа. Тухайлбал, Орон сууцны санхүүжилтийн корпорац, Ипотекийн батлан даалтын сан, Ипотекийн төрөлжсөн банк зэрэг шинэ институцуудыг байгуулах саналыг дэвшүүлж байна. Герман, Казахстан зэрэг орнуудын сайн туршлагад үндэслэн урт хугацааны хуримтлалын тогтолцоог бий болгож хөгжүүлэх, зорилтот бүлгийг тодорхойлж дэмжих талаар санал танилцуулна. Мөн амины орон сууцны стандартыг сайжруулах, баригдаж дуусаагүй орон сууцны төсөлд төрөөс баталгаа

гаргах, хүртээмжтэй, орлогод нийцсэн орон сууцны нийлүүлэлтийг дэмжих нь чухал гэдгийг онцлов.

Дэлхийн банк, Германы Шпаркассэ банкны Олон улсын хамтын ажиллагааны сан болон Монголын судлаачид Монгол Улсад орон сууцны санхүүжилтийн тогтолцоог төрөлжүүлэх, шинэчлэх шаардлагатайг онцолж байна. Одоогийн төрийн татаастай, тогтворгүй моделийг орлож болох зах зээлийн зарчимд нийцсэн, ил тод, хүртээмжтэй, санхүүгийн хувьд тогтвортой тогтолцоо руу шилжих нь салбарын тогтолцооны шинэчлэлд зайлшгүй хэрэгтэй алхам юм. Үүний тулд институцийн шинэчлэл, зорилтот бүлгийг чиглэсэн оновчтой дэмжлэгийг хэрэгжүүлэх шаардлагатай байгааг зөвлөж байна.

### 3.1. Дэлхийн банкны зөвлөмж

Дэлхийн банкнаас дараах санал, зөвлөмжийг гаргаж байна:

**Орон сууцны ипотекийн санхүүжилттэй зээлийн зардал өндөр байна.** Монгол Улсын орон сууцны зээлийн санхүүжилтийн тогтолцоо нь төсөв, санхүүгийн хувьд тогтворгүй буюу ипотекийн зээлийн хүүгийн татаас олгож байгаатай холбоотойгоор Монголбанкны баланс дээр төсвөөс гадуурх их хэмжээний өр, төлбөр хуримтлагдсаар байгаа. Энэхүү хагас төсвийн (quasi fiscal) шинж чанартай үйл ажиллагаа нь төсөвт тусгагддаггүй учир орон сууцны ипотекийн санхүүжилттэй хөтөлбөрийн зээлийн төсөвт үзүүлэх ачаалал ил харагдахгүй нуугдаж байна.

**Бага орлоготой өрхүүд, зорилтод бүлгүүд болон гэр хорооллын оршин суугчид орон сууцны ипотекийн санхүүжилттэй хөтөлбөрийн зээлд хамрагдаж чадахгүй байна.** Одоогийн орон сууцны ипотекийн санхүүжилттэй зээлийн тогтолцоо нь зах зээлийн хүүтэй орон сууцны энгийн зээл авах боломжтой дунд болон өндөр орлоготой өрхүүдэд илүү




ашиг тусаа өгч байна. Харин бага орлоготой өрхүүд болон гэр хорооллын оршин суугчид орон сууцны ипотекийн санхүүжилттэй зээлд хамрагдах боломж хязгаарлагдмал хэвээр байна.

Өнөөдөр хэрэгжиж байгаа орон сууцны ипотекийн санхүүжилттэй зээлийн тогтолцоо нь:

- Банкууд Монголбанкнаас 2% хүүтэй эх үүсвэр төвлөрүүлж, зээлдэгчдэд 6% хүүтэй зээл олгодог бол зах зээлийн хүүтэй орон сууцны энгийн зээлийн хүү 18-23% байна.
- Нийт орон сууцны зээлийн 75 орчим хувь нь хөнгөлөлттэй ипотекийн зээл эзэлдэг хэдий ч үүний дөнгөж 30 орчим хувьд бага, дунд орлоготой өрхүүд хамрагдсан байна.
- Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн татаасыг улсын төсөвт ил тод тусгахгүй байгаа учир ирээдүйд төсвийн хариуцлага, ачааллыг бий болгохоор байна.
- Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн татаасыг улсын төсөвт ил тод тусгахгүй байгаа учир ирээдүйд төсвийн хариуцлага, ачааллыг бий болгохоор байна.

**Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх шаардлагатай.** Ипотекийн зээлийг дахин санхүүжүүлэхэд ашигладаг ипотекийн зээлээр баталгаажсан бонд (ИЗББ) нь олон

Зураг 18 Дэлхийн банк. Орон сууц болон орон сууцны санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх замын зураглал



Манай орны орон сууцны санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх замын зураглалын санал, төслийг Дэлхийн банкны судлаачид санал болгож байна /Зураг 18/.

нийтэд нээлттэй арилжаалдаггүй зөвхөн Монголбанк болон банкуудад шууд хуваарилдаг. Иймд энэ нь эрсдэлийг төвлөрүүлж, хөрөнгийн зах зээлийг төрөлжүүлэн хөгжүүлэхэд түлхэц болохгүй байна. Түүнчлэн, Монгол Улс дотоодын бондын зах зээлийг хөгжүүлж чадахгүй байгаа нь зөвхөн гадаад зах зээл дээрээс гадаад валютаар зээл авах, мөнгө босгох, своп хэлцэл хийх г.м. эрсдэлүүдийг бий болгож байгаа нь санхүүгийн эмзэг байдлыг улам нэмэгдүүлж байна.

**Нүүрсний хэрэглээ эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна.** Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхийн 80 орчим хувь нь нүүрс түлдэг бөгөөд энэ нь:

- Улаанбаатар хотын агаарын бохирдлын 55.6%;
- Хүүхдийн эрүүл мэнд, амьсгалын замын өвчнийг үүсгэх гол асуудал болж байна.

Иймд гэр хорооллыг дахин төлөвлөх, орчин үеийн дэд бүтэц, шугам, сүлжээнд холбогдсон амины болон нам давхрын орон сууцжуулалтыг хөгжүүлэх шаардлагатай байна.

**Стандартад нийцсэн амины орон сууцжуулалтыг дэмжих шаардлагатай.**

Амины орон сууцны барилгын тогтолцоо, стандарт сайн хөгжөөгүй байгаа нь дараах нөхцөл байдлыг үүсгэж байна:

1. Иргэд өөрсдөө барьсан амины орон сууц, байшингийн 80% нь стандарт бус;
2. 60% нь хүчтэй газар хөдлөлтөд өртөмтгий;
3. Дийлэнх нь стандартын шаардлага хангаагүйн улмаас улсын бүртгэлд бүртгүүлэх, барьцаалах боломжгүй байна.

**Орон сууцжуулалтын бодлогын өөрчлөлтийг хийх шаардлагатай.** Зорилтот бүлгийг орон сууцжуулалтад илүү хамруулахын тулд орон сууцны хөнгөлөлттэй зээлийн тогтолцоонд өөрчлөлт оруулах шаардлага үүсэж байна. Мөн дэд бүтцэд хөрөнгө оруулах, иргэд өөрсдөө барих орон сууцны аюулгүй байдал, үр

ашгийг дээшлүүлэхийн тулд амины орон сууцны барилгын стандарт, урьдчилан батлагдсан зураг төсөл, гүйцэтгэгч нарын сургалтыг цогцоор зохион байгуулах зэрэг санаачилгуудыг нэвтрүүлэх шаардлагатай байна.

Татаас ихтэй, төрийн дэмжлэгтэй орон сууцны зээлийн загвараас хямд өртөгтэй, эрчим хүчний хэмнэлттэй, ялангуяа гэр хорооллын орон сууцжуулалтыг дэмжих, зах зээлд чиглэсэн, санхүүгийн тогтвортой тогтолцоонд шилжихийг зөвлөж байгаа бөгөөд орон сууцны санхүүжилтийн тогтолцоог бэхжүүлэх хүрээнд дараах зөвлөмжийг өгч байна.

• **Ипотекийн зээлийг дахин санхүүжүүлэх тогтолцоог бэхжүүлэх:** Зах зээлийн хүүтэй ипотекийн зээлийг дахин санхүүжүүлэх, хувийн хөрөнгө оруулалтыг татах зорилгоор ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас гаргах төрийн дэмжлэгтэй бүтэц хөгжүүлэх.

• **Ипотекийн зээлийн батлан даалтын тогтолцоог нэвтрүүлэх:** Олон улсын сайн туршлагад түшиглэн, зорилтот бүлэгт орон сууцны зээл олгоход банкуудтай санхүүгийн эрсдэлийг хуваалцах, хүртээмжийг нэмэгдүүлэх.

• **Засгийн газрын үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх:** Урт хугацааны төгрөгийн санхүүжилтийг бий болгох.

• **Урт хугацааны хуримтлалын тогтолцоо бий болгох:** Урьдчилгаа төлбөрийн хуримтлал үүсгэх сайн дурын хуримтлалын тогтолцоог дэмжих буюу төрийн татаас, хөнгөлөлттэй байдлаас хамаарал багатай орон сууцны зээлийн санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх.

• **Орон сууцны ипотекийн санхүүжилттэй хөтөлбөрийн үйл ажиллагааг Монголбанкнаас Засгийн газар руу шилжүүлэх:** Төсвийн ил тод байдлыг хангаж, Монголбанкны төсвийн шинж чанартай үйл ажиллагааг үе шаттайгаар халах.

• **Зорилтот бүлэг:** Орлогын босгыг бий болгох буюу зорилтот бүлгийг тодорхойлж, бага орлоготой өрхөд хөтөлбөрийн татаастай зээлийг чиглүүлэх, татаасыг ил тод болгох.

### 3.2. Германы Шпаркассэ банкны Олон улсын хамтын ажиллагааны сангийн зөвлөмж

Германы Шпаркассэ банкны Олон улсын хамтын ажиллагааны сан дараах зөвлөмжийг өгч, дэмжин ажиллах санал гаргаж байна:

Манай улсад иргэдийн дунд, урт хугацааны хуримтлал үүсгэх санхүүгийн соёл, хандлагыг төлөвшүүлэх тогтолцоо бүрдүүлж, бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Мөн



иргэдийг орон сууцны зориулалттайгаар тогтмол хадгаламж үүсгэж чадсан иргэдэд Засгийн газраас урамшуулал олгох нь урт хугацааны хуримтлалыг дэмжих үр дүнтэй хөшүүрэг болж өгдөгийг онцолж байгаа. Түүнчлэн, бага хүүтэй орон сууцны зээл олгодог зөвхөн орон сууцны зээл олгох үйл ажиллагаа явуулах тусгай зориулалтын банк буюу санхүүгийн байгууллага байгуулахыг санал болгож байна. Эдгээр шийдлүүд нь манай улсын орон сууцны санхүүжилтийн тогтолцоог төрөлжүүлэх, тогтвортой болгоход бодит суурь болох юм.

### 3.3. Орон сууцны зах зээлийн асуудлаар манай орны судлаачдын зөвлөмж

“Орон сууцны санхүүжилтийн өнөөгийн байдал, боловсронгуй болгох арга зам” сэдэвтэй Д.Болдбаатар нарын 2024 онд хийсэн судалгааны тайланд дараах зөвлөмжийг өгсөн байна:

Монгол Улсын орон сууцны санхүүжилтийн тогтолцоог илүү хүртээмжтэй, тогтвортой болгох зөвлөмжүүд:

- Хөнгөлөлттэй болон зах зээлийн нөхцөлтэй орон сууцны зээлийн багцыг тэнцвэржүүлж, төрийн дэмжлэгийг зорилтот бүлэгт чиглүүлэн, хөтөлбөр бус тогтолцоо хөгжүүлэхийг санал болгожээ.

- Урт хугацааны санхүүжилтийн эх үүсвэр бий болгохын тулд ипотекийн зээлийг үнэт цаасжуулах тогтолцоог гүнзгийрүүлж, олон улсын зах зээлээс хөрөнгө татах боломжийг нээх шаардлагатайг дурдсан.
- Орлогын түвшин болон орон сууцны үнийн зөрүүг багасгахын тулд үнийн өсөлтөд нөлөөлж буй хүчин зүйлсийг бодлогоор зохицуулж, дэд бүтцийг өргөтгөх, хот төлөвлөлтийг сайжруулах хэрэгтэй гэж үзжээ. Мөн орон сууцны санхүүжилтийн зах зээлийн тогтолцоог хөгжүүлэх, зах зээлд төрөлжсөн зээлийн бүтээгдэхүүнүүдийг санал болгох шаардлагатайг онцолсон байна.

### 3.4. Орон сууцны ипотекийн зах зээлийн санхүүжилтийн тогтолцоог төрөлжүүлэх Эдийн засгийн хөгжлийн төвийн загвар

Орон сууцны зээлийн санхүүжилтийн тогтолцоог төрөлжүүлэх буюу (i) орон сууцны санхүүжилтийн корпорац, (ii) ипотекийн батлан даалтын сан, болон (iii) орон сууц хадгаламжийн банк буюу ипотекийн төрөлжсөн банк гэсэн гурван шинэ институтийг үүсгэн байгуулж, үе шаттай хөгжүүлэх шаардлагатай.


Монгол Улсад орон сууцны санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх, дундаж болон бага орлоготой өрхүүдийг илүү үр дүнтэй орон сууцжуулалтад хамруулахын тулд зах зээлийн зарчимд нийцсэн, олон төрөлт санхүүгийн бүтэцтэй, урт хугацааны хуримтлалд суурилсан тогтолцоог үе шаттайгаар нэвтрүүлэх шаардлагатай байна. Орон сууцны санхүүжилтийн корпорац, Ипотекийн зээлийн



батлан даалтын сан, Ипотекийн төрөлжсөн банк зэрэг институт байгуулснаар зээлдэгчдэд сонголттой, уян хатан бүтээгдэхүүн санал болгож төсвийн ачааллыг бууруулахын зэрэгцээ тогтвортой орон сууцны зээлийн хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэхэд чиглэгдэнэ. Мөн иргэдийн дунд, урт хугацааны хуримтлал үүсгэх санхүүгийн соёл, хандлагыг төлөвшүүлэх юм.

Зах зээлийн зарчимд нийцсэн, худалдан авах чадвар, орлогод нийцсэн хүүтэй орон сууцны ипотекийн зээлийн шинэ тогтолцоо, шинэ бүтээгдэхүүнүүдийг (иргэдийн орлого, хүсэл сонирхолд нийцсэн, уян хатан, олон төрлийн ипотекийн зээлийн бүтээгдэхүүн) бий болгох боломж буйг доорх зураг 19 харуулж байна.

Зураг 19 Орон сууцны зээлийн тогтолцоог төрөлжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх боломжтой юу?



Тэмдэглэл: Судлаачийн тооцоолол




Зураг 19-д дүрсэлснээр өнөөдөр манай улсад 6% хүүтэй орон сууцны ипотекийн санхүүжилттэй зээл болон 18-23%-ийн хүүтэй арилжааны банкуудын орон сууцны энгийн зээл гэсэн хоёр сонголтын хүрээнд иргэд орон сууцны зээл авч байна. Орон сууцны ипотекийн санхүүжилттэй 6% хүүтэй зээл авах хүсэлтээ өгсөн 36 сарын хүлээлгийн дараалал арилжааны банкуудад үүссэн нь тус хөтөлбөрийн санхүүжилт хангалтгүй байгааг харуулж байна. Цаашид тус хөтөлбөрийн санхүүжилт нэмэгдэх магадлал хязгаарлагдмал юм. Арилжааны банкуудын орон сууцны энгийн зээлийн хүү өндөр учир зөвхөн өндөр орлоготой иргэд хамрагдаж чадаж байна. Тухайлбал, 150 сая төгрөгийн дүнтэй орон сууцны ипотекийн зээлийг арилжааны банкнаас зах зээлийн 19.2% хүүтэй авахад сарын төлбөр нь 2,454,380 ₮, болох бөгөөд өр орлогын харьцаа хангах (45%) цалингийн доод хэмжээ 5,454,180 ₮ болно.

**Судалгааны үндсэн дээр орон сууцны санхүүжилтийн тогтолцоог шинэчлэх дараах бүтцийн өөрчлөлтүүдийг санал болгож байна.**

Орон сууцны санхүүжилтийн корпорац нь ипотекийн зээлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын хөрвөх чадварыг сайжруулахад дэмжин ажиллаж урт хугацааны санхүүжилт босгох боломжийг нэмэгдүүлнэ. Харин Ипотекийн зээлийн батлан даалтын сан нь зорилтот бүлгийн өрхүүдийн зээлийн эрсдэлийг бууруулж, зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн батлан даалтын үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ ипотекийн зах зээлийн хоёрдогч зах зээлийг мөн дэмжинэ. Ипотекийн зээлийн төрөлжсөн банк байгуулах нь иргэдийг урт хугацааны хуримтлал үүсгэх дадалд сургаж, эдийн засагт дотоодын хөрөнгийн тогтвортой эх үүсвэрийг бүрдүүлэхийн зэрэгцээ орлогод нийцсэн орон сууцны санхүүжилтийг бий болгох хөгжлийн чухал хэрэгсэл болно /Зураг 20/.

**Зураг 20** Орон сууцны зах зээлийн санхүүжилтийн тогтолцоог шинэчлэх загвар




Тэмдэглэл: Судлаачийн тооцоолол

### 3.4.1. Орон сууцны санхүүжилтийн корпорац байгуулах

Орон сууцны санхүүжилтийн корпорац (ОС-СК)-ийг байгуулах нь орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, мөн орон сууцны зээлийн үйлчилгээ үзүүлэгч санхүүгийн байгууллагуудын санхүүгийн хөрвөх чадварыг сайжруулахад дэмжлэг болно.

Шинээр байгуулагдах ОССК нь төр хувийн хэвшлийн түншлэлийн бүтэцтэй байгууллага байж болно. Орон сууцны санхүүжилтийн корпорац нь



орон сууцны зээлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудыг (банк, банк бус) урт хугацааны санхүүжилтээр хангаж, хөрвөх чадварыг нэмэгдүүлнэ. Тухайлбал, ОССК нь ипотекийн зээлээр баталгаажсан бонд (ИЗББ) гаргаж олон улсын болон дотоодын хөрөнгийн зах зээл, урт хугацааны хөрөнгө оруулагч болох амьдралын даатгал, Хуримтлалын сангаас урт хугацааны санхүүжилт татна. Мөн Дэлхийн банк, Европын сэргээн босголтын банк, Олон улсын санхүүгийн корпорац зэрэг олон улсын санхүүгийн байгууллагуудаас урт хугацааны санхүүжилт татаж

ажиллана. Бүрдүүлсэн санхүүгийн эх үүсвэрээр орон сууцны ипотекийн зээлийг санхүүжүүлэх үйл ажиллагаа явуулна. Ингэснээр, Монгол Улсад урт хугацааны хөрөнгө оруулалт татах суурийг тавьж өгөх юм. Арилжааны банкууд урт хугацааны орон сууцны зээл гаргахад тогтвортой санхүүжилтээр ОССК нь дэмжих буюу хадгаламжийн эх үүсвэрээс хэт

хамааралтай байх эрсдэлийг бууруулж өгнө. Үүний үр дүнд банкуудын зардал буурах нөхцөл бүрдэх бөгөөд зээлийн хүү аажимдаа тодорхой хэмжээнд буурна. Мөн орон сууцны зээлийн хүсэлт, бичиг баримтыг нэгзагвар, нэг стандарттай болгох замаар зээл хүсэгчдэд илүү ойлгомжтой, шударга, нээлттэй орчин бүрдүүлснээр зээлүүдийг багцалж ИЗББ гаргахад хялбар болно.

### 3.4.2. Ипотекийн зээлийн батлан даалтын сан байгуулах

**Зөвхөн орон сууцны ипотекийн зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэх “Ипотекийн зээлийн батлан даалтын сан”-г ОССК-ын бүрэлдэхүүн хэсэг эсвэл бие даасан бүтэцтэйгээр байгуулж болно.**

Түүний үндсэн үйл ажиллагааны чиглэл нь ипотекийн зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлнэ. Зорилтот бүлэг, бага, дунд орлоготой иргэдийн зээлийн эрсдэлийг тодорхой хэмжээнд хариуцсанаар банкны эрсдэлийг бууруулна. Ингэснээр ипотекийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх буюу зорилтот бүлэг, бага, дунд орлоготой иргэдийн орон сууцны зээлд хамрагдалт нэмэгдэнэ. Мөн орлогын албан ёсны бичиг баримтын бүрдэл дутуу буюу хувиараа хөдөлмөр эрхлэгч (Нийгмийн даатгал төлдөггүй) орон сууцны зээлд хамрагдах нөхцөл бүрдэнэ. Орон сууцны ипотекийн зээлийн үйлчилгээ үзүүлэх банк, санхүүгийн байгууллагуудын ИЗББ-д баталгаа гаргана. /Зураг 20/

Мөн тус сан нь ирээдүйд ипотекийн зээлийг багцлан үнэт цаасжуулах, хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татах зэрэг санаачилгуудыг дэмжин



ажиллах боломжтой. Үүнд, ипотекийн зээлээр баталгаажсан бондын төлбөрийн чадварыг сайжруулах зорилгоор баталгаа гаргах, шаардлагатай нөхцөлд хөрөнгө оруулагчийн эрсдэлийг бууруулах механизмыг бүрдүүлэх зэрэг үүргийг хэрэгжүүлж болно.

Тус сангийн үйл ажиллагаа нь зохицуулалтын орчин тодорхой, ил тод, мэргэжлийн удирдлагатай байх шаардлагатай бөгөөд санхүүгийн сахилга баттай, дотоод хяналтын тогтолцоог сайтар бүрдүүлсэн байх ёстой. Ийнхүү батлан даалтын санг ОССК-тай уялдуулан хэрэгжүүлснээр орон сууцны зээлийн хүртээмжийг нэмэгдүүлж, зах зээлийг илүү тогтвортой, хүртээмжтэй болгоход чухал хувь нэмэр оруулах боломжтой. Үүний тулд ОССК болон Ипотекийн батлан даалтын сан нь төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр байгуулагдаж, хувийн хэвшил манлайлан гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ Олон Улсын Санхүүгийн Корпорац, Европын Сэргээн Босголтын Банк зэрэг олон улсын хөгжлийн санхүүжилтийн байгууллагуудыг хувь эзэмшигчээр оролцуулах нь чухал юм.

### 3.4.3. Орон сууцны ипотекийн төрөлжсөн банк байгуулах

**Орон сууцны зээлийн тогтолцоог төрөлжүүлэх ипотекийн төрөлжсөн банк байгуулж орон сууцны зээлийн хуримтлалын шинэ тогтолцоог бий болгож, хүртээмжийг нэмэгдүүлнэ** /Зураг 21/.

Герман, Австри, Казахстан, Чех, Словак, Унгар, Франц зэрэг орнуудын орон сууцжуулалтын урт хугацааны хуримтлалын тогтолцоог судалж энэхүү төрөлжсөн банкны манай улсын онцлогт зохицуулан хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, төр хувийн хэвшлийн түншлэлийн (PPP) загвартайгаар байгуулах боломжтой. Ипотекийн төрөлжсөн банк буюу орон сууцжуулалтын урт хугацааны хуримтлалын энэхүү тогтолцооны үндсэн зарчим нь хоёр үе шаттай санхүүгийн загвараас бүрдэх юм. Үүнд: (i) төрийн дэмжлэгтэй урт хугацааны хуримтлал (3-15 жил) үүсгэх, болон (ii) орлогод нийцсэн хүүтэй ипотекийн зээлд хамрагдах баталгаагаар хангахад оршино. Ингэснээр сахилга баттай урт хугацааны хуримтлал үүсгэх зан төлөвийг иргэдийн дунд төлөвшүүлж, урт



хугацаат, бага хүүтэй орон сууцны зээлээр орон сууцтай болох боломжийг иргэдэд бүрдүүлж өгөх болно.

Манай улсад хэрэгжүүлж болох орон сууцны зээлийн төрөлжсөн банкны хувилбарыг дараах жишээгээр тайлбарлая.

#### Жишээ:

**Хуримтлалын үе шат** Орон сууцны хадгаламжийн банкны ипотекийн зээлд хамрагдах хүсэлтэй иргэд худалдан авах орон сууцны үнийн дүнгийн 20-50%-ийг сар бүрийн хуримтлал үүсгэн хамгийн багадаа 36 сарын хугацаатай жилийн 3% хүүтэй хуримтлуулах гэрээг төрөлжсөн банкт байгуулна. Жил бүр хадгаламж эзэмшигч бүрд тухайн жилд хуримтлуулсан нийт хуримтлалын 10%-20%-тай тэнцэх урамшууллыг төрөөс олгоно. Жич: Урамшууллын дээд хязгаар 5 сая хүртэлх хадгаламжаас бодож олгох буюу хамгийн ихдээ 500,000-1 сая төгрөгийн урамшууллыг олгоно. Ингэснээр арилжааны банкуудтай хадгаламжийн төлөө өрсөлдөөнийг

хязгаарлана. Тухайлбал, 5 сая төгрөгийн хадгаламж үүсгэхийн тулд 417,000 төгрөг сар тутам хадгаламжийн дансанд хуримтлуулах гэрээ байгуулах бөгөөд жилийн хүү 69,382 төгрөг болох бөгөөд төрөөс 500,000-1 сая төгрөгийн урамшуулал тус дансанд хийнэ /Зураг 21/.

**Зээл авах үе шат** Тус банкны нэг онцлог нь хадгаламжийн гэрээ байгуулахад орон сууцны үнийн дүнгийн 30-50%-ийг бүрдүүлбэл зээл авах боломж нээгдэх заалтыг оруулдаг. Хамгийн багадаа гурван жилийн турш сар бүр тогтмол хуримтлал үүсгэн худалдан авах орон сууцны үнийн дүнгийн 30-50%-ийг бүрдүүлсний дараа үлдсэн 50-70%-д тус банкнаас 7% хүүтэй 30 хүртэл жилийн хугацаатай орон сууцны зээл авах эрх үүснэ.


**Синдикат зээл** Төрөлжсөн банк нь орон сууцны зээл олгоходоо өөрийн эх үүсвэрийг арилжааны банктай хамтран синдикат зээл олгож болох юм. Тухайлбал, арилжааны банкнаас ипотекийн зээлийн тал хувийг нь зах зээлийн хүүтэй (жишээ нь 17%) авбал жигнэсэн дундаж зээлийн хүү 12% болно. Синдикат зээл олгохын давуу тал нь орон сууцны урьдчилгаа төлбөрийн дүнг 50% хүртэл биш 20-30%-д байх боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ арилжааны банкуудтай өрсөлдөх биш хамтран ажиллах боломж олгоно. Ингэснээр арилжааны банкуудын зах зээлийн хүүтэй орон сууцны ипотекийн энгийн зээл олгох боломж нэмэгдэнэ.

**Зөвхөн орон сууцны зээлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах төрөлжсөн банк байгуулах тухай хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх** буюу ипотекийн зээл олгох үйл ажиллагаагаар төрөлжсөн банк байгуулах нь тухайн улсын санхүүгийн систем, орон сууцны зах зээлд томоохон эерэг өөрчлөлт оруулах чухал үүрэг гүйцэтгэдэг байна. Тухайлбал, иргэдийн дунд урт хугацааны

хуримтлал үүсгэх дадлыг төлөвшүүлж өгдөг. Өрхийн урт хугацааны хуримтлал нь эдийн засагт хөрөнгийн хуримтлал үүсгэхэд нэн ач холбогдолтой. Ялангуяа орон сууцны хуримтлал гэх мэт урт хугацааны бүтэцтэй хуримтлалын хөтөлбөрүүдэд иргэд тогтмол хуримтлал үүсгэх нь дотоодын хөрөнгийн тогтвортой нөөцийг эдийн засагт бий болгож улмаар урт хугацааны хөгжлийн төслүүдэд хөрөнгө оруулалт хийх боломжийг бүрдүүлж өгдөг. Хамгийн чухал нь орлогод нийцсэн, бага, дунд орлоготой өрхүүдэд хүртээмжтэй орон сууцны зээлийн санхүүжилтийг энэхүү төрөлжсөн банкаар дамжуулан (урт хугацааны хуримтлал үүсгэн) бий болгож чадна. Жишээ нь Герман Улсын Бауспаркасс систем нь иргэдийг бага хүүтэй орон сууцны зээлд хамрагдах эрх авахын тулд сар бүр хуримтлал үүсгэх механизмыг дэмжиж, төрөөс урамшуулж өгдөг. Энэхүү бүтэц нь үндэсний тогтвортой хуримтлалыг бий болгохын зэрэгцээ үе үеийн иргэд, өрхүүдийг орон сууцжуулж байна. Ипотекийн зээлээр мэргэшсэн төрөлжсөн банк нь зөвхөн санхүүгийн байгууллага биш харин хөгжлийн нэг арга хэрэгсэл юм /Зураг 20/. Төрөлжсөн банк нь ИЗББ гаргаж ипотекийн зээлийн эх үүсвэрээ нэмэгдүүлж болно.

**Орон сууцны хадгаламжийн (төрөлжсөн) банкны бүтээгдэхүүнүүд** Орон сууцны хадгаламжийн банкны 7-12% хүүтэй ипотекийн зээлд хамрагдах хүсэлтэй зээлдэгч урьдчилгаа төлбөрийн зохих түвшин хүртэл (30-50%) хадгаламжийн банканд багадаа 3 жилийн хугацаатай, 3% хүүтэй хадгалуулна /Зураг 21/. Зээлдэгч нь урьдчилгаа төлбөрийн хувь хэмжээ, орлогын хувь хэмжээ болон орон сууцны үнэ зэргээс шалтгаалан 3.4.4-т тайлбарласан зээлийн бүтээгдэхүүнээс (бүтээгдэхүүн 1, 2, 3) өөрт таарах нөхцөлтэйг сонгоно.


**Зураг 21** Орон сууцны зах зээлийн санхүүжилтийн тогтолцоог шинэчлэх санал /Орон сууцны хадгаламжийн банк



Тэмдэглэл: Судлаачийн тооцоолол

### 3.4.4. Орон сууцны ипотекийн төрөлжсөн банкны бүтээгдэхүүн

Бүтээгдэхүүн 1:



Ипотекийн зээл №1: Орон сууцны үнийн дүнгийн 30%-ийг зээлдэгч гэрээнд заасан хугацаанд хуримтлуулсны дараа (3–6 жил) орон сууцны хадгаламжийн банк арилжааны банкттай хамтран ипотекийн синдикат зээл олгоно.

Бүтээгдэхүүн 2:



Ипотекийн зээл №2: Орон сууцны үнийн дүнгийн 50% хүртэл 3-с доошгүй жил хуримтлуулсны дараа зээлдэгчид орон сууцны хадгаламжийн банк дангаараа 7% хүүтэй ипотекийн зээл олгоно.

Бүтээгдэхүүн 3:



Ипотекийн зээл №3: Зээлдэгчид орон сууцны үнийн дүнгийн 50%-тай тэнцэх урьдчилгаа төлбөр бэлэн байх үед:

- Орон сууцны үнийн 50%-тай тэнцэх дүнтэй хугацаат хадгаламжийг орон сууцны хадгаламжийн банканд 3 жилээр нээнэ.
- Орон сууцны 100% дүнтэй тэнцэх ипотекийн зээл орон сууцны хадгаламжийн банкнаас хугацаат хадгаламж нээсний дараа авч эхний 3 жил 12% хүү төлнө.
- 3 жилийн дараа хугацаат хадгаламжид байгаа дүнг зээлээс суутган үлдсэн дүнд (50% орчим) 10% хүү төлнө.

Тэмдэглэл: Судлаачийн тооцоолол

Арилжааны банкнуудын зах зээлийн нөхцөлтэй орон сууцны энгийн зээлийг орон сууцны хадгаламжийн банкны зээлийн бүтээгдэхүүнтэй харьцуулахад одоогийн нөхцөлөөр орон сууцны ипотекийн санхүүжилттэй зээлийн дээд хязгаар 150 сая төгрөг хүртэл байгаа ба зээлдэгчдэд тавигдах эхний шаардлага өр орлогын харьцааны шаардлагыг хангасан байх юм. Орон сууцны энгийн зээлд хамрагдахад хамгийн багадаа 4.9 сая төгрөгийн орлоготой байх шаардлага үүсэж байна. Харин Орон сууцны хадгаламжийн банкны ипотекийн зээлийн бүтээгдэхүүн 7% байх бөгөөд өр орлогын харьцаа хангахад 2.6 сая төгрөгөөс багагүй байхад 150 сая төгрөгийн зээл авах боломжтой байна.

Үзүүлэлт	Орон сууцны хадгаламжийн банкны өөрийн эх үүсвэртэй зээл	Орон сууцны хадгаламжийн банк ба арилжааны банкны хамтарсан синдикат зээл	Арилжааны банкны зээл
Байрны үнэ	215,000,000	215,000,000	215,000,000
Зээлийн дүн 70%	150,000,000	150,000,000	150,000,000
Урьдчилгаа төлбөр 30%	65,000,000	65,000,000	65,000,000
Зээлийн хүү	7%	12%	17.00%
Зээлийн хугацаа	20 жил	20 жил	20 жил
Сарын эргэн төлөлт	1,162,948.00	1,651,629	2,200,200.00
ӨОХ 45% хангах өрхийн орлого	2,584,328.89	3,670,287	4,889,333

Тэмдэглэл: Судлаачийн тооцоолол

### 3.5. Зорилтот бүлгийг тодорхойлох

**Зорилтот бүлгийг тодорхойлж, Монголбанкнаас хэрэгжүүлж байгаа орон сууцны ипотекийн санхүүжилттэй хөнгөлөлттэй 6% зээлийг одоо байгаа тогтолцоогоор үргэлжлүүлж зорилтот бүлэгт чиглүүлэх шаардлагатай.**

Олон улсын туршлагаас судлахад төрөөс үзүүлж буй ямар нэгэн татаастай хөтөлбөр, тэр дундаа орон сууцны ипотекийн санхүүжилттэй хөтөлбөрийн зээлийг зөвхөн

зорилтот бүлэгт зориулан олгодог байна. Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн бодлого нь ил тод, зорилтот бүлэгт чиглэсэн шалгуур үзүүлэлттэй буюу хамгийн их хэрэгцээтэй байгаа иргэдэд чиглэсэн байна. Жишээлбэл, Герман улсын нийтийн орон сууцны тогтолцооны Wohnraumförderungsgesetz (Орон сууцны дэмжих тухай хууль) хуулар орлогын босго хэмжээнээс доогуур орлоготой хүмүүсийг орон сууцаар дэмжих харилцааг зохицуулдаг байна. Доорх жишээгээр улс орнууд зорилтот бүлгийг хэрхэн тодорхойлж байгааг харуулав.

#### Зорилтот бүлэг (Казахстан):



- Олон хүүхэдтэй гэр бүл
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд өсгөж буй гэр бүл
- Залуу гэр бүл
- Орон нутаг руу шилжин амьдрагсад
- Төрөөс тогтоосон зорилтод бусад бүлэг (эмч, сувилагч, цэрэг, цагдаа, онцгой)

#### Зорилтот бүлэг (Герман):



- Бага орлоготой өрх
- Өрх толгойлсон эх, эцэг
- Залуу эрдэмтэн өрх
- Эрчим хүчний хяналттай орон сууцанд хөрөнгө оруулагч
- Эрүүл мэнд, нийгмийн шалтгаанаар орон сууцанд орох шаардлагатай иргэн

#### Зорилтот бүлэг (Унгар):



- Бага орлоготой залуу өрх
- Хотын алслагдсан бүсэд суурьшдэг өрх
- Эрүүл мэнд, нийгмийн шалтгаанаар орон сууцанд орох шаардлагатай иргэн

**Тэмдэглэл:** Судлаачийн тооцоолол


Манай улсын хувьд Засгийн газраас Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулж, орон нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангах зорилгоор төрийн албан хаагчдад зориулан алслагдсан гурван дүүрэг, 21 аймгийн төвд орон сууц авахад нь барьцаа төлбөрийн батлан даалт үзүүлэх хөтөлбөр одоогоор хэрэгжүүлж байна. Өөр бусад ямар нэгэн шалгуур үзүүлэлтээр хөтөлбөр, хөнгөлөлттэй зээлийг олгохгүй байна. Иймд төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн журамд өөрчлөлт оруулж зорилтот бүлэгт чиглүүлэх шаардлагатай.

Өрхийн дата, мэдээлэлд үндэслэн зорилтот бүлгийг орлого, хүүхдийн тоо болон насны ангиллаар тодорхойлбол: (i) сарын 1-3 сая төгрөгийн орлоготой, хүүхэдтэй, УБ хот, аймгийн төвүүдэд амьдардаг нийт 75 мянга орчим өрх байгаа бол, (ii) сарын 1-3 сая төгрөгийн орлоготой, хүүхэдтэй, 35-аас доош насны залуу гэр бүл болох нийт 19 мянга орчим өрх УБ хот, аймгийн төвүүдэд амьдардаг байна /Зураг 22/. Иймд эдгээр иргэдэд тэргүүн ээлжинд хөнгөлөлттэй орон сууцны зээл, хөтөлбөрүүдийг чиглүүлж болох юм.

#### Зорилтот бүлгийг дараах байдлаар тодорхойлж болно



#### Зорилтот бүлэг:




Хүүхэдтэй өрх



Өрхийн орлого 1-2 сая төгрөг хүртэл



Төрийн албан хаагч (эмч, багш, цэрэг, цагдаа, онцгой байдлын албан хаагч зэрэг)



Хөгжлийн бэрхшээлтэй иргэд

Эх сурвалж: ГБХНХЯ

Зураг 22

**Уб хот, аймгийн төвийн орон сууцгүй өрх хүүхдийн тоо, орлогын ангиллаар**

Хүүхэд	NA	1 сая хүртэл	1 - 2 сая	2 - 3 сая	3 - 4 сая	4 саяаас дээш
0	99,884	17,037	23,098	17,901	10,105	13,616
1	26,891	9,232	13,689	11,607	7,031	9,973
2	22,044	8,968	13,139	11,726	7,500	10,980
3	13,541	5,942	8,069	6,970	4,639	6,979
4	6,586	2,775	3,765	3,174	2,035	2,889
5	2,408	1,050	1,315	1,031	617	1,084
<b>НИЙТ</b>	<b>171,354</b>	<b>45,004</b>	<b>63,075</b>	<b>52,409</b>	<b>31,927</b>	<b>45,521</b>

УБ ХОТ БОЛОН АЙМГИЙН ТӨВ, ХҮҮХЭДТЭЙ, 1-3 Сая

**75k**

1-3 сая төгрөгийн орлоготой, хүүхэдтэй УБ хот, аймгийн төвүүдэд амьдардаг

**Уб хот, аймгийн төвийн орон сууцгүй өрх Хүүхдийн тоо, орлого, 18-34 насны ангилалаар**

Хүүхэд	NA	1 сая хүртэл	1 - 2 сая	2 - 3 сая	3 - 4 сая	4 саяаас дээш
0	11,711	3,153	4,408	3,910	1,904	2,175
1	5,804	2,463	3,297	2,722	1,540	1,623
2	6,479	2,832	4,001	3,477	2,071	2,630
3	3,861	1,663	2,025	1,664	1,052	1,344
4	1,671	651	791	598	361	386
5	512	158	195	135	79	113
<b>НИЙТ</b>	<b>30,038</b>	<b>10,920</b>	<b>14,717</b>	<b>12,506</b>	<b>7,007</b>	<b>8,271</b>

УБ ХОТ БОЛОН АЙМГИЙН ТӨВ, 18-34 насны, хүүхэдтэй, 1-3 сая


**19k**

1-3 сая төгрөгийн орлоготой, хүүхэдтэй УБ хот, аймгийн төвүүдэд амьдардаг 35- аас доош насны

Орон сууцны ипотекийн санхүүжилттэй хөнгөлөлттэй 6% зээлийг одоогоор Монголбанк хэрэгжүүлж байгаа. Энэхүү хөнгөлөлттэй хөтөлбөрийг Монголбанкаар үргэлжлүүлж харин зорилтот бүлгийн хэмжээ, жил болгон олгох санхүүжилтийн шаардлага, хэдэн жил цаашид үргэлжлэх хэрэгцээг сайтар судлан анхнаас нь тогтох хэрэгтэй. Урт хугацаандаа 5-10 жилийн дараа тус хөтөлбөрийг Монголбанкаас Засгийн газарт бүрэн шилжүүлэх шаардлагатай бөгөөд үүний тулд дээр дурдсан

ОССК, Ипотекийн батлан даалтын сан, Орон сууцны хадгаламжийн төрөлжсөн банк зэрэг нь тогтолцоонд бүрэн хэмжээгээр хэрэгжиж орон сууцны санхүүжилтийн зах зээлийн механизм бүрдсэн байх учиртай. Мөн Төрийн орон сууцны корпорац /ТОСК/, Нийслэлийн орон сууцны корпорац /НОСК/ зэрэг орон сууцны нийлүүлэлтийг дэмжих байгууллагуудаар дамжуулан зорилтот бүлэгт чиглэх арга хэмжээ тогтмолжиж оновчтой болсон байх шаардлагатай. Үүний талаар 5-р бүлэгт дурдсан байгаа.

Зураг 23 Ерөнхий төлөвлөгөө 2040



Улаанбаатар хот болон аймгийн төвүүдийн агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулах зорилготой орон сууцны ипотекийн санхүүжилттэй хөнгөлөлттэй зээлийн хэрэгжилт уялдах шаардлагатай бөгөөд цаашид 6%-ийн зээлийг гагцхүү гэр хорооллын дахин

төлөвлөлттэй бүсэд олгох нь чухал юм /Зураг 23/. Үүний тулд гэр хорооллын дахин төлөвлөлтийн бүсүүдэд газар чөлөөлөх, дэд бүтэц холбох цаашлаад хувийн хэвшил барилгын төсөл хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх шаардлагатай. Үүний талаар 5-р бүлэгт дурдсан болно.

### 3.6.Амины орон сууц барих стандарт, санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх


Инженерийн дэд бүтэцтэй, стандартад нийцсэн амины орон сууцны барилга барих тохиолдолд орон сууцны ипотекийн санхүүжилттэй зээл авах боломжтой байгаа хэдий ч олгож буй зээлийн тоо хэмжээ маш бага байна. Амины орон сууцны барилгажилтыг дэмжих ажлын хүрээнд “Амины орон сууцны барилга угсралтын ажилд захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэх үйл ажиллагааг

зохицуулах журам”-ын төслийг ХБОСЯ-ны Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцэж дэмжсэн байна. Мөн ХБОСЯ-ны 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн сайдын тушаалаар Ногоон барилгын (BestGER) гэрчилгээ олгох журмыг баталжээ. Түүнчлэн, иргэдийг мэдээллээр хангах зорилгоор Амины орон сууцны мэдээллийн төвийг ХБОСЯ-с байгуулан ажиллаж байна /Зураг 24/.

**Зураг 24 Шинээр амины орон сууц барих дүрэм, журам, гэрчилгээ**


**Монголбанкны Ерөнхийлөгчийн 2024.10.09-ний өдрийн А-235 дугаар тушаал**

1.2.13 “Амины орон сууц” гэж аймаг, нийслэл, сумын төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу баригдсан, орон сууцны бүх хэсэг нь бие даасан ханаар хүрээлэгдсэн, эсвэл тусгаарлах хана нь нийлсэн болон хагас нийлсэн, эгнээгээр баригдсан орон сууцны зориулалттай сууцыг




Сингли Хаус

**BestGER үнэлгээний аргачлал:**  
ХБООС Сайдын 2024.12.02-ны өдрийн 108-р тушаал




**BestGER Гэрчилгээ олгох журам:**  
ХБООС Сайдын 2024.12.30-ны өдрийн 153-р тушаал



**АМИНЫ ОРОН СУУЦНЫ МЭДЭЭЛЛИЙН ТӨВ**

- Технологи
- Банкны зээл
- Зураг төсөл
- Зөвлөх үйлчилгээ
- Сургаам

1



**Эх сурвалж:** ХБОСЯ

Амины орон сууц болон нам давхрын орон сууцжуулалтыг дэмжих, гэр хорооллын дахин төлөвлөлтийг идэвхжүүлэх, агаар орчны бохирдлыг бууруулахад дараах бодлогын шийдлүүдийг санал болгож байна. Үүнд:

**Амины орон сууцны зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх буюу квот тогтоох:**

- Зээлийн хувь хэмжээг нэмэгдүүлэх:** Орон сууцны ипотекийн санхүүжилттэй 6%-н зээлийн 10-20%-ийг зөвхөн амины орон сууцны зээлд олгох. Жишээлбэл, 2026 онд 1 их наяд төгрөгийн зээл олгоход 10%-ийг буюу 100 тэрбум төгрөгийг амины орон сууцны зээлд олгож болно. Нэг зээлдэгч 150 сая төгрөгийн зээл авна гэж тооцоолбол нийт 650 орчим амины орон сууцны зээл олгогдоно.
- Урьдчилгаа төлбөрийг бууруулах:** Амины орон сууцны зээлийн урьдчилгаа төлбөрийг 20% хүртэл бууруулж болно. Гэр хорооллын иргэд хашаандаа тохилог амины орон сууц барихад урьдчилгаа төлбөрийн ачааллыг бууруулж зээлийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Банкны шалгуурыг зөөлрүүлэх:** Амины орон

сууцны зээлийн өргөдлийн шаардлагыг хялбарчлах, тухайлбал, орлогын албан ёсны бичиг баримтын бүрдэл дутуу буюу хувиараа хөдөлмөр эрхлэгч (Нийгмийн даатгал төлдөггүй) орон сууцны зээлд хамрагдах нөхцөлийг бүрдүүлэх, гэх мэт.

#### Амины орон сууц барих стандарт баталж, хөгжүүлэх:

- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 онд баталсан Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журмын 1.2.13-т Амины орон сууц гэдгийг “аймаг, нийслэл, сумын төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу баригдсан, орон сууцны бүх хэсэг нь бие даасан ханаар хүрээлэгдсэн, эсвэл тусгаарлах хана нь нийлсэн болон хагас нийлсэн, эгнээгээр баригдсан орон сууцны зориулалттай сууцыг” гэж тодорхойлсон. Энэ заалтыг уян хатан болгох заавал эгнээгээр баригдсан амины орон сууцад бус дангаас барьсан орон сууцанд ипотекийн зээл олгох;
- Арилжааны банкуудаас амины орон сууц барих зээл авахад зайлшгүй тухайн банктай гэрээтэй барилгын компаниар бариулсан байх ёстой шалгуур үзүүлэлтийг уян хатан болгох буюу стандарт шаардлага хангасан бусад амины орон сууц хөгжүүлэлтийн компанитай хамтарч ажиллаж

болох;

- Стандарт загвар боловсруулах: Амины болон нам давхрын орон сууцны хорооллын стандарт загварыг (2-4 давхар, 20-50 айлын барилга, гэх мэт) боловсруулж, эрчим хүчний хэмнэлт, байгаль орчинд ээлтэй байдлыг харгалзан стандарт баталж болно.
- Туршилтын төсөл хэрэгжүүлэх: Улаанбаатар хотын алслагдсан дүүргүүдэд (жишээ нь, Сонгинохайрхан, Баянзүрх) амины орон сууцны болон нам давхрын цогц хорооллын туршилтын төсөл хэрэгжүүлж, амжилттай загварыг хөгжүүлж болно.

Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц, нам давхрын хорооллуудыг хөгжүүлснээр гэр хорооллын утааны хэмжээг бууруулна. Хотын захын бүсүүдэд нам давхрын хороолол хөгжүүлж, нийтийн тээврийн холболтыг сайжруулснаар авто замын түгжрэлийг бууруулах боломжтой. Орлого багатай өрхүүдэд амины орон сууцны зээлийн хүртээмжийг нэмэгдүүлснээр амьдрах нөхцөлийг сайжруулж, хотын хэт төвлөрлийг бууруулна. Амины орон сууц болон нам давхрын цогц хорооллын хөгжлийг дэмжих нь Улаанбаатар хотын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд чухал хувь нэмэр оруулах болно.

## 4. ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: ТӨРӨЛЖСӨН ИПОТЕКИЙН БАНК

Олон улсад ипотекийн зээлийн санхүүжилтийн тогтолцоо өндөр хөгжсөн Герман, Сингапур, Казахстан орнуудтай харьцуулахад манай орны тогтолцоонд орон сууцны санхүүжилтийн урт хугацааны хуримтлалыг бүрдүүлэх оролцогч тал (төрөлжсөн банк/mortgage bank) дутагдаж байна.



Тухайлбал, зурагт зөвхөн орон сууцны зээл олгох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрөлжсөн банктай улс орнуудыг жишээ болгон харуулав.

### 4.1. Герман Улсын ипотекийн санхүүжилтийн тогтолцоо



30 сая гаруй харилцагчтай Bauparkasse банк. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад Орон сууцны барилгажилт, хуримтлалын тогтолцоо 19-р зууны сүүл үеэс эхлэн хөгжиж эхэлсэн ба одоо 8 орон нутгийн эзэмшилтэй болон 12 хувийн баушпаркессэ (орон сууцны хадгаламж, зээлийн төрөлжсөн

үйлчилгээтэй) банкууд үйл ажиллагаа явуулж байна. Баушпаркессэ банк нь үйлчилгээгээ 30 сая гаруй харилцагчдад үзүүлж байна. Тус банк нь орон сууц худалдан авахаар төлөвлөж буй иргэдэд зориулан урт хугацааны мөнгөн хуримтлал үүсгэхэд үйлчилгээ үзүүлж, улмаар бага хүүтэй ипотекийн зээл олгодог. Хуримтлалын дансанд 3Г-аас 10%-тай тэнцэх урамшууллыг жил бүр олгодог.

**Хуримтлал үүсгэх:** Иргэд Баушпаркессэ банктай сар бүрийн хуримтлуулах дүн, хуримтлал үүсгэх нийт хугацаа, хүүг тохиролцон хадгаламжийн гэрээ байгуулна. Герман Улсад иргэд хамгийн багадаа

4.5-6 жил хуримтлал үүсгэн урьдчилгаа төлбөрөө бүрдүүлсний дараа ипотекийн зээлд хамрагддаг байна. Уг хадгаламжийн данс нь жилийн дунджаар 0.1-1.0% хүүтэй бөгөөд Герман Улсын төсвөөс жилд дунджаар 150 еврогийн урамшууллыг хуримтлал үүсгэж буй хадгаламж эзэмшигчдэд олгодог байна.

Герман Улсад орон сууцны зээлийн урьдчилгаа төлбөр нь 20%-50% хооронд хэлбэлзэх ба удаан хугацааны турш, тогтмол хуримтлуулж байгаа зэргээс хамаарч ирээдүйд авах зээлийн хүү буурах боломж үүсдэг. Иргэд гэрээнд заасан хугацааны турш сар бүр тогтмол дүнгээр хуримтлалыг үүсгэнэ.

## 0.1% - 1%

Хадгаламжийн хүү

## €150

Төрийн урамшуулал


## 1.1% - 2%

Зээлийн хүү (Хадгаламжийн хүүнээс 1%-иас илүүгүй)

## 6 жил

Хуримтлал үүсгэх хугацаа

**Зээл авах:** Иргэн урьдчилгаа төлбөрийг тодорхой хугацаанд (6-10 жил) хадгалуулсны дараа бага хүүтэй орон сууцны ипотекийн зээлд хамрагдах боломжтой болно. Зээлийн хүү хадгаламжийн хүүгээс 1%-иар илүү байна. Тухайлбал, хадгаламжийн хүү 1% байсан гэж үзвэл орон сууцны зээл 2% байна.



Эх сурвалж: Шпаркассе сан

Арилжааны банкууд болон Баушпаркассе ипотекийн төрөлжсөн банкны эх үүсвэрүүдээс бүрдсэн синдикат зээлийг иргэдэд санал болгох ба ипотекийн зээлийг хоёр банк хамтран санхүүжүүлснээр зээлийн хүртээмжтэй байдал нэмэгдэх, зээлийн эрсдэлийг хуваалцах зэрэг давуу талтай. Ипотекийн зээлийг 100% гэж авч үзвэл 20% нь иргэдийн баушпаркассе банк дахь хадгаламжаас бүрдсэн урьдчилгаа төлбөр, 30% нь баушпаркассе банкны эх үүсвэрийн зээл, үлдсэн 50% нь арилжааны банкны эх үүсвэрээс бүрдэнэ. Герман Улсын ипотекийн төрөлжсөн банкуудын зээлийн хүү нь дунджаар 1.5%-3% хүүгийн хооронд хэлбэлздэг ба энэ нь тус ипотекийн банкуудын татсан эх үүсвэр буюу бага хүүтэй иргэдийн хадгаламжаас бүрдэх тул зээлийн хүү бага байдаг.

### 1. Хуримтлуулах үе шат

- Баушпаркассе банкттай 0.1-1.05% хүүтэй хуримтлалын гэрээ байгуулна.
- Хадгаламж эзэмшигч нь сар бүр тогтмол хуримтлал үүсгэнэ.
- Хуримтлалыг дунджаар 6 жил үүсгэнэ.

Эх сурвалж: Шпаркассе сан

### 2. Засгийн газрын урамшуулал

- Герман Улсын Засгийн газраас жилд нэг удаа дунджаар 150 еврог хуримтлалын дансанд олгодог.

### 3. Зээл авах үе шат

- Баушпаркассе банкттай байгуулсан гэрээний үндсэн дээр орон сууцны үнийн дүнгийн 20-50%-д зээл авна.
- Зээлийн хүү хадгаламжийн хүүгээс 1%-иас илүүгүй байна

#### Баушпаркассе банкны хуримтлалын схем:

Энэхүү схемээр хуримтлал хэрхэн бүрэлдэх болон цаашид хэрхэн хуваарилагддагийг харуулав.

Хуримтлал нь дараах хоёр эх үүсвэрээс бүрддэг:

(i) харилцагчдын сар бүрийн тогтмол хуримтлал, (i)

зээлийн эргэн төлөлт. Эдгээр бүрэлдсэн хөрөнгийг зээл авах эрх нь бүрдсэн хадгаламж эзэмшигчдийн зээл болох, хуримтлал үүсэж буй хадгаламжийн данснууд руу болон зээл авалгүйгээр хугацаанаас өснө цуцлагдаж буй данснууд зэрэгт хуваарилагддаг.

## 4.2. Казахстан Улсын төрийн дэмжлэгтэй ипотекийн зээлийн тогтолцоо (Отбасы банк)



**Бүгд Найрамдах Казахстан Улс 2003 оноос эхлэн зөвхөн ипотекийн зээл олгох үйл ажиллагааны чиглэлтэй төрөлжсөн банкны тогтолцоог бий болгож, түүнийг хөгжүүлэх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, амжилттай хэрэгжүүлж байна.**

Казахстан Улсын Засгийн газар нь 2000 онд “Орон сууцны барилгажилтын хуримтлал”-ын тухай хуулийг баталснаар ипотекийн зээлийн чиглэлээр төрөлжсөн банкны үйл ажиллагааг эхлүүлэх үндэс суурийг тавьсан. Отбасы төрөлжсөн банк нь Казахстаны орон сууцны хуримтлалын тогтолцоог хэрэгжүүлэгч байгууллага бөгөөд иргэдийг орон сууцжуулах зорилгоор урт хугацааны хуримтлал үүсгэх болон бага хувийн хүүтэй (3.5-5%) зээлийг олгодог. Мөн төрийн орон сууцны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд орон сууцжуулалттай холбоотой бүх төрлийн үйлчилгээ, хуваарилалтыг нэгтгэсэн үндэсний орон сууцжуулалтын хөгжлийн байгууллага болохоор аажмаар шилжин хөгжиж байна. Отбасы Банк нь Герман, Англи Улсад 18-р зуунаас эхлэн амжилттай хэрэгжиж байгаа “Building society” загвар дээр суурилсан төрөлжсөн банк бөгөөд зөвхөн орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах буюу урт хугацааны бага хүүтэй хуримтлал иргэдээс төвлөрүүлэн бага хүүтэй ипотекийн зээлийн үйлчилгээ үзүүлдэг. 2024 оны байдлаар Отбасы банк нь Казахстаны нийт ипотекийн зах зээлийн 55%-60%-ийг эзэмшиж орон сууцны хадгаламж, зээлийн санхүүжилтийн өвөрмөц загвартай хамгийн том орон сууцны ипотекийн зээлдүүлэгч болсон байна.

**2%**  
Хадгаламжийн  
хүү

**20%**  
Төрийн  
урамшуулал

**5%**  
Зээлийн  
хүү

**36** сар  
Хуримтлал  
үүсгэх хугацаа

### Зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний ерөнхий нөхцөл:

- 1. Гэрээ байгуулах.** Иргэд орон сууцны зээлийн хадгаламжийн гэрээг төрөлжсөн Отбасы банктай байгуулна.
- 2. Урьдчилгаа төлбөр 50%.** Худалдан авах орон сууцны үнийн дүнгийн 50%-ийг 36 ба түүнээс дээш сар тэнцүү хувааж хуримтлуулна.
- 3. Хадгаламжийн хүү 2%.** Банкны хадгаламжийн жилийн хүү 2% буюу жил бүр хуримтлалд 2% хүү тооцож өгнө.
- 4. Төрийн урамшуулал.** Жил бүр хадгаламж эзэмшигч бүрд тухайн жилд хуримтлуулсан нийт хуримтлалын 20%-тай тэнцэх урамшууллыг төрөөс олгоно. Жич: Урамшууллын дээд хязгаар 786,400 тенге хүртэлх хадгаламжаас бодож олгох буюу хамгийн ихдээ 157,000 орчим тенгений урамшууллыг олгоно.
- 5. 36 ба түүнээс дээш сараар хуримтлал үүсгэх.**

- Тус банкны орон сууцны зээлд хамрагдахад иргэн хамгийн багадаа 36 сар ба түүнээс дээш хугацаатайгаар хуримтлал үүсгэх ерөнхий шаардлагатай.
- 6. 3.5% - 5% хүүтэй зээл олголт.** 36 сарын дараа худалдан авах орон сууцны үнийн дүнгийн 50%-ийг бүрдүүлсний дараа орон сууцны үнийн дүнгийн 50%-д 3.5%-5% хүүтэй зээл олгоно /Зураг 25/.
- Хадгаламжийн хүү нь дунджаар 2% байх ба хадгаламж үүсгэх явцад банк харилцагчийн сахилга бат, хадгаламж үүсгэсэн хугацаа зэрэг хэд хэдэн шалгуурыг үнэлж оноо өгөх ба харилцагч зээл авах үед үнэлгээнээс шалтгаалан зээлийн хүүг 3.5 - 5% хүүгийн хооронд тохируулан зээлийн гэрээ байгуулдаг. Тус банк нь зээлдэгчийн хэрэгцээ, орлого болон нийгмийн бүлэгт тохирсон зээлийн үндсэн 3, зорилтот бүлэгт зориулсан 10 гаруй зээлийн бүтээгдэхүүнтэй.

Эх сурвалж: Отбасы банк

Зураг 25



Эх сурвалж: Отбасы банк

**Зорилтот бүлэгт зориулсан зээлийн бүтээгдэхүүнүүд:**

Казахстаны орон сууцжуулалтыг дэмжих систем нь орон сууцны хүртээмж, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг сайжруулах зорилгоор санхүүгийн сахилга баттай хадгаламж эзэмшигчдэд Отбасы банкнаар

дамжуулан төрийн хадгаламжийн урамшууллыг олгодог. Мөн зээлийн хүүгийн болон урьдчилгаа төлбөрийн татаасыг төрийн зүгээс нийгмийн зорилтот бүлэгт "7-20-25", "Нурлы Жер" зэрэг олон төрлийн хөтөлбөрөөр дамжуулан хүргэдэг /Зураг26/.

Зураг 26 Зорилтот бүлэгт зориулсан зээлийн бүтээгдэхүүнүүд:

Зээлийн бүтээгдэхүүн	Зээлийн хүү	Зээлийн хугацаа	Зээлийн хэмжээ	Тайлбар
Орон сууцны зээл	3.5% - 5%	6 - 25 жил	100 сая ₸ хүртэл	Орон сууцны үнийн дүнгийн 50% ба түүнээс дээш хэмжээнд хүртэл багадаа 3 жил хадгална, тогтмол хүүтэй зээл
Гүүр зээл	6% - 8.5%	25 жил хүртэл	100 сая ₸ хүртэл	Орон сууцны үнийн дүнгийн 50% хүртэл хуримтлуулахаас өмнө авах боломжтой, хадгаламжийн үлдэгдэл 50%-д хүрснээр хүү буурна.
Урьдчилсан зээл	7% - 13.5%	15 жил хүртэл	50 сая ₸ хүртэл	Хадгаламжийн үлдэгдэл 10% хүрэхэд зээл авч болох ба 50% болтол хүү төлнө, эхний хүү өндөр, хадгаламжийн шаардлагад хүрмэгц орон сууцны зээлд шилжинэ.
"Залуу гэр бүл" хөтөлбөр	6% (дараа нь 5%)	6 - 9 жил	100 сая ₸ хүртэл	Гэрлээд 5 жил хүрээгүй залуу гэр бүлд зориулагдсан, 1 жилийн хадгаламж, орон сууцны үнийн 50%-ийн хуримтлал шаардлагатай.
"Бақытты отбасы" хөтөлбөр 2-10-20	2%	20 жил хүртэл	Төрийн хөтөлбөрийн хэмжээнд	Олон гишүүнтэй гэр бүл, гэр бүлийн гишүүн хөгжлийн бэрхшээлтэй эсвэл өнчин, тэжээгчээ алдсан хүүхэд
Цэргийн албан хаагчийн зээл	6% - 8%	25 жил хүртэл	100 сая ₸ хүртэл	Цэргийн албан хаагчдад зориулагдсан, төрөөс орон сууцны төлбөрийн дэмжлэгтэй,"Аскери баспана 6/50" зэрэг тусгай хөтөлбөртэй.
Засварын зээл	6%	6 сар - 25 жил	6 сая ₸ хүртэл	Өмнө нь Отбасы банкаар орон сууц авсан иргэдэд зориулсан, орон сууцны засварлахад зориулагдсан зээл.
Наурыз хөтөлбөр	7-9%	19 жил хүртэл	36 сая ₸ хүртэл	Сүүлийн 5 жил орон сууцгүй байсан иргэд хамрагдах боломжтой
Ногоон зээл	12.50%	6 сар - 25 жил	35 сая ₸ хүртэл	Олон улсын ногоон амины орон сууцны шаардлага хангасан байх, 20-50% урьдчилгаа төлбөртэй
Хотын захын суурьших хөтөлбөр	5%	19 жил хүртэл	10 сая ₸ хүртэл	Угсралт, ариутгал, байгаль орчинд ээлтэй байх, галын болон бусад стандартыг хангасан хотын захад байршилтай орон сууцны зээл

Герман, Казахстан зэрэг улсын туршлагаас харахад орон сууцны ипотекийн төрөлжсөн банк нь урт хугацааны тогтвортой, хүртээмжтэй орон сууцны санхүүжилтийг бүрдүүлэхэд чухал үүрэгтэй байна. Германы Баушпаркассэ загвар нь өрхүүдийг санхүүгийн сахилга баттайгаар хуримтлал үүсгэхэд урамшуулан дэмжиж, төрийн урамшуулал болон бага хүүтэй зээлээр иргэдийг орон сууцтай болох боломжоор хангасаар иржээ. Үүнтэй адил, Казахстаны Отбасы Банк нь Германы энэхүү “Building society” загвар дээр тулгуурлан хадгаламжийн хүүгийн урамшуулал, төрийн татаас, хөнгөлөлттэй ипотекийн

зээл олгох орон сууцжуулалтын системийг амжилттай хэрэгжүүлж, тус орны нийт ипотекийн зах зээлийн 55%–60%-ийг эзэлсэн хамгийн том тоглогч болж иргэдийг амжилттай орон сууцжуулахад үнэтэй хувь нэмрээ оруулж байна. Иймд эдгээр туршлагаас дүгнэхэд урт хугацааны хуримтлал төвлөрүүлэх, төрийн хуримтлалын дэмжлэг үзүүлэх, урт хугацаатай бага хүүтэй орон сууцны зээл олгох бүхий үйл ажиллагаа явуулах төрөлжсөн банк байгуулах нь орон сууцны хүртээмжтэй байдал, нийгмийн тогтвортой байдлыг хангах суурь бүтэц болно.

## 5. ОРОН СУУЦНЫ НИЙЛҮҮЛЭЛТ

### 5.1. Орон сууцны нийлүүлэлтийн боломж (2025-2032 он)

Үндэсний баялгийн сан, орон сууцжуулалтын үндэсний хороо (ҮБСОСҮХ) нь 2024 онд байгуулагдсан. Тус хорооны даргаар Монгол Улсын Ерөнхий сайд, дэд даргаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд болон Нийслэлийн Засаг дарга нар ажиллаж байна.

ҮБСОСҮХ-ны ажлын алба болон хорооны гишүүд орон сууцжуулалтын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх хүрээнд холбогдох төр, захиргааны байгууллагуудтай

хамтран ажиллаж, Улаанбаатар хотын орон сууцны нийлүүлэлтийг төрөөс хэрхэн дэмжих, мөн гэр хорооллын дахин төлөвлөлт, орон сууцжуулалтыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрхэн хэрэгжүүлэх талаар төлөвлөгөөний хувилбаруудыг боловсруулсан болно /Зураг 27, 28/.

Нийслэлийн Засаг даргын Тамгийн газар, Эрчим хүчний яам, Ус сувгийн удирдах газар болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулсан орон сууцны нийлүүлэлтийн хувилбарууд, санхүүжилтийн хэрэгцээг зураг 28-аар танилцуулж байна.

**Зураг 27** Орон сууцжуулах төлөвлөгөө 2025

### ОРОН СУУЦЖУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ 2025-2032

№	Ангилал	НЭР	Нийт	2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032
1	Дэд төв	Баянхошуу (162 га 2,267 н/т)	6,500	462			2,354	900	900	900	984
2		Шархад (122 га 2,416 н/т)	6,000	338			1,846	1,000	1,000	900	916
3		Толгойт (37.5 га 570 н/т)	3,776				500	1,000	800	800	676
4		Дамбадаржаа (71.8 га 805 н/т)	4,968				500	800	1,100	1,100	1,468
5		Дэнжийн мянга (44.5 га 710 н/т)	3,094	1,008			1,000	250	500	336	
6	Төсөл	Сэлбэ дэд төв (382.5 га 6,362 н/т)	23,865		4,362	2,851	3,355	3,050	2,800	3,420	4,027
7		Солонго 1, 2 хороолол (17.2 га)	5,002	1,280	980	2,742					
8		Баянголын ам (10 га)	2,007			2,007					
9		Ханын материал (4 га)	712			712					
10		Шинэ Яармаг (4 га) Яармаг (214.7 га 3,848 н/т)	540 8,536		540		500	1,800	1,800	1,800	2,636
<b>НИЙТ</b>			<b>65,000</b>	<b>3,088</b>	<b>5,882</b>	<b>8,312</b>	<b>10,055</b>	<b>8,800</b>	<b>8,900</b>	<b>9,256</b>	<b>10,707</b>
				<b>27,337</b>			<b>37,663</b>				
№	Ангилал	НЭР	Нийт	2025	2026	2027	2028	2029	2030	2031	2032
1	Хувийн хэвшил	Гэр хорооллын дахин төлөвлөлт	31,355	4,000	4,500	4,500	4,500	4,000	3,600	3,700	2,555
2		Хувийн хэвшил	30,265	1,958	3,695	4,370	4,333	4,225	4,150	4,500	3,034
3		ТХХТ (Морин даваа, Ханын материал 3,000, Баянголын ам 1,764, Залуус 5,616)	13,380		882	4,765	3,989	1,744	1,000	1,000	
<b>НИЙТ</b>			<b>75,000</b>	<b>5,958</b>	<b>9,077</b>	<b>13,635</b>	<b>12,822</b>	<b>9,969</b>	<b>8,750</b>	<b>9,200</b>	<b>5,589</b>
				<b>41,492</b>			<b>33,508</b>				
<b>Нэр</b>			<b>НИЙТ</b>	<b>2025</b>	<b>2026</b>	<b>2027</b>	<b>2028</b>	<b>2029</b>	<b>2030</b>	<b>2031</b>	<b>2032</b>
Орон сууц /өрхийн тоо/			<b>140,000</b>	<b>9,046</b>	<b>14,959</b>	<b>21,947</b>	<b>22,877</b>	<b>18,769</b>	<b>17,650</b>	<b>18,456</b>	<b>16,296</b>
				<b>68,829</b>			<b>71,171</b>				

Эх сурвалж: НЭДТГ




**Орон сууцны 2025 - 2032 оны нийлүүлэлтийн төлөвлөгөө:**

Зураг 27, 28-д Нийслэл Улаанбаатар хотын 2025-2032 онуудад НЗДТГ-ын захиалгаар болон хувийн хэвшлийн салбар нийтдээ 140 мянган айлын орон сууц бүтээн байгуулах боломжтойг харуулж байна.

**НЗДТГ захиалгат төслүүд.** НЗДТГ захиалгаар хөгжүүлэх 65,000 айлын орон сууцны дахин төлөвлөлтийг

Баянхошуу, Шархад, Толгойт, Дамбадаржаа, Сэлбэ дэд төвүүдийг түшиглэн хөгжүүлэх бөгөөд Сэлбэ дэд төв нь дангаараа 23,865 айлын орон сууцны төслийг бүрдүүлж байна. Төслүүдийг төлөвлөгөөт цаг хугацаанд багтаан хөгжүүлэхэд тулгарах томоохон сорилтууд нь (i) дэд бүтцийн хөгжүүлэлт, (ii) газар чөлөөлөлт, (iii) төслийн орон сууцны борлуулалт зэрэг юм.

Зураг 28



Эх сурвалж: Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө

**Хувийн хэвшил бүтээн байгуулах төслүүд.** Гэр хорооллын дахин төлөвлөлт (31,355 айл), хувийн хэвшлийн орон сууцны төсөл (30,265 айл), төр хувийн хэвшлийн хамтарсан (13,380 айл) зэрэг томоохон орон сууцны төслүүд

нийтдээ 89,404 айлын орон сууцны бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна. Хувийн хэвшлийн нийлүүлэлтийн оргил жил нь 2027 он бөгөөд 13,635 айлын орон сууцны төсөл хөгжүүлэхээр төлөвлөжээ.

Зураг 29 2025-2028 онд хэрэгжүүлэх орон сууцны төслүүдийн газар чөлөөлөлт, дэд бүтцийн санхүүжилтийн төлөвлөлт

Зардлын нэр	Нийт хөрөнгийн дүн /тэрбум.төг/	Нийслэлийн төсөв /тэрбум.төг/	Төр хувийн хэвшил /тэрбум.төг/	Гадаад эх үүсвэр /тэрбум.төг/	Улсын төсвөөр бүрдүүлэх /тэрбум.төг/	Орон сууцны өрхийн тоо: 68,829			
						9,046	14,959	21,947	22,877
						2025	2026	2027	2028
1 Газар чөлөөлөлт	1,420.0	320.0			1,100.0	620.0	620.0	180.0	
2 Цахилгаан хангамж	1,476.4	-	384.0	587.3	505.2		109.3	330.0	65.9
3 Дулаан хангамж	7,788.6	-	3,588.8	1,442.4	2,757.5	744.9	1,036.3	470.7	505.5
4 Цэвэр ус хангамж	130.0				130.0		130.0		
5 Бохир ус	864.0	195.0	5.0	464.0	200.0		147.5	147.5	100.0
<b>Нийт</b>	<b>11,679.0</b>	<b>515.0</b>	<b>3,977.7</b>	<b>2,493.7</b>	<b>4,692.6</b>	<b>744.9</b>	<b>2,043.1</b>	<b>1,568.2</b>	<b>851.4</b>

Эх сурвалж: НЗДТГ, ЭХЯ, УСУГ



Амины орон сууцны бүсчлэлийг шар өнгөөр, нам давхрын орон сууцны бүсчлэлийг бүдэг улбар шар өнгөөр, өндөр давхрын орон сууцны холимог бүсийг тод улбар шар өнгөөр дүрсэлсэн болно. Орон сууцны ипотекийн

санхүүжилттэй 6%-ийн зээлийг Улаанбаатар хотын захын бүсүүд буюу бүдэг улбар шар болон шар өнгөөр тодруулсан бүсүүд рүү бүсчлэл зааж олгох нь утаа, агаар, хөрс ба орчны бохирдлыг бууруулахад хувь нэмэр оруулна.

## 5.2. Нийслэлийн Орон сууцны корпорац, Төрийн орон сууцны корпорацын үүргийг өргөжүүлэх санал

Үндэсний орон сууцжуулалтын бодлогын хэрэгжилтийг дэмжих, баригдаж буй орон сууцны гүйцэтгэлд баталгаа гаргах болон орлогод нийцсэн хүртээмжтэй орон сууцны нийлүүлэлтийг хангах үйл ажиллагааны чиглэлтэйгээр ТОСК, НОСК-ийг үүргийг өргөжүүлэхэд чухал ач холбогдолтой байна.


Орон сууцжуулалтын бодлогыг амжилттай хэрэгжүүлж байгаа зарим орны жишээг дурдвал Сингапур Улсад “Орон сууц, хөгжлийн зөвлөл” (Singapore Housing & Development Board), Казахстан Улсад “Казахстаны орон сууцны компани” (Казахская Жилищная Компания - Kazakhstan Housing Company), АНУ-д Fannie Mae зэрэг байгууллагууд дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байна.

Тухайлбал Казахстан Улсын “Казахстаны орон сууцны компани” буюу “Казахская Жилищная Компания”, “КЖК”, байгууллагын үндсэн зорилго нь хувийн хэвшлийг




дэмжих замаар үндэсний хэмжээнд орон сууцжуулалтын нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд оршиж байна. Дараах үндсэн арга хэрэгслүүдээр орон сууцжуулалтыг дэмждэг:

- Баригдаж дуусаагүй барилгын төслүүд дээр гүйцэтгэлийн баталгаа гарган барилга дуусахаас өмнө борлуулах боломж бүрдүүлэх;
- Хувийн хэвшлийн хэрэгжүүлж буй орон сууцны төслүүдийн бүтээн байгуулалтын санхүүжилтийн зээлийн хүүд татаас олгох;
- Орон сууцжуулалтыг санхүүжүүлэх зорилгоор “орон нутгийн” гаргасан бондыг буцаан худалдан авч санхүүгийн дарамтаас чөлөөлөх;
- Хот байгуулалтын хөгжлийн хөрөнгө оруулалтын төслүүдийг санхүүжүүлэх.



## “КАЗАХСТАН УЛСЫН ОРОН СУУЦНЫ КОМПАНИ”-ИАС БАРИГДАЖ БУЙ ОРОН СУУЦНЫ ТӨСӨЛД БАТАЛГАА ГАРГАХ НЬ

Казахстаны орон сууцны хяналтын портал нь бүс нутгуудад баталгаатай болон баталгаа аваагүй орон сууцны барилгын төслийн мэдээллийг харуулж байна. Энэ нь худалдан авагчдыг хамгаалах, ил тод байдлыг хангах зорилгоор хэрэгжиж буй орон сууцны төслүүдийг баталгаажуулахад Орон сууцны үндэсний компанийн гүйцэтгэх үүргийг онцолж байна.



Манай улсын хувьд ялангуяа ТОСК, НОСК-н чиг үүрэгт баригдаж дуусаагүй барилгын төслүүд дээр гүйцэтгэлийн баталгаа гаргах тухай асуудлыг нарийн судалж, хэрэгжүүлэх нь (i) орон сууц худалдан авагч иргэд болон барилгын гүйцэтгэгчдийн аль алиных нь санхүүгийн эрсдэлийг буруулах, мөн (ii) орлогод нийцсэн (барилгын ажил дуусаагүй явцын үед орон сууц

захиалахад м2 үнэ хямд байдаг) орон сууцжуулалтын хүртээмж, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх зэрэгт ихээхэн ач холбогдолтой.

Казахстан Улсын “Орон сууцны компани”-ийн үндсэн гол үүргүүдийн нэг болох “баригдаж дуусаагүй барилгын төслүүд дээр гүйцэтгэлийн баталгаа гаргах”-ыг жишээгээр тайлбарлая:

### Жишээ:

Орон сууцны барилгын гүйцэтгэгч нь \$50,000 долларын үнэтэй 100 айлын орон сууц барихаар төлөвлөв. Төслийн нийт өртөг =  $100 \times \$50,000 = \$5,000,000$ .

Хөрөнгө оруулалтын бүтэц:

Хөрөнгө оруулагч	Хөрөнгө оруулалт / нэг орон сууц/		Хөрөнгө оруулалт / нийт орон сууц/
Орон сууц худалдан авагч	\$10,000	20%	\$1,000,000
Барилгын гүйцэтгэгч компани	\$5,000	10%	\$500,000
Банкны зээл	\$35,000	70%	\$3,500,000
Нийт	\$50,000	100%	\$5,000,000

**ЖИЧ:** Орон сууц худалдан авагч бүр хувь нийлүүлсэн өмчийн борлуулалтын өмнөх гэрээнд гарын үсэг зурж, барилгын ажлын явцад 10,000 доллар төлнө.

#### Төрийн баталгааны тогтолцоо:

10,000 долларын урьдчилсан төлөлтөд илүү олон хүнийг татах зорилгоор Засгийн газар (КЖК-аар дамжуулан) орон сууц худалдан авагчийн өмчид

(урьдчилж төлсөн \$10,000-т) эрсдэлийн баталгаа гаргаж өгдөг ба төслийн 1%-тай тэнцэх шимтгэлийг барилгын компани нь КЖК-д төлдөг.

Хэрэв төсөл амжилттай хэрэгжиж дуусвал: орон сууц худалдан авагч захиалсан орон сууцаа авч, орон сууцны үнийн дүнгийн үлдэгдэл зөрүүг төлнө.

#### Хэрэв төсөл хэрэгжихгүй, төсөл хэрэгжүүлэгч бүтэлгүйтвэл:

КЖК-ийн Баталгааны сангаас орон сууц захиалагчид нөхөн олговор олгодог (10,000 долларыг нөхөн төлөх эсвэл өөр хөгжүүлэгчээр дамжуулан төслийг дуусгана).

Засгийн газар хуулийн арга хэмжээ авах эсвэл хөгжүүлэгчээс хөрөнгө нэхэмжилж болно.

**Дүгнэлт:** (1) Иргэдийг өмч хөрөнгөөрөө хохирох эрсдэлийг бууруулж, хамгаалж байна. (2) Орон сууцжуулалт, орлогод нийцсэн (1м2 өртөг хямд) орон сууцжуулалтыг дэмжиж байна.

Эх сурвалж: Казахстан орон сууцны компани

## Дүгнэлт

Монгол Улсын орон сууцны санхүүжилтийн өнөөгийн тогтолцоо нь орон сууцны ипотекийн санхүүжилттэй хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн хүрээнд тодорхой үр дүнд хүрсэн хэдий ч хүн амын орон сууцны хэрэгцээг тогтвортой, хүртээмжтэй, орлогод нийцсэн байдлаар хангах хэмжээнд хараахан хүрээгүй байна.

Олон улсын туршлагаас судлахад орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн санхүүгийн байгууллага, гэрээт, урт хугацааны хуримтлалын тогтолцоог бий болгох нь орлогод нийцсэн бага хүүтэй зээлд иргэд хамрагдах нөхцөл бүрдэж, барилгын салбар, эдийн засгийн өсөлтийг дэмжиж байна. Герман болон Казахстан Улсын туршлагаар зөвхөн орон сууцны ипотекийн зээлийн үйлчилгээ үзүүлэх төрөлжсөн банкаар дамжуулан урт хугацааны хуримтлалын

тогтолцоог амжилттай хэрэгжүүлж, иргэдийг орлогод нийцсэн, тогтвортой, хүртээмжтэй ипотекийн зээлийн санхүүжилтээр иргэдийг хангах нөхцөлийг бүрдүүлж байна.

Мөн Орон сууцны санхүүжилтийн корпорац, Ипотекийн батлан даалтын сан, Ипотекийн банк зэрэг санхүүгийн төрөлжсөн байгууллагуудыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн бүтэцтэйгээр байгуулж, хөгжүүлэхийг санал болгож байна. Монголбанк орон сууцны ипотекийн санхүүжилттэй зээлийн хөтөлбөрийг үргэлжлүүлэн санхүүжүүлэх ба нийлүүлэлтийн тал дээр Төрийн орон сууцны корпорац, Нийслэлийн орон сууцны корпорацын үүргийг өргөжүүлэн, баригдаж дуусаагүй барилгын төслүүдэд гүйцэтгэлийн баталгаа гаргах эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтийг нарийвчлан судалж, хэрэгжүүлэх нь орон сууцны нийлүүлэлт, үнийг

тогтворжуулах, зах зээлийн эрсдэлийг бууруулахад чухал ач холбогдолтойг олон улсын сайн туршлага баталж байна. Түүнчлэн, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, орон сууцны зах зээлд өрхийн оролцоог дэмжихийн тулд төсвийн арга хэрэгслийг, ялангуяа татварын хөнгөлөлт, буцаан орголт зэргийг стратегийн хувьд

ашиглах ёстой. Эдгээр шинэчлэлийг хамтад нь хийснээр үндэсний хөгжлийн зорилтуудыг дэмжсэн, Монгол Улсын иргэдийн амьдралын чанарыг сайжруулах тогтвортой, хүртээмжтэй орон сууцны санхүүжилтийн экосистемийг бий болгох боломжтой болно.

## Эх сурвалж

1. Worldbank “Housing Finance Policy in Emerging Markets” (2009) , Edited by Loic Chiquier and Michael Lea

2. German Sparkassenstiftung Mongolia, Loch, M. (2025). “Green Building Society: Chances for Mongolia”.

3. World Bank Task Team. (2024). “Increasing Access to Housing and Housing Finance For the Underserved in Mongolia”.

4. Монголбанк. (2025). “Орон сууцны санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх арга хэмжээний санал”.

5. Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар. (2025). “Тэр хорооллыг орон сууцжуулах төлөвлөгөө”.

6. Д.Болдбаатар, Б.Мөнхзаяа, Г.Ичинноров нар. (2024). “Орон сууцны санхүүжилтийн өнөөгийн байдал, боловсронгуй болгох арга зам”.

7. Л.Болдбаатар, Ц.Энхбаяр, Д.Дүгэржав. (2024). “Орон сууцны санхүүжилтийн экосистем дэмжих, идэвхжүүлэх”.

8. Musuku, T. B., Dao, H., Fuchs, M., & Ganbat, E. (2025).

“Mongolia: A Roadmap to Increase Access to Housing and Housing Finance for the Underserved”. World Bank.

9. Монголбанк. Статистик портал. 2025. <https://stat.mongolbank.mn/>.

10. Казахстан Улсын орон сууц барилгажилт, хуримтлалын банк (HCSBK). 2025. <https://hcsbk.kz/ru/>.

11. Отбасы банк, Казахстан Улс. 2025. <https://otbasybank.kz/>.

12. Казахстан улсын орон сууцны компани (КНС). Главная страница. 2025. <https://knc.kz/ru/>.

13. Үндэсний статистикийн хороо. Статистик портал. 2025. <https://1212.mn/>.

14. Тэнхлэг зууч ХХК. Албан ёсны вэбсайт. 2025. <https://tz.mn/>.

15. UN-Habitat. "The Global Housing Affordability Challenge: A More Comprehensive Understanding of the Housing Sector." Urban Data Digest, May 2019. <https://un-habitat.org>



08



## ЁС ЗҮЙ

Улсын төсөвт үйлдвэрийн газар нь тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлогоос хамааран 30 орчим дүрэм, журам байх шаардлагатай байдаг. Үүнээс жишиг болгон тус Төвийн дүрэм болон Ёс зүйн дүрмийг оруулж байна.



### СУДЛААЧИЙН ҮГ

Мөнхнасан  
ЖАРГАЛМАА

АХЛАХ  
МЭРГЭЖИЛТЭН

“Эрх зүйн орчны  
шинэчлэлийн  
хөтөлбөр”

Email: jargalmaa@nrpa.gov.mn

Утас: 70116838

“Эдийн засгийн хөгжлийн төв” нь Эдийн засгийн хөгжлийн зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг хариуцан салбарын оролцогчдын үйл ажиллагааны уялдааг хангаж, судалгаа, шинжилгээ хийх, мэргэжлийн дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий, улсын төсөвт үйлдвэрийн газар юм.

Одоогийн мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд ёс зүйн асуудлыг төрийн албан хаагчдын хувьд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиар зохицуулдаг байна. Төрийн өмчит хуулийн этгээдийн ажиллагсдын хувьд ёс зүйн харилцааг зохицуулсан албан ёсны эрх зүйн баримт бичиг байхгүй хэдий боловч дээрх хууль тогтоомжийг жишиг болгон ёс зүйн дүрмийг байгууллага дотооддоо батлан дагаж мөрдөж болохоор байна.

Ёс зүйн дүрмээр байгууллага, хамт олны дунд зөвшөөрөх, эс зөвшөөрөх харилцаа, хандлагыг ёс зүйн үүднээс тодорхойлж хамтын зөвшилцөл, дагаж мөрдөх хэм хэмжээ болгох нь хөдөлмөр эрхлэлт, байгууллагын үйл ажиллагааг ёс зүйтэй, бүгдэд таатай байдлаар зөв орчин бүрдүүлж, бүтээмжтэй гүйцэтгэх гол түлхүүр болохоос гадна байгууллагын соёлын үндэс болно.

Байгууллагын ажиллагсдын ёс зүйн дүрмийг боловсруулах хүрээнд бид Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Ажлын байрны аюулгүй байдлын жишиг дүрэм, Бүгд Найрамдах Казахстан Улс, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс, Оросын Холбооны Улсын албан хаагчдын ёс зүйн дүрмийг судлан үзсэн болно.

Дээрх судалгаа, төрийн албан хаагчдын ёс зүйг зохицуулсан хууль тогтоомж болон Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ”-нд суурилан боловсруулсан энэхүү дүрмийг жишиг болгон бусад байгууллага өөрийн онцлогийг тусган үйл ажиллагаандаа хэрэглэх боломжтой гэж үзэж байна.

# “ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ” УТУГ-ЫН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Гүйцэтгэх захирлын 2025 оны 6 дугаар  
сарын 18-ны өдрийн А/16 дугаар  
тушаалын хавсралт

## Нэг. Нийтлэг үндэслэл

**1.1.** Энэхүү ёс зүйн дүрэм (цаашид “Дүрэм” гэх)-ээр “Эдийн засгийн хөгжлийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газар (цаашид “Төв” гэх)-ын ажилтны баримтлах ёс зүйн хэм хэмжээг тогтооно.

**1.2.** Энэхүү дүрмийг төвийн нийт ажилтнууд дагаж мөрдөх бөгөөд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т хамаарах төвийн удирдах, эрх бүхий албан тушаалтан болон тухайлсан мэргэжлийн ёс зүйн дүрэмтэй хуульч, мэргэшсэн нягтлан бодогч зэрэг ажилтнууд тэдгээр хууль, дүрмээс гадна энэхүү дүрмийг баримтална.

## Хоёр. Зорилго

**2.1.** Төвийн нийт ажиллагсад ёс зүйн хэм хэмжээг хэвшил болгож, аливаа хэлбэрийн дарамт, ялгаварлан гадуурхалт, зүй бус үйлдэл, үйл ажиллагааг үл тэвчинэ.

**2.2.** Ажилтны аюулгүй, чөлөөтэй, идэвхи санаачлага, өсөлт хөгжил, үр дүнтэй ажиллах хамт олонч орчин нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн хандлагыг эрхэмлэнэ.

**2.3.** Эрхэлж байгаа ажил, албан тушаалаас үл хамааран Төвийн нийт ажиллагсад энэ дүрмийг баримтална.

## Гурав. Баримтлах зарчим

**3.1.** Төвийн ажилтан үйл ажиллагаандаа дараах ёс зүйн зарчмыг мөрдөнө:

**3.1.1.** Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх;

**3.1.2.** Шударга ёсыг эрхэмлэх;

**3.1.3.** Мэргэшсэн, мэргэжлийн байх;

**3.1.4.** Хараат бус байж гадны нөлөөнд үл автах;

**3.1.5.** Төвийн ажил хэргийн нэр хүндийг хамгаалах, нэгдмэл байдлыг хангах;

**3.1.6.** Харилцааны соёлыг эрхэмлэх;

**3.1.7.** Хариуцлагатай байх.

## Дөрөв. Ёс зүйн хэм хэмжээ

**4.1.** Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх зарчмын хүрээнд:

**4.1.1.** Албан үүргээ гүйцэтгэхдээ хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, нийгмийн болон гэрлэлтийн байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, улс төрийн болон хувийн үзэл бодол, эрүүл мэндийн байдал, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, гадаад төрх, төрсөн нутаг усаар нь ялгаварлан гадуурхахгүй, эрхийг нь аливаа хэлбэрээр хязгаарлахгүй байх, ялгаварлан гадуурхсан, эрхийг нь хязгаарласан байдлаар ойлгогдох эсхүл тайлбарлаж болох үйлдэл хийхгүй байх;

**4.1.2.** Үзэл бодлоо илэрхийлэх эрхээ эдлэхдээ хүний эрх болон хүн, хуулийн этгээдийн нэр хүнд, нэр төр, ажил хэргийн нэр хүндийг хүндэтгэх, нууц болон эмзэг мэдээллийг ашиглах, задруулах, тараахгүй байх, тэдэнд учирч болох эрсдэл, сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх;

**4.1.3.** Албан тушаалын бүрэн эрхээ ашиглан болон бусад аливаа байдлаар ажиллагсдыг үг, үйлдэл, цахимаар болон бусад хэлбэрээр дарамтлах, хүчирхийлэл үзүүлэх, бэлгийн дарамт үзүүлэхгүй байх, аливаа хэлбэрээр дарамталж хууль бус үйлдэл хийхэд турхирахгүй байх, дарамталсан байдлаар ойлгогдох эсхүл тайлбарлаж болох үйлдэл хийхгүй байх;

**4.1.4.** Улс төрийн нөхцөл байдал, улс төрийн нам, эвсэл, шашин шүтлэгтэй холбоотой хувийн үзэл бодол, итгэл үнэмшлээ бусдад тулгахгүй байх;

**4.1.5.** Ажилтны үндсэн эрхээ эдлэхэд буюу, тухайлбал, ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, сурч боловсрох, мэргэшлээ дээшлүүлэхэд саад учруулахгүй, хясан боогдуулахгүй байх, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх эс үйлдэхүй гаргахгүй байх;

**4.1.6.** Ажилтан хуульд заасны дагуу хүүхэд гаргах, асрах, эрүүл мэндийн үйлчилгээ авахаар чөлөө авахад ажил, албан тушаалын байдлаа ашиглан саад учруулахгүй, хясан боогдуулахгүй байх, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх эс үйлдэхүй гаргахгүй байх;

**4.1.7.** Бусдын өмчлөлийн зүйлсийг зөвшөөрөлгүй авч ашиглахгүй байх.

**4.2.** Шударга ёсыг эрхэмлэх зарчмын хүрээнд:

**4.2.1.** Бусдын хууль тогтоомж зөрчсөн, авлига авсан, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан, ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн үйлдлийг үл тэвчих;

**4.2.2.** Өөрийн болон бусдын ажлын гүйцэтгэлийг шударга, бодитой үнэлэх, аль нэг ажилтанд давуу байдал үзүүлэхгүй байх;

**4.2.3.** Өөрийн гаргасан ажил мэргэжлийн алдаа, дутагдал, ёс зүйн зөрчлийг хүлээн зөвшөөрөх, үйлдэлдээ дүгнэлт хийж бусдаас уучлалт гуйх, зохих хариуцлага хүлээх чадвартай байх.

**4.3.** Мэргэшсэн, мэргэжлийн байх зарчмын хүрээнд:

**4.3.1.** Мэдлэг, ур чадвараа сайжруулах, ажлын шинэ арга барил ашиглахад суралцах, өөрийгөө тогтмол хөгжүүлэх;

**4.3.2.** Өөрийн мэдлэг, ур чадвар, туршлага, ажил хэргийн мэдээ, мэдээлэл, зөвлөгөөг хамтран ажиллагсадтай хуваалцах;

**4.3.3.** Гүйцэтгэх удирдлага болон хамтран ажиллагсдыг бодит баримт нотолгоонд тулгуурласан, үндэслэл бүхий үнэн зөв мэдээлэл, мэргэшлийн зөвлөгөөгөөр хангах буюу буруу, ташаа, үндэслэлгүй мэдээлэл тараахгүй байх;

**4.3.4.** Гүйцэтгэх удирдлага болон хамтран ажиллагсдын үзэл бодолд нийцэх эсэхийг үл харгалзан аливаа дүгнэлт, шийдвэрийн үр дагавар, эрсдэл, сөрөг талыг анхааруулж байх;

**4.3.5.** Албан үүргээ гүйцэтгэхдээ байгууллагаас зөвшөөрсөн албаны цахим шуудан ашиглах, албан харилцаанд хувийн цахим шуудан ашиглахгүй байх,

**4.3.6.** Удирдах, удирдуулах зарчмыг баримталж, удирдах дээд шатны байгууллага, албан тушаалтнаас баталсан шийдвэр, хууль ёсны үүрэг даалгавар, шаардлагыг цаг тухайд нь мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэх.

**4.4.** Хараат бус байж гадны нөлөөнд үл автах зарчмын хүрээнд:

**4.4.1.** Ажил үүргээ гүйцэтгэхдээ ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдлаас зайлсхийх, нөлөөлөл үзүүлэх байдлаар оролцохгүй байх;

**4.4.2.** Ажил үүргээ гүйцэтгэхдээ ашиг сонирхол нь хөндөгдөх хүн, хуулийн этгээдэд хууль бусаар давуу байдал олгохгүй байх, тэдгээрээс бэлэг, хөнгөлөлттэй үйлчилгээ, бусад хангамж, ашигтай нөхцөл бүхий саналыг хүлээж авахгүй байх;

**4.4.3.** Бусдыг албан ажил үүргээ гүйцэтгэхэд нь нөлөөлөх, саад учруулах, хөндлөнгөөс оролцох, хууль бус үйлдэл, эс үйлдэхүй хийхийг шаардахгүй байх;

**4.4.4.** Албан үүргээ гүйцэтгэх хугацаандаа улс төрийн хувьд төвийг сахиж, улс төрийн нам, эвсэл, хөдөлгөөнөөс аливаа үүрэг хүлээхгүй, нөлөөлөлд автахгүй байх, аль нэг нам, эвсэлд давуу байдал олгох, тэдгээрт чиглэсэн үйлдэл, үйл ажиллагаанд Төвийн ажилтны хувьд оролцохгүй байх.

**4.5.** Төвийн ажил хэргийн нэр хүндийг хамгаалах, нэгдмэл байдлыг зарчмын хүрээнд:

**4.5.1.** Төвийн ажил хэргийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөх үйлдэл гаргахгүй байх;

**4.5.2.** Төвд биечлэн ирсэн, эсхүл утас, цахим сүлжээгээр хандан тусламж, мэдээлэл хүссэн иргэн, хуулийн этгээдэд

өөрийн хариуцсан чиг үүргийн дагуух мэдээллийг, эсхүл уг асуудлаар хандах байгууллагыг зааж туслалцаа үзүүлэх;

**4.5.3.** Хамт олны дунд эерэг уур амьсгал бүрдүүлэх, саналын зөрүүтэй тохиолдолд бусдын үзэл бодол, итгэл үнэмшил, мэргэшсэн байдалд хүндэтгэлтэй хандаж зөрчилдөөнийг эв зүйгээр шийдвэрлэх.

**4.6.** Харилцааны соёлыг эрхэмлэх зарчмын хүрээнд:

**4.6.1.** Төвийн ажиллагсад болон хамтран ажилладаг бусад байгууллагын хүмүүстэй хүндэтгэлтэй, соёлтой харилцах;

**4.6.2.** Ажлын байр, олон нийтийн газар, олон нийтийг хамарсан үйл ажиллагаа болон цахим орчин, нийгмийн сүлжээнд зүй бус үг хэллэг, үйлдэл, зан авир гаргахгүй байх;

**4.6.3.** Албаны харилцаанд нүүрний хувирал, биеийн хэлэмж, үг хэллэг, бусад байдлаар бусдыг үл тоомсорлох, тохуурхан даажигнах, дорд үзэх зэрэг хандлага гаргахгүй байх;

**4.6.4.** Төвийн хамт олны дунд эв нэгдэл, найрсаг харилцааг эрхэмлэх;

**4.6.5.** Залуу үе ахмадаа хүндэлж, ахмад нь залуу үедээ мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх.

**4.7.** Хариуцлагатай байх зарчмын хүрээнд:

**4.7.1.** Төвийн зорилго, ажлын байрны чиг үүргийг бүрэн ойлгож, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэн ажиллах, ажлыг цагийг үр бүтээлтэй ашиглаж, цаг баримтлах;

**4.7.2.** Төвийн эд хөрөнгө, техник, тоног төхөөрөмж болон албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглахгүй байх;

**4.7.3.** Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин, нийгмийн сүлжээнд төвийн үйл ажиллагаатай холбоотой зөвхөн албан ёсны байр суурийг илэрхийлэх, эх сурвалж нь тодорхой бус мэдээ, мэдээллийг өгөхгүй байх;

**4.7.4.** Албан томиллолтоор гадаад улсад ажиллахдаа Монгол Улсын болон Төвийн нэр хүндэд харшилсан аливаа үг, үйлдэл гаргахгүй байх, тухайн нутаг, орны соёл, зан заншлыг хүндэтгэж харилцах;

**4.7.5.** Албан үүргээ гүйцэтгэхдээ нийтийн ашиг сонирхол, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх нөлөөллийг тооцоолох, сөрөг нөлөө үзүүлэхгүй байхад анхаарах;

**4.7.6.** Бусдад саад учруулахгүй байх, дундын ашиглалтын өрөө, тасалгаа, эд хэрэгслийг цэвэр, нямбай хэрэглэх.

**4.8.** Удирдах албан тушаалтны ёс зүйн манлайлал

**4.8.1.** Гүйцэтгэх захирал болон нэгжийн удирдлага хамт олондоо ёс зүйн хувьд үлгэрлэх, зөв хэвшил, орчин бүрдүүлэхэд хамт олондоо манлайлал үзүүлэх;

**4.8.2.** Бусдад үүрэг даалгавар өгч шаардлага тавихдаа албан ёсны зохистой үг хэллэг хэрэглэх, зүй ёсны байдлаар харилцах;

**4.8.3.** Ажилтнуудад дарамт, шахалт үзүүлэхгүй, айлган сүрдүүлэхгүй байх;

**4.8.4.** Төвийн үйл ажиллагааг ажиллагсдын ажил, амьдралын тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй байхаар зохион байгуулах;

**4.8.5.** Нийт ажиллагсадтай шударга, тэгш хандах.

## Тав. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх

**5.1.** Ажилтан ашиг сонирхлын зөрчил болон бусад байдлаар албан үүрэг нь хувийн ашиг сонирхолтой нь зөрчилдөх нөхцөл байдал үүсч болзошгүй байгаа тохиолдолд шууд удирдлага болон Захиргааны удирдлагын хэлтэст мэдэгдэнэ.

**5.3.** Ажилтан ашиг сонирхлын зөрчлийн талаар 5.1-т заасны дагуу мэдэгдсэнээс хойш уг асуудлыг шийдвэрлэх хүртэл хугацаанд тухайн үүргээ гүйцэтгэхийг түдгэлзүүлнэ.

**5.4.** Дүрмийн 5.1-т заасны дагуу мэдэгдсэн ашиг сонирхлын зөрчлийг Захиргааны удирдлагын хэлтэс Гүйцэтгэх захиралд танилцуулан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг баримтлан шийдвэрлэнэ.

**5.5.** Ажилтан албан ажил, чиг үүргээ хэрэгжүүлэн гүйцэтгэж буй ажил, судалгаа, үр дүн, шийдвэрийг гаргахдаа хувийн болон нэгдмэл сонирхол бүхий этгээдэд ашигтайгаар гаргах, эсхүл бусад этгээдээс өөрт (нэгдмэл сонирхолтой этгээдэд) санхүүгийн давуу байдал үүсгэх байдлаар төлбөр авахыг хориглоно. Энэ тохиолдолд ноцтой зөрчилд тооцохоос гадна холбогдох хуулийн дагуу эрх бүхий байгууллагад хандана.

## Зургаа. Ёс зүйн зөвлөл

**6.1.** Ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих, тус Төвийн ажиллагсадтай холбоотой гомдол, мэдээлэл, хүсэлт хүлээн авч шийдвэрлэх үүрэг бүхий 5-аас дээш хүний бүрэлдэхүүнтэй Ёс зүйн зөвлөл нь дараах бүтэцтэй байна:

- Зөвлөлийн дарга: Төвийн Гүйцэтгэх захирал болон Захиргааны удирдлагын хэлтсийн дарга байж болохгүй бөгөөд зөвлөлийн анхны хурлаас дийлэнх олонхын саналаар сонгоно,

- Зөвлөлийн нарийн бичиг: Хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн,

- Зөвлөлийн гишүүн:

- 29 хүртлэх насны ажиллагсдын төлөөлөл,
- 39 хүртлэх насны ажиллагсдын төлөөлөл,
- 49 хүртлэх насны ажиллагсдын төлөөлөл,
- 50-аас дээш насны ажиллагсдын төлөөлөл.

**6.2.** Зөвлөлийн гишүүдийг тухайн насны ангиллын ажиллагсдаас санал хурааж хамгийн олон санал авсан төлөөлөөс, бүрэлдэхүүний хүйсийн тэнцвэрт байдлыг ханган бүрдүүлж, анхны хуралдаанаар Зөвлөлийн даргыг сонгоно.

**6.3.** Зөвлөлийн бүрэлдэхүүнийг сонгох, бүрдүүлэхдээ албан тушаал, боловсрол, мэргэжлээс үл хамааран аливаа асуудалд зарчимч байдлаар тэгш эрхийн үүднээс ханддаг, хүнлэг ёсыг эрхэмлэдэг байдлыг шалгуур болгоно.

**6.4.** Зөвлөлийн хурал бүх гишүүд ирснээр хүчинтэйд тооцогдож, олонхийн саналаар шийдвэр гаргана.

**6.5.** Зөвлөл улиралд нэг удаа санал, мэдээлэл, хүсэлтийг хэлэлцэхээр, гомдол ирсэн тухай бүр хуралдана.

**6.6.** Ёс зүйн зөрчлийн шинжтэй үйлдэлд өртсөн ажилтны мэдээллийн нууцлалыг зөвлөлийн гишүүд хадгална.

## Долоо. Ёс зүйн зөрчлийг талаар гомдол, мэдээлэл гаргах, шийдвэрлэх

**7.1.** Ёс зүйн зөрчлийн шинжтэй санал, мэдээлэл, хүсэлтийг Зөвлөлийн нарийн бичиг хүлээн авна. Ажилтан болон бусад этгээдээс Төвийн ажилтантай холбоотой ёс зүйн асуудлаар санал, мэдээлэл, хүсэлт хүлээн авах тусгай цахим хаяг нээх болон хайрцаг байрлуулж болно.

**7.2.** Ёс зүйн зөрчлийн шинжтэй үйлдэлтэй холбоотой гомдлыг Зөвлөлийн дарга хүлээн авна.

**7.3.** Зөвлөлийн дарга ажилтнаас гомдол хүлээн авсан бол нэн даруй зөвлөлийн хурлыг зарлаж, шаардлагатай бол нэмэлт тайлбар, баримт бүрдүүлнэ.

**7.4.** Зөвлөлийн хурлаас дараах шийдвэрийг гаргана. Үүнд:

**7.4.1.** Ёс зүйн талаарх санал, мэдээлэл, хүсэлтийн дагуу хамт олны дунд уриалга гаргах, товч мэдээлэл хийх зэргээр нийтэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээ авах;

**7.4.2.** Тухайлсан ажилтанд нөхөрсөг зөвлөмж биечлэн өгөх;

**7.4.3.** Ёс зүйн зөрчил гаргасан болон түүнд өртсөн ажилтантай ганцаарчилсан уулзалт хийж асуудлыг эв зүйгээр шийдвэрлэж, тухайн зөрчлийг дахин гаргахгүй байх арга хэмжээ авах;

**7.4.3.** Ёс зүйн зөрчил нь ноцтой бөгөөд сахилгын зөрчилд тооцогдохоор бол Захиргааны удирдлагын хэлтсийн даргад, шаардлагатай бол Төвийн Гүйцэтгэх захирал мөн түүнчлэн харьяалах дээд байгууллагын удирдлагад уламжлах;

**7.4.4.** Ёс зүйн зөрчил нь захиргааны зөрчил, гэмт хэргийн шинжтэй бол төрийн эрх бүхий байгууллагад мэдээллийг хүргэж шалгуулна.

# “ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ”

## УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

**Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 77 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт**

### Нэг.Нийтлэг үндэслэл

**1.1.** Энэ дүрмийн зорилго нь “Эдийн засгийн хөгжлийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газар (цаашид “Төв” гэх)-ын чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэл, удирдлагын эрх хэмжээ, төвийн үйл ажиллагааны болон санхүү, хөрөнгийн хяналтыг хэрэгжүүлэх журам, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**1.2.** Төв нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Эдийн засгийн хөгжлийн зөвлөлийн ажиллах журам, холбогдох бусад хууль тогтоомж болон энэ дүрмийг баримтлан ажиллана.

**1.3.**Төвийн оноосон бүтэн нэр нь “Эдийн засгийн хөгжлийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газар, товчилсон нэр нь “ЭЗХТ-УТҮГ” байна.

**1.4.**Төв нь улсын төсвөөс санхүүжих бөгөөд чиг үүргээ батлагдсан төсөв, орон тооны хязгаарт багтаан хэрэгжүүлнэ.

**1.5.**Төв нь холбогдох журмын дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас болон албаны цахим хаяг, хуудсыг хэрэглэнэ. Тэмдгийг төвийн гүйцэтгэх захирлаас итгэмжлэн хариуцуулсан этгээд түшиж, ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг хариуцна.

### Хоёр.Төвийн чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэл

**2.1.**Төв нь бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлэх чиглэлээр шаардлагатай судалгаа, шинжилгээ хийх, салбарын оролцогчдын үйл ажиллагааны уялдааг хангаж, мэргэжлийн дэмжлэг үзүүлэх үндсэн үүрэгтэй бөгөөд Эдийн засгийн хөгжлийн зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг хариуцан гүйцэтгэнэ.

**2.2.**Төв нь үндсэн үүргийн хүрээнд дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулна:

**2.2.1.**Доор дурдсан асуудлын хүрээнд бие даан, эсхүл дотоод, гадаадын эрдэмтэн, судлаачдын оролцоотой хийсэн судалгаа, шинжилгээний үр дүн, тайланг Эдийн засгийн хөгжлийн зөвлөлд танилцуулах:

**2.2.1.1.**хөгжлийн урт болон дунд хугацааны бодлогын зорилтуудтай уялдуулан улс орны өрсөлдөх чадвар, давуу тал, тодорхой салбар, бизнест ээлтэй хөрөнгө оруулалтын орчны талаар;

**2.2.1.2.**олон улсад шинэ тутам хөгжиж байгаа эдийн засгийн үйл ажиллагааны шинэ салбар, үйлдвэрлэл, технологи, тэдгээрийг дотоодын зах зээл, бизнесийн орчинд нутагшуулах боломжийн талаар;

**2.2.1.3.**эдийн засгийн салбарын бүтээмж, экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээний талаар;

**2.2.1.4.**төсөв, санхүү, эдийн засгийн бодлогын төлөвлөлтийг сайжруулах, эдийн засгийн хөгжилд тулгарч болох эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар;

**2.2.1.5.**Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын тэргүүлэх салбар, хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг эрэмбэлэх, эдийн засгийг дэмжих томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний талаар.

**2.2.2.**Эдийн засгийн хөгжлийн зөвлөлийн хуралдааныг зохион байгуулах, шийдвэрийг албажуулах, гарсан зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлэх;

**2.2.3.**Эдийн засгийн хөгжлийн зөвлөлийн гишүүдийг шаардлагатай мэдээллээр хангаж, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

**2.2.4.**Эдийн засгийн хөгжлийн зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах тайлан, мэдээ, статистик тоо баримт, лавлагааг холбогдох байгууллагаас гаргуулан авах, холбогдох санал, дүгнэлтийг боловсруулж танилцуулах;

**2.2.5.**Эдийн засгийн хөгжлийн зөвлөлийн үйл ажиллагааны тайлан, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд түгээх;

**2.2.6.**дотоод, гадаадын томоохон аж ахуйн нэгж болон

шинэ хөрөнгө оруулагчид үйл ажиллагаагаа эхлүүлэх, бизнесээ өргөжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах, хамтарсан уулзалт зохион байгуулах;

**2.2.7.** Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр төрийн болон холбогдох бусад байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулж, мэргэжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

**2.2.8.** Шинэ сэргэлтийн бодлого, хөтөлбөрийн хөгжлийн төслүүдэд судалгаа, дүн шинжилгээ хийж, оролцогч тал болон холбогдох бусад байгууллагуудын тайлан, мэдээг нэгтгэх, мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээлэх.

## Гурав.Төвийн удирдлага

**3.1.** Төвийн өдөр тутмын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, энэ дүрэмд заасан эрх хэмжээний хүрээнд гүйцэтгэх захирал удирдан зохион байгуулна.

**3.2.** Гүйцэтгэх захирлыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга томилж, чөлөөлнө.

**3.3.** Гүйцэтгэх захирал нь Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан нийтлэг шаардлага болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан байна.

**3.4.** Гүйцэтгэх захирал нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

**3.4.1.** төвийн үндсэн үүрэг, үйл ажиллагаа болон холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах;

**3.4.2.** холбогдох судалгаа, шинжилгээний эцсийн үр дүнг хянах, баталгаажуулах;

**3.4.3.** батлагдсан төсөв, хөрөнгийг зориулалт, холбогдох хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, тайлагнах;

**3.4.4.** төвийн үйл ажиллагааны ажлын үр дүнг тооцох, тайлагнах;

**3.4.5.** батлагдсан бүтэц, орон тоондоо багтаан ажилтныг томилох, чөлөөлөх, хөдөлмөрийн гэрээ байгуулах, урамшуулал олгох, хариуцлага тооцох;

**3.4.6.** ажилтны ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн дотоод журам болон төвийн албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг зохих журмын дагуу баталж мөрдүүлэх;

**3.4.7.** төвийн үндсэн үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай

хүний нөөцийг бүрдүүлэх, чадавхжуулах болон техникийн болон эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны байдлыг хангах, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх;

**3.4.8.** анхан шатны бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг биечлэн хариуцах;

**3.4.9.** өөрийн эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, үйлдвэрийн газрыг гадаад, дотоодод итгэмжлэлгүйгээр төлөөлөх, итгэмжлэл олгох;

**3.4.10.** өөрийн эрх хэмжээнд хамаарах асуудлаар тушаал гаргах, байгууллагын хүрээнд мөрдөх дүрэм, журам, заавар баталж, биелэлтийг зохион байгуулах, үр дүнг тооцон ажиллах;

**3.4.11.** ажил үүргээ гүйцэтгэх явцад мэдсэн төрийн болон албаны нууцыг хамгаалах, ажиллах хугацаанд, ажлаас чөлөөлөгдсөний дараа ил болгох хүртэл хугацаанд задруулахгүй байх;

**3.4.12.** хууль тогтоомжид заасан бусад.

**3.5.** Гүйцэтгэх захирал нь Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад ажлаа улирал тутамд тайлагнана.

**3.6.** Гүйцэтгэх захирал нь ажил үүргээ гүйцэтгэхдээ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ дүрмийг мөрдөж ажиллана.

**3.7.** Гүйцэтгэх захирал нь хууль тогтоомж, энэ дүрмийг зөрчсөн, эсхүл хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажил үүргээ биелүүлээгүй нь түүнд хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

**3.8.** Гүйцэтгэх захирал нь ажил үүрэгт нь харшлах, эсхүл ашиг сонирхлын зөрчил үүсэх болон хуулиар зөвшөөрснөөс бусад ажил үүргийг давхар эрхлэхийг хориглоно.

## Дөрөв.Санхүү, хөрөнгийн бүртгэл, тайлан

**4.1.** Төв нь улсын төсвөөс хуваарилсан хөрөнгийг Төсвийн тухай хуульд заасны дагуу зарцуулж, орлого, зарлагын мэдээ, мөнгөн болон мөнгөн бус хөрөнгийн гүйцэтгэлийн тайланг улирал, жил тутам гаргаж, аудитаар баталгаажуулан төсвийн ерөнхийлөн захирагч, Үндэсний аудитын газарт тайлагнана.

**4.2.** Төв нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж,

олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу улирал, жилийн санхүүгийн тайлан гаргана. Санхүүгийн тайланд дараах зүйлийг тусгана:

**4.2.1.**баланс;

**4.2.2.**орлого, үр дүнгийн тайлан;

**4.2.3.**мөнгөн гүйлгээний тайлан;

**4.2.4.**өмчийн өөрчлөлтийн тайлан;

**4.2.5.**тухайн тайлангийн хугацаанд хийсэн их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр, төрөл, үнийн дүн;

**4.2.6.**бусдаас авах авлага, тэдгээрийн үүссэн шалтгаан, барагдуулалтын явц;

**4.2.7.**нэмэлт санхүүжилтийн тайлан;

**4.2.8.**санхүүгийн тайлангийн тодруулга.

**4.3.**Төв нь өөрийн эзэмшлийн эд хөрөнгийг зохих журмын дагуу бүртгэж, эд хөрөнгийн дотоодын тооллогыг хуульд заасан хугацаанд явуулж, жилийн тайлан, тэнцэлд тусгана.

**4.4.**Төвийн санхүүгийн тайлангийн үнэн зөвийг гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч хариуцна.

**4.5.**Төвийн үйл ажиллагаанд зориулж шинээр худалдан авах болон актальж устгах, худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгийн асуудлыг төсвийн ерөнхийлөн захирагчийн зөвшөөрлийн дагуу төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хандан шийдвэрлүүлнэ.

**4.6.**Төв нь Төсвийн тухай хуульд заасны дагуу өөрийн чиг үүрэг, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалт, урсгал зардлын төлөвлөгөөг тусгасан жилийн төсвийн төслийг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд боловсруулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.

**4.7.**Төв нь Шилэн дансны тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг хэрэгжүүлж, холбогдох мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллана.

## **Тав.Албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн хадгалалт**

**5.1.**Төв нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, түүнийг дагаж гарсан нийтлэг журмыг мөрдөн ажиллаж, дараах баримт бичгийг зохих журмын дагуу хадгална:

**5.1.1.**Төвийн дүрэм, түүнд орсон нэмэлт, өөрчлөлт, Төвийг байгуулах эрх бүхий байгууллагын шийдвэр, улсын бүртгэлийн гэрчилгээ, байгаа бол эрх, тусгай зөвшөөрөл, сертификат;

**5.1.2.**санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, түүнд хийсэн аудитын болон хэрэгжилтийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмж;

**5.1.3.**анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримт, нягтлан бодох бүртгэлд тусгасан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох бичиг баримт;

**5.1.4.**гүйцэтгэх захирлын гаргасан тушаал, үйл ажиллагаатай холбогдсон дүрэм, журам, заавар, стандарт, холбогдох бусад баримт бичиг;

**5.1.5.**Төвийн үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний биелэлтийн талаарх тайлан мэдээ, бусад байгууллага, албан тушаалтантай харилцсан албан баримт;

**5.1.6.**Төвийн чиг үүргийн дагуу боловсруулсан бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, судалгаа, дүн шинжилгээтэй холбоотой баримт бичиг болон энэ дүрмийн 2.2.8-д заасан мэдээллийн санд төвлөрүүлсэн мэдээлэл, холбогдох бусад баримт бичиг;

**5.1.7.**цахим баримт бичиг, мэдээлэл;

**5.1.8.**шаардлагатай бусад баримт бичиг.

**5.2.**Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон Байгууллагын архивын нийтлэг журамд нийцүүлэн хадгалах баримт бичгийн жагсаалт, хадгалах хугацааг тогтоосон “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт”-ыг гүйцэтгэх захирал баталж, мөрдүүлнэ.

**6.1.**Энэ дүрэмд зааснаас бусад Төвийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

**6.2.**Төвийг татан буулгах, өөрчлөн байгуулах асуудлыг холбогдох хуульд заасны дагуу Засгийн газар шийдвэрлэнэ.

**6.3.**Энэ дүрэм нь улсын бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

**6.4.**Засгийн газрын шийдвэрээр дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмэлт, өөрчлөлт нь улсын бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.



09



## ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ШИНЭЧЛЭЛ



СУДЛААЧИЙН ҮГ



**Явуухулан  
БУДДАЯН-ОЧ**  
СУДЛААЧ

“Зөвлөлийн үйл  
ажиллагааны  
хөтөлбөр”

Email: buddayan-och@nrpa.gov.mn

Утас: 70116838


Төрийн өмчит компани (ТӨК)-ийн засаглал, гүйцэтгэл, эдийн засагдахь оролцоо нь өнөөгийн дэлхий дахинд онцгой анхаарал татаж буй сэдвүүдийн нэг болоод байна. Эдгээр компаниуд нь олон улсын хэмжээнд нийт дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ)-ийн 5–10 хувийг эзэлдэг<sup>1</sup> бөгөөд байгалийн нөөц, дэд бүтэц, стратегийн үйлдвэрлэлийн салбарт төвлөрсөн байдлаараа эдийн засгийн суурь тогтолцоонд хүчтэй нөлөө үзүүлдэг. Монгол Улсын хувьд ч төрийн өмчит компаниуд нь уул уурхай, эрчим хүч, тээвэр зэрэг эдийн засгийн стратегийн салбаруудад давамгайл байр суурьтай ажиллаж буй ч тэдгээрийн үр ашиг, ил тод байдал, хариуцлага зэрэгт олон нийтийн хяналт, судалгааны хэрэгцээ улам бүр нэмэгдэж байна.

Сүүлийн жилүүдэд олон улсын байгууллагууд, ялангуяа Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD), Дэлхийн банк зэрэг нь ТӨК-ийн засаглалын тогтолцоог боловсронгуй болгох, зах зээлийн зарчимд нийцүүлэх, төрийн оролцоог үр ашигтай байлгах талаарх удирдамжийг боловсруулж, улс орнуудтай хамтран ажиллаж байна. Тухайлбал, OECD-ийн 2024 оны шинэчилсэн “Төрийн өмчит аж ахуйн нэгжийн засаглалын удирдамж” нь ТӨК-ийг зөвхөн эдийн засгийн үр ашигтай байлгах бус, нийгмийн хариуцлага, шударга өрсөлдөөн, хууль дээдлэх зарчмыг хэрэгжүүлэх субъект болгон харж байна.

Монгол Улсад төрийн өмчит компаниудыг тойрсон эдийн засгийн ашигт ажиллагаа, хөрөнгө оруулалтын хяналт, улс төрийн оролцоо, ТУЗ-ийн хараат бус байдал, олон нийтэд тайлагнах тогтолцооны асуудлууд нь шийдвэрлэгдээгүй сорилт хэвээр байна. Иймд ТӨК-ийн засаглал, бүтэц, хууль эрх зүйн орчин, төрийн оролцооны механизмыг олон улсын стандарт, жишиг загвартай харьцуулан шинжлэх нь улс орны эдийн засгийн засаглал, тогтвортой хөгжилд бодит хувь нэмэр оруулах чухал судалгааны зорилт юм.

# ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ШИНЭЧЛЭЛ: НОРВЕГ УЛСЫН ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИ ДЭЭР ХАРЬЦУУЛСАН ТАНИЛЦУУЛГА

Норвег улсын томоохон компаниудын нийт хөрөнгийн хэмжээ:



Equinor компанийн нийт хөрөнгийн үнэлгээ  
**70.5 тэрбум ам.доллар** байна.

Эх сурвалж: Nasdaq

The government's holdings on the Oslo Stock Exchange  
Market value in kroner

## 863 206 504 690

<b>Equinor</b>  494 mrd. Ownership: 67% Share price: 264 Market value: DKK 357 billion.	<b>DNB Bank</b>  109 mrd. Ownership: 34% Share price: 216,7 Market value: DKK 320 billion.
<b>Norwegian Hydro</b>  38 mrd. Ownership: 34,26% Share price: 55,44 Market value: DKK 111 billion.	<b>Children</b>  27 mrd. Ownership: 36,21% Share price: 292,3 Market value: DKK 71 billion.
<b>Telenor</b>  101 mrd. Ownership: 53,33% Share price: 136,5 Market value: DKK 187 billion.	<b>Kongsberg</b>  93 mrd. Ownership: 50% Share price: 1,824 Market value: DKK 185 billion.
<b>Aker Solutions</b>  1,2 mrd. Ownership: 6,11% Share price: 39,18 Market value: DKK 12 billion.	<b>Akator</b>  453 mill. Ownership: 12,08% Share price: 13,7 Market value: DKK 5,8 billion.

Line chart showing market value from 2020 to 2024.



## Төрийн эзэмшлийн компаниуд

ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГЫН  
ХҮРДАСГУУР ТӨВ

Ministry of Climate and Environment
Ministry of Culture and Equality
Ministry of Defence
Ministry of Digitalisation and Public Governance
Ministry of Education and Research
Ministry of Energy
Ministry of Finance
Ministry of Foreign Affairs
Ministry of Health and Care Services
Ministry of Local Government and Regional Development
<b>Ministry of Trade, Industry and Fisheries</b>
Ministry of Transport

Компанийн нэр	Төрийн эзэмшлийн хувь	Эдийн засгийн салбар
1 Nysne Klimainvesteringer AS	100%	climate investment
2 Petoro AS	100%	energy
3 Statkraft SF	100%	green energy
4 Mesta AS	100%	infrastructure
5 Siva - Selskapet for industrivekst SF	100%	infrastructure for innovation
6 Argentum Fondsinvesteringer ASpr	100%	investment
7 Investinor AS	100%	investment
8 Posten Bring AS	100%	logistics
9 Store Norske Spitsbergen Kulkompani AS	100%	mining/property/logistics/energy/tourism
10 Baneservice AS	100%	railway
11 Mantena AS	100%	railway
12 Norges sjømatråd AS	100%	seafood council
13 Fiskeri- og havbruksnæringens forskningsfinansiering AS	100%	seafood research fund
14 Space Norway AS	100%	space
15 Andeva Space AS	90%	aerospace
16 Equinor ASA	67%	energy
17 Nofima AS	56.80%	food research
18 Telenor ASA	53.97%	telecommunication
19 Innovasjon Norge (special legislation company)	51%	export consultancy company
20 Kongsberg Gruppen ASA	50%	naval vessels
21 Nammo AS	50%	defense and aerospace
22 Yara International ASA	36.21%	crop nutrition
23 Norsk Hydro ASA	34.26%	energy
24 DNB Bank ASA	34%	bank
25 Eksportfinans ASA	15%	export finance
26 Akator ASA	12.08%	oil-service investment
27 Aker Solutions ASA	6.11%	energy project solution

- 1. Эрчим хүч - 5
- 2. Дэд бүтэц - 3
- 3. Төмөр зам - 2
- 4. Хөрөнгө оруулалт - 2





## Төрийн эзэмшлийн компаниуд

ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГЫН ХУРДАСГУУР ТӨВ

- Хүнс хөдөө аж ахуйн яам
- Уур амьсгал, байгаль орчны яам
- Соёлын яам
- Батлан хамгаалах яам
- Цахим, олон нийтийн удирдлагын яам
- Боловсрол, шинжилгээний яам
- Эрчим хүчний яам
- Сангийн яам
- Гадаад хэргийн яам
- Эрүүл мэнд үйлчилгээний яам
- Орон нутгийн удирдлага, бүс нутгийн хөгжлийн яам
- Худалдаа, үйлдвэрлэл ба загасны аж ахуйн яам
- Тээврийн яам

Компанийн нэр	Төрийн эзэмшлийн хувь	Эдийн засгийн салбар
1 Nysne Klimainvesteringer AS	100%	climate investment
2 Petoro AS	100%	energy
3 Statkraft SF	100%	green energy
4 Mesta AS	100%	infrastructure
5 Siva - Selskapet for industrivekst SF	100%	infrastructure for innovation
6 Argentum Fondsinvesteringer ASpr	100%	investment
7 Investor AS	100%	investment
8 Posten Bring AS	100%	logistics
9 Store Norske Spitsbergen Kulkompani AS	100%	mining/property/logistics/energy/tourism
10 Baneservice AS	100%	railway
11 Mantena AS	100%	railway
12 Norges sjømatråd AS	100%	seafood council
13 Fiskeri- og havbruksnæringens forskningsfinansiering AS	100%	seafood research fund
14 Space Norway AS	100%	space
15 Andøya Space AS	90%	aerospace
16 Equinor ASA	67%	energy
17 Nofima AS	56.80%	food research
18 Telenor ASA	53.97%	telecommunication
19 Innovasjon Norge (special legislation company)	51%	export consultancy company
20 Kongsberg Gruppen ASA	50%	naval vessels
21 Nammo AS	50%	defense and aerospace
22 Yara International ASA	36.21%	crop nutrition
23 Norsk Hydro ASA	34.26%	energy
24 DNB Bank ASA	34%	bank
25 Eksportfinans ASA	15%	export finance
26 Akastor ASA	12.06%	oil-service investment
27 Aker Solutions ASA	6.11%	energy project execution

- 1. Эрчим хүч - 5
- 2. Дэд бүтэц - 3
- 3. Төмөр зам - 2
- 4. Хөрөнгө оруулалт - 2

4



## Equinor компанийн түүхэн товчоон

ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГЫН ХУРДАСГУУР ТӨВ

### Европ тивийн томоохон газрын тос, байгалийн хий, салхины эрчим хүч нийлүүлэгч

**1970-аад он**  
1972 онд Норвег улсын парламентын шийдвэрийн дагуу "Statoil" нэртэйгээр 100 хувь төрийн өмчит компани байгуулагдсан.

**1980-аад он**  
Томоохон ордуудыг нээж, хөгжүүлсэн хүчтэй өсөлтийн арван жил байлаа. 1981 онд Хойд тэнгис дэх Gullfaks бүтээн байгуулалтын операторын эрхийг авсан. 1987 онд "Statfjord"-ийн операторын эрхийг авсан.

**1990 -ээд он**  
Хийн тээврийн систем, терминалуудыг хөгжүүлэх, ашиглах томоохон борлуулалтын гэрээ байгуулж, Европын хийн зах зээлд томоохон нийлүүлэгч болж, олон улсын хэмжээнд хөгжсөн.

**2000-аад он**  
2007 онд "Statoil" Норск Гидрогийн газрын тос, байгалийн хийн салбартай нэгдсэн. Ангол, Алжир, Бразил, Канад, Танзани болон АНУ-ын эх газар, далайн эрэг орчмоор хайгуулын ажил эхлүүлсэн.

**2010-аад он**  
АНУ-ын хайгуулын ажлууд цар хүрээгээ тэлсэн. 2017 онд эрчим хүчний шилжилтийн стратегия тодорхойлсон.

**2020-оод он**  
2022 онд Equinor эрчим хүчний шилжилтийн төлөвлөгөөгөө танилцуулсан. 2050 он гэхэд "Net Zero" компани болох зорилго тавьсан.

5



## Бизнесийн үйл ажиллагаа



### Товч

#### танилцуулга:

Дэлхий даяарх ажилчдын тоо

**23,00**

Бизнесийн үйл ажиллагаа хамтран явуулдаг улс орнууд

**0**

Өдөр бүр эрчим хүч хүргэж буй хүмүүсийн тоо (сая)

**30**

Хамтран ажилладаг ханган нийлүүлдэг байгууллага

**170**

**8,000**



ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГЫН  
ХУРДАСГУУР ТӨВ

### Алсын хараа

**2030** онд үйлдвэрлэж буй эрчим хүчний нүүрсхүчлийн ялгарлыг **20 хувиар** бууруулах

**2050** онд **NET ZERO** болох

### Үйлдвэрлэлийн хэмжээ

2023 он байдлаар

Газрын тос болон байгалийн хийн үйлдвэрлэл **2,082** Мянган баррель/өдөрт

Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс гаргаж авсан эрчим хүч **1.9** ТВ/цаг

6



## Бизнесийн үйл ажиллагаа хамтран явуулдаг улс орнууд



ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГЫН  
ХУРДАСГУУР ТӨВ

#### PARTNERSHIPS AND PRESENCE

Algeria	D&P	Canada	EXP	D&P	M&T	Japan	REN	South Korea	REN	
Angola	EXP	D&P	China	M&T		Libya	D&P	Spain	REN	
Argentina	EXP	D&P	Denmark	M&T	REN	Netherlands	LC	Suriname	EXP	
Australia	REN		France	REN		Nigeria <sup>1</sup>	D&P	Tanzania	EXP	
Azerbaijan <sup>2</sup>	EXP	D&P	Germany	REN	M&T	LC	Singapore	M&T	Vietnam	REN
Belgium	M&T		India	M&T						

<sup>1)</sup> Countries we announced exits from in 2023.

#### KEY ACTIVITIES

EXP = Exploration  
D&P = Development & production  
REN = Renewables  
M&T = Marketing & Trading  
R&P = Refining & processing  
LC = Low carbon project funnel

#### OPERATOR OF ASSETS


Brazil	EXP	D&P	REN	M&T		
Norway	EXP	D&P	REN	M&T	R&P	LC
UK	EXP	D&P	REN	M&T	LC	
USA	EXP	D&P	REN	M&T	LC	
Poland	REN					





## ИРО болон санхүүгийн үзүүлэлт

- 2001 онд Осло болон Нью Йоркийн хөрөнгийн зах дээр компанийн **23 хувийг ИРО зарлан гаргасан**. Анхны үнэлгээ нэгж хувьцаа 7.3 доллар байсан бөгөөд өнөөгийн үнэлгээ 25.31 доллар болж 346 хувиар өссөн байна.
- 2018 онд компанийн нэрээ **Equinor** болгон сольсон.



Эх сурвалж: Yahoo finance



ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГЫН  
ХУРДАСГУУР ТӨВ

2023 он байдлаар

Нийт орлого **107.2** Тэрбум ам.доллар

Нийт ашиг **35.8** Тэрбум ам.доллар

Ноогдол ашиг, хувьцааны тараасан дүн **17** Тэрбум ам.доллар

8

Эх сурвалж: 2023 Equinor annual report




## Хувьцаа эзэмшигчид




ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГЫН  
ХУРДАСГУУР ТӨВ

### 2023 оны эцсийн байдлаар

#### Хувьцаа эзэмшигчдийн тархалт



#### Нээлттэй хувьцаа эзэмшигчид



Тус компанийн хувьцааны **67%-ийг Худалдаа, аж үйлдвэр, загас агнуурын яам**, 3.6%-ийг Үндэсний даатгалын сан (Folketrygdfondet) эзэмшдэг бөгөөд **нийт 70.6%-ийг төр эзэмшдэг**.

Нийт хувьцааны тоо: **2,792,781,230**

Ногдол ашиг : 2024/5/14 хувьцаа эзэмшигчдийн хурлаар нэгж хувьцаанд 0.35\$ ногдол ашиг тараахаар шийдвэрлэсэн.


9

Эх сурвалж: 2023 Equinor annual report



## Засаглалын бүтэц

Нээлттэй ХХК-ийн тухай хууль, Норвегийн бусад хууль



**Хувьцаа эзэмшигчид** жилд нэг удаа хуралддаг /жил бүрийн 6 сард/. Хурлаар компанийн менежмент, Чуулган, нэр дэвшүүлэх хорооны гишүүдийг сонгох, гишүүдийн цалин хөлсийг тогтоох, жилийн эцсийн тайлан батлах зэрэг асуудлуудыг хөнддөг.

### ТУЗ-ийн үүрэг:

Төлөөлөн удирдах бүлгийг удирдах, компанийн удирдлагын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих.

### Гүйцэтгэх удирдлагын үүрэг:


Өдөр тутмын үйл ажиллагаа хариуцах, стратеги, зорилго, үйл ажиллагаа санхүүгийн тайлан болон хөрөнгө оруулалтын санал танилцуулах.

10

Эх сурвалж: [Governing bodies](#) -



## Засаглалын дэлгэрэнгүй бүтэц



11





## Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц



ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГЫН ХҮРДАСГУУР ТӨВ

- ✓ - Дарга
  - ⊗ - Дэд дарга
  - ✓ - Гишүүн
  - - Компанийн хувьцаа эзэмшдэггүй гишүүд
  - ТУЗ нь үндсэн 11 гишүүнтэй бөгөөд үүнээс гурван гишүүнийг нийт ажигчдын санал асуулгаар сонгосон байна (Шар өнгөөр тэмдэглэсэн болно).
  - ТУЗ-ийн үйл ажиллагаа дараах дүрмээр зохиулагддаг (2024.04.24-нд шинэчлэгдсэн).
  - ТУЗ нь гурван дэд хороотой бөгөөд дэд хороо тус бүр өөрийн гэсэн дүрэмтэй.
  - ТУЗ-н гишүүдийн намтрүүд
- Дундаж**  
 Нас – 60.9  
 Цалин – 67,000\$  
 Норвег улсын дундаж цалин – 5338 \$

Нэр	Туслах	Audit Committee	Safety, Sustainability and Ethics Committee	Compensation and Executive Development Committee
<b>Jon Erik</b> 2017/09/01-ний өдрөөс ТУЗ-ын дарга Master's degree in Applied Mathematics and Geophysics from the University of Bergen	✓	✓	✓	✓
<b>Anne Drinkwater</b> Их Британийн иргэн, АНУ-д оршин суудаг. Bachelor of Science in Applied Mathematics and Statistics, Brunel University London	⊗	✓	✓	✓
<b>Jonathan (Jon) Lewis</b> Их Британийн иргэн, АНУ-д оршин суудаг. PhD in Reservoir Characterization, University of Reading, Bachelor of Science degree in Geology, Kingston University.	✓	✓	✓	✓
<b>Finn Bjørn Ruyter</b> Master's in mechanical engineering from the Norwegian University of Technology, MBA from BI Norwegian School of Management.	✓	✓	✓	✓
<b>Naakon Bruun-Hanssen</b> Military Command and Staff college, Institut Defense Leergangen in The Netherlands, Board Nordic Academy.	✓	✓	✓	✓
<b>Mikael Karlsson</b> Шведийн иргэн, Швейцарьт оршин суудаг. MBA, Massachusetts Master of Science in Industrial Engineering and Management – Sweden	✓	✓	✓	✓

**Fernanda Lopes Larsen**  
Бразил болон Их Британийн иргэншилтэй. Сингапурт оршин суудаг.  
Master of Science in Civil Engineering from the Graz University of Technology, Austria, Master of Business Administration from IESE Business School, Spain and Professional Certificate in Corporate Innovation from Stanford University, US.

**Tone Hegland Bachke**  
MSc in Economics and Business Administration ("Sivilekonom") from the Norwegian School of Economics

**Stig Lægrend**  
Bachelor's degree, Mechanical Construction from OIH.

**Per Martin Labråthen**  
Craft certificate as a process/chemistry worker.

**Hilde Møllerstad**  
Chartered engineer from NTNU (Norwegian University of Science and Technology) and Project Management, Essential (PME) from BI NTNU (Norwegian Business School BI Norwegian University of Science and Technology).

Эх сурвалж: Equinor Remuneration report 2023, Board of Directors CV's

Ажилчид дундаас сонгогдсон гишүүн



## Гүйцэтгэх удирдлагын бүтэц



ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГЫН ХҮРДАСГУУР ТӨВ

**Дундаж**  
 Нас 57.7  
 Цалин 891,462\$ ?  
 Хувьцаа 24,056 ш  
 Туршлага 25 жил /Equinor/

**Anders Opedal**  
President and CEO  
2020/11/2 хоног гүйцэтгэх захирлын албан тушаалд очиж эхэлж байна.

Heriot-Watt University – Бизнесийн удирдлагын магистр  
 Norwegian Institute of Technology – Инженерийн чиглэлээр магистрын зэрэг  
 1997 онд газрын тосны инженерээр анх ажилд орж, тус компанид техникийн, үйл ажиллагааны болон удирдах гэх мэт төрөл бүрийн албан тушаалуудыг хашиж тушаал дэвшсэн. Тэрээр 56 настай бөгөөд компанийн 56,649ш (0.00002%) хувьцааг эзэмшдэг. 2023 оны байдлаар нийт 1,9 сая долларын цалингийн орлоготой. (Үндсэн цалин \$951К)

Нэр	Нас	Төрсөн жил	Төрийн үйлчилгээний байрлал
<b>Kjetil Hove</b>	23,861	1991	Хайгуур, олборлолт, харууцсан захирал
<b>Philippe François Mathieu</b>	7,529	1995	Хайгуур, олборлолтын цэвэр ус, харууцсан захирал
<b>Pål Eitroim</b>	21,737	1998	Эрчим хүч харууцсан захирал
<b>Hege Skryseth</b>	5,364	2022	Технологи, дэмжлэг ба инженер харууцсан захирал
<b>Geir Tungesvik</b>	20,702	1985	Өрмдөгч, болон Худалдан авалт харууцсан захирал
<b>Irene Rummelhoff</b>	31,872	1991	Маркетинг болон Боловсруулалт үйл ажиллагаа харууцсан захирал
<b>Torgir Reitan</b>	15,482	1995	Сонгоу харууцсан захирал
<b>Jannicke Nilsson</b>	63,106	1999	Аюул үйл байдал болон тогтвортой бодлог харууцсан захирал
<b>Siv Helen Rygh Torstensen</b>	19,136	1998	Хууль зох туй харууцсан захирал
<b>Aksel Stenerud</b>	11,642	2008	Хүрээ үйл ажиллагаа, Эколог байгуулалт харууцсан захирал
<b>Jannik Lindbak</b>	11,592	2010	Харилцаа залбоо харууцсан захирал
<b>SCOT ALF</b>		1997	Байгууллагын аудит харууцсан захирал

Эх сурвалж: Equinor Remuneration report 2023, Corporate executive committee



## Цалингийн бодлого



ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГЫН  
ХУРДАСГУУР ТӨВ

Norwegian Public Limited Liabilities Company Act,  
The State's Guidelines for the Remuneration



— Цалин тогтоох  
- - - Санал, зөвлөмж өгөх

Гүйцэтгэх удирдлагуудын жилийн нэмэлт цалинг (урамшуулал) тооцоолоход ашигладаг нийтлэг гол гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийн (КРП) нэг нь:

**Өмнөх шатны CO<sub>2</sub>: ялгарлын эрчимшил: 5.8 кг/нэвтрэх баррель (boe).**

Цаг уурын болон эрчим хүчний шилжилтийн зорилтуудыг урамшууллын бодлогод тусгасан байдаг. Газрын тос, байгалийн хийн багцын өмнөх шатны CO<sub>2</sub>: ялгарлын гүйцэтгэлийг Компанийн Гүйцэтгэлийн Үнэлгээний Комисс (СЕС)-ийн гол үзүүлэлт болгон авч үзэж, цалин урамшуулалтай холбосон байдаг. Судалгаа, хөгжүүлэлтийн (R&D) зардал нь түншүүдэд шилжүүлсэн дүнгүүдийг багтаан 2023 онд 311 сая ам.доллар, 2022 онд 308 сая ам.доллар, 2021 онд 291 сая ам.доллар байсан. Эдгээр зардлын Equinor компанийн эзэмшлийн хувь нь Нэгдсэн Орлогын Тайлангийн "Нийт Үйл ажиллагааны зардал" хэсэгт тусгагдсан болно.

### Note 4. Salaries and personnel expenses

Equinor ASA remuneration amounts in USD million	2023	2022
Salaries <sup>1)</sup>	2,360	2,428
Person cost <sup>2)</sup>	39	48
Payroll tax	45	37
Other compensations and social costs	112	366
Total remuneration	2,462	2,482
Average number of employees <sup>3)</sup>	19,700	18,700

<sup>1)</sup> Salaries include bonuses and expatriate costs in addition to base pay.  
<sup>2)</sup> See note 2. Pensions.  
<sup>3)</sup> Part time employees amount to 2% for both 2023 and 2022.

1



## Компанийн сайн засаглал /Төрөөс баримтлах 10 зарчим/



ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГЫН  
ХУРДАСГУУР ТӨВ

- 1 Төр нь урт хугацаанд идэвхтэй, хариуцлагатай өмчлөгч байна.
- 2 Төрийн өмч, өмчлөх эрх болон санал хураалтын ил тод байдлыг хувьцаа эзэмшигчдийн нэгдсэн хуралдаанд тусган харуулна.
- 3 Төр өмчлөх эрхээ эдлэхдээ төрийн өмчлөгчийн зорилгод нийцсэн байх. Энэ нь компаниудын хүлээлт, нэгдсэн хуралдаанд өгөх санал, өмчлөх эрхийн бусад хэрэгслээр харагдана.
- 4 Төрийн өмчлөх эрхийн хэрэгжилт нь Компанийн тухай хуульд заасан өмчлөгч, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын үүрэг, хариуцлагын тогтолцоо, компанийн засаглалын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандартын дүрмэнд үндэслэнэ.
- 5 Төр өмчийн бүрэн эрхээ хувьцаа эзэмшигчдийн нэгдсэн хуралдаанаар эдэлнэ.
- 6 ТУЗ нь компанийг удирдах үүрэгтэй. Төр нь компанийн үйл ажиллагаа, зорилго нь төрийн хүлээлтэд нийцэж буй эсэх, үүний хүрээнд ТУЗ-ын оруулсан хувь нэмрийг үнэлнэ.
- 7 ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг бүрдүүлэхдээ тороос анхаарах гол зүйл нь холбогдох мэргэжлийн үр чадвар байх ёстой. Хэрэв тухайн этгээд туршлагатай бол тороос мэдлэг, үр чадвар болон олон талт байдлыг чухалчилна.
- 8 Төр өмчлөх эрхээ компанийн тухай хуульд заасан хувьцаа эзэмшигчдэд тэгш хандах зарчмын дагуу хэрэгжүүлнэ.
- 9 Төр өмчлөх эрх, үүргээ төрийн бусад үүргээс ангид байлгана.
- 10 Төрийн өмчийн оролцоо нь төрийн өмчийн оролцоотой компаниуд, хувийн хэвшлийн компанигай ижил зарчмаар зах зээлд үйл ажиллагааг явуулна.

Норвегийн төрийн өмчит компаниудын өмчлөл нь 2 ангилалд багтдаг. Equinor нь 1-р ангилалд багтдаг.

**Ангилал 1.** Тогтвортой байдлаар урт хугацааны туршид хамгийн их ашиг олох зорилготой.

**Ангилал 2.** Төрийн бодлогыг тогтвортой, хамгийн үр дүнтэй хэрэгжүүлэх зорилготой.

Эх сурвалж: The Ministry of Trade, Industry, and Fisheries  
"Greener and more active state ownership"  
white paper 2022-2023

1





## Төр хэрхэн эзэмшлээ тогтоодог вэ?



ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГЫН  
ХУРДАСГУУР ТӨВ

Төр өөрийн эзэмшлээ яамдаар дамжуулан бодлогын хэлэлцүүлэг хийх, ерөнхий чуулганд санал оруулах зэргээр тогтоодог.

### Дөрөвдүгээр улирал

- Компанийн удирдлагатай уулзаж, улирлын үнэлгээ хийнэ
- Ногдол ашгийн хүлээлтэйг тооцох
- ТУЗ-ын сонгууль: ТУЗ-ын гишүүд, Гүйцэтгэх захиралтай тус тусад нь уулзаж, ТУЗ-г нийтээр нь үнэлэх

### Гуравдугаар улирал

- Компанийн удирдлагатай уулзаж, улирлын үнэлгээ хийнэ
- ТУЗ-ын бүх гишүүдтэй хийх жил тутмын уулаалт
- Тухай компанийн жилийн зорилт болон Төрийн хүлээлт хоёрыг харьцуулсан дүгнэлт хийх
- Эзэмшигчийн жилийн толоологоог тодорхойлох



### I нэгдүгээр улирал

- Компанийн удирдлагатай уулзаж, улирлын үнэлгээ хийнэ
- ТУЗ сонгон шалгаруулах процесс: ТУЗ-ын гишүүдийг сонгон шалгаруулах, ярилцлага хийх

### Хоёрдугаар улирал

- Компанийн удирдлагатай уулзаж, улирлын үнэлгээ хийнэ
- Өнгөрсөн жилд тодорхойлсон зорилгод хүрсэн эсэхийг хянана
- Хувьцаа эзэмшигчдийн нэгдсэн хурал дээр хэлэлцсэн асуудлуудын санал хураалтыг үнэлнэ
- Хувьцаа эзэмшигчдийн нэгдсэн хурал зохион байгуулах

## Норвеги ASA (Allmennaksjeloven)-ийг Монгол Улсын Компани, ТӨҮГ-ын тухай хуультай харьцуулах нь



ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГЫН  
ХУРДАСГУУР ТӨВ

### Монголд улсын ТӨК-ийн засаглалд хийх өөрчлөлт

Зохицуулалт	Норвеги ASA (Allmennaksjeloven)	Монгол (Компанийн хууль ба Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль)
Хэлхийн бага хурал	NOK 1 сая (ойролцоогоор -MNT 340 сая)	Капиталгүй, хувьцаат компанид хэлхийн бага хуралдаж байхгүй
ТӨК-ийн хуулийн хэлбэр	ТӨК-д түгээмэл; жишээ нь Equinor ASA	ТӨК-үүд ихэвчлэн ХХК хэлбэртэй. Компанийн хууль эсвэл Төрийн орон нутгийн өмчийн тухайн актиудад байрладаг
Зөвлөлийн бүтэц	Зөвлөл заавал байх ёстой, эз гишүүд хүйсийн тэнцэрийн квоттай	Зөвлөл заавалдаггүй; хүйсийн квот байхгүй, улс төрийн тэнцлэг түгээмэл
Нэр дэвшүүлэх хороо	Бүртгэлтэй компаниуд заавал	Шардлагагүй; амьтлын гишүүдийг улс төрийн шалтгаанаар томилох нь түгээмэл
Аудитын хароо	Том, бүртгэлтэй ASA-д заавал байх	Сонголттой; ТӨК-үүд ихэвчлэн аудитын хароогүй
Гүйцэтгэх захирлын томилоо	Зөвлөлийн томилодог	Ихэвчлэн засаг захиргаа, яамал/нийслэл эсвэл Засгийн газрын шийдвэрээр томилодог
Санхүүгийн ил тод байдал	IFRS эсвэл Норвегийн GAAP; эрдэг заавал	Ялгаатай, үргэлж эрдэг байхгүй, олон нийтэд мэдэгддэггүй
Нөлөөтэй хувьцаа гаргах	Зөвшөөрөгдсөн ба эхлээд үйлддэггүй	ТӨК-үүдийн хувьд эвэр; Хөрөнгийн биржийг өргөн ашигладаггүй
Хүйсийн квот	Тус бүр 40%-ийн хүйсийн квот (заавал мөрдөнө)	Хүйсийн квот байхгүй
Хувьцаа эзэмшигчийн эрх	Хүний эрх хамгаалах; өмчийн эрхийг аюулдасдэг	Дурагдмал тулсан ч эрх зөв шийдэх эрх; санал, саналга бат суу
Үнэт цаасны зохицуулалт	EU/US-ийн стандарттай үндсэн, найдвартай	Хэргийн буй шалтгаан, хяналт шалгалт болон ил тод байдлын асуудалтай

Сэдэв	Зөрүү	Монголд үзүүлэх үр дагавар
Зөвлөлийн хараат бус байдал	Монголын ТӨК-үүд хараат бус гишүүний тодорхой шалгуургүй	Хараат бус байдал болон үр чадварт суурилсан зөвлөл томилох шаардлага нэвтрүүлэх
Хүйсийн олон талт байдал	Норвегид хүйсийн тэнцэр заавал байдаг	Хүйсийн квот эсвэл олон талт байдалд чиглэсэн зорилт тавихыг авч үзэх
Аудит ба тайлагнал	Норвеги нь хатуу санхүүгийн ил тод байдлыг шаардаж мөрдүүлдэг	IFRS стандартад нийцүүлж, ТӨК-үүдийн жилийн тайланг заавал нийтлэхийг шаардах
Нийтийн хариуцлага	Норвегийн ASA компаниуд зах зээлийн хяналтанд ордог	ТӨК-үүдийн хувьцааг хэсгчилэн олон нийтэд санал болгох замаар хариуцлагыг нэмэгдүүлэх
Хувьцаа эзэмшигчийн эрх хамгаалалт	Норвегид хувьцаа эзэмшигчдэд зууль эрх зүйн хамгаалалт сайтай	Цөөнзүйн эрхийг хамгаалах зууль зүйн арга хэрэгслийг сайжруулах
Ашиг сонирхлын зөрчил ба улс төрийн томилоо	Норвегийн тогтолцоо улс төрийн нөлөөг хязгаарладаг	Зөвлөлд мэргэжлийн хүмүүсийг хараат бус, бие давсан комиссоор дамжуулан томилох системд шилжих

Дэлгэрэнгүй: [lov.om.allmennaksjeloven/allmennaksjeloven](http://lov.om.allmennaksjeloven/allmennaksjeloven)

## Төрийн өмчит компанийн өнөөгийн нөхцөл байдал



## ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ

	TEMASEK e. o. Temasek Holdings (Сингапур)	equinor n. o. Equinor ASA (Норвеги)	СЭМБРИК KazMunayGas - Kazyna (Казахстан)
Үүсгэлт	1974 он	1972 он (StatOil), 2018 онд Equinor болсон	2008 он
Бүтэц	Төрийн өмчит холдинг, арилжааны зэрчмтэй байгууллага	Хувьцаат компани (хөрөнгийн биржид бүртгэгдэн), төрийн олонхын эзэмшлттэй	Төрийн өмчит холдинг компани
Өмчлөгчийн хэлбэр	100% Сингапурын Сэнгийн лам	~67% Норвегийн Засгийн газар	100% Казахстаны Засгийн газар
Үйл ажиллагааны чиглэл	Төрийн орлогоны хөрөнгийг удирдах, урт хугацааны үнэ цэнэ бий болгох	Газрын тос, байгалийн хай, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл	Стратегийн ТӨК-үүдийг удирдах, холгийн бодлогыг хэрэгжүүлэх
Хөрөнгө оруулалтын багц	Сенгүү, харилцаа холбоо, төсвөр, технологи, хэрэгжээний салбарууд	Газрын тос, хай, сэргээгдэх эрчим хүч	KazMunayGas, Temir Zholu, Kazatomprom зэрэг ТӨК-үүд
Засаглалын загвар	Компанийн тухай зуулс, хараат бус ТУЗ, хувийн оудит	Норвегийн хууль, OECD-ийн ТӨК-ийн заавар мөрддөг	2016 оноос OECD-ийн зааврыг хэрэгжүүлж эхэлсэн
ТУЗ-ийн төмөрлөг	Сэнгийн сайд томилдог болон ТУЗ хараат бусар ажилладаг	Засгийн газар томилдог, ТУЗ хараат бус	Төрөөс томилдог, хараат бус байдлыг нэмэгдүүлж байгаа
Улс төрийн оролцоо	Төрөөс салгууржилт өвдөг түк бие даасан шийдвэр гаргадаг	Өдөр тутмын үйл ажиллагаанд оролцдоггүй	Стратегик, хүний нөөцийн бодлогод төр идэвхтэй оролцдог
Ил тод байдал	Жил бүр тайлан гаргаж, хувийн оудит хийлгэдэг	Хөрөнгийн биржийн ил тод мэдээлэл, тайлагналтай	Ил тод байдал, тайлагнал сайжирч байна

### Дүгнэлт:

- Олон улсын менежментийн баг, дэлхийд нэр хүндтэй банк, зөвлөх компаниудаар **тодорхой хугацаанд менежментийг хэрэгжүүлж**, Монгол Улсын томоохон ТӨК-д арилжааны зарчмаар ажиллах, улс төрөөс хараат бус удирдлагын тогтолцоог бүрдүүлэх.
- Уул уурхай, эрчим хүч зэрэг салбарын ТӨК-ийг эхний ээлжид **дотоодын хөрөнгийн бирж дээр арилжаалж** олон нийтэд нээлттэй, ил тод болгон гүйцэтгэлийн хариуцлагыг нэмэгдүүлэх.
- Төвлөрсөн холдинг бүтэц** нь төрийн өмчит хөрөнгийг нэгдмэл байдлаар удирдах, хөрөнгө оруулалтыг оновчтой болгох, институтийн шинэтгэлийг үе шаттай хэрэгжүүлэх боломжийг бий болгоно.
- Монгол Улсын төрийн өмчит компанид олон улсын сайн засаглалын зарчмыг үе шаттай нэвтрүүлэх нь стратегийн чухал ач холбогдолтой ба энэ нь компанийн бүтэц, хөгжлийн бодлого, төсөв, хувийн хэвшлийн оролцоог уялдуулсан загвар бүрдүүлэх боломжийг бий болгоно.

# 10



## ХУВИЙН ХЭВШЛИЙН ТӨЛӨӨЛЛӨӨС ХОЛБОГДОХ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ХҮРЭЭНД ИРҮҮЛСЭН **САНАЛ, ЗӨВЛӨМЖ**



### СУДЛААЧИЙН ҮГ



**Даваасүрэн  
АЛТАНБИЛЭГ**

ЗАХИРАЛ

"Зөвлөлийн үйл  
ажиллагааны хөтөлбөр"

Email: altanbileg@nrpa.gov.mn

Утас: 70116838

- Монгол Улсын Татварын тухай хууль тогтоомжийг шинэчилж боловсронгуй болгох ажлын хүрээнд Засгийн газраас боловсруулсан хуулийн төсөлд Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим НҮТББ, Улаанбаатар хотын худалдааны танхим ГҮТББ, Монголын бизнесийн зөвлөл ГҮТББ, АмЧам Монгол ГҮТББ, Монгол дахь Австралийн худалдааны танхим ГҮТББ нар хамтран хувийн хэвшлийг төлөөлөн өөрсдийн гишүүн болон гишүүн бус байгууллагуудын саналыг нэгтгэн Эдийн засгийн хөгжлийн зөвлөлөөр дамжуулан Сангийн яамны хуулийн ажлын хэсэгт хүргүүлсэн. Тэдгээр саналаас нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай 20 чухал асуудлыг тодорхойлж, холбогдох өөрчлөлтийн санал, зөвлөмжийн хамт боловсруулсан болно.
- Монголын Бизнесийн Зөвлөл болон Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын Эрчим Хүчний Зөвлөлөөс Эрчим хүчний тухай хууль, сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд хувийн хэвшлийн зүгээс тулгамдаж буй асуудлуудын талаар нэгтгэсэн саналыг боловсруулан Эрчим Хүчний Яам-д хүргүүлсэн. Уг саналд төрийн байгууллагын чиг үүргийн тодорхойгүй байдал, дахвардсан хяналтын тогтолцоо, хуулийн ойлгомжгүй зохицуулалт, төр бүхнийг шийдэж болохгүй гэсэн агуулга бүхий саналуудаас хэсэгчлэн хүргэж байна.
- Монголын уул уурхайн салбарын хайгуулын үйл ажиллагааг эрчимжүүлэх, хөрөнгө оруулалт татах ажлын хүрээнд ашигт малтмал, газрын тосны эрэл хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл олголт болон түүний шилжилттэй холбоотой дараах асуудлуудад өөрчлөлт тусгах саналтай байна. Одоо мөрдөгдөж буй хайгуулын сонгон шалгаруулалтын журамд зааснаар судалгааны үр дүнд магадлал өндөртэй гэж үнэлэгдсэн талбайд хайгуулын сонгон шалгаруулалт зохион байгуулах боломжийг бүрдүүлэх, харин эрсдэл өндөр, судлагдаагүй талбайд хайгуулын үйл ажиллагаа явуулахыг хүсэгчдэд өргөдлийн журмаар зөвшөөрөл олгох зохицуулалтуудыг тусгах саналуудыг ирүүлсэн болно.

# ТАТВАРЫН ШИНЭЧЛЭЛ: ШИЙДВЭРЛЭХ ШААРДЛАГАТАЙ ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ АСУУДЛУУД



## 1. ЕРӨНХИЙ ХУУЛЬ

### ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ: Нэр томъёоны тодорхойлолт

#### Хуулийн холбогдох заалт:

6.1.48. "Эцсийн эзэмшигч" гэж ашигт малтмал, газрын тос, цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, газар эзэмших, ашиглах эрх эзэмшигч этгээдийн 30 болон түүнээс дээш хувийн хувьцаа, хувь оролцоо, эсхүл саналын эрхийг өөрөө, эсхүл нэг болон түүнээс дээш үргэлжилсэн хэлхээ холбоо бүхий хуулийн этгээдээр төлөөлүүлэн эзэмшдэг, саналын эрхийг төлөөлүүлэн хэрэгжүүлдэг, эсхүл ногдол ашгийг хүлээн авах эрхтэй этгээдийг.

#### Өөрчлөх санал:

6.1.48. "Эцсийн эзэмшигч" гэж ашигт малтмал, газрын тос, цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, газар эзэмших, ашиглах эрх эзэмшигч этгээдийн 30 болон түүнээс дээш хувийн хувьцаа, хувь оролцоо, эсхүл саналын эрхийг өөрөө, эсхүл нэг болон түүнээс дээш үргэлжилсэн хэлхээ холбоо бүхий хуулийн этгээдээр төлөөлүүлэн эзэмшдэг, саналын эрхийг төлөөлүүлэн хэрэгжүүлдэг, эсхүл ногдол ашгийг хүлээн авах эрхтэй хөрөнгө оруулалтын эцсийн өгөөжийг хүртэх хувь хүнийг.

#### Үндэслэл:

- Шууд болон шууд бус байдлаар хөрөнгө оруулалт хийсэн компаниуд эцсийн эзэмшигч мэтээр тодорхойлогдож буй нь татварын ногдуулалтад хүндрэл учруулж байна. Тодруулбал, дан жижиг хувьцаа эзэмшигчидтэй буюу 30%-аас дээш хувь эзэмшил бүхий хувь хүн байхгүй тохиолдолд үргэлжилсэн хэлхээ холбоонд багтах завсрын хуулийн этгээдийг эцсийн эзэмшигчээр тооцох, уг хуулийн этгээдийн эзэмшил 30 хувиас буурах бүрд татвар ногдуулах тохиолдол гарч байна.

- Бусад холбогдох хуулийн заалтад тодорхойлноор нэг агуулгаар өөрчлөлт оруулах сайжруулах шаардлагатай.

### ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ:

#### Нөхөн ногдуулалтын актын хэрэгжилтийг хангах

#### Хуулийн холбогдох заалт:

- 43.3.Татвар төлөгч энэ хуулийн 43.1-д заасны дагуу гомдол гаргасан нь ногдуулсан татвар, алданги, торгууль төлөхийг зогсоох үндэслэл болохгүй.
- 47.3.Нөхөн ногдуулалтын актад гомдол гаргахдаа уг актаар нөхөн ногдуулсан татварын хүлээн зөвшөөрөөгүй дүнгийн 10 хувийг урьдчилж төлөх ба уг төлөх дүн нь 100 сая төгрөгөөс хэтрэхгүй байна.

#### Хүчингүй болгох:

- 43.3.Татвар төлөгч энэ хуулийн 43.1-д заасны дагуу гомдол гаргасан нь ногдуулсан татвар, алданги, торгууль төлөхийг зогсоох үндэслэл болохгүй.

#### Үндэслэл:

- Маргаан шийдвэрлэсэн эсэхээс үл хамааран маргаантай актыг бүхэлд нь хэрэгжүүлээд зогсохгүй алданги, торгууль ногдуулах дарамтыг бий болгож байна.
- Аж ахуйн нэгжүүдэд татварын маргаан дуусах хүртэл өөрийн үйл ажиллагааг доголдуулалгүйгээр татвар төлөх үүргээ хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай
- Дээрх хоёр заалт хоорондоо зөрчилдөж байна

### ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ:

#### Татварын буцаан олголт, суутгалын үйл явцыг хөнгөвчлөх

#### Хуулийн холбогдох заалт:

- 49.1.1. буцаан олгох (татварын хяналт шалгалтанд ордог)
- 49.1.2. тухайн хугацаанд төлбөл зохих бусад татварт



суутган тооцох (татварын хяналт шалгалтанд ордог)

49.1.3. татвар төлөгч зөвшөөрвөл дараагийн хугацаанд төлөх татварт суутган тооцох.

**Өөрчлөх санал:**

49.1.1. буцаан олгох (татварын хяналт шалгалтанд ордог)

49.1.2. татвар төлөгчийн хүсэлтээр татварын хяналт шалгалтгүйгээр тухайн хугацаанд төлбөл зохих бусад татварт шууд суутган тооцох (татварын хяналт шалгалтанд ордог)

49.1.3. татвар төлөгч зөвшөөрвөл дараагийн хугацаанд төлөх татварт шууд суутган тооцох.

**Үндэслэл:**

- Татварын илүү төлөлтийг бусад татварт суутгуулахад заавал татварын хяналт шалгалтад хамруулдаг. Энэ нь процессын хувьд цаг хугацаа шаарддаг, татвар төлөгчдөд татвараа төлөхийн хувьд нэмэлт санхүүжилт шаарддаг, эсвэл хугацааны торгуул алданги тооцогддог гэх мэт хүндрэлүүд үүсдэг.
- Илүү төлсөн татварыг бусад татварт суутган тооцуулсан ч тухайн татвартай холбоотой хариуцлагыг татвар төлөгч өөрөө хариуцсан хэвээр байх тул заавал хяналтаар орж, хугацаа, нэмэлт зардал чирэгдэл үүсгэх шаардлагагүй. Тиймээс татвар төлөгчийн хүсэлтээр тухайн хугацаанд төлбөл зохих бусад татварт шууд суутган тооцох процессийг хялбарчлах нь оновчтой

## ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ: Алдангийн дээд хязгаар тогтоох

**Хуулийн холбогдох заалт:**

73.2. Алданги тооцох хугацааг доор дурдсанаар тодорхойлно:

73.2.1. татварын хууль тогтоомжид заасны дагуу тухайн татварыг төлбөл зохих өдрөөс түүнийг төлсөн өдрийг хүртэлх хоногийн тоогоор;

**Өөрчлөх санал:**

73.2. Алданги тооцох хугацааг доор дурдсанаар тодорхойлно:

73.2.1. татварын хууль тогтоомжид заасны дагуу тухайн татварыг төлбөл зохих өдрөөс түүнийг төлсөн өдрийг хүртэлх хоногийн тоогоор тооцох бөгөөд нийт алдангийн хэмжээ төлбөл зохих албан татварын 50%-с хэтрэхгүй байна.

**Үндэслэл:**

- Одоогийн зохицуулалтаар алданги нь татварыг төлбөл зохих өдрөөс түүнийг төлөх өдрийг хүртэл ямар ч хязгаарлалтгүйгээр тооцогддог.
- Энэ нь төлөх татварын зөрчлөөс ч хэд дахин өндөр тооцогдож татвар төлөгчийг төлж чадахааргүй дарамтанд оруулах эрсдэл үүсгэдэг.
- Монгол Улсын Иргэний хуулийн 232.4 болон бусад холбогдох зохицуулалтын дагуу ангийн хэмжээ

гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50%-аас хэтрэх ёсгүй.

## 2. АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬ

### ААНОАТ: Татвар ногдох орлогоос хасагдах зардалд тавигдах шаардлагыг тодорхой болгох

**Хуулийн холбогдох заалт:**

13.1.1. Тухайн татварын тайлант хугацаанд хамаарсан байх

13.1.2. Албан татвар төлөгчийн албан татвар ногдох орлого олох үйл ажиллагаатай шууд холбогдон гарсан байх;

13.1.3. Зардал бодитой гарсан бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан баримт болон холбогдох бүртгэлээр баталгаажсан байх

13.1.4. Дор дурдсан бараа, ажил, үйлчилгээний зардал ..... баримтаар баталгаажсан байх

13.1.4.б. хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө, биет бус хөрөнгө худалдан авахтай холбогдон гарах зардал.

13.1.5. зардлыг тухайн үйл ажиллагаа эрхэлж байгаа албан татвар төлөгч төлсөн, эсхүл төлөхөөр тайлагнасан байх

**Өөрчлөх санал:**

13.1.1. Тухайн татварын тайлант хугацаанд хамаарсан байх;"

13.1.2. Албан татвар төлөгчийн тухайн татварын тайлант хугацаанд албан татвар ногдох орлого олох үйл ажиллагаатай шууд холбогдон гарсан байх;

13.1.3. Зардал бодитой гарсан бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан баримт болон холбогдох бүртгэлээр баталгаажсан байх;"

13.1.4. Дор дурдснаас бусад бараа, ажил, үйлчилгээний зардал ..... баримтаар баталгаажсан байх

13.1.4.б. НӨАТ ногдуулах төрлийн орлогод ордоггүй, бусад баримтаар нотлогдох хөрөнгө оруулалт, санхүүгийн хэрэгслийн өртөг, зардал, цалин хөлс, элэгдэл хорогдлын зардал болон бусад адилтгах зардал.

13.1.5. Гадаад улсад төлсөн татвар, төлбөр хураамж, бусад зардал.

**Үндэслэл:**

- Татвар ногдох орлогоос хасагдах зардалд тавигдах шаардлага хэт ерөнхий, давхардсан утга агуулгатай байдгаас татвар төлөгчдийг эрсдэлд оруулдаг
- хөрөнгө оруулалт, санхүүгийн хэрэгслийн өртөг,

зардалын хувьд Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтаар нотлох боломжгүй байдаг.

- ААНОАТ: Татвар ногдох орлогоос хасагдах сайн дурын даатгалын хязгаарлалт бууруулах

#### **Хуулийн холбогдох заалт:**

13.2.6. Даатгалын тухай хуулийн 4.1.2-т заасан даатгагчаас бусад этгээдийн сайн дурын даатгалын хураамжийн дүн нь тухайн татварын жилийн албан татвар ногдуулах орлогын 15 хувиас хэтрэхгүй байх;

13.2.7. Даатгалын тухай хуулийн 4.1.2-т заасан даатгагчийн харилцан хамааралтай этгээдүүдтэй хийсэн сайн дурын даатгалын хураамжийн дүн нь тухайн татварын жилийн албан татвар ногдуулах орлогын 15 хувиас хэтрэхгүй байх;

#### **Шинээр нэмэх заалт:**

13.2.13. Тус хуулийн 13.2.6, 13.2.7-д заасан хязгаарлалтад хууль тогтоомжоор зөвшөөрсөн болон заасан үндсэн үйл ажиллагааны хүрээнд холбогдох гэрээ, стандартаар шаардсан сайн дурын даатгалын зардал хамаарахгүй

#### **Үндэслэл:**

- Барилгын салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниуд сайн дурын даатгалд хуулийн дагуу зайлшгүй даатгуулах шаардлага үүсдэг ба эргээд 15%-ийн хязгаарлалтын улмаас үйл ажиллагааны зардлаа бүрэн хасаж чаддаггүй.
- Нэг компанийн даатгалын зардал нөгөө талдаа Даатгалын компанийн орлого болж татвар төлөгддөг тул дээр дурьдсан даатгалын зардлыг ТНО-с 100% хасах логик зарчмын хувьд зөв юм.
- ААНОАТ: Татвар ногдох орлогоос хасагдах хүүгийн зардлын давхардлыг арилгах

#### **Хуулийн холбогдох заалт:**

14.2. ... ажил гүйлгээний ... хасагдах зардлын хэмжээ нь тайлант хугацааны нийт борлуулалтын орлогоос хүү, элэгдэл, хорогдлоос бусад ... зардлыг хассан дүнгийн 30 хувиар хязгаарлагдана.

14.3. ... хөрөнгө оруулагчаас ... оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг 3 дахин нэмэгдүүлснээс илүү хэмжээний тухайн хөрөнгө оруулагчийн зээлд төлсөн хүүгийн төлбөрийг албан татвар ногдох орлогоос хасаж тооцохгүй бөгөөд түүнийг тухайн хөрөнгө оруулагчийн ногдол ашигт тооцож албан татвар ногдуулна.

14.6. ... зээлийн хүүгийн зардлыг тухайн албан татвар төлөгчийн албан татвар ногдох орлогоос хасаж тооцохгүй. Хүчингүй болгож шинээр өөрчлөн найруулах:

14.2, 14.3, 14.6 дахь заалтуудыг хүчингүй болгох  
“Хөрөнгө оруулагчаас авсан зээлийн хүүгийн зардлын

хэмжээ нь тайлант хугацааны нийт борлуулалтын орлогоос хүү, элэгдэл, хорогдлоос бусад зардлыг хассан дүн (EBIDTA)-ийн 30 хувиар хязгаарлагдана” гэсэн заалт болгон өөрчлөн найруулах.

#### **Үндэслэл:**

- ААНОАТ-н хуулиар хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчээс авсан зээлийн хүүгийн зардалд эдгээр хязгаарлалт давхардан тавигддаг нь шинээр эхлэж байгаа, өндөр дүнтэй хөрөнгө оруулалт, санхүүжилт шаарддаг бизнесийн хувьд банкнаас зээл авахад хүндрэлтэй байдаг тул хөрөнгө оруулагчаас санхүүжилт (зээл) олгох нь бизнесийн ердийн зарчим юм. Гэтэл энэ тохиолдол зээлийн хүүгийн зардлаа ТНО-с бүрэн хасаж чадахгүй байгаа нь бизнес эрхлэгчийг татварын дарамтад оруулсан хязгаарлалт болж байна.
- Олон улсын жишигт хязгаарлалтыг давхардуулан ашигладаггүй

## **ААНОАТ: Алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох**

#### **Хуулийн холбогдох заалт:**

19.2.Харьяалах татварын албаар баталгаажуулсан ирээдүйд шилжүүлэн тооцох алдагдлыг тухайн алдагдал гарсан татварын жилийн дараах дараалсан дөрвөн жил бүр албан татвар ногдуулах орлогын нийт дүнгийн 50 хувиар хязгаарлан хасаж тооцно.

19.3.Татварын дараалсан дөрвөн жилийн хугацаанд хасагдаагүй үлдсэн болон тухайн татварын жилд энэ хуулийн 19.2-т заасан хязгаараас хэтэрсэн алдагдлын дүнг цаашид албан татвар ногдуулах орлогоос хасаж тооцохгүй.

#### **Хүчингүй болгож шинээр өөрчлөн найруулах:**

19.2. Хөөн хэлэлцэх хугацаанд баталгаажуулсан ирээдүйд шилжүүлэн тооцох алдагдлыг тухайн алдагдал гарсан татварын жилийн дараах жилүүдэд албан татвар ногдуулах орлогын нийт дүнгээс хязгаарлалтгүйгээр хасаж тооцно.” гэж өөрчлөн найруулах.

19.3 дахь заалтыг хүчингүй болгох.

#### **Үндэслэл:**

- Аливаа шинэ бизнес хөрөнгө оруулалтын хүлээсэн бодит алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцохдоо хугацааны болон дүнгийн хязгаарлалт тавьдаг нь бизнес эрхлэгчийг дэмжээгүй, тухайн бизнесийг хурдан хугацаанд хөл дээрээ босох боломжийг хязгаарласан хэтэрхий хатуу, бодит бус зохицуулалт тул хязгаарлалтгүй болгож, ашигтай ажилласан жилээсээ эхлэн өмнөх алдагдлаа бүрэн нөхдөг байхаар өөрчлөх.

## ААНОАТ: Оршин суугч бус этгээдийн албан татварын хувь хэмжээ

### Хуулийн холбогдох заалт:

20.2.4. Энэ хуулийн 18.6.6, 18.6.8, 18.13-т заасан орлогод орлогод 20 хувиар” гэж оршин суугч бусын албан татварын хувь хэмжээг 20 хувийн суутган татвар байх болно гэж зааж өгсөн байдаг.

### Өөрчлөн найруулах, шинэ заалт нэмэх:

20.2.4. Монгол Улсад байрладаг албан татвар төлөгч оршин суугч бусад шилжүүлсэн орлогод 10 хувиар татвар ногдуулан суутган төлөх; гэж өөрчлөн найруулах “20.2.4’. Оршин суугч бус банк, санхүүгийн байгууллагад олгосон хүүгийн орлогоос 5 хувиар татвар ногдуулан суутган төлөх;” шинэ заалт нэмэх.

### Үндэслэл:

- Энэ төрлийн татварыг (ногдол ашгаас бусад төрлийн орлогын хувьд) аж ахуйн нэгжүүд өөрсдийн зардлаа нэмэх байдлаар “суутган” төлдөг. Иймд татварын хувь хэмжээг OECD – Global Anti – Base Erosion Model Rules (Pillar Two)-д тусгагдсан хамгийн бага татварын хувь хэмжээ болох 15%-д барих үүрэгтэй уялдуулан татварын хувь хэмжээг бууруулах боломжтой. ТНО-с хасагдах зардлаар хүлээн зөвшөөрөхдөө гэрээ болон нэхэмжлэхийн дүнд оруулсан байх шаардлага тавихгүйгээр ТНО-с шууд хасдаг байх нь илүү ойлгомжтой болгоно.
- Дотоодын санхүүжилтийн нөөц, боломж хязгаарлагдмал байдгаас хамаарч аж ахуйн нэгжүүд гадаад зах зээлээс санхүүжилт босгох замаар төсөл, үйл ажиллагааг санхүүжүүлдэг бөгөөд холбогдох санхүүжилтийн зардал өндөр болдог. Иймд гадаад зээлийн санхүүжилттэй холбоотой хүүгийн орлогоос суутгах татварын хувь хэмжээг 5% болгон бууруулах нь бизнесүүд үйл ажиллагаагаа өргөтгөх, улмаар татвар ногдох орлогын суурь өсөх нөхцөлийг бүрдүүлэхэд бодитой дэмжлэг болно.

## ААНОАТ: Зээл, өрийн хэрэгслийн хүүгийн орлогын татвар

### Хуулийн холбогдох заалт:

20.2.6. Монгол Улсын арилжааны банкны гадаад, дотоодын эх үүсвэрээс татсан зээл, өрийн хэрэгслийн хүүгийн орлогод 5 хувиар. Өөрчлөн найруулах: 20.2.6. Монгол Улсын арилжааны банк, санхүүгийн байгууллагуудын гадаад, дотоодын эх үүсвэрээс татсан зээл, өрийн хэрэгслийн хүүгийн орлогод 5 хувиар.

### Үндэслэл:

- Санхүүгийн нэг ижил салбарт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудыг хооронд нь ялгаварлан,

зөвхөн банкинд давуу эрх олгож байгаа тул энэ заалтыг тус салбарт тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байгаа бүх санхүүгийн байгууллагуудад ижил хэрэглэх шаардлагатай байгаа тул ийнхүү өөрчлөх хэрэгтэй байна

## ААНОАТ: Хувь эзэмшлийн хэмжээг багасгах

### Шинэ хуулийн төслийн:

21.1.18. Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн өөрийн 100 хувь эзэмшдэг аж ахуйн нэгжээс авсан ногдол ашиг.”-ийг татвараас чөлөөлөх.

### Өөрчлөн найруулах, шинэ заалт нэмэх:

“21.1.18. Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн өөрийн 20 хувь эзэмшдэг аж ахуйн нэгжээс авсан ногдол ашиг.”-ийг татвараас чөлөөлөх” гэж өөрчлөн найруулах

“21.1.19. Ноогдол ашиг хуваарилах аж ахуйн нэгж нь аливаа татварын өр төлбөргүй байх” гэсэн шинэ заалт “ гэж нэмэх.

### Үндэслэл:

- Монгол Улсын групп компаниудад зориулсан тусгайлсан татварын зохицуулалт байхгүйгээс үүдэн олон давхарга бүхий бүтэцтэй байх шаардлагатай групп компаниудын YATT нь ойролцоогоор 50% болдог. Энэ нь дотоодын групп компаниудын өсөлтийн боломжийг хязгаарлаж байна.
- Томоохон хэмжээний хөрөнгө оруулалт бүхий үйл ажиллагаанд хэд хэдэн хөрөнгө оруулагч нар хамтран оролцох зайлшгүй шаардлага байдаг. Гэтэл 100% гэсэн хязгаарлалт нь энэ төрлийн хөрөнгө оруулалт бүхий том төсөл, үйл ажиллагаанд хөрөнгө оруулах сонирхлыг бууруулах магадлалтай. Иймээс хамрах хүрээг томруулан нөлөө бүхий хөрөнгө оруулагч нарт буюу 20%-иас дээш хувийн хөрөнгө оруулалт хийж хувь оролцоо эзэмшсэн бол ногдол ашгийн татвараас чөлөөлдөг байх нь оновчтой гэж үзэж байна.

## ААНОАТ: Оршин суугч бус этгээдийн орлогын татварын чөлөөлөлтийг ижил үйлчлэхээр зохицуулах

### Хуулийн холбогдох заалт:

30.7. Энэ хуулийн 30.1-д заасан эцсийн эзэмшигч нь Монгол Улсад байрладаг албан татвар төлөгч бол тухайн эцсийн эзэмшигчийн хувьцаа, хувь оролцоо, саналын эрхээ борлуулсан, шилжүүлсний орлого болон энэ хуулийн 30.3, 30.4, 30.5, 30.6-д заасны дагуу тооцсон эрх борлуулсан, шилжүүлсний орлогын зөвхөн аль өндөр дүнтэй орлогод холбогдох албан татварыг ногдуулна. Бага дүнтэй орлогыг албан татвараас чөлөөлнө.

### Өөрчлөн найруулах:

“30.7. Эцсийн эзэмшигч бол тухайн эцсийн эзэмшигчийн хувьцаа, хувь оролцоо, саналын эрхээ борлуулсан, шилжүүлсний орлого болон энэ хуулийн 30.3, 30.4, 30.5, 30.6-д заасны дагуу тооцсон эрх борлуулсан, шилжүүлсний орлогын зөвхөн аль өндөр дүнтэй орлогод холбогдох татварыг ногдуулна. Бага дүнтэй орлогыг албан татвараас чөлөөлнө” гэж өөрчлөн найруулах.

#### Үндэслэл:

- Оршин суугч бус этгээдийн хувьд хуулийн хөнгөлөлт чөлөөлөлт нэгэн адил үйлчлэхээр өөрчлөн зохицуулж, татварын үйл ажиллагааны ШУДАРГА байх зарчмыг хэрэгжүүлэх шаардлагатай.

## 3. НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬ

### НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлэх борлуулалтын орлогын заалтуудыг хүчингүй болгох

#### Хуулийн холбогдох заалт:

4.1.8. "нэмэгдсэн өртгийн албан татвар суутгах үүрэг үүсэх өдөр" гэж ... хувь хүн, хуулийн этгээдийн уг үйл ажиллагааны борлуулалтын орлогын хэмжээ 50 сая ба түүнээс дээш төгрөгт хүрсэн өдрийг;

5.2. Үйл ажиллагааны борлуулалтын орлогын хэмжээ нь 50 сая ба түүнээс дээш төгрөгт хүрч, ... суутган төлөгч байна;

6.5. ... борлуулалтын орлогын хэмжээ нь энэ хуулийн 5.2-т заасан орлогын 20 буюу түүнээс дээш хувьд хүрсэн бол ... сайн дураар бүртгүүлж болно. Хүчингүй болгох, өөрчлөн найруулах:

4.1.8, 5.2, 6.5 дахь заалтуудыг хүчингүй болгох

“5.2. Бизнесийн үйл ажиллагаа явуулж орлого олж буй хувь хүн, хуулийн этгээд бүр НӨАТ суутган төлөгч байна” гэж өөрчлөн найруулах.

#### Үндэслэл:

- Босго тогтоосноор татвар төлөгч татварыг бууруулах зорилгоор хий бичилт бүхий хуурамч НӨАТ-н баримтыг үнийн дүнгийн 4%-5%-ийг төлөх замаар хууль бус худалдан авалтын баримт бүрдүүлэх суурь шалтгаан болж байна.
- Энэ нь төсөвт орлого цуглахгүй, татвар төлөгчийг эрсдэлд оруулж байгаа бөгөөд жижиг дунд бизнес эрхлэгчид 10%-н татварыг төлж чадахгүй ч 5%-6%-н татварыг төлөх боломжтойг харуулж байна.

### Оршин суугч бус этгээдээс худалдан авсан ажил, үйлчилгээнд төлсөн НӨАТ-ыг суутгадаг болгох

#### Хуулийн холбогдох заалт:

14.1. ... төлсөн доор дурдсан албан татварыг түүний төсөвт төлөх албан татвараас хасч тооцно:

14.1.2. худалдах, түүнчлэн үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар импортоор оруулсан бараанд төлсөн;

14.1.4. мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг хуулийн этгээд ... анхан шатны боловсруулалтад ороогүй ... дотоодын үйлдвэрлэгчдэд борлуулсан бол үнийн дүнд нь 10 хувийн албан татвар шингэсэн гэж үзэж, тэдгээрийг худалдан авсан албан татвар суутган төлөгчийн албан татварыг уг хувиар

#### Өөрчлөн найруулах, шинэ заалт нэмэх:

“14.1.4. мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг хуулийн этгээд, хувь хүн ... анхан шатны боловсруулалтад ороогүй мах, сүү, өндөг, арьс шир, хонь, тэмээний ноос, ноолуур, ... дотоодын үйлдвэрлэгчдэд борлуулсан бол үнийн дүнд нь 10 хувийн албан татвар шингэсэн гэж үзэж, тэдгээрийг худалдан авсан албан татвар суутган төлөгчийн албан татварыг уг хувиар;” гэж өөрчлөн найруулах.

“14.1.6. Оршин суугч бус этгээдээс худалдан авч импортоор оруулсан бараа болон ажил, үйлчилгээнд төлсөн;” гэсэн шинэ заалт нэмэх.

#### Үндэслэл:

- Одоогийн зохицуулалтаар, татвар төлөгч өөрөө Оршин суугч бус этгээдээс худалдан авсан үйлчилгээнд 10 хувийн татварыг суутгуулахыг гүйцэтгэгч тал зөвшөөрдөггүй тул аж ахуйн нэгж 10 хувийн татварын зардлыг өөрсдөө хариуцан төлдөг хэдий ч НӨАТ-аа буцаан авах боломжгүй байдаг.

### НӨАТ: Албан татвар ногдох зарим бараа, ажил, үйлчилгээг нэмж тодорхойлох

#### Шинэ заалт нэмэх:

7.5. Эцсийн эзэмшигч” хүртэлх үргэлжилсэн хэлхээ холбоонд хамаарах хуулийн этгээд хооронд хувьцаа шилжүүлэх, нэгдэх, нийлэх, тусгаарлах, шинэ хуулийн этгээд үүсгэн байгуулах хэлбэрээр хэлхээ холбоо доторх хувьцаа, хувь оролцоонд хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийсэн тохиолдолд НӨАТ ногдуулах орлогод тооцохгүй.” гэсэн заалт нэмэх.

#### Үндэслэл:

“Эцсийн эзэмшигч” хүртэлх үргэлжилсэн хэлхээ холбоонд хамаарах хуулийн этгээд хооронд хувьцаа шилжүүлэх, нэгдэх, нийлэх, тусгаарлах, шинэ хуулийн этгээд үүсгэн байгуулах хэлбэрээр хэлхээ холбоо доторх

хувьцаа, хувь оролцоонд хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийсэн тохиолдолд НӨАТ ногдуулах орлогод тооцох эрсдэлтэй байдаг. Энэ нь арилжааны шинж чанартай, НӨАТ-н хуулийн хамрах хүрээнээс гадуур харилцаа тул ойлгомжтой, маргаан үүсгэхгүй байлгах зорилгоор НӨАТ ногдуулах орлогод орлогын тодорхойлолтой холбоотой хамаарахгүй хэсгийг нэмж оруулах.

## НӨАТ: Шаардах эрх

**НӨАТ-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд:**

11.1.6. шаардах эрхийг худалдан авч, санхүүжилт хийж байгаа этгээдийн татвар тооцох үнэлгээг шаардах эрхэд хамаарах нийт үнийн дүнгээс санхүүжилтэд өгсөн үнийн дүнг хасах.

**Шинэ заалт нэмэх:**

“11.1.7. тус хуулийн 11.1.6 дахь заалтад факторингийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй банк, санхүүгийн байгууллагын худалдан авсан шаардах эрх хамаарахгүй” гэсэн заалт нэмэх.

**Үндэслэл:**

Монгол улс санхүүгийн үйлчилгээ нь НӨАТ-с чөлөөлөгддөг, Олон улсын жишгээр санхүүгийн үйлчилгээ болон үүнээс үүссэн шаардах эрх нь НӨАТ-с чөлөөлөгддөг. Хуулийн төсөл дээр санхүүгийн үйлчилгээ болон үүнээс үүссэн шаардах эрх нь НӨАТ-с чөлөөлөгдөх зохицуулалт нь орхигдсон.

**НӨАТ: Татварын хөнгөлөлт**

НӨАТ-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд: 15.2. Оршуулгын үйлчилгээ, албан боловсролын үйлчилгээ, Эрүүл мэндийн даатгалын сан, улсын төсвөөс төлбөрийг хариуцах эмнэлгийн тусламж, үйлчилгээ, нийтийн тээврийн үйлчилгээ, нотариатын үйлчилгээнд ногдуулах татварыг татвар төлөгчөөс нэхэмжлэхгүй бөгөөд татвар суутган төлөгч үйлчилгээний борлуулалтад холбогдох татвар төлөгдсөн гэж үзэж татварын өглөг үүсгэн татварын авлагаас хасаж эцсийн тооцоог хийнэ.

**Шинэ заалт нэмэх:**

“6.6. Оршуулгын үйлчилгээ, албан боловсролын үйлчилгээ, Эрүүл мэндийн даатгалын сан, улсын төсвөөс төлбөрийг хариуцах эмнэлгийн тусламж, үйлчилгээ, нийтийн тээврийн үйлчилгээнд төлсөн татварыг татвар төлөгчид буцаан олгоно.” гэсэн заалт нэмэх

**Үндэслэл:**

- Татварын дарамт, ачаалал нэмсэн заалт болж харагдаж байгаагаас гадна татварын ачааллыг аж ахуйн нэгж буюу суутган төлөгч нь үүрэхээр ойлгогдож байгаа нь одоогийн нөхцөл байдлыг дордуулах магадлалтай. Иймээс дээр дурьдсанаар

100% хөнгөлөн иргэдэд буцаан олгодгоор зохицуулах нь зүйтэй гэж үзэж байна.

**НӨАТ: Татварын илүү төлөлт, суутгалт**

НӨАТ-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд: 19.1. Энэ хуулийн 15.1-д заасны дагуу тухайн сард хийх хасалтын хэмжээ нь мөн хугацаанд төлбөл зохих татварын дүнгээс их байвал татварын алба дараах байдлаар шийдвэрлэнэ

**Өөрчлөн найруулах:**

“19.1. Энэ хуулийн 15.1-д заасны дагуу тухайн сард хийх хасалтын хэмжээ нь мөн хугацаанд төлбөл зохих татварын дүнгээс их байвал татварын алба дараах байдлаар 30 хоногт багтаан шийдвэрлэнэ” гэж өөрчлөн найруулах

**Үндэслэл:**

- НӨАТ-ын буцаан олголтыг зөвшөөрдөг ч практикт буцаан олгодоггүй. НӨАТ-ын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу буцаан авах гэхэд НӨАТ-ын авлагыг баталгаажуулах, буцааж олгох шат дамжлага нь хуульд заасан хугацаанаас хэтэрдэг (зарим тохиолдолд татварын хяналт шалгалт нь 4-6 жил үргэлжлэх тохиолдол ч байдаг) мөн практикт ААНОАТ болон АМНАТ-ийн өрнөөс ч хасаж тооцдоггүй, хяналт шалгалтаар ороод НӨАТ-ын авлагын дүнг баталгаажуулсан байлаа ч татварын өргүй компанид мөнгөн дүнгээр буцаалт хийдэггүй гэх мэт асуудлаас болоод уг авлагыг зардал руу шилжүүлж байна. Улмаар аж ахуйн нэгжийн эргэлтийн хөрөнгө багасаж, мөнгөн хөрөнгөгүй болж үйл ажиллагаа нь доголдож дампуурах хүртэл эрсдэлд ч оруулж байна. Иймд шинэ хуулинд НӨАТ-ын буцаан олголтыг баталгаажуулахын тулд буцаан олголтыг шийдвэрлэх тодорхой хугацаа тавьж өгөх шаардлагатай.

## 4. ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬ

**ХХОАТ: Татварын орлогын шатлалыг хүчингүй болгох**

НӨАТ-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд: 21.1. ... жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар, 120 000 001-180 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 12 000 000 төгрөг дээр 120 000 000 төгрөгөөс дээш давсан орлогод 15 хувиар, 180 000 000 төгрөгөөс дээш

албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 21 000 000 төгрөг дээр 180 000 000 төгрөгөөс дээш давсан орлогод 20 хувиар нэмж тооцон албан татвар ногдуулна.

#### **Өөрчлөн найруулах:**

21.1. Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого болон шууд бус орлогын хувьд жилийн татвар ногдуулах орлогод 10 хувиар албан татвар ногдуулна.” гэж өөрчлөн найруулах

#### **Үндэслэл:**

- Хувь хүний орлогын шаталсан албан татвар нь жилийн 120 сая төгрөг буюу сарын 10 сая төгрөгөөс дээш орлоготой, ажил хөдөлмөр эрхэлж буй, өндөр боловсрол, ур чадвар эзэмшсэн, бусдаас илүү хөдөлмөрлөж буй 6,000 (давхардсан тоогоор) орчим хувь хүмүүс рүү чиглэгдэж байна. Энэ нь төсвийн орлогод дорвитой хувь нэмэргүйгээс гадна тус татварыг тооцох, төлүүлэхэд илүү ажиллагаа, зардал чирэгдэлтэй, мөн далд эдийн засгийг дэмжих, мэргэшсэн боловсон хүчний хомсдолд хүргэх зэрэг эрсдэл үүсгэхээр байна.
- Татварын нэг хувь хэмжээ ашиглах нь татварын системийг илүү ойлгомжтой, хялбар болгодог. Тухайлбал, Олон улсад, Казахстан, Болгар зэрэг улсууд ХХОАТ-ыг олон шатлал, олон хувь хэмжээ бүхий системээс нэг буюу 10%-иар татвар ногдуулж, татварын хураалт, тайлагналтыг энгийн болгож үр дүнд хүрсэн жишээ байна.

### **ХХОАТ: Оршин суугч бусын албан татвар**

**НӨАТ-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд:**

21.2.5. энэ хуулийн 20.1, 20.4-т заасан орлогын дүнд 20 хувиар

#### **Өөрчлөн найруулах, шинэ заалт нэмэх:**

“21.2.5. энэ хуулийн 20.1-д заасан орлогын дүнд 10 хувиар;” гэж өөрчлөн найруулах

“21.2.6. Оршин суугч бус банк, санхүүгийн байгууллагад олгосон хүүгийн орлогоос 5 хувиар татвар ногдуулан суутган төлөх;” гэж шинээр нэмэх

#### **Үндэслэл:**

- Энэ төрлийн татвар нь Ногдол ашгаас бусад төрлийн орлогын хувьд татвар төлөгч өөрсдийн зардлаа нэмэх байдлаар “СУУТГАН” төлдөг. Иймээс ТНО-с хасагдах зардлаар хүлээн зөвшөөрөхдөө гэрээ болон нэхэмжлэхийн дүнд оруулсан байх шаардлага тавихгүйгээр ТНО-с шууд хасдаг болох нь чухал байна. Мөн дотоодын санхүүжилтийн хязгаарлалтаас хамаараад гадаад зах зээлээс босгоход санхүүжилтийн зардал өндөр байдаг тул хүүгийн

орлогоос суутгах татварын хувь хэмжээг 5% болгон бууруулах нь эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх болно.

- Татварын хувь хэмжээг OECD – Global Anti-Base Erosion Model Rules (Pillar Two-н дагуу хамгийн бага татварын хувь хэмжээ буюу 15% -д барих үүрэгтэй тул бууруулах боломжтой гэж үзэж байна.

### **ХХОАТ: Оршин суугч бусын албан татвар**

**НӨАТ-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд:**

23.1. Албан татвар төлөгчийн энэ хуулийн 14, 15, 18 дугаар зүйлийн дагуу тодорхойлсон 9,600,000 хүртэлх төгрөгийн орлогод ногдуулах албан татварыг 100 хувиар хөнгөлнө

#### **Өөрчлөн найруулах, шинэ заалт нэмэх:**

“23.1. Албан татвар төлөгчийн энэ хуулийн 14, 15, 18 дугаар зүйлийн дагуу тодорхойлсон 9,600,000 хүртэлх төгрөгийн орлогод ногдуулах албан татварыг 100 хувиар хөнгөлнө” гэж өөрчлөн найруулах

23.17. Энэ хуулийн 15.1 дэх заалтад тодорхойлсон орлогод ногдох татварт 90%-ийн хөнгөлөлт үзүүлнэ” гэсэн заалт шинээр нэмэх

#### **Үндэслэл:**

- Хөнгөлөлтийн дүнг өндөр болгосноор хөнгөлөлтийг бодит болгох. Сар бүр 80 мянган төгрөг бол маш бага дүн болж байна. Бизнесийн орлогын хувьд хөнгөлөлтийн дүнг нэмэх шаардлагатай.

### **ХХОАТ: Цалин хөлсний болон хувь хүний бизнесийн орлогын аль алинд ижил хөнгөлөлт үзүүлэх**

**НӨАТ-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд:**

23.1. Албан татвар төлөгчийн энэ хуулийн 14, 15, 18 дугаар зүйлийн дагуу тодорхойлсон 9,600,000 хүртэлх төгрөгийн орлогод ногдуулах албан татварыг 100 хувиар хөнгөлнө.

#### **Өөрчлөн найруулах, шинэ заалт нэмэх:**

23.1. Албан татвар төлөгчийн энэ хуулийн 14, 15, 18 дугаар зүйлийн дагуу тодорхойлсон 9,600,000 хүртэлх төгрөгийн орлогод ногдуулах албан татварыг 100 хувиар хөнгөлнө” гэж өөрчлөн найруулах.

23.17. Энэ хуулийн 15.1 дэх заалтад тодорхойлсон орлогод ногдох татварт 90%-ийн хөнгөлөлт үзүүлнэ” гэсэн заалт шинээр нэмэх.

#### **Үндэслэл:**

- Хөнгөлөлтийн дүнг өндөр болгосноор хөнгөлөлтийг бодит болгох. Сар бүр 80 мянган төгрөг бол маш бага дүн болж байна. Бизнесийн орлогын хувьд хөнгөлөлтийн дүнг нэмэх шаардлагатай.



# ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬ, СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ХУВИЙН ХЭВШЛИЙН ЗҮГЭЭС ӨГЧ БУЙ САНАЛ

№	Асуудал, холбогдох хуулийн зохицуулалт	Асуудлын тайлбар	Шийдвэрлэх санал
1	<p>Эрчим хүчний тухай хуулийн 14.4.Эрчим хүч дамжуулах шугам, дэд станц нь төрийн өмчлөлд байна.</p> <p>Хувийн хөрөнгө оруулалт бүхий эрчим хүчний үйлдвэрлэгч, хангагчийн үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчин тодорхой бус, хувийн хөрөнгө оруулалт бүхий эрчим хүчний эх үүсвэрийг дамжуулах сүлжээнд холбогдсон гэдэг үндэслэлээр нэгдсэн сүлжээний бүрэлдэхүүн хэсэгт хамруулан тарифын зохицуулалтад оруулах шаардлага үүсдэг.</p>	<p>110кВ -с дээш хүчдэлийн хэмжээтэй шугам барих хувийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төслүүд нэмэгдэж байгаа бөгөөд ийнхүү барьсан хувийн өмчийн хөрөнгийг төрд шилжүүлэх нь зохисгүй, хувийн өмчийг хуулиар хамгаалах зарчимд нийцэхгүй байна. Нэгдсэн сүлжээ үүсгэхгүй байгаа өөрөөр хэлбэл эх үүсвэр хоорондын холболтод орж чадал, энергийн 2 талын урсгалыг зохицуулахгүй байгаа 110, 220 кВ хүчдэлтэй шугам дэд станцыг дамжуулах сүлжээнд хамааруулахгүй байх хуулийн зохицуулалт хэрэгтэй.</p>	<p>Зарчмын өөрчлөлтийн санал. Хувийн хөрөнгө оруулалтаар баригдах эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээний өмчлөл болон тэдгээрийг ашиглах харилцааг тодорхой болгож хуульд хувийн өмчийн эх үүсвэр бүхий харилцааг зохицуулсан бүлгийг бий болгох, эсвэл шинээр хууль боловсруулах, холбогдох нэр томьёо, нэгдсэн сүлжээний ойлголтод өөрчлөлт оруулах.</p>
2	<p>Эрчим хүчний сайдын 2019 оны 125 дугаар тушаалаар батлагдсан Эрчим хүчний барилга байгууламж барих ажлын журам</p> <p>Эрчим хүчний салбарт мөрдөгдөх дүрэм журам нь голчлон төрийн өмчит, нэгдсэн сүлжээнд холбогдсон байгууллагуудын үйл ажиллагаанд хамааралтай буюу түүнд тулгуурласан байх боловч, түүний хамрах хүрээ, хязгаарыг хөрөнгө оруулалтын хэлбэрийг үл харгалзан төрийн өмчит болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт бүхий харилцааг нийтлэг байдлаар зохицуулахаар заасан байдаг нь хууль тогтоомжийн хэрэгжүүлэлтийн ойлгомжгүй байдлыг үүсгэж, бие даасан эрчим хүч үйлдвэрлэгч болон хувийн хэвшлийн компаниудын үйл ажиллагаанд төрийн оролцоог нэмэгдүүлэх, улмаар үйл ажиллагааг үндэслэлгүй саатуулах, үйл ажиллагаанд уялдаагүй нөхцөл, шаардлагыг биелүүлэхэд нэмэлт зардал гаргах зэрэг хүндрэлийг үүсгэж байна.</p> <p>Иймд, УИХ, ЗГ-с баримталж буй Эрчим хүчний бодлогын хүрээнд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, хувийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл хөтөлбөрийг дэмжих, эрх зүйн харилцааг төрийн өмчит болон хувийн хэвшлийн онцлогт нийцүүлэн ялгаатай зохицуулсан эрх зүйн орчныг бүрдүүлэх зэргээр хууль тогтоомжийн шинэчлэлд тусгах шаардлагатай.</p>	<p>Журмын 1.1 Монгол улсын нутаг дэвсгэрт хөрөнгийн эх үүсвэр өмчийн хэлбэр харгалзахгүйгээр эрчим хүчний барилга байгууламж барих ажлыг зохион байгуулах хүрээнд ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулахтай холбогдсон үйл ажиллагааг журмаар зохицуулна гэж заасан.</p> <p>Хууль болон түүнийг дагалдан гарах журмыг төрийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих үйл ажиллагааны зохицуулалтаар ангилж, ялгаатай зохицуулах, хувийн хэвшлийн үйл ажиллагаанд төрийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагаагаар шууд нөлөөлдөг, эрх ашигт хохиролтой шийдвэр гаргадаг байдлыг арилгах зарчмын өөрчлөлтүүдийг тусгаж, хувийн хөрөнгө оруулалт бүхий эрчим хүчний үүсвэр, түүнд хамаарах харилцааг шинэ бүлэг үүсгэн зохицуулах.</p>	<p>- Хуульд эрх бүхий байгууллагаас дүрэм журам батлах асуудлын үндсэн шалгуурыг хувийн хэвшлийн үйл ажиллагаанд хамрах эсэхийг тодорхой тогтоож, хэт өргөн хүрээг хамрахаас хязгаарлах нөхцөлийг оруулах.</p> <p>-Дүрэм журам батлах, шинээр байгууллага байгуулах, тэдгээрийн зардлыг санхүүжүүлэх талаарх заалтыг тусгахдаа эдгээр нь холбогдох хууль тогтоомжийн шаардлагаас давсан болон хууль тогтоомжийг зөрчсөн, дордуулсан нөхцөл тусгахгүй байх, хувийн хэвшлийн үйл ажиллагаанд хуулиар тогтоогоогүй татвар, хураамжийг бий болгохгүй байх, төрөөс ийм байгууллагуудыг байгуулахдаа үйл ажиллагаа нь төсвөөс санхүүждэг байх гэсэн үндсэн зарчмуудыг баримтлах шалгууртай болгох.</p>
3	<p>Эрчим хүчний тухай хуулийн 6-р зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх 6.1.13 ЭХ-ний салбарт хэрэгжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах;</p>	<p>Одоо хэрэгжиж буй хуулийн үндэслэл, найруулга, бүтэц, зохицуулалтаас харвал тус хууль нь илүүтэйгээр төрийн өмчит болон төрийн оролцоот байгууллагуудын үйл ажиллагаа, чиг үүрэг, тэдгээрээс хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийг хэрхэн шийдвэрлэх, хэрэгжүүлэх талаарх асуудлаар зохицуулсан, түүнд тулгуурласан шинжтэй байгаа.</p>	<p>Хуулийн заалтыг доорх тодруулсан байдлаар өөрчлөх:</p> <p>6.1.13 Эрчим хүчний салбарт хэрэгжих улсын төсвийн хөрөнгө болон гадаад улсын тусламж, зээлээр санхүүжиж буй төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах;</p>

4	<p>Энэхүү хуульд заасан "эрчим хүчний дэд станц шугам, тоноглолыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэх" нь хэрэглэгчийн эрх үү, эсхүл үүрэг үү гэдэг нь тодорхойгүй байдгаас хэрэглэгч болон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хооронд үл ойлголцол үүсдэг.</p> <p>Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дугаар тогтоолын 3.1д зааснаар төрийн болон орон нутгийн өмчийг үнэ төлбөргүй шилжүүлж авах талаар заасан байна. Нийтийн эзэмшлийн хөрөнгийн ашиглалт сайжрах.</p> <p>Эрчим хүчний тухай хуулийн 30.1.13 Хэрэглэгч нь нийтийн эзэмшлийн орон сүүцны барилга барих тохиолдолд барьсан эрчим хүчний дэд станц шугам, тоноглолыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэх</p>	<p>Цахилгаан шугам болон дэд станцтай холбоотой эд хөрөнгийг тухайн хөрөнгийг өмчлөх зорилгоор бус найдвартай ажиллагааг хангаж, ашиглалт үйлчилгээг хариуцах зорилготой ТЭЭ эзэмшигчид шилжүүлж байгаа тул төрийн болон орон нутгийн өмчийг үнэ төлбөргүй шилжүүлж авахтай адил замаар эзэмшүүлж, нийтийн эзэмшлийн асуудлыг шийдвэрлэж байгаа гэдэг утгаар албан татвараас хөнгөлж чөлөөлбөл, тухайн хөрөнгүүдийн засвар, ашиглалтын үйлчилгээг нэмэлт зардал гаргахгүйгээр хариуцаж, найдвартай ажиллагааг хангаж ажиллах боломж бүрдэнэ.</p>	<p>Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 11.7; 11.8-д заасны дагуу, Эрчим хүчний дэд станц, шугам, тоноглолыг шилжүүлэхдээ, улсын комисс ажиллах үед тусгай зөвшөөрөл эзэмшигчид шууд шилжүүлдэг байх, мөн тус хөрөнгийг албан татвараас чөлөөлдөг байх.</p>
5	<p>Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль 5.3 Эрчим хүчний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 5.3.6.сэргээгдэх эрчим хүчний нөөцийн судалгаа хийх;</p> <p>Одоо мөрдөгдөж байгаа хуулийн агуулга нь зохицуулалттай тарифтай, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан эх үүсвэрийн харилцаанд суурилсан шинжтэй, хувийн хөрөнгө оруулалтаар баригдах эх үүсвэрийн харилцааг зохицуулаагүй орхигдуулсан, өөрийн хэрэглээнд болон хэрэглэгчтэй шууд гэрээгээр хангах эх үүсвэрийн зохицуулалт тодорхойгүй зэргээр эрх зүйн орчин тодорхой бус байна.</p>	<p>Нөөцийн судалгааг зөвхөн ЭХЯ хийх эрхтэй ба хувийн хэвшил болон бусад этгээд ийм эрхгүй гэдэг хязгаарлагдмал ойлголтыг агуулж байна. Түүнчлэн ЭХЯ үнэхээр bankable түвшний өгөгдөл цуглуулах техник чадавх бүрдүүлж, эрсдэлээ үүрч чадах уу? Одоо ийм чадавх байхгүй байгаа.</p>	<p>Хувийн хэвшил нөөцийн судалгааг өөрийн хөрөнгөөр хийх, төрд худалдан борлуулах болон бусад нөхцөлөөр шилжүүлдэг боломжтой байх. Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн "5.3.6.улсын төсвөөр санхүүжүүлэх сэргээгдэх эрчим хүчний төслийн нөөцийн судалгаа хийх;" гэж өөрчлөх</p>
6	<p>Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 5.3.7.сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж, техник хэрэгслийн ашиглалт, аюулгүй ажиллагаа, засвар, үйлчилгээний норм, дүрэм, стандартыг боловсруулж, зохих журмын дагуу батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих.</p>	<p>Салхин турбин генераторууд, бусад тоноглол олон улсын type certificate-тай, засвар үйлчилгээ хийх гарын авлагатай, техник технологи хурдан өөрчлөгдөж байгаа тул хувийн хэвшлийн үйл ажиллагаанд саад учруулах заалт байна</p>	<p>5.3.7.улсын төсвөөр санхүүжүүлсэн сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж, техник хэрэгслийн ашиглалт, аюулгүй ажиллагаа, засвар, үйлчилгээний норм, дүрэм, стандартыг боловсруулж, зохих журмын дагуу батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих</p>
7	<p>Эрчим хүчний үндэсний төвийн эрх хэмжээг дахин тодорхойлох</p>	<p>Тодруулж хэлбэл гадаадын хөрөнгө оруулалттай төсөл хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулагчийн шаардлагаар хөндлөнгийн хяналтын байгууллагад өндөр төлбөр төлж техникийн хяналтыг гүйцэтгүүлдэг. Гэтэл төрийн байгууллагын зүгээс мөн өөрийн хяналтыг тавих шаардлага ирүүлж төлбөртэй үйлчилгээ үзүүлдэг. Эрчим хүчний барилга байгууламжийн хувьд эрчим хүч, барилгын салбараас ижил төрлийн үйлчилгээг үзүүлэх шаардлагыг хоёр төрийн байгууллага тавьж нэг барилга байгууламжийн техникийн хяналтыг гурван байгууллага хийж болж зардлыг өсгөн хувийн хэвшлийг санхүүгийн хүнд байдалд оруулж байна.</p>	<p>Эрчим хүчний яамны мэдэлд байгаа Эрчим хүчний үндэсний төвийг зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээний техникийн хяналт хийх, эрчим хүчний төрийн өмчит компаниудын хэмнэлт үр ашгийн асуудал ялангуяа үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр ашиг, зардлыг хянах үүргийг хариуцуулах</p>
8	<p>Эрчим хүчний тухай хуулийн 5-р зүйл. Засгийн газрын бүрэн эрх 5.1.6. бие даасан эрчим хүч үйлдвэрлэгчид шаардлагатай дэмжлэг үзүүлэх.</p>	<p>Ямар төрлийн дэмжлэг үзүүлэх нь тодорхойгүйгээс Засгийн газраас хангалттай дэмжлэг үзүүлэхгүй байна. Эрчим хүч нь аливаа улс орны стратегийн ач холбогдолтой, тусгаар тогтнол аюулгүй байдалд шууд нөлөөтэй ба эрчим хүчний төсөл нь өндөр зардалтай, мега төслүүдэд хамаардаг тул энэхүү салбар хөгжихөд төрийн</p>	<p>Ямар төрлийн дэмжлэг үзүүлэхийг тодорхой болгох. Санхүүжилт татаас өгөх, Засгийн газрын баталгаа гаргах гэх мэт.</p> <p>Эрчим хүчний тухай хуульд дамжуулах сүлжээ ашиглан (дамжуулалтын алдагдал, дамжуулалтын хөлс төлөөд) үйлдвэрлэгчээс хэрэглэгчид шууд цахилгаан худалдах зохицуулалтыг оруулж өгөх. Ингэснээр эрчим хүчний үйлдвэрлэл нэмэгдэх, дамжуулах шугамын ашиглалт дээшилнэ.</p>



		дэмжлэг зайлшгүй шаардлагатай байдаг. Төрийн дэмжлэг нь эрчим хүчний төсөл хөгжүүлэх, ашиглалтад оруулаад зогсохгүй хувийн өмчийг хамгаалах, талууд гэрээгээр тохиролцсон үүргээ хэрэгжүүлэхэд хяналт тавих, цаашид бизнес үр ашигтай байхад дэмжлэг үзүүлэх гэх зэрэг хоорондоо уялдаа холбоотой дэмжлэгийн цогц тогтолцоо шаардлагатай байдаг.	
9	Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль /Ерөнхий/ Одоо мөрдөгдөж байгаа хуулийн агуулга нь зохицуулалттай тарифтай, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан эх үүсвэрийн харилцаанд суурилсан шинжтэй, хувийн хөрөнгө оруулалтаар баригдах эх үүсвэрийн харилцааг зохицуулаагүй орхигдуулсан, өөрийн хэрэглээнд болон хэрэглэгчтэй шүүд гэрээгээр хангах эх үүсвэрийн зохицуулалт тодорхойгүй зэргээр эрх зүйн орчин тодорхой бус байна.	Жишээлбэл: 5.6.1.дамжуулах сүлжээнд холбогдох үүсгүүр бүхий үйлдвэрлэгчийн үйлдвэрлэн нийлүүлэх эрчим хүчний үнийн тооцоог хянаж, энэ хуулийн 11 дүгээр зүйлийн дагуу тарифыг батлах; 5.6.4.цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээний үйлчлэх хугацаа дууссаны дараа үнэ, тарифыг тухай бүр тогтоох. 5.6.5.хэрэглэгчийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээс үйлдвэрлэсэн цахилгааны түгээх сүлжээнд нийлүүлэх үнэ, тарифыг жил бүр хянаж, тогтоох. 10.1. Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах тухай үйлдвэрлэгч, Диспетчерийн үндэсний төвийн хоорондын гэрээг Эрчим хүчний зохицуулах хорооны баталсан загварын дагуу байгуулна. гэх мэтээр зохицуулалттай тариф бүхий харилцаанд чиглэсэн шаардлагууд байгаа нь зохицуулалтгүй тариф бүхий дамжуулах сүлжээнд холбогдох төсөл хэрэгжих боломжгүй гэж үзэх буюу зохицуулалтын ойлгомжгүй байдлыг үүсгэж байна.	Сэргээгдэх эрчим хүчний салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар дамжуулах сүлжээнд холбогдсон болон холбогдоогүй эрчим хүчний эх үүсвэрүүд ихээр баригдаж буй бөгөөд цаашид энэ салбарын хөгжлийг дэмжих хүрээнд зохицуулалтгүй буюу хувийн хөрөнгө оруулалтаар баригдсан эх үүсвэрийн харилцааг түсгайлан зохицуулах, дамжуулах сүлжээнд холбогдсон ч гэрээний үнээр эрчим хүч нийлүүлэх боломжтой байх тодорхой зохицуулалт шаардлагатай байна.
10	Эрчим хүчний зохицуулах хорооны 2015 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 264 дүгээр тогтоол "Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ"-ний загвар 8 дугаар зүйлийн 8.2.5 "Арилжаа эхлэх өдөр"-ийн тодорхойлолт эрчим хүчний салбарын одоогийн зах зээлийн нөхцөл шаардлагад нийцэхгүй байгаа юм	"Арилжаа эхлэх өдөр" гэж Станцыг ашиглалтад оруулах туршилт амжилттай хийгдэж барилга, байгууламжийг ашиглалтад оруулах Улсын комисс хүлээн авсны дараа Худалдан авагчаас арилжаа эхлүүлэх зөвшөөрөл олгосон өдрийг гэж тодорхойлсон. Гэтэл станцыг ашиглалтад оруулах туршилт хийж цахилгаан сүлжээнд ажилд залгасны дараа улсын комисс ажиллах хүртэл ихээхэн урт хугацаанд үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчний борлуулалтын орлого тооцогдохгүй байгаа тул хөрөнгө оруулагчид ихээхэн алдагдалд орох нөхцөл байдал үүсэж байна.	"Арилжаа эхлэх өдөр" гэдэг тодорхойлолтыг Станцыг ашиглалтад оруулах туршилт амжилттай хийгдэж эрчим хүчний эх үүсвэрийг цахилгаан сүлжээнд залгах зөвшөөрөл олгон эрчим хүч нийлүүлж эхэлсэн өдрийг гэж өөрчлөх
11	Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруул	Хуримтлуурын системийг зохицуулсан хуультай болох шаардлагатай	Эрчим хүчний тухай хуульд Эрчим хүчний хуримтлуурын байгууламжтай холбоотой шинээр нэмэлт өөрчлөлтүүдийг оруулах Технологийн томоохон хэрэглээтэй үйлдвэр аж ахуй нэгжид эрчим хүч нөөцлөх хадгалах хуримтлуулан оргил ачаалал хөнгөлөх талаар заалт оруулах

12	Эрчим хүчний салбар нь бие даасан бодлогын баримт бичиг, бодлоготой байх шаардлагатай	Эрчим хүчний салбар нь бие даасан бодлогын баримт бичиг, бодлоготой байх шаардлагатай	Салбар өөрийн бие даасан бодлоготой байх хэрэгтэй
13	Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 5.3.1.сэргээгдэх эрчим хүчний талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх;	Хаана, хэдэн МВт хүчин чадал хэрэгтэй байгаагаа урьдчилан мэдээлж байвал хувийн хэвшил бэлтгэлээ хангаж, СЭХ-ний нөөцөө тодорхойлох ажлаа эхлүүлнэ	5.3.1.сэргээгдэх эрчим хүчний сонгон шалгаруулалтын дүнд хугацааны төлөвлөгөөг боловсруулж, хэвлэн нийтлэх, жил бүрийн дуудлага худалдааг хэрэгжүүлэх;
14	Хангалттай нөөц бүрдүүлэлт		ЭХ-ний байгууллагууд мэргэжилтнүүдийг сургах, дадлагажуулах, мэргэшүүлэх тухай асуудлыг нэгдсэн бодлогын баримт бичгээр тогтворжуулан зохицуулах
15	Эрчим хүчний тухай хуулийн 6-р зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх 6.1.6 Тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгохтой холбогдон гарсан маргааныг хянаж дүгнэлт гаргах;	Тусгай зөвшөөрлийг олгох, нөхцөл шаардлагыг тогтоох, тусгай зөвшөөрлийн хэрэгжилтийн хянах зэрэг үүрэг нь ЭХЗХ-д олгогдсон ба хуулиар Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхэд мөн хамааруулж улмаар маргааныг хянан шийдвэрлэхээр заасан нь давхардсан чиг үүрэг үүсгэсэн.	Тус заалтыг төрийн захиргааны байгууллагын бүрэн эрхээс хасаж, тусгай зөвшөөрлийг олгох эрхийг мэргэжлийн байгууллага (төрийн бус байгууллагууд болон ЭХЗХ зэрэг) руу шилжүүлэх, холбогдох маргааныг урьдчилсан шатаар мэргэжлийн байгууллага шийдэх, улмаар маргааныг шүүхээр шийдвэрлүүлэхээр тусгах. Санал: 1/ Хасах: Эрчим хүчний тухай хуулийн 6.1.6-г хасах 2/ Нэмэх: Тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгохтой холбогдон гарсан маргааныг тухайн тусгай зөвшөөрлийг олгох байгууллагын дээд шатны захиргааны байгууллага хянаж дүгнэлт /эсхүл шийдвэр/ гаргана. Дээд шатны захиргааны байгууллагын гаргасан дүгнэлт /эсхүл шийдвэр/-ийг эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж болно.
16	Эрчим хүчний тухай хуулийн 22.1.Эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах тусгай зөвшөөрлийн хугацаа 5-25 жил, эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрлийн хугацаа 5 хүртэл жил, бусад тусгай зөвшөөрлийн хугацаа 10 хүртэл жил байна. 22.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зохих ёсоор биелүүлсэн бөгөөд техник, технологийн хувьд цаашид үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөл, боломжтой гэж тусгай зөвшөөрөл олгогч үзвэл тусгай зөвшөөрлийн хугацааг 25 хүртэл жилээр сунгана.	Зөвшөөрлийн тухай хуулийн 14.Хуульд өөрөөр заагаагүй бол зөвшөөрөл эзэмшигч зөвшөөрлийн хугацааг сунгуулах тухай өргөдөл гаргасан, холбогдох хууль тогтоомж зөрчөөгүй, хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангаж байгаа бол эрх бүхий этгээд тухайн зөвшөөрлийн хугацааг анх олгосон хугацаагаар сунгана. хэмээн заасан бөгөөд тус хуулиудын зөвшөөрлийн сунгах хугацаа зөрчилдөж байна. Улмаар ЭХЗХ-с зөвшөөрлийг зөвхөн 5 жилийн хугацаагаар сунгах үндэслэлгүй шийдвэр гаргаж байгаа нь тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн эрх ашигт хохиролтой байна.	Эрчим хүчний тухай хууль болон Зөвшөөрлийн тухай хуулийн холбогдох зохицуулалт нь зөрчилдөж байгаа бөгөөд хууль хоорондын нийцлийг хангах. Эрчим хүчний салбарт мөрдөж буй тусгай зөвшөөрөл олгох шаардлага, нөхцөлийг эргэн харж сайжруулалт хийх, хугацааг тусгайлсан хууль буюу эрчим хүчний тухай хуульд нийцүүлэн тогтоох талаар зохих байгууллагуудад чиглэл хүргэх.
17	Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 5.6.3.хэрэглэгчийн худалдан авах дэмжих тарифын хэмжээг тогтоох;	Дэмжих тарифыг хасах	5.6.3.Сэргээгдэх эрчим хүчний хэрэглэгчийн ангиллын аж ахуйн нэгж, ахуйн хэрэглэгчийн тарифыг тогтоох;




18	Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 5.3.8.төсөл шалгаруулалтын журмыг боловсруулах, батлах;	Сэргээгдэх эрчим хүчний хувьд аль нэг байршлын нөөцөөс хамааран нийлүүлэх цахилгаан энергийн таамаглал өөр байх учир СЭХ хэрэгцээтэй гэж үзсэн цэгт буюу газар нутагт үнээр өрсөлдөх боломжтой болно	5.3.8.төслийг шалгаруулах үнийн дуудлага худалдаа /аукцион/-ны журмыг боловсруулах батлах. Хувийн хэвшлийг сэргээгдэх болон сэргээгдэх бус эх үүсвэрүүдийн хувьд үнээр өрсөлдүүлэх боломжийг бүрдүүлэх,
19	Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд шинээр нэмэх	Одоо байгаа станцуудын хүчин чадлыг өргөтгөх, генераторуудаа нэгж бүрийн хүчин чадал ихтэй тоноглолоор орлуулах нь дэд станц шугамын хөрөнгө оруулалт шаардахгүй СЭХ-ний суурилагдсан чадлыг нэмэгдүүлэх бага өртөгтэй хувилбар бөгөөд хуулиар ийм боломжийг нээж өгөх хэрэгтэй.	4.1.13."хүчин чадлын өргөтгөл" гэж дамжуулах шугам болон дэд станцын бүтээн байгуулалт шинээр шаардахгүй, дамжуулах сүлжээнд холбогдон ажиллаж буй сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийн хүчин чадлыг өргөтгөх эсвэл тодорхой хэсгийг орлуулан хүчин чадлыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг;
20	Нэгдсэн сүлжээний дүрэм	Нэгдсэн сүлжээний дүрэмд 2002 оноос хойш 3 удаа өөрчлөлт орсон байна. Цахилгаан системд хэрэглэгдэж байгаа бусад дүрмүүдийг техник, технологийн болон стандартын өөрчлөлттэй уялдуулан 2 жил тутамд өөрчилж байх шаардлагатай. Ийм дүрмийн өөрчлөлт, шинэчлэл хариуцах байгууллага салбарын бүтцэд байгаа ч уялдаа холбоог хангаж ажиллуулан дүрэм журмаа өөрчилж чадахгүй байна	Нэгдсэн сүлжээний дүрмийг эргэн харах, бусад хууль журам, өнөөгийн нөхцөлтэй уялдуулах. Цахилгаан системийн найдвартай ажиллагааг хангахад өмчийн бүх төрлийн эх үүсвэрүүд ялангуяа тархмал эх үүсвэрийн оролцоо, горим ажиллагааг зохицуулах боломж бүхий нэгдсэн сүлжээний дүрэм шаардлагатай байна.
21	Төрийн өмчит компанийн тухай хууль		Эрчим хүчний 100% төрийн өмчит компаниудыг олон нийтэд нээлттэй хувьцаат компани болгох



МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН  
ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ

# ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРТ ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

**График 1. Улсын төсөвт уул уурхайн салбарын оруулж буй хувь нэмэр**




Эх сурвалж: Сангийн яам (2024)

### Нөхцөл байдал:


Уул уурхайн салбар нийт төсвийн орлогын 30 гаруй хувийг бүрдүүлж байгаа бөгөөд үүнээс АМНАТ (рояльти) 50 орчим хувь буюу өмчлөлийн хэлбэрээр үл хамаарах энэхүү хоёр татвар нь 75 хувийг бүрдүүлж байна. Харин төрийн өмчит компанийн ногдол ашиг нь уул уурхайн салбарын төсөвт оруулах орлогын 5 орчим хувь байгаа.

**График 2. Улсын төсөвт уул уурхайн салбарын оруулж буй хувь нэмэр /тэрбум төгрөг, 2023 он/**



Эх сурвалж: ОУИТБС-ын 2023 оны нэгтгэл тайлан


**График 3. УУ-н салбарын төлсөн татварын улсын төсвийн орлогод эзлэх хувь**



### Нөхцөл байдал:

Уул уурхайн салбарын улсын төсөвт оруулсан орлогын 80 хувийг 5 компани бүрдүүлж байна

**График 4. Монгол улсын экспортын бүтэц**



Эх сурвалж: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам

### Нөхцөл байдал:

Уул уурхайн салбар нийт экспортын 90 гаруй хувийг бүрдүүлж байгаа бөгөөд үүнээс нүүрс, зэсийн баяжмал, алт гэх 3-хан бүтээгдэхүүн нийт экспортын 80 гаруй хувийг дангаараа бүрдүүлж байна.





## ХАРИУЦЛАГАТАЙГААС ТОГТВОРТОЙ УУЛ УУРХАЙ РҮУ

Монгол Улсын эдийн засагт эрдэс баялгийн салбар ямар чухал байр суурь эзэлдгийг 2024 оны тоон үзүүлэлтүүдээс тодорхой харж болно. Дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувь, аж үйлдвэрийн салбарын 70 хувь, улсын төсвийн орлогын 30 хувь, экспортын 94 хувь, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 79 хувийг бүрдүүлдэг эдийн засгийн тулгуур салбар болохын тулд салбарын хөгжлийг дараагийн шатанд гаргах, дэлхийн улс орнуудын чиг хандлага болж буй хариуцлагатай, тогтвортой уул уурхайн бодлого, стратегид нэгдэх, түүнийг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага зүй ёсоор тавигдах боллоо.

Хариуцлагатай уул уурхайн яриа хэлэлцээ, санал санаачилга ч төрийн бодлогын баримт бичгүүдэд тусгалаа олсныг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “...Уул уурхайн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлж, орлогод тавих хяналтыг сайжруулна”, мөн “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичиг, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлүүдэд “хариуцлагатай уул уурхайг” хөгжүүлж, дэмжих талаар тодорхой зааснаас харж болно.

Хариуцлагатай уул уурхайн талаар тогтсон, нэгдмэл тодорхойлолтыг албан ёсны баримт бичгийн түвшинд авч үзвэл, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрөөс гаргасан “Хариуцлагатай уул уурхайн санаачилга” (2007) баримт бичигт “Уурхайг ашигласнаар улс орны хөгжилд нь нэмэртэй, ард түмний амьдралд тустай, байгаль орчин, хүний эрүүл мэндэд хохиролгүй байхыг хэлэх ба энэ нь уул уурхайг төлөвлөж эхлэхээс авхуулаад дуусах хүртэл хийгдэх олон талын цогц арга хэмжээ” хэмээн тодорхойлжээ. Сүүлийн жилүүдэд олон улсын зах зээлд ESG (Environment, Social and Governance) буюу Байгаль орчин, Нийгэм, Засаглалын шалгуур үзүүлэлтүүдийг чухлаар авч үзэх болсон. Дээрх шалгуурууд нь компанийн үйл ажиллагаа уур амьсгал, агаар, ус, хөрс, хог хаягдал, газар ашиглалт зэрэг байгалийн хүчин зүйлд хэрхэн нөлөөлж буйг илтгэн харуулахаас гадна ажилтнуудын нөхцөл, жендэрийн тэгш байдал, олон нийттэй харилцах харилцаа, хөдөлмөрийн стандарт, үйлчилгээний хариуцлага зэрэг хүний хөгжлийн асуудлууд, компанийн манлайлал, удирдлага, дотоод хяналт, хувьцаа эзэмшигчдийн эрх, ил тод байдал, авлига, улс төрийн оролцоо зэргийг хамаардаг.

Канадын уул уурхайн үндэсний ассоциациас боловсруулсан “Тогтвортой уул уурхайн төлөө” (ТУУТ, англи хэлээр: Towards Sustainable Mining-TSM) стандарт нь дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн, уул уурхайн үйл

ажиллагааг хариуцлагатай, тогтвортой явуулахад чиглэсэн цогц тогтолцоо юм. Уг стандарт нь ESG буюу Байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын шалгуур үзүүлэлтийг бүрэн хамардаг бөгөөд НҮБ-ын Тогтвортой хөгжлийн 17 зорилтын 10 зорилттой шууд уялддаг байна. Монгол Улс энэ стандартыг хэрэгжүүлэгч 13 дахь орон болж, 2024 оны 10 дугаар сард зохион байгуулагдсан “Уул уурхайн долоо хоног-2024”-ийн үеэр талууд гарын үсэг зурж баталгаажуулсан нь салбарын хувьд шинэ шатны эхлэл болов.

Монголын уул уурхайн үндэсний ассоциаци (МУУҮА) нь Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамтай хамтран ажиллах санамж бичиг байгуулж, ТУУТ стандартыг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлээд байна. Тус стандартыг Монгол Улсад нутагшуулах зорилгоор 8 жилийн өмнө хариуцлагатай уул уурхайн анхан шатны шалгуур үзүүлэлт бүхий “Хариуцлагатай уул уурхайн кодекс” (ХУУК)-ыг боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд ХУУК нь уул уурхайн үйл ажиллагаанд ёс зүй, ил тод байдал, байгаль орчин, нийгмийн хариуцлагын үндсэн зарчмуудыг шингээсэн, уул уурхайн компаниудын үйл ажиллагааг тогтвортой хөгжилд нийцүүлэх чухал алхам болсон юм. 2019 онд МУУҮА-ийн санаачилгаар олборлох салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг нэгтгэх зорилгоор “Хариуцлагатай нэгд” аяныг зохион байгуулж, тус салбарын тэргүүлэх 8 компани харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурж, хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. Эдгээр үр дүн, туршлагын үндсэн дээр Монгол Улс ТУУТ стандартыг хэрэгжүүлэх албан ёсны эрхийг авч, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тогтолцоог уул уурхайн салбарын бодлого, үйл ажиллагаанд үе шаттайгаар нэвтрүүлэх, хариуцлагатай, тогтвортой хөгжил рүү шилжих ажлыг эрчимжүүлсээр байна.

Дээрх ажлын хүрээнд уул уурхайн ТОП аж ахуйн нэгж, компаниудад зориулсан сургалтыг Канадын уул уурхайн ассоциацитай хамтран зохион байгуулж, ТУУТ стандартыг Монгол хэл рүү хөрвүүлэн, техникийн хяналт, редакторлах ажлыг салбарын экспертүүдийн хамт гүйцэтгэж байна. Компаниуд тус стандартыг нэвтрүүлж, хэрэгжүүлснээр олон улсын шилдэг туршлагыг дагаж мөрдөж, хариуцлагатай уул уурхайг эрхэмлэж буйгаа нотлон харуулахаас гадна салбарын өрсөлдөх чадварыг олон улсын тавцанд ахиулах том алхам болох юм.

ТУУТ стандартын 9 протоколд нутгийн иргэдтэй харилцах, аюулгүй эрүүл ажлын байр бий болгох, тэгш боломж олгох, эрсдэлийн менежмент, хүүхдийн хөдөлмөрийг хориглох, биологийн олон янз байдлыг хамгаалах, хаягдлын далан, ус, уур амьсгалын



## МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ

өөрчлөлтийн менежмент зэрэг олон асуудлыг хамруулсан байдаг. Тус стандартыг хэрэгжүүлэхдээ компани жил бүр өөрийн үнэлгээг хийж, гурван жил тутам хөндлөнгийн үнэлгээгээр баталгаажуулж, олон талын зөвлөлөөр хянуулах нь оролцогч талуудын эрх ашгийг тэгш хангах, харилцааг илүү нээлттэй, шударга үнэлэх давуу талтай.

Тус стандартыг хэрэгжүүлэх нь уул уурхайн компаниудын ил тод байдал, олон улсын нэр хүндийг нэмэгдүүлэх чухал механизм болох юм. Тухайлбал, дэлхийн хэмжээний үйлдвэрлэгч, хөрөнгө оруулагчид болох Apple, Tesla, BMW, La Mancha Capital зэрэг томоохон компаниуд ТУУТ стандартыг хүлээн зөвшөөрч, хангаж буй түүхий эдийнхээ гарал үүсэл, хариуцлагын түвшинг онцгойлон анхаардаг болсон нь энэ стандартын олон улсын ач холбогдлыг тод харуулж байна. Монгол Улсын хувьд, "Mongolian Mining Corporation" (ММС) компани ТУУТ стандартыг хэрэгжүүлж эхэлснээр 2023 онд аюулгүй ажиллагаа болон биологийн олон янз байдлын үнэлгээгээр AA+ буюу хамгийн өндөр зэрэглэл авч, хариуцлагатай уул уурхайн жишиг үзүүлэлтийг тогтоон манлайлан ажиллаж байна. Мөн “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь ТУУТ стандартыг анхлан хэрэгжүүлэгчдийн нэг болохоор бэлтгэл ажлаа хангаж буй нь цаашлаад төрийн өмчит уул уурхайн компаниудын засаглал, хариуцлагын тогтолцоог шинэ шатанд хүргэх, бүтээгдэхүүний үнэ цэнийг өсгөх, олон улсын зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх стратегийн чухал ач холбогдолтой алхам болж байна.

Дэлхий дахинд хариуцлагатай уул уурхайн нэгдсэн стандарт боловсруулах ажил ид өрнөж байна. Олон улсад

“The Copper Mark”, Канадын ТУУТ стандарт, Дэлхийн алтны зөвлөлийн зарчим, ICMM-ийн уурхайн зарчмуудыг нэгтгэн хамгийн өргөн хүрээтэй "Consolidated Mining Standards Initiative" стандартыг боловсруулж байна. Энэ ажлын хүрээнд компаниуд, төрийн байгууллага, судлаач, иргэний нийгмийн төлөөлөл оролцож, өргөн хэлэлцүүлэг зохион байгуулж байгаа бөгөөд тун удахгүй эцэслэн батлах аж. Монголын уул уурхайн үндэсний ассоциаци энэхүү санаачилгад идэвхтэй нэгдэн, олон улсын туршлагыг Монголдоо нутагшуулах, өөрийн орны онцлогт тохируулах чиглэлд анхаарч ажиллаж байна.

ТУУТ стандарт нь хариуцлагатай, ил тод үйл ажиллагааг төлөвшүүлэхийн зэрэгцээ Монголын уул уурхайн салбарын нэр хүндийг олон улсын түвшинд өргөж, нийгэмд ээлтэй, тогтвортой хөгжлийг хэрэгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулах чухал хөшүүрэг болох юм. Энэхүү стандартыг хэрэгжүүлснээр дотоодод уул уурхайн салбарын хариуцлагын тогтолцоо сайжрахаас гадна төр, хувийн хэвшил, иргэний нийгэм, орон нутгийн иргэд зэрэг оролцогч талуудын хамтын ажиллагаа, харилцан ойлголцол гүнзгийрэх суурь нөхцөл бүрдэх давуу талтай. Түүнчлэн Монгол Улсаас олборлосон бүтээгдэхүүний олон улсад өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, зах зээл дэх үнэ цэнийг өсгөхөөс гадна эрдэс баялгийн салбарыг хариуцлагатай, тогтвортой үйлдвэрлэл эрхэлдэг орчин үеийн хөгжлийн жишигт нийцүүлэх өргөн боломжийг нээснээр уул уурхайн салбарын тогтвортой байдал, олон улсын зах зээл дэх байр суурийг бататгах стратегийн ач холбогдолтой, үе шаттай цогц алхам юм.





## ТУУТ СТАНДАРТЫН 9 ПРОТОКОЛ 34 ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

ТУУТ стандартыг нэвтрүүлж хэрэгжүүлэх уул уурхайн компани нь дараах 2 хамрах хүрээ, 9 протоколын дагуу нийт 34 шалгуур үзүүлэлтийг хангах юм. Төсөл хэрэгжүүлэгч уг шалгуурыг хангаж буй эсэхдээ өөрийн үнэлгээг хийж бэлэн болмогц хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар аудит хийлгэх бөгөөд тогтмол сайжруулалтыг хийж явах юм.



### НУТГИЙН ИРГЭД БОЛОН ОРОН НУТГИЙН ХАРИЛЦАА

- › Сонирхогч бүлгүүдийг тодорхойлсон байх
- › Сонирхогч бүлгүүдтэй үр дүнтэй харилцдаг байх
- › Нутгийн иргэдтэй үр дүнтэй харилцдаг байх
- › Орон нутагт үзүүлэх нөлөө болон үр өгөөжийн менежемент
- › Сонирхогч бүлгүүдтэй харилцах механизм



### ТЭГШ БОЛОМЖ, ОЛОН ТАЛТ, ХҮРТЭЭМЖТЭЙ АЖЛЫН БАЙР

- › Удирдлагын түвшний манлайлалтай байх
- › Уурхай дээр тэгш боломж, олон талт, хүртээмжтэй ажлын байр бий болгох
- › Уурхайн дээр тэгш боломж, олон талт, хүртээмжтэй ажлын байр бий болгож буй талаар тайлагнах



### ХҮҮХДИЙН БОЛОН АЛБАДАН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХЭЭС СЭРГИЙЛЭХ

- › Албадан хөдөлмөр эрхлэлтээс сэргийлэх
- › Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтээс сэргийлэх



### ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

- › Хаягдлын менежментийн бодлого ба үүрэг амлалт
- › Хаягдлын менежментийн систем, үүрэг хариуцлага тодорхой байх
- › Хаягдлын менежментийн систем болон онцгой байдлын бэлэн байдал
- › Үйл ажиллагаа, үйлчилгээ, магадлах хяналтын загвар
- › Хаягдлын менежментийн жил тутмын дүн шинжилгээ



### АЮУЛГҮЙ, ЭРҮҮЛ, ҮНЭЛЭМЖТЭЙ АЖЛЫН БАЙР

- › Үүрэг амлалт ба эгэх хариуцлага
- › Аюулгүй байдал, эрүүл мэндийн менежментийн систем
- › Сэтгэл зүйн аюулгүй байдал болон хүндэтгэлтэй зан үйл төлөвшүүлэх
- › Сургалт, зан үйл, соёл
- › Хянах, тайлагнах
- › Биеийн аюулгүй байдал болон эрүүл мэндийн чанар



### ХЯМРАЛЫН МЕНЕЖМЕНТ БОЛОН МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

- › Хямралын менежмент болон мэдээлэл харилцааны бэлэн байдал
- › Хяналт
- › Сургалт



### БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН МЕНЕЖМЕНТ

- › Биологийн олон янз байдлыг хамгаалах компанийн үүрэг амлалт, эгэх хариуцлага, мэдээлэл харилцаа
- › Уурхай дээрх биологийн олон янз байдлыг хамгаалах төлөвлөгөө, түүний гүйцэтгэл
- › Тайлагнал



### УСНЫ МЕНЕЖМЕНТ

- › Ус ашиглалтын талаар бодлоготой байх
- › Ус ашиглалтын менежмент
- › Усны сав газрын төлөвлөлт
- › Ус ашиглалтын гүйцэтгэл ба тайлан



### УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН МЕНЕЖМЕНТ

- › Компанийн түвшинд уур амьсгалын өөрчлөлтөд үзүүлэх нөлөөллийг бууруулах менежмент
- › Лицензийн талбай болон түүний орчимдуур амьсгалын өөрчлөлтөд үзүүлэх нөлөөллийг бууруулах менежмент
- › Лицензийн талбай болон түүний орчимд уур амьсгалын өөрчлөлтөд үзүүлэх нөлөөллийг бууруулахаар тавьсан зорилт, гүйцэтгэлийн тайлагнал

# “ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ” УТҮГ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 77 дугаар тогтоолоор Эдийн засгийн хөгжлийн зөвлөл байгуулагдсан. Энэхүү зөвлөл нь бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, эдийн засгийн төрөлжсөн болон тогтвортой өсөлтийг хангах зорилгоор нотолгоонд суурилсан бодлогын зөвлөмж боловсруулж, төр-хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх үүрэгтэй.

Зөвлөлийн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх, мэргэжлийн судалгаа шинжилгээний үндэслэлээр хангах, хэлэлцэх асуудлыг боловсруулах, оролцогч талуудын уялдаа холбоог зохион байгуулах зорилгоор “Эдийн засгийн хөгжлийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрыг байгуулсан.

## Тус төв нь дараах үндсэн чиглэлээр ажилладаг:

- Эдийн засгийн хөгжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлыг урьдчилан боловсруулж, хувийн хэвшлийн төлөөллөөс санал авах;
- Эдгээр саналыг нэгтгэн шийдвэр гаргах түвшинд хүргэх уялдаа холбоог хангах;
- Мэргэжлийн судалгаа, шинжилгээ хийж, зөвлөлийн үйл ажиллагаанд бодит дэмжлэг үзүүлэх;
- Салбарын оролцогч талуудын уялдаа холбоог сайжруулахад чиглэсэн арга хэмжээ, хамтын ажиллагааг зохион байгуулах.

Эдийн засгийн хөгжлийн төв нь төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлж, эдийн засгийн шинэтгэлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чухал гүүр болон ажиллаж байна.


## Удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнд

1	ЭЗХЗ-ийн дарга - Монгол Улсын Ерөнхий сайд	22	"Алсын хараа 2050" салбар дундын уялдааг хангах Үндэсний хорооны Ажлын албаны дарга
2	Дэд дарга - Улсын Их Хурлын гишүүн	23	Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Ерөнхийлөгч
3	Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд	24	Монгол Улсын Их сургуулийн Бизнесийн сургуулийн захирал, профессор
4	Монгол Улсын Улсын Шадар сайд (Бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал хариуцсан)	25	Санхүү, эдийн засгийн их сургуулийн Ахисан түвшний профессор
5	Монгол Улсын Шадар сайд (Гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан)	26	Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Бизнесийн ахисан түвшний сургуулийн захирал
6	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	27	Хөдөө аж ахуйн их сургуулийн ректор
7	Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга	28	Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын ерөнхийлөгч
8	Сангийн сайд	29	Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч
9	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд	30	Улаанбаатар хотын Худалдааны танхимын Ерөнхийлөгч
10	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	31	Монголын ноос, ноолуурын холбооны гүйцэтгэх захирал
11	Зам тээврийн сайд	32	Дотоодын хөрөнгө оруулагчдын төлөөлөл "М-Си-Эс Холдинг" ХХК-ийн ерөнхий захирал
12	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд	33	Дотоодын хөрөнгө оруулагчдын төлөөлөл "Шүнхлай Холдинг" ХХК-ийн ерөнхийлөгч
13	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	34	Дотоодын хөрөнгө оруулагчдын төлөөлөл "Монголын алт МАК" ХХК-ийн Ерөнхийлөгч
14	Эрчим хүчний сайд	35	Дотоодын хөрөнгө оруулагчдын төлөөлөл "Ньюком" группын Ерөнхий захирал
15	Монгол банкны ерөнхийлөгч	36	Дотоодын хөрөнгө оруулагчдын төлөөлөл "Макс" группийн ерөнхийлөгч
16	Санхүүгийн зохицуулах хорооны дарга	37	Дотоодын хөрөнгө оруулагчдын төлөөлөл "Нано интернэйшнл" ХХК-ийн гүйцэтгэх захирал
17	Үндэсний статистикийн хорооны дарга	38	Рио Тинто компанийн Монголыг хариуцсан захирал
18	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга	39	"Монголын эдийн засгийн форум" НҮТББ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга
19	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эдийн засгийн бодлогын зөвлөх	40	Дотоодын хөрөнгө оруулагчдын төлөөлөл "Юрика" ХХК-ийн гүйцэтгэх захирал
20	Монгол Улсын Ерөнхий сайдын ахлах зөвлөх бөгөөд ажлын албаны дарга	41	Нарийн бичгийн дарга "Эдийн засгийн хөгжлийн төв" УТУГ-ын гүйцэтгэх захирал
21	"Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн гүйцэтгэх захирал		

## “Эдийн засгийн хөгжлийн төв” УТУГ-ын бүтэц

“Эдийн засгийн хөгжлийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газар нь төр-хувийн хэвшлийн харилцаа, хамтын ажиллагааг илүү үр дүнтэй, уян хатан болгох зорилгоор байгуулагдсан бөгөөд эдийн засгийн бодлогын ил тод байдал, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд

чиглэсэн бүтэц, зохион байгуулалттайгаар ажиллаж байна. Төв нь олон улсын сайн туршлага, үндэсний хэрэгцээнд тулгуурласан судалгаа, хэлэлцүүлэг, зөвлөмжөөр дамжуулан эдийн засгийн хөгжлийг дэмжих бодлогын шинэчлэл, хамтын оролцоог хэрэгжүүлэгч байгууллага юм.



## Эдийн засгийн хөгжлийн төвийн чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэлийн тухайд

Эдийн засгийн хөгжлийн төв нь бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлэхэд чиглэсэн мэргэжлийн судалгаа, шинжилгээ хийх, салбарын оролцогчдын үйл ажиллагааны уялдааг ханган дэмжлэг үзүүлэх үндсэн үүрэгтэй. Судалгаа, шинжилгээ хийх болон хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлүүд:

- Хөгжлийн урт болон дунд хугацааны бодлогын зорилтуудтай уялдуулан улс орны өрсөлдөх чадвар, давуу тал, тодорхой салбар, бизнест ээлтэй хөрөнгө оруулалтын орчны талаар;
- Олон улсад шинээр хөгжиж байгаа эдийн засгийн үйл ажиллагааны шинэ салбар, үйлдвэрлэл, технологи, тэдгээрийг дотоодын зах зээл, бизнесийн орчинд нутагшуулах боломжийн талаар;
- Эдийн засгийн салбарын бүтээмж, экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээний талаар;
- Төсөв, санхүү, эдийн засгийн бодлогын төлөвлөлтийг сайжруулах, эдийн засгийн хөгжилд тулгарч болох эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар;
- Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн

бодлогын тэргүүлэх салбар, хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг эрэмбэлэх, эдийн засгийг дэмжих томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний талаар;

- Эдийн засгийн хөгжлийн зөвлөлийн хуралдааныг зохион байгуулах, шийдвэрийг албажуулах, гарсан зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлэхтэй холбоотой асуудлуудыг зохион байгуулах;
- Дотоод гадаадын томоохон аж ахуйн нэгж болон шинэ хөрөнгө оруулагчид үйл ажиллагаагаа эхлүүлэх, бизнесээ өргөжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх чиглэлээр бусад байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах, хамтарсан уулзалт зохион байгуулах;
- Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр төрийн болон холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулж, мэргэжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх;
- Шинэ сэргэлтийн бодлого, хөтөлбөрийн хөгжлийн төслүүдэд судалгаа, дүн шинжилгээ хийж, оролцогч тал болон холбогдох бусад байгууллагуудын тайлан, мэдээг нэгтгэх, мэдээллийн сан бүрдүүлэх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж ажиллана.

## Эдийн засгийн хөгжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудлууд

Эдийн засгийн хөгжлийн зөвлөлийн нийт дөрвөн удаагийн хурлыг амжилттай зохион байгуулж, 20 гаруй чухал асуудлыг хөндсөн. Хурлаар хөрөнгө оруулалт болон бизнесийн таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн бодлогын асуудлыг түлхүү хэлэлцүүлсэн. Эдгээр хэлэлцсэн асуудлуудад манай улсад идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг худалдааны танхимууд болон хувийн хэвшлийн төлөөллийн саналыг тусган шийдвэр гаргах түвшинд хүргэх зорилгоор ажиллаж байна.


Хэлэлцсэн асуудлуудтай холбоотойгоор:

- Татварын тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд хувийн хэвшлийн төлөөлөлтэй хамтран ажилласан бөгөөд Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Улаанбаатар Хотын Худалдааны Танхим, Монголын Бизнесийн Зөвлөл, АмЧам Монгол болон Монгол дахь Австралийн Худалдааны Танхим зэрэг хувийн хэвшлийн төлөөллийн саналыг нэгтгэн Сангийн яам болон зөвлөлийн гишүүдэд албан ёсоор хүргүүлсэн болно. Мөн эдгээр байгууллагын төлөөлөөс бүрдсэн ажлын хэсэг татварын шинэчлэлтэй холбоотойгоор нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай 20 чухал асуудлыг тодорхойлж, холбогдох өөрчлөлтийн санал, зөвлөмжийг боловсруулан Эдийн засгийн хөгжлийн зөвлөл болон Сангийн яамны хууль боловсруулах ажлыг хэсэгт танилцуулахаар ажиллаж байна.

- Эрчим хүчний тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд Монголын Бизнесийн Зөвлөл болон Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Эрчим хүчний зөвлөлөөр дамжуулан хувийн хэвшлийн төлөөллийн саналыг тусган Эдийн засгийн хөгжлийн зөвлөлийн хуралдаанд танилцуулсан. Энэхүү хамтын ажиллагаа нь хууль, эрх зүйн орчныг сайжруулахад хувийн хэвшлийн дуу хоолойг хүргэх, салбарын хөгжлийг түргэтгэхэд чухал ач холбогдолтой юм.
- Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудлууд, нэгдсэн системийн талаар танилцуулсан бөгөөд энэхүү хуулийн төсөл нь Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар дэмжигдэж, Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэгдэхээр төлөвлөгдөж байна.
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд хувийн хэвшилтэй хамтран ажиллаж байна. Хуулийн төслийг танилцуулах уулзалтыг зохион байгуулж, ажлын хэсгийн хүрээнд хувийн хэвшлийн төлөөллийн саналыг тусгуулах зорилгоор хэлэлцүүлэг, хамтын ажиллагааг өрнүүлэн ажиллаж байна. Энэхүү үйл явц нь худалдан авах ажиллагааны ил тод, үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх, бизнес эрхлэгчдэд тэгш боломж бүрдүүлэхэд чиглэх юм.

## ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ТАНИЛЦУУЛГА

Засгийн газрын хөрөнгө оруулалттай холбогдох чиг үүрэгтэй бүх оролцогч талуудын нарийн уялдаа холбоог шаардах бөгөөд зохицуулалтыг сайжруулахын тулд **Эдийн засгийн хөгжлийн зөвлөлийг** байгуулсан.



## ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛААР ХЭЛЭЛЦҮҮЛЭХЭЭР

ТӨЛӨВЛӨЖ БУЙ АСУУДЛУУД



## ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛААР ХЭЛЭЛЦҮҮЛЭХЭЭР

### ТӨЛӨВЛӨЖ БУЙ АСУУДЛУУД



1. ТАТВАРЫН ХУУЛИЙН ТӨСӨЛД ХУВИЙН ХЭВШЛИЙН САНАЛ ХЭРХЭН ТУССАН ТАЛААРХ.



2. УУЛ УУРХАЙН САЛБАРТ ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛЫН ТАЛААРХ ХУВИЙН ХЭВШЛИЙН САНАЛ.



3. АЛТНЫ БИЗНЕС ЭРХЛЭГЧ, ХУВИЙН ХЭВШИЛД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛЫН ТАЛААРХ ХУВИЙН ХЭВШЛИЙН САНАЛ.



4. ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНТАЙ ХОЛБОГДУУЛАН ЗГ-ААС ТАНИЛЦУУЛСАН АСУУДАЛД ХУВИЙН ХЭВШЛЭЭС ИРҮҮЛСЭН САНАЛ.



5. ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙГ НЭГТГЭН ТАНИЛЦУУЛАХ.

## ЭЗХТ-ийн чиг, үүргийн хүрээнд 2025 онд хийж буй судалгааны ажлууд

2025 онд Эдийн засгийн хөгжлийн төвөөс дараах сэдвүүдийн хүрээнд бодлогын судалгаа, шинжилгээний ажлуудыг гүйцэтгэж байна. Эдгээр судалгаа нь төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах, эдийн засгийн үр ашиг, засаглалыг нэмэгдүүлэх, бүтцийн шинэчлэлийг бодитойгоор дэмжихэд чиглэж буй юм. Үүнд:

### 1. Орон сууцны тулгамдсан асуудал ба шийдэл

Хүртээмжтэй, тогтвортой орон сууцны бодлого, санхүүжилтийн механизмыг тодорхойлох судалгаа.

### 2. Шинэ сэргэлт 2.0

Монгол Улсын эдийн засгийн хоёр дахь үе шатны сэргэлтийн бодлогын зорилт, хэрэгжилтийн үнэлгээ, шинэ чиг хандлагын судалгаа.

### 3. Эрчим хүчний эх үүсвэрийн дуудлага худалдааны загвар /Аукцион/

Эрчим хүчний шинэ эх үүсвэрийг зах зээлийн зарчмаар сонгон шалгаруулах механизмын олон улсын туршлага, Монгол Улсад нутагшуулах боломжийн тухай судалгаа.

### 4. Төрийн өмчит компанийн засаглалыг олон улсын жишигт харьцуулах

Монгол Улсын төрийн өмчит компаниудын засаглалын түвшин, хариуцлага, ил тод байдлыг олон улсын сайн туршлагатай харьцуулан үнэлэх.

### 5. Татварын хөнгөлөлт, урамшууллын бодлого

Одоогийн хөнгөлөлт, урамшууллын бодлогын үр нөлөө, эдийн засгийн үр ашигт байдал, сайжруулах санал, чиглэл.

### 6. Төсөв ба төрийн албаны хэмнэлт

Төсвийн зардлын бүтцийн оновчлол, төрийн албаны үр ашигтай байдал, хэмнэлтийн боломжийг тодорхойлох судалгаа зэрэг ажлууд хийгдэж байна.

Танилцуулгыг бэлтгэсэн: Дарамрагчаа ОЮУНБАТ  
МЭРГЭЖИЛТЭН  
“Зөвлөлийн үйл  
ажиллагааны хөтөлбөр”



АЛСЫН ХАРАА  
**2050**  
МОНГОЛ УЛС

**ЭЗХТ** Бизнес  
Ээлтэй  
Монгол

ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

АЛСЫН ХАРАА  
**2050**  
МОНГОЛ УЛС

**ЭЗХТ** Бизнес  
Ээлтэй  
Монгол

Эдийн засгийн хөгжлийн төв  
Mongolia Economic  
Development Board EDB

**Хаяг:** Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг  
Нэгдсэн үндэстний гудамж –  
Засгийн газрын 2 дугаар байр

**Утас:** 70116838  
**Facebook** EDB- Mongolia.mn